

МОНГОЛЫН ХААНДИЙН
ИЛГЭЭНИЙН ХААНДИЙН
2023-11-15
БҮРГЭВ

СЗХ
2023-11-08
БҮРГЭВ
№ 1

Үүсгэн байгуулагч
Омни Капитал ББСБ ХХК


Үнэт цаас гаргагч
Омни Ассет ТЗК ХХК

Андеррайтер
Апекс Капитал ҮЦК ХХК

Хөндлөнгийн хуулийн зөвлөх
Өмгөөллийн ХаанЛекс Партнерс ХХН

Зээлийн шинжилгээ гаргагч
Шонхор Үнэлгээ Аудит ХХК

Хөрөнгө итгэмжлэн удирдагч
Юү Эй Эф Ассет Менежмент ХХК



ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаасны хүү

19.6 хувь

Үнэт цаасны хугацаа

24 сар

Татан төвлөрүүлэх дүн

6 тэрбум ₮





ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРЛАД

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох журмуудын дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж байгаа болно.

Уг танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас нэг бүр нь 100,000 /Нэг зуун мянган/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 60,000 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй гаргахтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулан бэлтгэсэн болно. Үнэт цаас гаргагч "Омни Ассет ТЗК" ХХК нь 6,000,000,000 төгрөгийн үнэт цаасыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох "Омни Капитал ББСБ" ХХК-аас зээлийн багцыг шилжүүлэн авах буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны хүрээг тэлэхэд ашиглана.

"Энэхүү танилцуулгад тусгасан баталгаат үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь уг баталгаат үнэт цаасанд гаргасан аливаа баталгаа биш бөгөөд түүний агуулсан аливаа мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хариуцахгүй! Баталгаат үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, баталгаат үнэт цаасны танилцуулга, баталгаат үнэт цаас гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна."

"Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын хөрөнгийн бирж бүртгэсэн нь уг үнэт цаасны эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч Таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна."

Энэхүү танилцуулгад тусгагдсан зарим мэдээлэл нь үнэт цаасны танилцуулга бэлтгэгдэж дууссан үеэс хойш шинэчлэгдэх боломжтой. Андеррайтер нь холбогдох баталгаат гэж үзсэн эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурлан тооцоолол төсөөллийг оруулсан, санаатайгаар ямар нэг мэдээллийг орхигдуулаагүй бөгөөд үүний биелэлтэд ямар нэг баталгаа өгөөгүй болно.

Үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таныг шийдвэрээ гаргахад шаардлагатай буюу нэмэлтээр асууж, лавлан тодруулах зүйл байвал Андеррайтер "Апекс капитал" ҮЦК-д хандана уу.



ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Үүсгэн байгуулагч / Анхны үүрэг гүйцэтгүүлэгч



Omni Capital

"ОМНИ КАПИТАЛ ББСБ" ХХК

Утас: +976 7277-8282

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр оффис, 712-713 тоот

Э-Шуудан: info@omnicapital.mn

Вэб хуудас: www.omnicapital.mn

Андеррайтер



"АПЕКС КАПИТАЛ ҮЦК" ХХК

Утас: +976 7510-7500

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Олимпийн гудамж, Нью Хорайзонс оффис, 901 тоот

Э-Шуудан: investment@apex.mn

Вэб хуудас: www.apex.mn

Хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч



ӨМГӨӨЛЛИЙН "ХААНЛЕКС ПАРТНЕРС" ХХН

Утас: +976 7747-1112

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн 5-р гудамж, Аюуд тауэр 14 давхар 1404 тоот

Э-Шуудан: info@khanlex.mn

Вэб хуудас: www.khanlex.mn

Хөрөнгө итгэмжлэн удирдагч



"ЮУ ЭЙ ЭФ АССЕТ МЕНЕЖМЕНТ" ХХК

Утас: +976 7012-2346

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын төв өргөө, 1005 тоот

Э-Шуудан: info@uaf.mn

Вэб хуудас: www.uaf.mn

Зээлийн шинжилгээ гаргагч



"ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ" ХХК

Утас: +976 8011-0088

Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар, 6-р хороо, сүхбаатар, 302 барилга 603 тоот

Э-Шуудан: shonkhor.mn@gmail.com





ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД.....	2
ОРОЛЦОГЧ ТАЛУУД.....	3
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР.....	8
ҮНЭТ ЦААСНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	10
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны онцлог.....	11
Хууль эрх зүйн орчин.....	12
НЭГ. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ТУХАЙ.....	16
1.1 Үүсгэн байгуулагч буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Омни Капитал ББСБ" ХХК-ийн тухай.....	17
1.2 Хуулийн этгээдийн бүртгэл.....	18
1.3 Хувьцаа эзэмшил.....	19
1.4 ТУЗ-ийн мэдээлэл.....	20
1.5 "Омни капитал ББСБ" ХХК-ийн онцлог.....	21
1.6 Компанийн гүйцэтгэх удирдлага.....	22
1.7 "Омни капитал ББСБ" ХХК-ийн санхүүгийн мэдээлэл.....	23
ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ.....	30
2.1 ТЗК-ийн тухай.....	31
2.2 Үнэт цаас гаргагчийн удирдлага зохион байгуулалт, түүний эрх хэмжээ.....	32
2.3 ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл.....	34
2.4 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, төсөөлөл.....	37
2.5 ТЗК татан буугдах нөхцөл.....	42
2.6 Үнэт цаас гаргагч компанийн зэргэлдээ компанийн тухай.....	43
ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ.....	44
3.1 Үнэт цаасны нөхцөл.....	45
3.2 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг үнэт цаас эзэмшигчдээс буцаан худалдан авах нөхцөл.....	46
3.3 Үнэт цаасны хүү тогтоосон үндэслэл.....	46
3.4 Хөрөнгө оруулалтын өгөөж.....	49
3.5 Үнэт цаасны төлбөрийн тооцоолол.....	50
3.6 Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал.....	52
3.7 Багцын тойм.....	55
ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН.....	64
4.1 Гадаад орчин.....	65
4.2 Дотоод орчин.....	68
4.3 Банк бус санхүүгийн байгууллагын салбар.....	70





4.4 Хөрөнгийн зах зээлийн төлөв	73
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА.....	78
5.1 Эрсдэл, эрсдэлийн удирдлага	79
5.2 Үнэт цаасны арилжаа, захиалга өгөх заавар	86
ЗУРГАА. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД.....	87
6.1 Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон байгууллагууд	88
6.2 Оролцогч талууд нь нэгдмэл сонирхол, бизнесийн холбоо хамааралтай эсэх, түүнийг мэдэгдэх.....	97



2023-11-15

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ



График 1 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл	24
График 2 Арилжааны банкны хадгаламжийн хүүгийн түвшин	47
График 3 Нээлттэй бондуудын хүүгийн түвшин	47
График 4 ХБҮЦ-уудын хүүгийн түвшин	48
График 5 2012 оноос хойш ХБҮЦ-ны зах зээлийн хэмжээ (Тэрбум \$)	65
График 6 2020 оноос хойш инфляцын динамик	67
График 7 Инфляцын түвшний төсөөлөл	67
График 8 Дотоодын нийт бүтээгдэхүүн	69
График 9 Инфляц ба бодлогын хүүгийн динамик	69
График 10 ББСБ салбарын нийт санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээ	70
График 11 МУ-ын санхүүгийн зах зээлийн хэмжээ	70
График 12 2018 оноос хойш МУ-ын санхүүгийн зах зээлийн бүтэц	71
График 13 ББСБ-ын санхүүгийн үзүүлэлтүүдийн өсөлт	72
График 14 МУ-ын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ	73
График 15 Арилжааны идэвх	73
График 16 Арилжааны бүтэц	74
График 17 ТОП-20 индексийн түүхэн үзүүлэлт	75
График 18 ХБҮЦ-ны арилжаа	76
График 19 МХБ дээр арилжаалагдсан шинэ бүтээгдэхүүнүүд	77






ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлан.....	23
Хүснэгт 2 “Омни Капитал ББСБ” ХХК-ийн орлогын тайлан	25
ББСБ-уудын хувьд хүү төлөх чадвар, төлбөрийн чадварыг илэрхийлэх гол үзүүлэлтийн нэг нь эрсдэлийн сангийн өмнөх ашиг юм. 2023 оны анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн сангийн өмнөх ашиг 1.2 тэрбум төгрөг байна.....	27
Хүснэгт 3 ББСБ салбар ба Омни капитал ББСБ-ын харьцуулалт.....	27
Хүснэгт 4 ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	28
Хүснэгт 5 “Омни ассет ТЗК” ХХК Эхлэлтийн баланс.....	37
Хүснэгт 6 “Омни ассет ТЗК” ХХК Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл.....	37
Хүснэгт 7 “Омни ассет ТЗК” ХХК Орлогын тайлангийн төсөөлөл.....	37
Хүснэгт 8 “Омни ассет ТЗК” ХХК Үйл ажиллагааны зардлын төсөөлөл	38
Хүснэгт 9 “Омни ассет ТЗК” ХХК Мөнгөн урсгалын тайлангийн төсөөлөл.....	39
Хүснэгт 10 Үнэт цаасны нөхцөл.....	45
Хүснэгт 11 Хадгаламжийн хүү.....	47
Хүснэгт 11 Хөрөнгө оруулалтын өгөөжийн жишээ тооцоолол.....	49
Хүснэгт 12 ХБҮЦ-ны нийт эргэн төлөлтийн тооцоолол.....	49
Хүснэгт 13 Хүү тооцох аргачлал.....	50
Хүснэгт 14 Хэлцлийн тойм хүснэгт.....	52
Хүснэгт 15 Багцын үндсэн үзүүлэлтүүд.....	55
Хүснэгт 16 Зээлийн багцын хугацааны мэдээлэл.....	56
Хүснэгт 17 Багцын анх олгосон хугацааны мэдээлэл.....	56
Хүснэгт 18 Багцын анх олгосон дүнгийн мэдээлэл.....	56
Хүснэгт 19 Багцын LTV харьцаа.....	57
Хүснэгт 20 Зээлийн хүүгийн тархалт	57
Хүснэгт 21 Багцад багтсан зээлийн барьцааны төрөл.....	58
Хүснэгт 22 Санхүүгийн салбаруудын сүүлийн 5 жилийн дундаж өсөлт	71

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Тусгай зөвшөөрлийн мэдээлэл.....	18
Зураг 2 Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал	52





НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР

Анхдагч зах зээлийн арилжаа	Үнэт цаас гаргагч анх удаагаа олон нийтэд санал болгох замаар арилжих арилжааны үе
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	Зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий, тухайн багцалсан зээлийн анхны эзэн буюу "Омни капитал ББСБ" ХХК
Багцын шаардлага	"Омни ассет ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-23/012 тоот тогтоолын "Хавсралт 1, 2"-оор баталсан зээлийн багцад тавигдах хуулийн болон санхүүгийн шалгуур
Баталгаат үнэт цаас	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үнэт цаас
Зэргэлдээ компани Зээлдэгч	Компанийн тухай хуулийн 6.15-д тусгагдсан хуулийн этгээдийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй Зээлийн гэрээ байгуулж, зээл авсан бөгөөд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг уг зээлийн гэрээний дагуу төлөх үүргийг хүлээсэн иргэн, хуулийн этгээдийг
Зээлийн эргэн төлөлт	Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцад багтсан зээлийн төлөлт буюу зээлдэгчээс зээлийн гэрээний дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх мөнгөн төлбөрийг
Зээлийн багц эсхүл багц	Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид худалдсан хөрөнгүүдийн багц
Омни Ассет ХБҮЦ эсхүл ХБҮЦ	Хөрөнгө оруулагчдад санал болгож буй үнэт цаас
Үнэт цаас гаргагч	"Омни ассет ТЗК" ХХК
Үйлчилгээ үзүүлэгч	Үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэхээр тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан хуулийн этгээд буюу "Омни капитал ББСБ" ХХК
Фидуцийн гэрээ	Үүргийн гүйцэтгэл хангах арга буюу үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ
Хөрөнгө итгэмжлэн удирдагч	Тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах үүрэг бүхий этгээд




2023-Н-13

СЭА
2023 11 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ЗМС	Зээлийн мэдээллийн сан
МХБ	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЗК	Тусгай зориулалтын компани
ҮЦТХТ	Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ХБҮЦ-ны тухай хууль	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль
DVP	Delivery versus payment буюу үнэт цаасны төлбөр тооцоо хийгдэх процесс





ҮНЭТ ЦААСНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргагч	“Омни ассет ТЗК” ХХК;
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	“Омни капитал ББСБ” ХХК;
Үнэт цаасны төрөл	Зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас;
Үнэт цаасны тоо ширхэг	60,000 ширхэг;
Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ	100,000 төгрөг;
Үнэт цаасны нийт дүн	6,000,000,000 төгрөг;
Үнэт цаасны хугацаа	24 сар
Үнэт цаасны хүү	19.6 хувь (жилийн)
Хүү төлөгдөх хугацаа	Улирал тутам
Үндсэн төлбөр төлөгдөх хугацаа	12 сард 1 удаа
Үнэт цаасны төлбөр төлөгдөх эх үүсвэр	Хөрөнгийн багцын зээлийн үндсэн болон хүүгийн орлого
Үнэт цаасны хүүд ногдох татвар	Хувь хүн болон ААН-д хүүгийн орлогод ногдох дүнгээс 5 хувь
Үнэт цаасны хадгалалт	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн данс
Арилжаалах зах зээл	Монголын хөрөнгийн бирж ХК
Багцын зээлийн нийт дүн	6,836,676,535 төгрөг
Автомашин барьцаалсан зээл	340,030,588 төгрөг
Автомашинны лизинг	4,701,301,615 төгрөг
Бизнесийн зээл	1,489,185,358 төгрөг
ҮХХ, Газар барьцаалсан-Хэрэглээний зээл	306,158,974 төгрөг
Зээлдэгчдийн тоо	426
Зээлийн чанар	100 хувь хэвийн
Андеррайтер	“Апекс капитал ҮЦК” ХХК





Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны онцлог

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн дундаас эрсдэлийн түвшин багад тооцогддог санхүүгийн хэрэгсэл юм. Учир нь хууль болон санхүүгийн шаардлага хангасан ирээдүйд мөнгөн урсгал бий болгох хөрөнгө буюу зээл, түрээсийн орлого зэргийг “Тусгай зориулалтын компани”-д шилжүүлэн эргэн төлөлтийг тусгаарлан баталгаажуулж энэ төрлийн үнэт цаасыг гаргагчаараа онцлогтой.

2022 оны бодлогын хүүгийн өөрчлөлт, инфляцын өсөлт, зах зээлийн тогтворгүй байдлаас шалтгаалан тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж буйн зэрэгцээ МУ-ын хөрөнгийн зах зээлд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчдын тоо ч нэмэгдэж байна.

<u>Ойлгомжтой байдал</u>	<p>Зээлийн багцыг ТЗК руу тусгаарлахдаа хууль болон санхүүгийн шалгуур хангасан эсэхийг хөндлөнгийн хуулийн болон аудитын компаниуд судалж, дүгнэлт гаргадаг. Энэ утгаараа зээлийн багцын эргэн төлөлтийн хугацаа, хэмжээ, барьцаа хөрөнгө нь тодорхой байдгаараа онцлогтой.</p> <p>Мөн хугацааны дундуур зээлийн багцаас шалгуур хангахгүй зээл гарсан тохиолдолд хууль болон санхүүгийн шаардлага хангасан ойролцоо төрлийн эргэн төлөлтийн хугацаа, хэмжээтэй зээлийг анхны үүрэг гүйцэтгүүлэгч солих арга хэмжээ авна.</p>
<u>Эрсдэл ба өгөөж</u>	<p>Бусад өрийн хэрэгсэлтэй харьцуулахад эрсдэл бага, өгөөж өндөртэй байхаас гадна хөрөнгө оруулагчдад тогтмол хүүгийн өгөөжийг олгоно.</p>
<u>Хяналтын тогтолцоо</u>	<p>ТЗК-ийн үйл ажиллагаанд олон төрлийн тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн оролцогчид оролцдог онцлогтой. Тодруулбал, андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч, хуулийн компани, аудитын компани үнэт цаас гаргах ажиллагаанд заавал оролдог бол ТЗК-ийн үйл ажиллагаа идэвхитэй байх хугацаанд тохиромжтой этгээд бүхий ТУЗ-ийн гишүүд, хөрөнгө итгэмжлэн удирдагч, үйлчилгээ үзүүлэгч, хөндлөнгийн аудит оролцдог тул хяналтын тогтолцоо өндөртэй.</p>
<u>Удирдлага</u>	<p>Тусгай зориулалтын компани нь ажилтан авч ажиллуулахыг хориглодог бөгөөд үйл ажиллагааг ТУЗ хэрэгжүүлдэг. ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байх хуулийн шаардлагатай.</p> <p>Нөгөө талаас хөрөнгө оруулагчдыг төлөөлөн хөрөнгийн удирдлагыг СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий Хөрөнгө итгэмжлэн удирдагч компани хэрэгжүүлдэг.</p>
<u>Татвар</u>	<p>Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүгийн орлогын албан татвар 5 хувь байна.</p>





Хууль эрх зүйн орчин

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, түүнийг гаргагчтай холбоотой үндсэн харилцааг “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-аар зохицуулж байна. Тус хуульд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон оролцогч этгээдүүдэд тавигдах шаардлага, хөрөнгийн багцад тавигдах шаардлага, үнэт цаас гаргах харилцаанд оролцогч этгээдүүдийн хоорондын харилцаа, эрх үүрэг болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахаар зохицуулсан.

Мөн дээрх хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулиар Үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь Санхүүгийн зохицуулах хороо байхаар тодорхойлсон.

Өөрөөр хэлбэл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах нарийвчилсан зохицуулалтууд нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм журмаар зохицуулагдахаас гадна олон нийтэд нээлттэй санал болгон гаргах үнэт цаасны хувьд арилжаа эрхлэх байгууллага болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн зохицуулалтууд хамаарна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах эрх зүйн орчин болон үнэт цаас гаргагч түүний үүсгэн байгуулагчийн даган мөрдөж буй хууль, дүрэм журам, гэрээний мэдээлэл. Үүнд:

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалтууд


Монгол Улсын хууль

- Иргэний хууль (2002)
- Зөвшөөрлийн тухай хууль (2022)
- Компанийн тухай хууль (2011)
- Татварын ерөнхий хууль (2019)
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль (2019)
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль (2019)
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль (2009)
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013)
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013)
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль (2010)
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль (2015)

СЗХ-оос баталсан дүрэм журмууд

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам (2022)
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам (2013)
- Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүний мэдээллэх журам (2019)





- Үнэт цаасанд нэг дсэн дугаар олгох журам (2010)

Хөрөнгийн биржийн журмууд /“Монголын хөрөнгийн бирж” ХК/

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам (2020)
- Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам (2021)
- Арилжааны журам (2012)
- Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам (2022)

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн журмууд

- Үнэт цаасны хадгаламжийн журам (2020)
- Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам (2019)

Үүсгэн байгуулагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтууд

Үүсгэн байгуулагч нь Банк бус санхүүгийн байгууллагын хувьд хууль эрх зүйн орчны хувьд дараах хууль тогтоомжуудаар зохицуулагдаж байна. Үүнд:

Монгол улсын хууль

- Монгол Улсын Үндсэн хууль (1992)
- Иргэний хууль (2002)
- Компанийн тухай хууль (2011)
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002)
- Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021)
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013)
- Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль (2009)
- Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015)


Монгол улсын Олон улсын гэрээ

- Монгол Улс 2001 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын конвенци
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол, галт зэвсэг, бүрдэл хэсэг, эд анги, галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протоколд нэгдэн орсныг соёрхон батлах тухай /Палермогийн конвенци/

Зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм журмууд

- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам (2016)
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам (2019)





- Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам (2020)
- Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам (2020)
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам (2019)
- Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам (2020)
- Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалуулагчид мэдээлэл өгөх журам (2010)
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам (2023)

Үнэт цаас гаргагчийн болон хөрөнгийн багцтай холбоотой эрх зүйн зохицуулалтууд

Үнэт цаас гаргагч "Омни ассет ТЗК" ХХК нь үйл ажиллагааны хүрээнд дараах хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөнө.

Монгол улсын хууль

- Иргэний хууль (2002)
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль (2010)
- Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль 2009)
- Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015)

Зохицуулагч байгууллагаас баталсан дүрэм, журам

- Монголын Хөрөнгийн биржийн Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам (2022)

"Омни ассет ТЗК" ХХК-ийн баталсан журмууд

- Компанийн дүрэм
- Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам
- Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам
- Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам
- Хөрөнгө итгэмжлэн удирдах журам
- Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам





"Омни ассет ТЗК" ХХК-тай холбоотой гэрээнүүд


1. Тохиролцсон горимоор ажил гүйцэтгэх гэрээ
2. Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ
3. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ
4. Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ
5. Банктай байгуулсан данс нээх гэрээ
6. Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ
7. Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ
8. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ
9. Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ
10. Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ
11. Фидуцийн барьцааны гэрээ




МОНГОЛ
УЛАС
СЭНГИЙН
ГЭМЭЭ-02

СЗХ
2023.09.08 ооор
БҮРТГЭВ
№ 01

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/
АНХНЫ ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ



Signature



1.1 Үүсгэн байгуулагч буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч “Омни Капитал ББСБ” ХХК-ийн тухай

“Омни капитал ББСБ” ХХК нь 2016 оны 5 дугаар сарын 11-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны хүрээнд СЗХ-ноос олгосон 5 төрлийн тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.

2022 оны байдлаар 34,000 гаруй харилцагчидтай, "Шилдэг хүртээмжтэй ББСБ", "Засаглалаар тэргүүлэгч ББСБ"-ын тэргүүлэгчдээр тодроод байна.

ТҮҮХЭН ЗАМНАЛ

- 2022**
 - Омни Актив ТЗК-ийг үүсгэн байгуулж 2022 оны хамгийн анхны олон нийтэд нээлттэй ХБҮЦ-ыг гаргав.
 - Биржийн бус зах зээл дээр анх удаагаа хаалттай бонд гаргаж амжилттайгаар арилжив.
 - Мони апп дээр санхүүгийн зөвлөгөө цэс нэмэгдэв.
 - Мэдээллийн аюулгүй байдлын ISO27001:2013 стандартыг амжилттай нэвтрүүлэв.
 - ББСБ-ын салбарын сайн засаглалтай ББСБ-уудаас 2-т орсон бөгөөд мөн Монголын ББСБ-ын Холбооны "Шилдэг хүртээмжтэй ББСБ"-ээр тодорсон билээ.
 - 34,000+ Харилцагч
- 2021**
 - Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх тусгай зөвшөөрөл СЗХ-ноос авав¹.
 - 22,000+ Харилцагч
- 2020**
 - Итгэлцэл ба факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл СЗХ-ноос авч үйл ажиллагаагаа өргөжүүлэв Финтек хэлтэс байгуулагдав.
 - "Мони апп" мобайл зээлийн апп хэрэглэгчдэдээ нэвтрүүлэв.
 - 5000+ Харилцагч
- 2019**
 - 700+ Харилцагч
- 2018**
 - Монголын ББСБ Холбоонд элсэв.
- 2017**
 - 60+ Харилцагч.
- 2016**
 - Төлбөрийн баталгаа гаргах тусгай зөвшөөрөл СЗХ-ноос авав
 - Омни Капитал ББСБ үүсгэн байгуулагдав.
 - Зээл, төлбөрийн баталгаа гаргах тусгай зөвшөөрлийг СЗХ-ноос олгов.
 - 60+ Харилцагчтай үйл ажиллагаа эхлэв.



¹ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь хэсэгт заасан Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагааг 2023 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.



БҮРТГЭВ-02

1.2 Хуулийн этгээдийн бүртгэл

Нэр:	"Омни капитал ББСБ" ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9015003126
Регистрийн дугаар:	6075657
Тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл:	<ol style="list-style-type: none"> 1. Зээлийн үйл ажиллагаа /2016.06.10/ 2. Төлбөрийн баталгаа /2016.06.10/ 3. Итгэлцлийн үйл ажиллагаа /2020.01.15/ 4. Факторингийн үйл ажиллагаа /2020.01.15/ 5. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх /2021.10.13/
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:	2,500,000,000₮
Нийт гаргасан энгийн хувьцаа	1,000₮-ийн нэрлэсэн үнэ бүхий 2,500,000 ширхэг энгийн хувьцаа
Хувьцаа эзэмшигч:	Ч.Даваасүрэн – 56 хувь "ЦБОН" ХХК- 44 хувь
Хаяг:	Салбар 1: СБД, 8-р хороо, "Монгол Ньюс Тауэр" 403 тоот Салбар 2: БЗД, 15-р хороо, 7/3 байр, 11-р байр, 01 тоот Салбар 3: СХД, 32-р хороо, 22 авто худалдааны төв, 2 давхар Салбар 4: БГД, 16-р хороо, Баруун 4 зам, Шинэ Монгол Хаад оффис, 4 давхар Салбар 5: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гранд оффис, 6 давхар Төв салбар: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр оффис, 712, 713 тоот

Зураг 1 Тусгай зөвшөөрлийн мэдээлэл



Зээлийн үйлчилгээ



Төлбөрийн баталгаа



Факторинг



Итгэлцэл



Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх





1.3 Хувьцаа эзэмшил



"ЦБОН" ХХК-44%

"ЦБОН" ХХК нь 1999 онд байгуулагдсан ба өдгөө уул уурхайн салбарын шилдэг ханган нийлүүлэгч компанийн нэгээр тооцогдож байна. Үйл ажиллагааны хувьд

- Эрдэс боловсруулалтын хүнд машин механизм, тэдгээрийн нийлүүлэлт;
- Гүний уурхайд ашиглагдах бүх төрлийн хоолой, холбох хэрэгсэл, насос ханган нийлүүлэлт;
- Аюулгүй ажиллагааны олон улсын шаардлагад нийцсэн чанарын өндөр шалгууруудыг хангаж үйлдвэрлэгддэг 1,000,000 гаруй төрлийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээний бүтээгдэхүүнүүдийн нийлүүлэлт чиглэлээр ажиллаж байна.

"ЦБОН" ХХК нь Оюу толгой, Эм Си Эс, Эрдэнэт үйлдвэр зэрэг томоохон аж ахуйн нэгжүүдийн ханган нийлүүлэгчээр хамтран ажиллахаас гадна Швейцар болон Австралийн томоохон брэндүүдийн албан ёсны төлөөлөгч юм.



Ч.Даваасүрэн-56%

Ч.Даваасүрэн нь Омни Капитал ББСБ-ыг анх Фрэндс Финанс нэртэйгээр 2016 онд үүсгэн байгуулсан бөгөөд 2019 оныг хүртэл Үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажилласан. 2019 оноос одоог хүртэл ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.

- 14 жилийн хугацаанд төсөв боловсруулж, байгууллагын санхүү хянаж, 20 гаруй ажилчинтай мэргэжлийн хамт олон удирдсан туршлагатай.
- 2016 он: Үүсгэн байгуулагч, Омни капитал ББСБ
- 2005-2015 он: Захирал, Өрхийн Эрүүл Мэндийн Төв
- 1995 он: Хүний Их Эмч (Ахлах Эрхтэй), Анагаах Ухааны Их Сургууль





1.4 ТУЗ-ийн мэдээлэл



Э.ПҮРЭВСҮРЭН /ТУЗ-ийн дарга-2022/

АНУ-ын "Virginia International University" их сургуулийг Бизнес удирдлагын мастерын зэрэгтэй төгссөн. Уул уурхай, ханган нийлүүлэлтийн компани болох "ЦБОН" ХХК-гийн Гүйцэтгэх захирлаар 2017-2019 хооронд, 2019 оноос хойш "Омни капитал" ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн дарга, "Омни смарт" ХХК-ийн гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байна.



Ч.ДАВААСҮРЭН /ТУЗ-ийн гишүүн-2019/

АШУИС-ийг Хүний эх эмч мэргэжлээр төгссөн бөгөөд Омни капитал ББСБ-ыг анх Фрэндс Финанс нэртэйгээр 2016 онд үүсгэн байгуулсан. 2016-2019 оныг хүртэл Үйл ажиллагаа хариуцсан захирлаар, 2019 оноос одоог хүртэл ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.



Ч.ЭРЭЛХЭГ /ТУЗ-ийн гишүүн-2019/

2017 онд АНУ-ын "Johns Hopkins University" их сургуулийг Бизнес удирдлагын бакалаврын зэрэгтэй төгссөн. "Омни капитал ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа бөгөөд АНУ-ын "The Advisory Board Company"-д Санхүүгийн шинжээч, "Голомт Банк ХК"-д Хөрөнгө оруулалтын менежерээр тус тус ажиллаж байсан туршлагатай.



Г.УУГАНБАЯР /ТУЗ-ийн гишүүн-2019/

2017 онд АНУ-ын "Minnesota State University" их сургуулийг Банкны удирдлагын бакалаврын зэрэгтэй төгссөн. "Омни капитал ББСБ" ХХК-ийн Хөрөнгө оруулалтын газрын захирлаар ажиллаж байгаа бөгөөд "Microsoft Corporation"-д Ахлах санхүүгийн шинжээчээр, "First Western Bank&Trust"-д Санхүүгийн шинжээчээр ажиллаж байсан туршлагатай.



Ч.БАТГЭРЭЛ /ТУЗ-ийн хараат бус гишүүн-2022/


2020 онд Австралийн Сидней хотын "Holmes Institute" их сургуулийг Бизнес удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн бөгөөд "Актив пасс" ХХК-ийн Дэд захирлын албан тушаалыг хашиж байна. Батгэрэл нь мэргэшсэн аудитор, дотоодын банкуудад Дотоод аудитор, албаны захирал зэрэг албан тушаалуудыг хашиж байсан арвин туршлагатай.



Д.ЭНХБАЯР /ТУЗ-ийн хараат бус гишүүн-2022/

МУИС-ийн ЭЗ-ийн сургуулийг Санхүү, нягтлан бодох бүртгэлийн мастерын зэрэгтэй төгссөн бөгөөд өдгөө "CDA audit" ХХК-ийн ТУЗ-ийн даргын албан тушаалыг хашиж байна. Энхбаяр нь 1981 оноос хойш нийт 42 жилийн турш татвар, аудитын чиглэлээр ажилласан бөгөөд Сангийн Яам, татварын газрууд, Татварын ерөнхий газар зэрэг байгууллагуудад ажилласан туршлагатай.






1.5 “Омни капитал ББСБ” ХХК-ийн онцлог

01. Тасралтгүй хурдацтай хөгжил

Цар тахлын өмнө үйл ажиллагаа явуулж эхэлсэн компанийн хувьд нийгэм орчны хувьсан өөрчлөгдөж буй нөлөөллийн явцад тасралтгүй үйл ажиллагаа явуулан өсөн хөгжиж буй компани.



02. Үйлчилгээгээ төрөлжүүлсэн байдал

ББСБ-ын үндсэн үйл ажиллагаа болох уламжлалт зээл олголтоос гадна финтек зээлийг түлхүү хөгжүүлж байгаа. Охин компани Spirit mobile-тай хамтран зээл олголтын сувгийг нэмэгдүүлэхийн сацуу тус суурь системийг ашиглан бусад бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулах, тэдний хэрэглээний зээл олголтын сувгийг шийдэх урт хугацааны шийдлүүд дээр ажиллаж байна.



03. Засаглалын чанар

Туршлагатай ТУЗ болон олон улсын хэмжээний чадвартай удирдлагын баг хамт олонтой үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд засаглалын шатууд ойлгомжтой, үр дүнтэй байхаар зохион байгуулагдсан. СЗХ-ны 2022 оны компанийн засаглалын үнэлгээний тайлангаар засаглал сайтай ББСБ-ын 2 дугаарт бичигдэв.



04. Итгэл хүлээсэн найдвартай түнш

2016 онд үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш босгосон итгэлцэл, бонд мөн түүнчлэн нээлттэй зах зээл дээр арилжсан ХБҮЦ зэргийн хүүгийн болон үндсэн төлөлтийг хоцроолгүй төлсөн. Цар тахал, эдийн засгийн хямралтай үеүдэд тогтмол өндөр түвшинд үйл ажиллагаагаа явуулж байна.

₮5 тэрбум
Нийт ХБҮЦ

₮24.6 тэрбум
Нийт итгэлцэл

+200
Нийт хөрөнгө оруулагч

₮6.4 тэрбум
Нийт бонд





Ч.ЭРЭЛХЭГ
Гүйцэтгэх захирал

Мэргэжил
Банкны удирдлага

Ажлын туршлага
2016-2017 он, NRECA, Санхүүгийн шинжээч
2017-2018 он, Advisory board company
2018-2020 он, Голомт банк, Хөрөнгө оруулалтын менежер
2020-2022 он, “Омни капитал ББСБ” ХХК, ТУЗ-ийн дарга
2022-одоог хүртэл, “Омни капитал ББСБ” ХХК, Гүйцэтгэх захирал



С.НИНА
Зээлийн үйл ажиллагааны газрын захирал

Мэргэжил
Банкны эдийн засаг, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага
2006-2017 он, Хас банк, Зээлийн мэргэжилтэн, Зээлийн менежер, Зээлийн эрсдлийн шинжээч
2017-2018 он, “Омни капитал ББСБ” ХХК, Эдийн засагч
2018-2022 он, “Омни капитал ББСБ” ХХК, Гүйцэтгэх захирал
2022 оноос, “Омни капитал ББСБ” ХХК, Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Зээл эрхэлсэн захирал



Г.УУГАНБАЯР
Хөрөнгө оруулалтын газрын захирал

Мэргэжил
Банкны удирдлага

Ажлын туршлага
2017-2019 он, Microsoft HQ, Санхүүгийн шинжээч
2019-одоог хүртэл, Омни капитал ББСБ ХХК, Хөрөнгө оруулалтын газрын захирал



Программ хангамжийн хувьд 2009 онд байгуулагдсан мэдээлэл технологи, програм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа тасралтгүй явуулж буй “Everest Solution” компанитай хамтран ажиллаж байна. Тус компанийн “Everest ERP” систем нь тогтмол сайжруулалт бүхий автоматжуулсан санхүү бүртгэлийн систем юм. Энэхүү системийг анхны үүрэг гүйцэтгүүлэгч үйл ажиллагаандаа ашиглаж, программ хангамжийн нөхцлөөр бүрэн хангагдсан байна.

1.7 "Омни капитал ББСБ" ХХК-ийн санхүүгийн мэдээлэл

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлан


сая төгрөг	2020	2021	2022	2023Q2	Бүтэц
Мөнгөн хөрөнгө	436	935	2,377	2,255	6.3%
Богино хугацаат ХО	-	505	1,038	2,093	5.8%
Зээл	7,099	12,781	22,668	25,244	70.2%
Факторингийн авлага	-	1,300	1,480	1,880	5.2%
Бусад эргэлтийн хөрөнгө	593	731	2,148	1,995	5.6%
Эргэлтийн хөрөнгө	8,128	16,252	29,712	34,810	96.8%
Үндсэн хөрөнгө	128	263	447	550	1.5%
Биет бус хөрөнгө	103	188	469	584	1.3%
Эргэлтийн бус хөрөнгө	231	451	916	1,134	3.2%
НИЙТ ХӨРӨНГӨ	8,360	16,703	30,627	35,944	100%
Богино хугацаат зээл	-	400	3,653	4,956	13.8%
Өрийн бичгээрх өглөг	1,935	2,520	1,770	4,500	12.5%
Бусад эх үүсвэр	2,345	5,771	8,541	9,453	26.3%
Бусад өр төлбөр	119	690	4,859	4,172	11.6%
Богино хугацаат өр	4,400	9,381	18,824	23,081	64.2%
Урт хугацаат зээл	-	-	1,000	1,000	2.8%
Хойшлогдсон татвар	0	1	3	-	-
Урт хугацаат өр	0	1	1,003	1,000	2.8%
Өр төлбөрийн нийт дүн	4,401	9,382	19,827	24,081	67.0%
Эзэмшигчдийн өмч	2,500	2,500	2,500	2,500	7.0%
Хуримтлагдсан ашиг	1,459	3,421	5,900	6,964	19.4%
Хоёрдогч өглөг	-	1,400	2,400	2,400	6.7%
Эздийн өмчийн дүн	3,959	7,321	10,800	11,864	33.0%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	8,360	16,703	30,627	35,944	100%



"Омни Капитал ББСБ" ХХК-ийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд нийт 35.9 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байх ба үүнээс 97 гаруй хувийг эргэлтийн хөрөнгө эзэлж байна. Тус компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор эргэлтийн хөрөнгийн 70 хувийг зээлийн багц эзэлж байна.


Зээлийн багц шинжилгээ

График 1 Зээлийн бүтээгдэхүүн



- Автомашин барьцаалсан зээл
- Автомашинны зээл
- Бизнесийн зээл
- Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл
- Хэрэглээний лизинг

График 2. Зээлийн бүтэц



- Хэвийн зээл
- Хугацаа хэтэрсэн зээл
- Хэвийн бус зээл
- Эргэлзээтэй зээл
- Муу зээл

"Омни Капитал ББСБ" ХХК-ийн нийт зээлийн багц нь 5 бүтээгдэхүүнд хуваагдаж байгаа ба Автомашин барьцаалсан зээл 5 хувь, Автомашинны лизинг 58 хувь, Бизнесийн зээл 21 хувь, Үл хөдлөх хөрөнгө газар барьцаалсан хэрэглээний зээл 4 хувь, Хэрэглээний лизингийн зээл 12 хувийг тус тус эзэлж байна. Хэрэглээний лизингийн зээлийн хувьд үл хөдлөх хөрөнгө барьцаалах гэрээ хийдэг бол бусад зээлүүдийн хувьд үл хөдлөх хөрөнгө, автомашин барьцаалан зээл олгодог байна.

Нийт зээлийн багцын 26.5 тэрбум төгрөгөөс дийлэнх хувь буюу 90 хувь нь хэвийн зээл байх ба зээлүүд батлагдсан хуваарийн дагуу хугацаандаа төлөгдөж байна. Хугацаа хэтэрсэн зээл 609.7 сая төгрөг буюу 2.3 хувь, хэвийн бус зээл 514.4 сая төгрөг буюу 1.9 хувь, эргэлзээтэй зээл 751.9 сая төгрөг буюу 2.8 хувь, муу зээл 723.9 сая төгрөг буюу 2.7 хувийг тус тус эзэлж байна. Компани нь чанаргүй зээлд 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1,258.6 сая төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулснаар цэвэр зээлийн багц 25.2 тэрбум төгрөг байна.





2023
Эх үүсвэрийн бүтэц, сая төгрөгөөр



Орлогын тайлангийн шинжилгээ

Хүснэгт 2 "Омни Капитал ББСБ" ХХК-ийн орлогын тайлан

сая төгрөг	2020	2021	2022	2023Q2	Бүтэц
Хүүгийн орлого	2,255	2,635	9,622	5,330	100%
Хүүгийн зардал	367	1,083	2,848	948	17.8%
Цэвэр хүүгийн орлого	1,888	1,552	6,774	4,382	82.2%
Хүүгийн бус орлого	53	2,449	536	701	13.2%
Хүүгийн бус зардал	449	1,236	2,983	2,945	55.3%
Цэвэр хүүгийн бус орлого	396	1,213	2,447	-2,245	-42.1%
Эрсдэлийн сан байгуулахаас өмнөх ашиг	1,492	2,765	4,327	2,137	40.1%
Эрсдэлийн сангийн зардал	395	565	1,556	946	17.7%
Үндсэн үйл ажиллагааны ашиг	1,097	2,200	2,771	1,191	22.3%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	144	48	95	58	1.1%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	10	41	99	44	0.8%
Татвар төлөхийн өмнөх ашиг	1,231	2,207	2,767	1,206	22.6%
Орлогын албан татварын зардал	115	245	288	143	2.7%
Цэвэр ашиг	1,116	1,962	2,479	1,063	19.9%

Компани нь 2023 оны эхний хагас жилд нийт 5.3 тэрбум төгрөгийн хүүгийн орлоготой ажилласан ба үүнээс 5.9 тэрбум төгрөг нь хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого, 32.0 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого, 14.9 сая төгрөг нь үнэт цаасны хүүгийн орлого, 16.5 сая төгрөг нь хугацаандаа байгаа факторингийн үйлчилгээний хүүгийн орлого, 2.0 сая





төгрөг нь хугацаа хэтэрсэн факторингийн үйлчилгээний хүүгийн орлого, 11.9 сая төгрөг нь банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого тус тус эзэлж байна. Үүнээс нийт 598.9 сая төгрөгийн хүүгийн буцаалт хийгдсэнээр хүүгийн орлого нийт 5.3 тэрбум төгрөг болсон байна.

График 3 Хүүгийн орлого




График 4 Хүүгийн зардал



Хүүгийн орлого, зардал ба цэвэр хүүгийн орлого, сая төгрөгөөр



“Омни Капитал ББСБ” ХХК-ийн орлого 2020-2022 онд жилд дунджаар 106 хувь өссөн байна. Харин тус хугацаанд цэвэр хүүгийн орлого жилд дунджаар 89 хувь өссөн байна. Энэ нь тайлант хугацаанд банк болон бусад санхүүгийн байгууллагуудаас эх үүсвэрийн өрийн санхүүжилт ашигладаг болсонтой холбоотойгоор хүүгийн зардал өссөн байна.





Эрсдэлийн сангийн зардлын өмнөх орлого, сая төгрөгөөр



ББСБ-уудын хувьд хүү төлөх чадвар, төлбөрийн чадварыг илэрхийлэх гол үзүүлэлтийн нэг нь эрсдэлийн сангийн өмнөх ашиг юм. 2023 оны анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн сангийн өмнөх ашиг 1.2 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 3 ББСБ салбар ба Омни капитал ББСБ-ын харьцуулалт

	ББСБ салбар	Омни капитал ББСБ
Зээлийн өсөлт	31%	47%
Нийт хөрөнгийн өсөлт	27%	55%
Цэвэр ашгийн өсөлт	26%	32%

Үүсгэн байгуулагч Омни капитал ББСБ-ын сүүлийн 4 жилийн дундаж зээлийн өсөлт 47 хувь байсан бол салбарын дундаж 31 хувьтай байжээ. 2016 оноос хойш үйл ажиллагаа явуулж буй компани хэдий ч салбарын дунджаас давсан тогтвортой өсөлтийг үзүүлж, хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.





Зохистой харьцаа үзүүлэлтийн шинжилгээ

ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмын дагуу ББСБ-ын үйл ажиллагааны эрсдэлийг урьдчилан тооцох, үнэлэх, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоож, түүний биелэлтийг хянадаг.

Хүснэгт 4 ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

	2020	2021	2022	2023Q2	Шалгуур
Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт					
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	46.9%	35.5%	29.0%	26.3%	10%<
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	46.9%	43.6%	36.8%	33%	20%<
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	48.5%	36.2%	28.9%	26.3%	10%<
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа					
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	9.9%	9.9%	12.7%	9.8%	8%<
Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт					
I зээлдэгч, холбогдох этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	7.3%	3.8%	4.4%	4.2%	30%>
ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	0%	0%	0%	0%	70%>
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	56.7%	80.0%	79.7%	79.7%	80%>





Өрийн бичгийн
зохистой харьцаа

46.8%

30.2%

15.6%

37.9%

50%>

Үндсэн хөрөнгийн
зохистой харьцаа

1.5%

1.6%

1.4%

1.5%

15%>



МОНГОЛ УЛАС
МОНГОЛ УЛАС


2023

БҮРТГЭЭ-02

БҮРТГЭЭ

УХ
2023.11.01
БҮРТГЭВ
№ 01

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ





2.1 ТЗК-ийн тухай

“Омни ассет” ХХК нь анх 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилготойгоор үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлийн байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 4-ний бүртгэгдсэн хуулийн этгээд юм.


Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т зааснаар ТЗК-г банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон СЗХ-ноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулхаар заасан. Энэ хүрээнд “Омни ассет” ХХК-ийг “Омни капитал ББСБ” ХХК үүсгэн байгуулсан бөгөөд компанийн 100 хувийн хувьцааг дангаараа эзэмшдэг болно.

“Омни ассет ТЗК” ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт зааснаар Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 256 тоот тогтоолоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авсан.

Ингэснээр Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т заасан Баталгаат үнэт цаасыг тусгай зориулалтын компани гаргах хуулийн шаардлагыг хангасан байна.

Үнэт цаас гаргагч:	“Омни ассет ТЗК” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011851823
Регистрийн дугаар:	8356327
Үйл ажиллагааны үндсэн чиглэл:	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах
МХБ-д бүртгэлтэй эсэх:	Үгүй
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:	10,000,000 төгрөг
Хувьцаа эзэмшигч:	"Омни капитал ББСБ" ХХК
Эзэмшиж буй хувьцааны тоо:	10,000 ширхэг энгийн хувьцаа
Эзэмшиж буй хувьцааны хувь:	100 хувь
Хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 11-р хороолол, Н тауэр оффис, 402 тоот
Утас:	976 7277-8282
Имэйл:	info@omniasset.mn





2.2 Үнэт цаас гаргагчийн удирдлага зохион байгуулалт, түүний эрх хэмжээ

Хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид "ХЭХ" гэх)

ТЗК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ болон бусад асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна. Компанийн дүрмээр ХЭХ-ын бүрэн эрхийг ХЭХ-аас томилсон ТУЗ хэрэгжүүлхээр заасан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)

ТЗК-ийн ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг удирдаж, хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй байна. ТУЗ нь өөрийн үйл ажиллагаандаа ТУЗ-өөс баталсан ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баримтлан ажиллана.

ТЗК-ийн ТУЗ нь 3 гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ.

Хөрөнгөөр баталгаажин үнэт цаасны тухай 12 дугаар зүйлийн 12.12.5 дахь хэсэгт заасны дагуу ТЗК нь хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахыг хориглох бөгөөд Гүйцэтгэх захирал томилохгүйгээр үйл ажиллагааг ТУЗ хэрэгжүүлэх буюу дараах үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

- Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах;
- ТЗК-ийн хөрөнгийг хадгалж, хамгаалах;
- Эрх бүхий байгууллагаас Хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр Компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх;
- Компанийн хөрөнгийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшил, удирдлагад шилжүүлэх. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулснаас хойш хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх үүргийн дагуу хяналт тавих;
- Дүрэмд заасан Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах;
- Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллаас бусад төлбөр, зардлын төсвийг батлах;
- Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, шаардлагатай бол тэдгээрийг солих санал гаргах;
- Компани нь өөрийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр хүлээсэн үүргээ чанд мөрдөж, гүйцэтгэж байгаад хяналт тавьж, хангуулах;





- Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хэрэгжүүлэх;
- ТЗК-ийн хөрөнгийн бүртгэлийг хянаж, хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалж ажиллах;
- ТЗК-ийн нээлттэй болон хаалттай хүрээнд санал болгон гаргасан үнэт цаасны танилцуулгын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;
- ТУЗ-ийн хараат бус гишүүн нь ТЗК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, хөрөнгө оруулагчид хүргэх тогтоосон болон тухай бүр мэдээлэх мэдээллийн үнэн зөв, баталгаат байдалд хяналт тавьж ажиллах;
- Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, аудитор болон хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг томилох, солих;
- Хөрөнгийг бүртгэлээс хасах, нэмэх;
- ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн журам болон Компанийн дүрэм, Компанийн дотооддоо дагаж мөрдөж буй журам, зааварт заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
- ТЗК-ийн ТУЗ нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн даргын санаачилгаар, эсхүл ТУЗ-ийн гишүүдийн олонхын санал, эсхүл Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санал, шаардлагаар ээлжит бус хурлыг хуралдуулж болно.
- ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор хурлын ирцийг бүрдүүлэх ба ТУЗ-ийн шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн санал нэгтэй шийдвэрээр батлагдана.
- ТУЗ-ийн гишүүн нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд тооцогдох бөгөөд тус хуулийн 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.
- Компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийг төлөөлж аливаа баримт бичигт ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна.
- ТУЗ болон түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь Компани Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан үеэс эхлэн Компани татан буугдах буюу ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан үндэслэлээр бүрэн эрхийг дуусгавар болгох хүртэл хугацаанд үргэлжилнэ.





БҮЭГ ТҮЗ-ийн гишүүдийн мэдээлэл

“Омни’ассет ТЗК” ХХК нь 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн ХЭХ-23/003 тоот Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр ТҮЗ-ийн 3 гишүүнийг томилсон байна.

Үүний дагуу ТҮЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар ТҮЗ-ийн даргаар А.Батболдыг сонгож, ХЭХ-23/001 тоот тогтоолоор баталгаажуулжээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	Мэргэжил Хуульч, Хууль зүйн ухааны магистр
А.Батболд	<u>Ажлын туршлага</u> 2012-2014 он, “И Ай Ти” ХХК, Гүйцэтгэх захирал 2014- 2015 он, Монет капитал ХХК, Гүйцэтгэх захирал 2015-2020 он, “Ард даатгал” ХК, Гүйцэтгэх захирал, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал 2021 оноос одоог хүртэл “Грандлекс Партнерс” ХХК, Хуульч
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Мэргэжил Банкны эдийн засаг, Бизнесийн удирдлагын магистр
С.Нина	<u>Ажлын туршлага</u> 2006-2017 он, Хас банк, Зээлийн мэргэжилтэн, Зээлийн менежер, Зээлийн эрсдлийн шинжээч 2017-2018 он, “Омни капитал ББСБ” ХХК, Эдийн засагч 2018-2022 он, “Омни капитал ББСБ” ХХК, Гүйцэтгэх захирал 2022 оноос, “Омни капитал ББСБ” ХХК, Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Зээлийн үйл ажиллагааны газрын захирал
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Мэргэжил Түүхч, Санхүү менежментийн магистр
Х.Хэрлэн	<u>Ажлын туршлага</u> 2019 оноос одоог хүртэл, “Голомт банк” ХК-д ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн ТҮЗ-ийн гишүүд нь СЗХ-ны Тохиромжтой этгээдийг тодорхойлох журмын шаардлага хангасан талаар Хөндлөнгийн хуулийн Фирмийн дүгнэлтийн “Хавсралт 2”-оор шалгаж, дүгнэлт гаргасан байна.





ОМНИ АССЕТ ТЗК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРМУУД

Компанийн дүрэм

ТЗК-ийн хувьцаа эзэмшигч "Омни капитал ББСБ" ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 256 тоот тогтоолоор олгосон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг үндэслэн Компанийн дүрмийг шинэчлэн баталсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам

Энэхүү журмыг ТЗК-ийн ТУЗ нь 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 23/007 тоот тогтоолоор баталсан. Журмаар ТУЗ-ийн гишүүдийн тоо болон үнэт цаас гаргах болон үйл ажиллагаатай холбоотой эдлэх эрх, хүлээх үүргийг тус тус оруулсан байна. Мөн ТУЗ-ийн дарга болон гишүүдийн эрх хэмжээг тус тус нарийвчлан тодорхойлсон.

Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох солих журам

Энэхүү журмыг ТЗК-ийн ТУЗ-ийн 2023 оны 5-р сарын 23-ны өдрийн 23/002 тоот тогтоолын "Хавсралт 2"-оор баталсан. Журмаар ТЗК-ийн хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шаардлагыг тус бүрээр нь тодорхойлсон байна. Үүнээс гадна оролцогчидтой байгуулах гэрээнд заавал тусгах агуулгыг журамд нарийвчлан оруулсан байна.

Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам

Энэхүү журмыг ТЗК-ийн ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 23/011 тоот өдрийн тогтоолын "Хавсралт 3"-аар баталсан.

Хөрөнгө итгэмжлэн удирдах журам

Энэхүү журмыг ТЗК-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 23/011 тоот тогтоолын "Хавсралт 2"-ээр баталсан.

Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам

Энэхүү журмыг ТЗК-ийн ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 23/011 тоот тогтоолын "Хавсралт 4"-өөр баталсан.

Эрдсдэл сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам

Энэхүү журмыг ТЗК-ийн ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 23/011 тоот тогтоолын "Хавсралт 1"-ээр баталсан

Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам

Энэхүү журмыг ТЗК-ийн ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 23/002 тоот тогтоолоор баталсан бөгөөд тус журмаар МУТСТ тухай хуулийн хэрэгжилтийг ТЗК






болон түүнд үйлчилгээ үзүүлж буй оролцогчид хангаж ажиллах талаар зохицуулсан.

Монголын Хөрөнгийн Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журамд заасны дагуу "ХаанЛекс партнерс" ХХН нь үнэт цаас гаргагчийн баталсан дээрх журмууд нь хууль тогтоомжид нийцсэн талаар 2023 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн Хууль зүйн дүгнэлтийн 3.3 дахь хэсэгт дүгнэсэн байна.





2.4 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн тайлангийн мэдээлэл

Хүснэгт 5 "Омни ассет ТЗК" ХХК Эхлэлтийн баланс

Эхлэлтийн баланс (төгрөг)

Үзүүлэлтийн нэр	Дүн
Мөнгөн хөрөнгө	10,000,000
Нийт хөрөнгө	10,000,000
Компани хувь нийлүүлсэн хөрөнгө	10,000,000
Өр төлбөр ба эздийн өмч	10,000,000

Үүсгэн байгуулагч "Омни капитал ББСБ" ХХК нь үнэт цаас гаргагчид 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийснээр үнэт цаас гаргагчийн эхлэлтийн хөрөнгө 10 сая төгрөгтэй тэнцэж байна.

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын төсөөллийг одоогийн буй багцаас орж ирэх мөнгөн урсгалд үндэслэн дээрх байдлаар төсөөлж байна.

Хүснэгт 6 "Омни ассет ТЗК" ХХК Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл

Баланс тайлан (сая.төгрөг)	Q0	Q1	Q2	Q3	Q4	Q5	Q6	Q7	Q8
Бэлэн мөнгө	10	1,175	2,334	3,551	1,639	2,225	2,765	3,300	992
Дансны авлага	6,837	5,529	4,551	3,444	2,403	1,872	1,357	809	227
Бусад авлага	-	-	-	-	-	6	10	10	-
Нийт хөрөнгө	6,847	6,703	6,885	6,995	4,042	4,103	4,132	4,119	1,219
Богино хугацаат өр төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат зээл	6,000	6,000	6,000	6,000	3,000	3,000	3,000	3,000	-
Бусад өглөг	837	837	855	844	839	834	831	831	990
Нийт өр төлбөр	6,837	6,837	6,855	6,844	3,839	3,834	3,831	3,831	990
Хувь нийлүүлсэн хөрөнгө	10	10	10	10	10	10	10	10	10
Хуримтлагдсан ашиг	-	(143)	20	141	193	253	281	268	219
Эздийн өмчийн дүн	10	(133)	30	151	203	263	291	278	229
Өр төлбөр ба эздийн өмч	6,847	6,703	6,885	6,995	4,042	4,097	4,122	4,109	1,219

Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл

Хүснэгт 7 "Омни ассет ТЗК" ХХК Орлогын тайлангийн төсөөлөл

Орлогын тайлан (сая.төг)	Q0	Q1	Q2	Q3	Q4	Q5	Q6	Q7	Q8
Хүүгийн орлого	595	526	418	299	202	149	97	41	
ХБУЦ-ийн хүүгийн төлбөр	294	294	294	294	294	147	147	147	147





Удирдлагын зардал	3	3	3	3	3	3	3	3
Үйлчилгээ	77	77	71	56	35	29	24	20
үзүүлэгчийн төлбөр								
Хэлцлийн зөвлөх үйлчилгээний төлбөр	30	-	-	-	-	-	-	-
Аудитын үйлчилгээний төлбөр	-	-	6	-	-	-	6	6
Үнэт цаас гаргалтын зардал	222	-	-	-	-	-	-	-
Маркетингийн зардал	80	-	-	-	-	-	-	-
Захиргааны үйлчилгээний төлбөр	5	5	5	5	5	5	5	5
Бусад зардал	30	-	-	-	-	-	-	-
Хөрөнгө итгэмжлэн удирдах төлбөр	15	15	15	15	15	15	15	15
Үйл ажиллагааны ашиг	(160)	132	25	(74)	(2)	(49)	(103)	(155)
Хадгаламжийн хүүгийн орлого	17	49	85	121	57	74	90	106
Татварын өмнөх ашиг	(143)	182	110	47	55	25	(13)	(49)
Татварын зардал	-	(18)	(11)	(5)	(5)	(2)	-	-
Цэвэр ашиг	(143)	164	121	52	60	27	(13)	(49)
Хуримтлагдсан ашиг	(143)	20	141	193	253	281	268	219

Зардлын тухай

“Омни ассет ТЗК” ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж, үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг дуусах буюу 24 сарын хугацаанд дараах зардал төлбөр гаргахаар байна. Доорх зардал нь ТЗК нь үйл ажиллагаа явуулж байх хугацаанд гарах зардлууд юм.

Хүснэгт 8 “Омни ассет ТЗК” ХХК Үйл ажиллагааны зардлын төсөөлөл

№	Тогтмол зардал	Дүн	Давтамж
1	Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ажлын хөлс	Удирдаж буй нийт хөрөнгийн 2 хувь	Сар тутам
2	Үйлчилгээ үзүүлэгчийн ажлын хөлс	Багцад орох мөнгөн урсгалын 2.5 хувь	Сар тутам
3	Хөндлөнгийн аудитын ажлын хөлс	6,000,000 төгрөг	Жил тутам
4	ТУЗ-ийн гишүүдийн цалин	3,000,000 төгрөг	Улирал тутам
5	Захиргааны үйлчилгээ	1,500,000 төгрөг	Сар тутам

№	Үнэт цаас гаргахтай холбоотой зардал	Дүн	Давтамж
1	Андеррайтерийн хөлс	Нийт санхүүжилтийн 3 хувь	Нэг удаа
2	Хөндлөнгийн хууль зүйн дүгнэлтийн хөлс	20,000,000 төгрөг	Нэг удаа
3	Зээлийн шинжилгээний хөлс	20,000,000 төгрөг	Нэг удаа
4	Хэлцлийн зөвлөх үйлчилгээний хөлс	30,000,000 төгрөг	Нэг удаа
5	Зохицуулагч байгууллагуудын хөлс	МХБ, СЗХ болон МҮЦТХТ-ийн зардал	Нэг удаа



2023-11-15

БҮРТГЭВ-02

Хүснэгт 9 "Омни ассет ТЗК" ХХК Мөнгөн урсгалын тайлангийн төсөөлөл

ХБҮЦ Мөнгөн урсгал (сая.төг)	Q0	Q1	Q2	Q3	Q4	Q5	Q6	Q7	Q8
Хүүгийн орлого	0	595	526	418	299	202	149	97	41
Зээлийн үндсэн болон илүү төлбөрийн орлого	2,480	2,561	2,409	1,952	1,181	991	876	752	
Зээлийн багцыг борлуулснаас орж ирэх орлого	-	-	-	-	-	-	-	-	159
ХБҮЦ-ийн хүүгийн төлбөр	294	294	294	294	147	147	147	147	147
ХБҮЦ-ийн үндсэн төлбөр	-	-	-	-	3,000	-	-	-	3,000
Багц нэмэгдүүлэх төлбөр	1,172	1,584	1,302	911	650	476	328	171	
Удирдлагын зардал төлсөн	3	3	3	3	3	3	3	3	3
Үйлчилгээний төлбөр төлсөн	77	77	71	56	35	29	24	20	
Хэлцлийн зөвлөх үйлчилгээний төлбөр	30	-	-	-	-	-	-	-	-
Аудитын үйлчилгээний төлбөр	-	-	6	-	-	-	-	6	6
Үнэт цаас гаргалтын зардал	222	-	-	-	-	-	-	-	-
Маркетингийн зардал	80	-	-	-	-	-	-	-	-
Захиргааны үйлчилгээний төлбөр	5	5	5	5	5	5	5	5	5
Бусад зардал	30	-	-	-	-	-	-	-	-
Хөрөнгө итгэмжлэн удирдах ү.а төлсөн	15	15	15	15	15	15	15	15	15
Үйл ажиллагааны мөнгөн урсгал	1,148	1,110	1,132	(2,033)	528	467	445	(2,414)	
Хадгаламжийн хүүгийн орлого	17	49	85	121	57	74	90	106	
Өөрийн хөрөнгө оруулалт	10	-	-	-	-	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн урсгал	10	17	49	85	121	57	74	90	106
Богино хугацаат өр төлбөр авсан /Эрсдэлийн сан/	-	-	-	-	-	-	-	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал	-	-	-	-	-	-	-	-	-

6.67.1





Мөнгөн урсгалын эхний үлдэгдэл	-	10	1,175	2,334	3,551	1,639	2,225	2,765	3,300
Мөнгөн урсгалын эцсийн үлдэгдэл	10	1,175	2,334	3,551	1,639	2,225	2,765	3,300	992

Дансны тухай мэдээлэл

Төлбөр цуглуулах данс

ТЗК нь Үйлчилгээ үзүүлэгчийн Зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгийг хүлээн авах, үнэт цаасны төлбөр төлөх зорилгоор Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэж, төлбөр хүлээн авах бэлэн байдлыг хангана. Тус дансны захиран зарцуулах эрхтэй этгээд нь Хөрөнгө итгэмжлэн удирдагч компани байна.

Зээлийн эргэн төлөлтийн данс

Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэнэ. Тус дансны захиран зарцуулах эрхтэй этгээд нь Үйлчилгээ үзүүлэгч байна.

Хадгаламжийн данс

ТЗК-ийн мөнгөн хөрөнгийг ашиглагдахгүй хугацаанд үр ашигтай байлгах үүднээс тодорхой хэмжээг хадгаламжийн дансанд байршуулна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд хадгаламжийг цуцлан, мөнгөн үлдэгдлийг төлбөр гүйцэтгэх данс руу татан шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй. Тус хадгаламжийн данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр гүйцэтгэх данс руу зарлага гаргах боломжтой.

Үнэт цаасны данс

ТЗК нь өөрийн гаргасан үнэт цаасаа хадгалуулах, хөрөнгө оруулагчдад эзэмшүүлэх, үнэт цаасны төлбөр тооцоог гүйцэтгүүлэх зорилгоор Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд данстай байна. Энэхүү дансаараа дамжуулан үнэт цаасны төлбөрийг хүлээн авах ба хүү болон үндсэн төлбөрийг хөрөнгө оруулагчдад хуваарилна.

Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний тухай

2023 оны 8 дугаар сарын 23-ны өдөр "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-г нэг талаас Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Омни Капитал ББСБ" ХХК, нөгөө талаас Үнэт цаас гаргагч "Омни ассет ТЗК" ХХК нар байгуулсан. Тус гэрээгээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид энэхүү гэрээнд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан зээлийн авлагын эрх, түүнд дагалдах эрхүүдийг худалдах, Үнэт цаас гаргагч нь хэлэлцэн тохиролцсон үнийг төлөх болон бусад холбогдох харилцааг зохицуулах зорилготой.

Үнэт цаас гаргагч нь хэлцэл биелэх өдөр зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрхүүдийг багц болгон худалдан авч, гэрээнд заасан үнийг төлөх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцыг энэхүү гэрээнд заасан солих,



2023-11-15

БҮРТГЭВ

хөрөнгийн багцыг гэрээнд заасан үндэслэлээр нэмэх нөхцөлтэйгөөр худалдахаар тохиролцсон байна. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ үнэнч шударгаар биелүүлж, харилцан бие биеийн ашиг сонирхлыг хүндэтгэх, гэрээгээр тохиролцсон анхны тохиролцоог тууштай хадгалах бөгөөд хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны үргэлжлэх хугацаанд талууд Хөрөнгө оруулагч буюу үнэт цаас эзэмшигчийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж идэвхтэй, шуурхай, бүтээлчээр хамтран ажиллах гэрээ байгуулсан.


Хөрөнгө худалдах үндсэн нөхцөл

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13.2-т зааснаар ТЗК нь Хөрөнгийг шилжүүлэн авснаар тухайн Хөрөнгөтэй холбоотой аливаа эрх, барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга, санхүүгийн хэрэгсэл хөрөнгөтэй хамт шилжүүлэн авсанд тооцно.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчид хөрөнгийг худалдан шилжүүлэх жагсаалт үйлдэн шилжүүлэх бөгөөд хөрөнгийг солих болон нэмж худалдаж болох нөхцөлтэйгөөр худалдаж байгаа болно.
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11, 14.3-т заасны дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо Хөрөнгийн багцыг бүртгэсэн өдөр уг багцад орсон хөрөнгийг ТЗК-ийн өмчлөлд шилжсэнд тооцно.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгө шилжсэнтэй холбоотойгоор тухайн зээлдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах, зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийхгүй байх үүрэгтэй ба Үйлчилгээ үзүүлэх гэрээгээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд зээлдэгчийн зээлтэй холбоотой зээл олгогчийн хувьд хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээ, үйлчилгээг зээлдэгчид үзүүлэх үүрэгтэй.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлийн данс бүртгэлийг хадгалж хөтлөх, үнэт цаас гаргагчтай тулган баталгаажуулах болон хөрөнгө солих, зээлийн баримт бичгийг үнэт цаас гаргагчид хүргүүлэх, хүлээн авах зэргээр Хөрөнгөтэй холбоотой ажиллагааг хариуцан гүйцэтгэх, Үнэт цаас гаргагчтай харилцах эрх бүхий ажилтныг томилж, уг ажилтны мэдээллийг Үнэт цаас гаргагчид өгөх үүрэг хүлээнэ.

Зээлийн данс бүртгэл хөтлөх, баримт бичгийг хадгалах

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багц дахь зээлийн данс бүртгэлийг өөрийн бусад зээлээс тусад нь данс бүртгэл үүсгэн хадгалах бөгөөд санхүүгийн тайлан тэнцлийг тусад нь хөтөлж холбогдох баримт бичгийг өөрийн оффис дээр хадгална.
- Үнэт цаас гаргагч болон түүнд хөрөнгө итгэмжлэн удирдах болон аудитын үйлчилгээ үзүүлэгч, мөн бусад эрх олгогдсон этгээд хэдийд ч Зээлийн болон хөрөнгийн багцын баримт бичгүүдэд бүхэлд нь болон хэсэгчлэн шалгалт хийх эрхтэй.
- Үнэт цаас гаргагч нь дээрх шалгалтыг хийх зорилгоор Зээлийн баримт бичгүүдийг авах тухай ББСБ-д мэдэгдсэнээс хойш ажлын 3 хоногт багтаан ТЗК-д материалыг хүргүүлэх эсхүл ажлын байран дээрээ ажлын цагаар томилогдсон ажилтныг ажиллах боломжоор хангах үүргийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хүлээнэ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тайланг хүлээн авч хянан баталгаажуулна.





БҮРТГЭВ Барьцааны зүйл, барьцааны эрхийг хэрэгжүүлэх

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13.2 дахь заалтын дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү гэрээний дагуу худалдах, солих, нэмэх зэргээр ТЗК-д шилжүүлэх Хөрөнгийн багцын авлагын эрхийг баталгаажуулах зорилгоор багц дахь зээлийн гэрээнүүдээс үүсэх бүхий л эрх (үүнд, шаардах эрх, барьцаа, фидуци, баталгаа, үүргийн гүйцэтгэлийг хангах аливаа бусад арга, санхүүгийн хэрэгсэл зэрэг орно)-ийг ТЗК-д шилжүүлж барьцаалуулна.

2.5 ТЗК татан буугдах нөхцөл

“Омни Ассет ТЗК” ХХК нь ХБҮЦ-ны тухай хууль болон компанийн дүрмийн 9.1 дугаар зүйлд зааснаар ТЗК нь дараах үндэслэлээр татан буугдана. Үүнд:

1. Компани үүсгэн байгуулагдсан зорилгоо бүрэн биелүүлж, Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг бүрэн төлж дууссан;
2. Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн түүний анхны үнийн 20 хувьд хүрсэн тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон багцыг буцаан худалдсан;
3. Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан.

ТЗК-ийг татан буулгах шийдвэрийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт зааснаар (а) Тусгай зориулалтын компани, (б) Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлэгч, (в) баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан үндэслэлээр СЗХ-ны хүсэлтийг үндэслэн шүүх тус тус гаргана.

ТЗК нь татан буугдах үед хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсний дараа үлдсэн зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу ТЗК-ийн үүсгэн байгуулагч-Хувьцаа эзэмшигчид шилжинэ.

ХБҮЦ-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасны дагуу татан буугдсан ТЗК-ийн хөрөнгийг хуваарилахдаа дараах дарааллыг мөрдөнө.

1. Татан буулгах ажиллагааны зардал;
2. Үнэт цаасны танилцуулгад заасан дарааллын дагуу хөрөнгө оруулагчид олгох үнэт цаасны төлбөр;
3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан гэрээний дагуу ТЗК-иас авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад бүх этгээдийн шаардлага;
4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан гэрээний дагуу авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага;





2.6. Үнэт цаас гаргагч компанийн зэргэлдээ компанийн тухай

Үнэт цаас гаргагчийн толгой компани болох “Омни капитал ББСБ” ХХК дараах компаниудын хувьцааг эзэмшиж байгаа буюу Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.15 дахь хэсэгт заасны дагуу ТЗК-ийн зэргэлдээ компани болох юм.

№	Компанийн нэр	Хувьцааны хувь эзэмшил
1	“Омни актив ТЗК” ХХК	100%
2	“Омни смарт” ХХК	50%

“Омни капитал ББСБ” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Омни актив ТЗК” ХХК нь СЗХ-ны 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 534 тоот тогтоолоор олгосон тусгай зөвшөөрлийн дагуу Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах үйл ажиллагааг эрхэлж байна. Тус компани нь үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар нийт 825,625,000 төгрөгийн хүүгийн төлөлт, 2,500,000,000 төгрөгийн үндсэн төлбөрийг хуваарийн дагуу хөрөнгө оруулагч нарт төлсөн бөгөөд үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. Түүнчлэн “Омни актив ТЗК” ХХК -ийн гаргасан ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааны идэвхи 67.99 хувьтай буюу 3,399,374,990 төгрөгийн дүнгээр арилжаалагдсан байгаа нь хөрвөх чадварын үзүүлэлт харьцангуй сайн байгаагийн илрэл юм.


“Омни смарт” ХХК 2021 онд үүсгэн байгуулагдсан компани юм. 2022 оноос эхэлж цахилгаан бараа худалдан борлуулж эхэлсэн ба өдгөө 4 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.



БҮРТГЭЭГЭЭ

СЗХ
2023.07.06
БҮРТГЭЭ

ҮНЭТ ЦААСНЫ
ТУХАЙ





2023-11-13

3.1 Үнэт цаасны нөхцөл
БҮРТГЭВ-02

Хүснэгт 10 Үнэт цаасны нөхцөл

Үнэт цаас гаргагч	"Омни ассет ТЗК" ХХК;
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	"Омни капитал ББСБ" ХХК;
Үнэт цаасны төрөл	Зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас;
Үнэт цаасны тоо ширхэг	60,000 ширхэг ;
Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ	100,000 төгрөг;
Үнэт цаасны нийт дүн	6,000,000,000 төгрөг;
Үнэт цаасны хугацаа	24 сар
Үнэт цаасны хүү	19.6 хувь (жилийн)
Хүү төлөгдөх хугацаа	Улирал тутам
Үндсэн төлбөр төлөгдөх хугацаа	12 сард 1 удаа
Үнэт цаасны төлбөр төлөгдөх эх үүсвэр	Хөрөнгийн багцын зээлийн үндсэн болон хүүгийн орлого
Үнэт цаасны хүүд ногдох татвар	Хувь хүн болон ААН-д хүүгийн орлогод ногдох дүнгээс 5 хувь
Үнэт цаасны хадгалалт	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн данс
Арилжаалах зах зээл	Монголын хөрөнгийн бирж ХК
Багцын зээлийн нийт дүн	6,836,676,535 төгрөг
Автомашин барьцаалсан зээл	340,030,588 төгрөг
Автомашинны лизинг	4,701,301,615 төгрөг
Бизнесийн зээл	1,489,185,358 төгрөг
ҮХХ, Газар барьцаалсан-Хэрэглээний зээл	306,158,974 төгрөг
Зээлдэгчдийн тоо	426
Зээлийн чанар	100 хувь хэвийн
Андеррайтер	"Апекс капитал ҮЦК" ХХК



2023-11-13

БҮРТГЭЭ-02



3.2 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг үнэт цаас эзэмшигчдээс буцаан худалдан авах нөхцөл

Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг хуульд заасан дараах үндэслэлээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах тохиолдолд ХБҮЦ-ыг Үнэт цаас гаргагч нь үнэт цаас эзэмшигчээс буцаан худалдан авна. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3-д заасны дагуу хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувьд хувьд зээлийн эргэн төлөлтийн хугацаа 90-ээс дээш хоног хэтэрсэн, эсхүл 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11.5-д заасны дагуу баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн түүний анхны үнийн 20 хувьд хүрсэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцсон;
- Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний 3.5 дахь хэсэгт заасан багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах нөхцөл үүссэн тохиолдолд үнэт цаас гаргагч нь ХБҮЦ-ыг буцаан худалдан авна.

3.3 Үнэт цаасны хүү тогтоосон үндэслэл

Үнэт цаасны хүүгийн түвшинг тогтоохдоо эрсдэл багатай банкны хадгаламжийн хүү, хугацааны хувьд ижилт төстэй нээлттэй бондууд болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг тогтмол өгөөжтэй санхүүгийн хэрэгслүүдтэй харьцуулав. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн тус бүрийн эрсдэл болон өгөөжийн хамаарлыг харгалзан үзэж ЗГҮЦ, хадгаламжийн хүүгээс өндөр, хаалттай бондын хүүгээс бага байхаар тогтоов. Мөн үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгал, давтамжийг харгалзан үзэв.

Төв банкны зүгээс инфляцыг бууруулах зорилгоор 2022 онд Төв Банк бодлогын хүүг нэмэгдүүлж дараах байдлаар өөрчилсөн.

- 2022 оны 01 сарын 31-нд 0.5 нэгжээр нэмэгдэж 6.5 хувьд
- 2022 оны 03 сарын 24-нд 2.5 нэгжээр нэмэгдэж 9.0 хувьд
- 2022 оны 06 сарын 22-нд 1.0 нэгжээр нэмэгдэж 10 хувьд
- 2022 оны 09 сарын 20-нд 2.0 нэгжээр нэмэгдэж 12 хувьд
- 2022 оны 12 сарын 16-нд 1.0 нэгжээр нэмэгдэж 13 хувьд хүрсэн.

Үүний нөлөөгөөр арилжааны банкуудын хадгаламжийн хүү дараах байдлаар өссөн байна.



У.С.А
 2023 о. 11. 01 өдөр
 БҮРТГЭВ
 № 01

2023
 БҮХСНЭГТ II Хадгаламжийн хүү

Он/сар		10-12 хугацаатай хадгаламж	19-24 сарын хугацаатай хадгаламж
2022	01	8.7	10.6
	02	8.6	10.4
	03	8.3	10.3
	04	8.6	10.1
	05	8.8	10.2
	06	9.0	9.8
	07	9.2	9.6
	08	9.5	9.8
	09	9.7	9.6
	10	11.3	11.8
	11	11.9	12.2
	12	12.4	12.7
2023	01	12.4	12.9
	02	12.4	13.1
	03	12.5	13.3
	04	12.6	13.0
	05	12.7	13.1

Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалагдсан тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүн букуу ХБҮЦ-ны арилжаа 2021 онд нийт арилжааны 0.3 хувийг л бүрдүүлж байсан бол 2022 онд уг үзүүлэлт 17.45 хувь болж өсжээ. Энэ нь хөрөнгө оруулагчдад банкны хадгаламжаас өндөр өгөөжтэй, хууль эрх зүйн хувьд эрх ашгийг нь хамгаалсан, тогтмол хүүтэй бүтээгдэхүүн хэрэгцээтэй буйг илтгэж байна. Хаалттай бондын хувьд зөвхөн тодорхой тооны шалгуур үзүүлэлтийг хангасан мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгох, хаалттай хүрээнд арилжааг зохион байгуулах, татварын хувь хэмжээ зэргээс шалтгаалан олон нийтэд хүртээмжтэй бус байна.

График 2 Арилжааны банкны хадгаламжийн хүүгийн түвшин



График 3 Нээлттэй бондуудын хүүгийн түвшин






График 4 ХБҮЦ-уудын хүүгийн түвшин



3.4 Хөрөнгө оруулалтын өгөөж

БҮРГГЭВ-02

Омни ассет ХБҮЦ-ны хүү DVP (үнэт цаасны төлбөр тооцоо) хийгдсэн өдрөөс хүү тооцогдож эхэлнэ. Үнэт цаасны хүү улирал тутам, үндсэн төлбөр 12 сард 1 удаа буюу 12 болон 24 дөх саруудад тэнцүү хуваан төлөгдөх юм.

Хөрөнгө оруулагч нь Омни ассет ХБҮЦ-д 10,000,000 төгрөгөөр хөрөнгө оруулалт хийсэн гэж үзвэл хөрөнгө оруулагчдад очих өгөөж дараах байдлаар тодорхойлогдоно.

Хүснэгт 11 Хөрөнгө оруулалтын өгөөжийн жишээ тооцоолол


	Улирал	Анхы хөрөнгө оруулалт	Хүүний орлого татварын өмнөх	Хүүний орлого татварын дараах	Үндсэн төлбөр	Хугацааны эцэст хүү болон үндсэн төлбөр
	0	10,000,000				
1 жил	1		490,000	465,500		465,500
	2		490,000	465,500		465,500
	3		490,000	465,500		465,500
	4		490,000	465,500	5,000,000	5,465,500
	5		245,000	232,750		232,750
2 жил	6		245,000	232,750		232,750
	7		245,000	232,750		232,750
	8		245,000	232,750	5,000,000	5,232,750
	Нийт		2,940,000	2,793,000	10,000,000	12,793,000

Үнэт цаас эзэмшигчийн хувьд жилийн 19.6 хувийн хүүтэй 24 сарын хугацаатай ХБҮЦ-ыг 24 сарын хугацаанд бүрэн эзэмшсэнээр татварын өмнөх өгөөж 29.93% байх бол татварын дараах бодит өгөөж 27.93% -тай байхаар байна.

Хүснэгт 12 ХБҮЦ-ны нийт эргэн төлөлтийн тооцоолол

Төлбөр (сая.төгрөг)	Q0	Q1	Q2	Q3	Q4	Q5	Q6	Q7	Q8
Зээлийн үндсэн төлбөр		2,480	2,561	2,409	1,952	1,181	991	876	752
ХБҮЦ-ийн хүүгийн төлбөр	-	595	526	418	299	202	149	97	41
Нийт	-	3,075	3,088	2,827	2,251	1,383	1,141	973	793





3.5 Үнэт цаасны төлбөрийн тооцоолол

Үнэт цаасны төлбөрийн бодолтын дэлгэрэнгүй

Хүснэгт 13 Хүү тооцох аргачлал

ХБҮЦ-ны хугацаа	24 сар
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр төлөх давтамж	Улирал тутам
ХБҮЦ-ны хүүгийн жилийн хувь /татварын өмнөх/	19.6%
Татварын хувь	5.0%
ХБҮЦ-ны хүүгийн жилийн хувь /татварын дараах/	[18.62%]
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр /татварын өмнөх/	(Тоо ширхэг * Нэрлэсэн үнэ * Хүүгийн жилийн хувь)/Хүүгийн төлбөр төлөх давтамж
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр /татварын дараах/	Татварын өмнөх хүүгийн төлбөр *(1-Татварын хувь хэмжээ)
ХБҮЦ-ны үндсэн төлбөр	12 сард 1 удаа

* Хүүгийн төлбөрийг 365 хоногоор тооцно.


Төлбөр төлөх дараалал

“Үнэт цаасны төлбөр цуглуулах, үнэт цаасны төлбөр төлөх журам”-д үнэт цаас гаргагчийн төлбөр төлөх дарааллыг зохицуулсан ба дараах байдалтай байна.

1. ТЗК-ийн татварын төлбөр;
2. ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар;
3. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр, үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой зардал;
4. Үйлчилгээ үзүүлэгч, захиргааны үйлчилгээ үзүүлэгчийн шимтгэл, зардал;
5. Аудит зэрэг бусад мэргэжлийн оролцогчид, үйлчилгээ үзүүлсэн этгээдийн үйлчилгээний төлбөр;
6. ТУЗ-ийн гишүүдэд олгох хөлс;
7. ХБҮЦ-ны хүүгийн төлбөр;
8. ХБҮЦ-ны үндсэн төлбөр;
9. Журамд заасан бусад зардал.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдсөн өдрөөс хойш 3 хоногийн дотор ТЗК-ийн “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-д заасны дагуу ХБҮЦ-ны төлбөр төлсөн тухай мэдээллийг хүргэнэ. Үнэт цаасны төлбөрийг ҮЦТХТ-өөс ирсэн Үнэт цаас эзэмшигчдийн нэрсийн дагуу шилжүүлэх бөгөөд заасан хугацаанаас өмнө үнэт цаасыг эзэмшиж байсан хөрөнгө оруулагчид үнэт цаасны төлбөр хүлээн авах эрхтэй байна.





Үнэт цаасны төлбөрийн эх үүсвэр

Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр нь ТЗК-д шилжүүлсэн 6 тэрбум төгрөгийн дүн бүхий зээлийн багцаас орох үндсэн төлөлтийн болон хүүгийн орлого байх юм. 24 сарын хугацааны турш багцад нийт 8.9 тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн төлөлтийн орлого орж ирэх хүлээлттэй байна. Тус тооцоолол нь одоогоор багцалсан зээлүүдийн гэрээгээр хүлээсэн үүргийг харуулах боловч хугацааны дундуур зээлийн төлөлтийн хугацаанд өөрчлөлт орох, зээлдэгч урьдчилан төлөх, хугацаа хэтрүүлэх, түүнтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шалгуур хангахгүй болсон зээлүүдийг солин шалгуур хангасан зээлүүдээр солих, худалдан авах зэрэг харилцаатай холбоотойгоор мөнгөн урсгалын төсөөлөлд өөрчлөлт орох боломжтой юм.

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу худалдан авах, 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрөөр нийт 6.8 тэрбум төгрөгийн дүн зээлийн багцаас орох мөнгөн хөрөнгөөр төлөх бөгөөд уг үнэт цаасыг гаргахтай холбоотойгоор гуравдагч этгээдээс баталгаа, батлан даалт гаргуулаагүй, мөн Омни Ассет ХБҮЦ-ны тухайд эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгоогүй болно.


Сул чөлөөтэй эх үүсвэрийн удирдлага

"Омни ассет ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-23/011 тоот тогтоолоор батлагдсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-ын дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Төлбөр цуглуулах дансан дахь үндсэн төлбөрийн болон хүүгийн хэсгийн үлдэгдэл хэсгээр ТЗК-ийн дүрэмд заасны дагуу хөрөнгө оруулалтын хэрэгслийн эрсдэл, өгөөж болон ХБҮЦ-ны холбогдох үүргийг гүйцэтгэхэд аливаа хүндрэл учрахгүй байх бүхий л бололцоог харгалзан тооцоо судалгаа хийсний үндсэн дээр дараах хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулна.

- Банкны хадгаламж,
- Засгийн газар болон Монголбанкнаас гаргасан үнэт цаас;
- Зохицуулах байгууллагаас хүлээн зөвшөөрсөн бусад.


ХБҮЦ-ны төлбөрийг хугацаандаа төлөх боломжийг хангах зорилгоор дээр дурдсан хөрөнгө оруулалтын дуусах хугацааг ХБҮЦ-ны төлбөр төлөх хугацаатай уялдуулан тохируулсан байна.






	Зээлийн шинжилгээ гаргагч	<ul style="list-style-type: none">• Зээлийн шинжилгээ гаргагч нь ТЗК-д худалдах зээлийн багцад багтаж буй зээлүүд нь Үнэт цаас гаргагчийн баталсан журам дүрмийн хүрээнд олгогдсон болон тасалбар болгон худалдах өдрөөр холбогдох санхүүгийн шаардлага, үзүүлэлтүүдийг хангасан эсэхийг тохиролцсон горимоор шалгаж дүгнэлт гаргасан".
2. Багцад сонгосон хөрөнгүүд нь шалгуур хангасан эсэхэд хөндлөнгийн этгээд дүгнэлт гаргах	"Шонхор аудит үнэлгээ" ХХК Хуулийн фирм "ХаанЛекс Партнерс" ХХН	<ul style="list-style-type: none">• Хуулийн фирм нь зээлийн багцад багтах зээлүүд хуулийн шалгуур хангасан эсэх талаар дүгнэлт гаргахаас гадна СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 10.4 дэх хэсэг, МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2.5.5 дэх хэсэгт тус тус заасан асуудлаар дүгнэлт гаргасан.
3. Үйлчилгээ үзүүлэгч нь эргэн төлөлтийг цуглуулж ажиллана.	Үйлчилгээ үзүүлэгч "Омни капитал ББСБ" ХХК	<ul style="list-style-type: none">• ТЗК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр зээлийн багцын эргэн төлөлтийг цуглуулах ажлыг хариуцах бөгөөд гэрээнд заасан нөхцлийн дагуу ТЗК-ийн данс руу зээлийн эргэн төлөлтийг төвлөрүүлнэ.
4. Үнэт цаасыг СЗХ, МХБ-д бүртгүүлэх, анхдагч арилжааг зохион байгуулах	Андеррайтер "Апекс капитал ҮЦК" ХХК	<ul style="list-style-type: none">• Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу үнэт цаасны танилцуулга, хүсэлтийг боловсруулж, үнэт цаасыг бүртгүүлнэ• Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн дагуу үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад санал болгох.
5. Үнэт цаасыг олон нийт нээлттэй худалдан авах арилжааг зохион байгуулах	МХБ, ҮЦТХТ	<ul style="list-style-type: none">• Үнэт цаасыг олон нийт нээлттэй худалдан авах арилжааг зохион байгуулах• ТЗК-ийн гаргасан үнэт цаасыг хадгалах, төлбөр тооцоог гүйцэтгэх





6. Хөрөнгийг удирдах	Хөрөнгө итгэжлэн удирдагч "Юү Эй Эф ассет менежмент" ХХК	<ul style="list-style-type: none">ТЗК-ийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулалтыг бүртгэх, үнэт цаасны хэлцэлтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг гүйцэтгэнэ.
7. Төлбөр төлөх	Үнэт цаас гаргагч "Омни ассет ТЗК" ХХК	<ul style="list-style-type: none">Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс тусгаарласан, хөндлөнгийн хууль болон аудитын дүгнэлтээр баталгаажсан зээлийг гэрээний дагуу хүлээн авна. ТЗК идэвхтэй байх хугацаанд гэрээний үндсэн дээр Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар хөрөнгийн багцыг удирдуулна.Үйлчилгээ үзүүлэгчийн цуглуулсан зээлийн эргэн төлөлтийг цуглуулж хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй үнэт цаасны төлбөрийг хуваарийн дагуу төлнө.
8. Төлбөр хүлээн авах	Хөрөнгө оруулагч	<ul style="list-style-type: none">МХБ-р дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалагдаж буй ХБҮЦ-ыг худалдан авч, үнэт цаасны танилцуулгад заасан төлбөрийн хуваарийн дагуу хүүний болон үндсэн төлбөрийг хүлээж авна.





3.7 Багцын тойм

Үнэт цаасжуулах хөрөнгийн багцын тасалбар болгох өдрийн байдлаарх мэдээллийг доорх байдлаар тоймлож харуулав. Шалгуур үзүүлэлт хангасан нийт 426 зээлдэгчийн 6,836,676,535 төгрөгийн үлдэгдэл бүхий 432 зээлийн гэрээг багцалсан болно.

Хүснэгт 15 Багцын үндсэн үзүүлэлтүүд

Багцын үндсэн үзүүлэлтүүд

Нийт зээлийн үлдэгдэл	6,836,676,535
<i>Автомашин барьцаалсан</i>	340,030,588
<i>Автомашинны лизинг</i>	4,701,301,615
<i>Бизнесийн зээл</i>	1,489,185,358
<i>ҮХХ, Газар барьцаалсан-Хэрэглээ</i>	306,158,974
Нийт анх олгосон дүн	8,627,257,000
Барьцааны дүн	13,988,020,000
Зээлийн гэрээний тоо	432
Зээлдэгчийн тоо	426
Зээлийн дундаж үлдэгдэл	15,825,640
Хамгийн том 1 зээлийн нийт багцад эзлэх %	2.1%
Хамгийн том 10 зээлийн нийт багцад эзлэх %	9.2%
Хамгийн том 50 зээлийн нийт багцад эзлэх %	12.1%
Жигнэсэн дундаж үзүүлэлт	
Жигнэсэн дундаж хүү	3.03%
Жигнэсэн дундаж зээлийн анхны хугацаа /сар/	33.6
Жигнэсэн дундаж зээлийн үлдсэн хугацаа /сар/	25.9
Жигнэсэн дундаж LTV	60.5%
Багцын зээлийн чанар	100 хувь хэвийн

Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 болон түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа үүрэг гүйцэтгэгч дээрх зээлийн багцад байхгүй болно.





Хүснэгт 16 Зээлийн багцын хугацааны мэдээлэл

Зээлийн багцын хугацаа

Зээлийн анхны хугацаа /сар/	Зээлийн тоо		Анх олгосон дүн	
	Тоо	Хувь	Дүн	Хувь
6-15 сар	14	3.24%	127,600,000	1.48%
16-30 сар	140	32.41%	2,110,580,000	24.46%
31 - дээш	278	64.35%	6,389,077,000	74.06%
Нийт	432	100.00%	8,627,257,000	100.00%
Хамгийн их сар			48	
Хамгийн бага сар			12	
Жигнэсэн дундаж сар			33.6	

Нийт зээлийн багцын 64 хувийг 31-ээс дээш сарын хугацаатайгаар анх олгож байсан бөгөөд тус зээлийн тоо хамгийн их буюу 278 ширхэг байна. Анх олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа нь 33.6 сар.

Хүснэгт 17 Багцын анх олгосон хугацааны мэдээлэл

Багцын анх олгосон хугацаа

Анх олгосон огноо	Зээлийн тоо		Анх олгосон дүн	
	Тоо	Хувь	Дүн	Хувь
2021	20	4.63%	415,900,000	4.82%
2022	190	43.98%	4,003,000,000	46.40%
2023	222	51.39%	4,208,357,000	48.78%
Нийт	432	100.00%	8,627,257,000	100.00%

2022-2023 онд олгосон зээл нийт багцын 95 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд үлдсэн зээлийн жигнэсэн дундаж хугацаа нь 25.9 сар байна.

Хүснэгт 18 Багцын анх олгосон дүнгийн мэдээлэл

Багцын анх олгосон дүн

Анх олгосон дүн /мян.төг/	Зээлийн тоо		Анх олгосон дүн	
	Тоо	Хувь	Дүн	Хувь
0-6,000	32	7.41%	141,300,000	1.64%
6,001-12,000	74	17.13%	727,490,000	8.43%
12,001-18,000	114	26.39%	1,756,285,000	20.36%
18,001-24,000	111	25.69%	2,306,282,000	26.73%





24,001-дээш	101	23.38%	3,695,900,000	42.84%
Нийт	432	100.00%	8,627,257,000	100.00%
Хамгийн их	180,000,000			
Хамгийн бага	1,500,000			
Дундаж	19,970,502			

Зээлийн багцын 7 хувийг 6-аас доос сая төгрөгийн үнийн дүн бүхий зээлүүд бүрдүүлж байгаа бол 24-өөс дээш сая төгрөгийн үнийн дүн бүхий зээл нийт багцын 23 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 19 Багцын LTV харьцаа

Багцын харьцаа үзүүлэлт (LTV)

Хувиар	Зээлийн тоо	
	Тоо	Хувь
0-40%	98	22.69%
41-55%	88	20.37%
56-65%	70	16.20%
66-75%	120	27.78%
76% - дээш	56	12.96%
Нийт	432	100.00%

Багцад тавигдах шалгуур дагуу зээл, үнэлгээний харьцаа 85 хувиас хэтрэхгүй байх бөгөөд тус багцын хувьд хамгийн өндөр ЗҮХ нь 80 хувь байна. Зээлийн багцын 87 хувь буюу дийлэнхи хэсгийг 75 хувиас бага ЗҮХ-тай зээлүүд бүрдүүлж байна.

Хүснэгт 20 Зээлийн хүүгийн тархалт

Зээлийн хүүгийн тархалт

Хүүгийн хэмжээ	Зээлийн тоо		Анх олгосон дүн	
	Тоо	Хувь	Дүн	Хувь
2-3%	205	47.45%	4,131,757,000	47.89%
3.1-4%	227	52.55%	4,495,500,000	52.11%
Нийт	432	100.00%	8,627,257,000	100.00%
Хамгийн их	3.50			
Хамгийн бага	2.20			
Жигнэсэн дундаж	3.03%			

Зээлийн багцын 53 хувийг 3.1-4 хувийн хүүтэй зээл эзэлж байгаа бөгөөд хамгийн өндөр зээлийн хүү нь сарын 3.5 хувь, хамгийн бага зээлийн хүү нь 2.2 хувь байна.



2023-11-13


Хүснэгт 21 Багцад багтсан зээлийн барьцааны төрөл

Багцын төрөл

Багцын төрөл	Зээлийн тоо		Барьцааны үнэлгээ	
	Тоо	Хувь	Дүн	Хувь
Автомашин	367	84.95%	10,051,820,000	71.86%
Газар	7	1.62%	95,000,000	0.68%
Үл хөдлөх	55	12.73%	3,780,700,000	27.03%
Хөдлөх хөрөнгө	3	0.69%	60,500,000	0.43%
Нийт	432	100.00%	13,988,020,000	100.00%

Багцад багтсан зээлүүдийн барьцаа нь автомашин, газар, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө байгаа. Зээлийн багцын 85 хувийг автомашин барьцаалсан зээл бүрдүүлж байгаа бол 13 хувийг үл хөдлөх барьцаалсан зээл бүрдүүлж байна.





ЗЭЭЛИЙН БАГЦЫН САНХҮҮ БОЛОН ХУУЛИЙН ШАЛГУУР, ДҮГНЭЛТ

“Омни ассет ТЗК” ХХК-ийн зээлийн багцад “Шонхор үнэлгээ аудит” ХХК болон “ХаанЛекс партнерс” ХХН хөндлөнгийн дүгнэлт гаргасан бөгөөд дараах байдлаар хуульд заасан болон “Омни ассет ТЗК”-ийн ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-23/012 тоот тогтоолоор баталсан хууль болон санхүүгийн шаардлагыг хангаж байгаа талаар дүгнэлт гаргасан байна.

Зээлийн шинжилгээ гаргач “Шонхор үнэлгээ аудит” ХХК нь 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдөр “Омни ассет” ХХК-тай байгуулсан Тохиролцсон горимоор ажил гүйцэтгэх гэрээний дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”, Холбогдох Үйлчилгээний Олон Улсын Стандарт 4400-ийн хүрээнд нийт 432 багц зээлийн мэдээллийг шинжилж үзсэний үндсэн дээр түүнийг төлөөлөхүйц сонгогдсон 58 зээлд хийсэн шалгалтын үр дүнг доор оруулав.

Зээлийн хөрөнгөд тавигдах санхүүгийн шалгуур

1. Тасалбар болгох өдрөөр хэвийн ангилалдсан зээл байх

2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрөөр тасалбар болгон худалдагдаж буй нийт 432 зээлийн мэдээллийг программаас татан авч багцыг төлөөлөх 58 зээлийг түүвэрлэн сонгосон. Тасалбар болгосон өдрөөр түүврийн багц дахь зээлүүд хэвийн ангилалтай байгаа болох нь Зээлийн дансны хуулга болон зээлийн гэрээний зээл эргэн төлөх хуваариар нотлогдож байна.

2. Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх

Зээлийн гэрээнүүд болон дансны хуулгаар тус зээлүүд нь Монгол төгрөгөөр олгогдож, Монгол төгрөгөөр эргэн төлөгдөж байна.

3. Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх;

Зээлийн гэрээ болон зээлийн эргэн төлөлтийн хуваарь, хуваарийн дагуу төлөгдөж байгаа эсэхийг шалгахад түүвэрт орсон зээлүүд хуваарийн дагуу төлөгдөж байна. Зээлийн хугацааны эцэст гэхэд төлөгдөж дуусахаар тооцоологдсон байна.

4. Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх;

Зээлийн төлөлтийн хуваарийг, дансны хуулгатай тулган үзэхэд түүвэрт орсон зээлүүдээс 1 зээл хуваарьт хугацаанаасаа өмнө илүү төлөлттэй, бусад зээлүүд хэвийн төлөлттэй байна.

5. Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 85%-с хэтрэхгүй байх.



2023-11-15



Зээл үнэлгээний харьцаа нь нийт зээлийн хувьд 1-ээс 81 хувийн хооронд байгаа бөгөөд түүвэрт хамрагдсан зээлүүдийн хувьд 30-аас 80 хувийн хооронд байна.

Зээлдэгчид тавигдах шалгуур

6. Монгол Улсын нутаг дэвсгэрт тогтвортой оршин суудаг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байх;

Тухайн багцын хувьд эрх зүйн бүрэн чадамжтай болох нь хүчин төгөлдөр иргэний үнэмлэхийн хуулбар, Төрийн цахим мэдээллийн сангийн лавлагаагаар баталгаажиг байна. "Омни капитал ББСБ" ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны ТУЗ 22/20 дугаар тогтоолоор батлагдсан Зээлийн бодлогын 3.2.1 дэх заалтыг дагаж мөрдөж ажилласан байна.

7. Банк, санхүүгийн байгууллагад чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй байх.

Түүвэрт хамрагдсан зээлдэгчид зээлийн мэдээллийн сангийн лавлагаагаар хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй байна.


8. Өр орлогын харьцаа (ӨОХ) нь татварын дараах орлогын 80%-с илүүгүй байх

ӨОХ тооцсон байдлыг татвар, шимтгэлийн дараах цалингийн болон бизнесийн орлого, ЗМС дах бусад зээлийн өрийн үлдэгдлийн төлөлт, сарын зээл төлөлтийн дүн зэргийг гарган ӨОХ-ны томъёогоор давтан гүйцэтгэж шалгасан.

9. Зээл олгосон шалгуур нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо мөрддөг шалгуур үзүүлэлтэд нийцсэн байх;

Зээл олгосон шалгуур нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо мөрддөг шалгуур үзүүлэлтэд нийцэж байна. Тухайлбал, "Омни капитал ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны А/004 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан Зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөлд бүтээгдэхүүн тус бүрд орлого нотлох баримтыг харгалзан зээлдэгчийн төлбөрийн чадварыг харгалзан зээл олгохоор заасан.





Хөндлөнгийн хууль зүйн дүгнэлт гаргагч ХаанЛекс Партнерс ХХН нь Үнэт цаас гаргагчаас тогтоосон хууль зүйн дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэх талаар дүгнэлт гаргасан ба мөн хөрөнгийн багцтай холбоотой үүргийн гүйцэтгэлийг хангуулах гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрээ, хэлцэлд үүргийн гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгасан эсэх тухай дүгнэсэн.

Ингэхдээ нийт 432 зээлийн багцаас 11%-ийг буюу 47 зээлийг санамсаргүй түүврийн аргаар сонгон, Үнэт цаас гаргагчаас тавьсан хуулийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээ хийж, дүн шинжилгээний дүгнэлт гаргасан байна. /Дэлгэрэнгүй мэдээллийг Хууль зүйн дүгнэлтийн 3.6 дахь хэсгээс үзнэ үү /

Зээлийн хөрөнгөд тавигдах хуулийн шалгуур үзүүлэлт

1. Зээлийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.
2. Фидуцийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.
3. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.
4. Фидуцийн гэрээний дагуу автомашиныг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн байх, холбогдох бүртгэлийг хийлгэсэн байх, үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжинд хангуулах боломжтой байх
5. Фидуцийн зүйл, үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний барьцаа хөрөнгө нь хуульд заасны дагуу төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө биш байх.
6. Тасалбар болгох өдрийн байдлаар фидуцийн зээлийн гэрээ, үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээний үүрэг дуусгавар болоогүй, үүрэг гүйцэтгэгчийн хувьд аливаа сөрөг шаардлага гаргаагүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх.
7. Зээлдэгч нь эрх зүйн бүрэн чадамжтай эсэх.
8. Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгуулсан байх
9. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь Үнэт цаас гаргагчийн эзэмшилд шилжих боломжтой бөгөөд эрхийн доголдолгүй байх.
10. Зээлийн гэрээнд заасны дагуу зээлийг зээлдэгчийн зээлийн дансанд шилжүүлсэн, эсхүл зээлдэгч зээлийн данснаас зээлээ ашигласан байх.





ХӨРӨНГИЙН ХӨРӨНГИЙН БИРЭГ
LONG TERM STOCK EXCHANGE

2023-11-13

БҮРТГЭВ

ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу багцыг шилжүүлэн авсан зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл болон зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон эсхүл Журамд заасан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад өөрчлөлт оруулна.

Хөрөнгийн багцад дараах байдлаар өөрчлөлт оруулна. Үүнд:

- ✓ Багцын хөрөнгийг солих;
- ✓ Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;
- ✓ Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах.

ХӨРӨНГИЙГ БАГЦААС ХАСАХ ҮНДЭСЛЭЛ

- Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь Үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхгүйц байна гэж ТЗК-аас үзсэн;
- Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн “Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ”-нд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн;
- Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн зээл эргэн төлөх үүргээ биелүүлээгүй 90-ээс дээш хоног хэтэрсэн эсхүл;
- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болох нь тогтоогдсон бол.


ХӨРӨНГИЙН БАГЦЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.1-д заасны дагуу ХБҮЦ-ны хөрөнгийн багцаас орох орлого нь ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу ТЗК нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргахаар болсон
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолд нийцүүлэн үнэт цаас эзэмшигчдэд төлөх төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон.

ХӨРӨНГИЙН БАГЦЫГ АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИД БУЦААН ХУДАЛДАХ ҮНДЭСЛЭЛ

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Журамд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй





- хөрөнгийн багцын хэмжээгээр;
- Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш, эсхүл 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд;
 - Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд.

Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэхэд багцад ийнхүү нэмэгдсэн хөрөнгө нь баталгаат үнэт цаас гаргах өргөдөл, үнэт цаасны танилцуулгад тусгагдсантай адил онцлог, шинж чанартай байна.


ТЗК-ийн хөрөнгийн багц дахь хөрөнгөөс ХБҮЦ эзэмшигч этгээдээс өөр гуравдагч этгээд нэхэмжлэл гаргах эсхүл шаардах эрх хэрэгжүүлэхгүй.



МОНГОЛ
2025
БҮРТГЭВ

2025.4.16 08:00
БҮРТГЭВ
№ 01

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН
ОРЧИН




Signature
Circular stamp

Asset-backed securities буюу хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) нь анх 1985 онд компьютер, тоног төхөөрөмжийн лизингийн эргэн төлөлтөөр баталгаажин гарч байсан. Үүнээс хойш энэхүү зах зээл нь өргөжин тэлж автомашины, тоног төхөөрөмжийн, сургалтын төлбөрийн болон кредит картын зээлээр баталгаажин, олон төрлийн ХБҮЦ хөрөнгийн зах зээлд нэмэгдээд байна.

1985 оноос хойш АНУ-ын ХБҮЦ-ийн зах зээл тасралтгүй өсөж, 2007 онд 1.96 их наяд ам.долларт буюу бүх цаг үеийн хамгийн дээд хэмжээндээ хүрсэн хэдий ч дэлхийн санхүүгийн хямралын үеэр ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасанд ихээхэн хохирол үүссэнээр АНУ-ын ХБҮЦ-ны зах зээл буурч эхэлсэн.

Уг зах зээл нь 2012 оноос сэргэж эхэлсэн ба тухайн үед 1.28 их наяд ам.долларын үнэлгээтэй байсан бол 2022 оны байдлаар 1.59 их наяд ам.доллар болж 24.22 хувиар өсөөд байна.

График 5 2012 оноос хойш ХБҮЦ-ны зах зээлийн хэмжээ (Тэрбум \$)²



2020 онд дэлхий дахинд цар тахал дэгдсэнээр олон улсын эдийн засгийн есөлт удааширч АНУ-ын ХБҮЦ-ны зах зээл 8%-иар буурч байсан бол 2022 оны байдлаар уг зах зээл 1.585 их наяд ам.доллар хүрч 3%-иар тэлээд байна.

Ковид 19 цар тахлын дараагаар буюу 2022 онд дэлхийн эдийн засгийг сэргэнэ гэсэн хүлээлттэй байсан хэдий ч Хятад улсад Ковид үргэлжлэн гарч, ОХУ-Украины дайны улмаас инфляц дэлхийн хэмжээнд 8.9% хүрсэн ба энэ нь сүүлийн 27 жилд байгаагүй дээд түвшин байв.



² Эх сурвалж : Securities Industry and Financial Markets Association (SIFMA)



Дээрх шалтгааны улмаас Дэлхий банк ихэнх орнуудын эдийн засгийн өсөлтийн таамгаа буруулаад байгаа бөгөөд 2023 онд хөгжингүй орны өсөлтийг ердөө 0.5% хэмээн тооцоолжээ.

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ³

Жилийн өөрчлөлт (хувиар)	2021	2022	2023*	2024*
Дэлхийд (Олон улсад)	5.9	2.9	1.7	2.7
Хөгжингүй эдийн засаг	5.3	2.5	0.5	1.6
АНУ	5.9	1.9	0.5	1.6
Евро бүсийн орнууд	5.3	3.3	0.0	1.6
Япон	2.2	1.2	1.0	0.7
Хөгжиж буй эдийн засаг	6.7	3.4	3.4	4.1
Зүүн Ази, Номхон далай	7.2	3.2	4.3	4.9
Хятад	8.1	2.7	4.3	5.0
Индонез	3.7	5.2	4.8	4.9
Тайланд	1.5	3.4	3.6	3.7
Европ болон төв Ази	6.7	0.2	0.1	2.8
ОХУ	4.8	-3.5	-3.3	1.6
Турк	11.4	4.7	2.7	4.0
Полш	6.8	4.4	0.7	2.2
Латин Америк ба Карибын тэнгис	6.8	3.6	1.3	2.4
Бразил	5.0	3.0	0.8	2.0
Мексик	4.7	2.6	0.9	2.3
Аргентин	10.4	5.2	2.0	2.0
Ойрхи Дорнод болон Хойд Африк	3.7	5.7	3.5	2.7
Саудын Араб	3.2	8.3	3.7	2.3
Иран, Исламын Бүгд Найрамдах Улс	4.7	2.9	2.2	1.9
Египет, Арабын Бүгд Найрамдах Улс	3.3	6.6	4.5	4.8
Өмнөд Ази	7.9	6.1	5.5	5.8
Энэтхэг	8.7	6.9	6.6	6.1
Пакистан	5.7	6.0	2.0	3.2
Бангладеш	6.9	7.2	5.2	6.2
Сахарын цөлөөс өмнөх Африк	4.3	3.4	3.6	3.9
Нигери	3.6	3.1	2.9	2.9
Өмнөд Африк	4.9	1.9	1.4	1.8
Ангол	0.8	3.1	2.8	2.9

Инфляц


Орос Украины дайн, Хятадын цар тахлын бодлого, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал зэрэг шалтгаанаас үүдэн эрчим хүч болон хүнсний салбарт нийлүүлэлт буурч, үнийн хөөрөгдөл үүссэн. 2021 онд инфляц дэлхийн хэмжээнд 4.7% байсан бол дээрх шалтгааны улмаас 2022 онд 8.9% болж өсжээ.



³ Эх сурвалж : World Bank




График 6 2020 оноос хойш инфляцын динамик⁴



Дээрх графикаас харвал 2022 онд эрчим хүчний хомсдолоос үүдэлтэй Европын холбооны улсуудад инфляц хамгийн их өссөн бол АНУ-д оны сүүлээр тогтворжин буурч эхэлжээ. 2022 онд дээрх улсуудын төв банкнууд бодлогын хүүгээ нэмсэн нь үр дүнгээ өгч, 2023 онд тэдгээрийн инфляц буурч байна. Тухайлбал АНУ-ын инфляц 2022 оны 12-р сард 6.5 хувь байсан бол 2023 оны 4-р сарын байдлаар 4.9 хувь болж буурсан. Мөн Европын орнуудын инфляц 11.1 хувиас 8.3 болжээ. Харин Англи улсын хувьд инфляц харьцангуй тогтвортой байж 2022 оны 12-р сараас хойш 0.4 хувиар буурч 10.1 болоод байна.

График 7 Инфляцын түвшний төсөөлөл⁵



Дээрх орнуудаас гадна ихэнх улсын төв банкнууд 2022 онд бодлогын хүүгээ нэмсэн нь 2023 оноос эхлэн үр дүнгээ өгч, инфляц дэлхийн хэмжээнд 2 хувиар



⁴ Эх сурвалж : U.S. Bureau of Labor Statistics (BLS) Office for National Statistics (ONS)

⁵ Эх сурвалж : ОУВС (IMF)



2023-11-15
БҮРТГЭВ

буурах төлөвтэй байна. ОУВС-ийн зүгээс хөгжингүй орны инфляц 2023 онд 3.3 хувь, хөгжиж буй орнуудынх 8.1 хувь болж буурна гэж тооцоолоод байгаа. Цаашлаад 2024 онд дэлхийн дундаж инфляц 4.1 хувь, хөгжингүй орнуудад 2.3 хувь, хөгжиж буй орнууд 5.4 хувьд тус тус хүрч буурна гэсэн хүлээлттэй байна.

Бодлогын хүү


2021 онд АНУ-ын бодлогын хүү ердөө 0.25 хувь байсан бол 2022 онд 4.5 болж нэмэгдсэн байна. Үнийн хөөрөгдөл хамгийн их болж буй Европын холбооны төв банкны хүүгийн хэмжээ 2021 онд 0 хувь байсан бол 2022 онд 2.5 хувь болж нэмэгдсэн. Бодлогын хүү нь инфляцын хэмжээнээс шууд хамааралтай тул дийлэнх орнууд инфляцыг зохих хэмжээнд хүртэл хүүгийн хэмжээг бууруулахгүй гэдгээ мэдэгдсэн. 2023 онд АНУ бодлогын хүүг бууруулах бодолгүй байгаа бол Европын холбоо болон Англи зэрэг орнуудад инфляц өндөр хэвээр байгаа тул хүүгийн түвшнийг нэмэх хандлагатай байна. Дээрх шалтгааны улмаас хөрөнгийн зах зээл уналтад орох, хөрөнгө оруулагчид засгийн газрын үнэт цаас болон бусад тогтмол өгөөжтэй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах төлөвтэй байгаа юм.

4.2 Дотоод орчин

Эдийн засгийн хэмжээ

Монгол Улсын эдийн засгийн хэмжээ 2018 оноос хойш жилд дунджаар 13.2 хувиар, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн дунджаар 11.6 хувийн өсөлтийг тус тус үзүүлжээ. Өсөлтийн үр дүнд ДНБ 52.9 их наяд төгрөгт хүрсэн байна. Харин 2015 оны зэрэгцүүлсэн үнээр тооцсон бодит ДНБ сүүлийн 5 жилд дунджаар 1.9 хувиар өссөн буюу бодитоор ДНБ сул өсөлт үзүүлсэн байна. 2023 оны 1-р улирлын байдлаар ДНБ 13.6 их наяд буюу өмнөх оны мөн үеэс 42 хувиар өссөн үзүүлэлттэй байна.






Мөнгөний зах зээл

Зах зээл дээрх бэлэн мөнгөний хэмжээ, хилийн хориг зэрэг хүчин зүйлсээс үүдэлтэй инфляцийн хүчтэй өсөлтийн эсрэг Төв банк бодлогын хүүг нэмэгдүүлж, 12 сарын хугацаанд 6 хувиас 12 хувь хүртэл өсгөсөн байна. 2023 онд Монгол банкны зүгээс инфляцийн хэмжээг зорилтот түвшинд очтол (6% (±2%)) бодлогын хүүг бууруулахгүй байх бодлоготой байгаа ба энэ нь 2023 болон 2024 оны эхэн үе хүртэл зах зээл дээрх хүүгийн түвшин хэвээр хадгалагдах нөхцөл байдлыг үүсгээд байна.

График 9 Инфляц ба бодлогын хүүгийн динамик⁷



⁶ Эх сурвалж : Үндэсний Статистикийн Хороо

⁷ Эх сурвалж : Үндэсний Статистикийн Хороо




4.3 Банк бус санхүүгийн байгууллагын салбар

БҮРГЭВ-02

Дэлхийн ББСБ салбар ба санхүүгийн зах зээл

График 10 ББСБ салбарын нийт санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээ⁹

Нийт санхүүгийн хөрөнгө
\$486.6 их наяд




2021 оны жилийн эцсийн байдлаар дэлхийн банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгө 8.9 хувиар өссөн бөгөөд, сүүлийн 5 жилийн дундаж өсөлт болох 6.6 хувийг давжээ. Ингэснээр тус салбарын нийт санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээ 49.2 хувьд хүрсэн байна.

МУ-ын зах зээлийн бүтэц

2023 оны эхний улирлын эцсээр нийт санхүүгийн байгууллагын үнэлгээ 57.4 их наяд төгрөг байгаа бөгөөд үүний 80.9 хувийг арилжааны банкууд, 11.4 хувийг үнэт цаасны зах зээл, 6.4 хувийг ББСБ-ын салбар, үлдсэн 1.3 хувийг даатгал болон хадгаламж зээлийн хоршоод тус тус бүрдүүлж байна.

График 11 МУ-ын санхүүгийн зах зээлийн хэмжээ⁹



■ Арилжааны банкууд ■ Хөрөнгийн зах зээл ■ ББСБ ■ ХЗХ ■ Даатгал



⁹ Эх сурвалж : Financial Stability Board
⁹ Эх сурвалж : Үндэсний Статистикийн Хороо



График 12 2018 оноос хойш МУ-ын санхүүгийн зах зээлийн бүтэц¹⁰

БҮРТГЭВ-02



МУ-ын санхүүгийн салбар доторх арилжааны банкууд нийт зах зээлийн 80-аас дээш хувийг сүүлийн 5 жилд бүрдүүлж байна. Нийт зах зээлийн хэмжээ өссөн боловч салбаруудын эзлэх хувийн жин өөрчлөгдсөн буюу үнэт цаасны зах зээл болон банк бус санхүүгийн байгууллагын эзлэх хувь 2018 онтой харьцуулахад өсжээ.

Санхүүгийн салбарын эзлэхүүн, хувиар

Хүснэгт 22 Санхүүгийн салбаруудын сүүлийн 5 жилийн дундаж өсөлт


	2018-2022 (CAGR)
Арилжааны банкууд	6.8%
Үнэт цаасны зах зээл	22.3%
ББСБ	22.4%
Даатгал	6.0%
ХЗХ	7.4%

Санхүүгийн зах зээл дээрх салбаруудын сүүлийн 5 жилийн дундаж өсөлтөөр үнэт цаас болон ББСБ 22.3, 22.4 хувиар тус тус тэргүүлж байна. Бусад салбаруудын өсөлт ойролцоо буюу 6-7.4 хувиар өсжээ.




¹⁰ Эх сурвалж : Үндсэний Статистикийн Хороо





Өсөлт /зээл, хөрөнгө, цэвэр ашиг, хүүгийн орлого, зардал/

График 13 ББСБ-ын санхүүгийн үзүүлэлтүүдийн өсөлт¹⁾



¹⁾ Үндэсний Статистийк Хороо, СЗХ-ны жилийн тайлан




4.4 Хөрөнгийн зах зээлийн төлөв

Зах зээлийн үнэлгээ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2022 оны 12-р сарын 31-ны өдрийн байдлаар 6.89 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар өссөн бөгөөд уг үзүүлэлт нь ДНБ-ны 14.35%-тай тэнцэж байгаа юм. Сүүлийн 5 жилд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2.7 дахин өссөн бөгөөд ДНБ-д эзлэх хувь 2018 оноос хойших хамгийн өндөр түвшинд байгаа юм.


График 14 МУ-ын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ¹²



Арилжааны идэвх

2022 онд нийт 580.41 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа Монголын хөрөнгийн биржээр дамжин хийгдсэн бөгөөд энэ нь 2021 онтой харьцуулахад 59 хувиар буурсан хэдий ч 2018 онтой харьцуулахад 2.7 дахин өссөн үзүүлэлт болжээ. 2021 хөрөнгийн зах зээл түүхэн том өсөлтийг үзүүлсэн бөгөөд өмнө энэ хэмжээний арилжаа хийгдэж байгаагүй юм.

График 15 Арилжааны идэвх¹³



¹² Эх сурвалж : Монголын хөрөнгийн бирж

¹³ Үндэсний Статистийн Хороо



Арилжааны задаргаа

Арилжааны үнийн дүнг задаргаагаар харвал 2021 хамгийн өндөр дүнг компанийн бондын арилжаа бүрдүүлж нийт арилжааны 74.12 хувийг эзэлсэн байна. Харин 2022 онд хамгийн өндөр дүнг хувьцааны арилжаа бүрдүүлж нийт арилжааны 57.73 хувийг эзэлжээ. Мөн доорх үзүүлэлтээс харахад Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас нийт арилжааны ердөө 0.3 хувийг бүрдүүлж байсан бол 2022 он гэхэд 17.45 хувь болж нэмэгдсэн байна. Энэ нь сүүлийн үед тус бүтээгдэхүүн ач холбогдол давуу тал зах зээлд танигдаж хөрөнгө оруулагчдын дунд эрэлт өндөртэй байгааг харуулж байна.

График 16 Арилжааны бүтэц¹⁴




Зах зээлийн индексүүд

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компаниас бүрдэж буй ТОП-20 индексийн 2020 оноос хойш 84 хувиар өсөөд байгаа бол 2022 оны хувьд 6,846.05 нэгжээр буюу 15.42 хувиар буурч, 37,565.55 нэгж болсон байна. Дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 44,119.22 нэгж, доод үзүүлэлт 32,795.68 нэгж, дундаж үзүүлэлт 36,252.42 нэгж байна.

¹⁴ Эх сурвалж : Санхүүгийн зохицуулах хороо

График 17. ТОП-20 индексийн түүхэн үзүүлэлт¹⁵



MSE-A индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,344.83 нэгжээр буюу 8.69 хувиар буурч, 14,137.94 нэгж болсон бол MSE-B индекс 464.88 нэгжээр буюу 3.81 хувиар өсөж, 12,667.44 нэгжид хүрчээ.

Индекс	2021	2022	Өөрчлөлт
ТОП 20	44,411.60	37,565.55	-15.42%
MSE A	15,482.77	14,137.94	-8.69%
MSE B	12,202.56	12,667.44	3.81%



Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

2022 онд нийт 6 удаагийн нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас анхдагч зах зээлд амжилттай арилжаалагдаж, олон нийтээс нийт 89.85 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн бол хоёрдогч зах зээлд нийт 13.90 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.



¹⁵ Эх сурвалж : Монголын хөрөнгийн бирж





Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Шинэ бүтээгдэхүүнүүд


2022 оноос хойш 2023 оны 5-р сарын 18 хүртэл нийт 21 бүтээгдэхүүн бирж дээр гарч олон нийтээс нийт 605.23 орчим тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна. Үүний 140.40 тэрбум төгрөг буюу 23.2 хувийг тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүн буюу бонд болон ХБҮЦ-аар татан төвлөрүүлжээ.



¹⁶ Эх сурвалж : Санхүүгийн зохицуулах хороо



Графиктө МХБ дээр арилжаалагдсан шинэ бүтээгдэхүүнүүд¹⁷



Хөрөнгийн зах зээлд системийн нөлөө бүхий банкнууд IPO хийж орж ирснээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2023 оны 5-р сарын 24-ны байдлаар 8.46 их наяд болж нэмэгдэн түүхэн дээд амжилтдаа хүрээд байгаа юм. Зах зээлийн үнэлгээнээс гадна дотоодын болон гаднын хөрөнгө оруулагчдын хэмжээ өдөр ирэх тусам нэмэгдэж энэ хэрээр арилжаа идэвх зах зээлийн хөгжил улам нэмэгдсээр байна.

¹⁷ Эх сурвалж : Монголын хөрөнгийн бирж



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-11-15

БҮРТГЭВ-02

СЭХ

2023 оны 01 сарын 01

БҮРТГЭВ

№ 01

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА,
ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ,
ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА



A circular seal is located in the bottom left corner of the page. It contains a signature written in cursive, which is partially obscured by the seal's border.

2023-11-15

5.1 Эрсдэл, эрсдэлийн удирдлага



Үнэт цаас гаргагч болон анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс үнэт цаасны төлбөрийг үнэт цаас эзэмшигчдэд хуваарийн дагуу төлөхтэй холбоотой үйл ажиллагаа болон хөрөнгийн эрсдэлийг дараах гурван ангиллаар тодорхойлсон. Тодруулбал,

1. Зээлтэй холбоотой эрсдэл;
2. ХБҮЦ гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудтай холбоотой эрсдэл /Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үйлчилгээ үзүүлэгч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч/
3. Бусад гадны хүчин зүйлстэй холбоотой эрсдэл /Хууль, журам, зохицуулалт болон Давагдашгүй хүчин зүйлс/

1. ЗЭЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Үүсэж болох эрсдэл.

- Зээлийн эрсдэл гэдэг нь зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй улмаас үүсэх эрсдэлийг хэлнэ. Үүнд зээлдэгч зээлийн хугацаа хэтрүүлэх, төлбөрийн чадваргүй болох, Зээлдэгч эрх зүйн чадамжгүй болох, нас барах, сураггүй алга болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон байхыг ойлгоно.
- Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл гэдэг нь зээлдэгч зээлээ хугацаанаас нь өмнө төлөх буюу хүлээгдэж байсан хүүгийн орлого буурах, хаагдахыг ойлгоно.

Эрсдэлийн удирдлага

- ТЗК нь хугацаа хэтэрсэн зээл дээр үйлчилгээ үзүүлэгч талаас зээлийг эргэн төлүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчийн дотооддоо мөрдөж буй холбогдох заавар журмын хүрээнд үйлчилгээг авч, хяналт тавьж ажиллана. Үүнтэй холбоотой зохицуулалтыг Үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгана.
- ТЗК нь зээл хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл үүссэн тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг болон ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу хөрөнгийн багцад хөрөнгө нэмэх замаар арга хэмжээ авна.
- Баталгаат үнэт цаасны төлбөр хугацаандаа төлөгдөхгүй нөхцөлд авах арга хэмжээ
 1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь багцын хөрөнгийг солих, багцын хөрөнгийг нэмэгдүүлэх, анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэргээр багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах боломжгүй тохиолдолд барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулан ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой Үйлчилгээ үзүүлэгчид шүүхэд нэхэмжлэл гаргахыг мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавина.
 2. Хэрэв Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг төлөх чадваргүй болсон тохиолдолд барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэл хангуулах бөгөөд дараах алхмуудыг хэрэгжүүлнэ:
 - 2.1. Барьцаалуулагч нь Зээлдэгчтэй байгуулсан Зээлийн болон Фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйлээс зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээ авах үүрэгтэй. Уг үүргийг ТЗК-тай байгуулсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд Үйлчилгээ үзүүлэгч хэрэгжүүлнэ.





- 2.2. Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний 10-д заасан (Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу энэхүү гэрээний Барьцаалуулагч үүргээ гүйцэтгэхгүй байх) зөрчлийн улмаас ББСБ нь зээлийн төлбөрийг цуглуулж ТЗК-д шилжүүлэх үүргээ биелүүлж чадахгүй нөхцөл байдал үүссэн үед Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх ТЗК-д үүснэ.
- 2.3. Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх ТЗК-д шилжсэнээр тэрээр барьцааны зүйлийг өөрийн өмчлөлд үл маргах журмаар шилжүүлэн авч болно. Энэ тохиолдолд барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг ТЗК-ийн нэрийн өмнөөс Хөрөнгө итгэмжлэн удирдагч хэрэгжүүлнэ. Барьцаалуулагч төлбөрийн чадваргүй болж, мэдэгдлийг хүлээн авах боломжгүй болсон нь түүнийг барьцааны үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Тайлбар

Зээлдэгчтэй холбоотой эрсдэлийг хаах зохицуулалтыг “Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журамд зааснаас гадна “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-аар тус тус зохицуулсан байна. Тодруулбал, ТЗК-ийн багцад буй зээл нь ТУЗ-ийн баталсан хууль болон санхүүгийн шаардлага хангасан байх шаардлагатай. Хэрэв хугацааны дундуур шаардлага хангахгүй зээл үүссэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь шаардлага хангасан зээлээр солих, хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зүгээс багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хэвийн зээлээр нэмэх ажиллагаа хийгдэхээр зохицуулсан.

Нөгөө талаас Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь шаардлага хангасан зээлийг солих нөөцтэй буюу 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 25.2 тэрбум төгрөгийн зээлийн багцтай байна.

2. ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Үүсэж болох эрсдэл.

- **Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл.**
 - 1) ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан зээл шилжүүлсэн;
 - 2) Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг сольж нэмж чадахгүй болсон;
 - 3) Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдсан.
- **Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл.**
 - 1) Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийг бүрэн гүйцэд, гэрээгээр хүлээсэн хугацааны дагуу цуглуулан ТЗК-д шилжүүлэхгүй байх;
 - 2) Үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцлах;
 - 3) Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдсан, дампуурсан.
- **Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл.**
 - 1) Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийг гэрээнд зааснаас гадуур, Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид хохиролтойгоор зүй бусаар удирдах, ашиглах;
 - 2) Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцалсан;
 - 3) Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь татан буугдсан, дампуурсан.



2023 -11- 15

Эрсдэлийн удирдлага
БҮРТГЭВ-02

2023 оны 11 08 өдөр

БҮРТГЭВ

№ 01

■ **Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг удирдах.**

- 1) Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл үүссэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгийн багцыг солихыг шаардах, ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу эрсдэлийг удирдана.
- 2) Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь сайн дурын үндсэн дээр эсхүл хуульд заасан үндэслэлээр татан буугдах тохиолдолд түүний ТЗК-д шилжүүлсэн Багцын хөрөнгийн үлдэгдлийг зохих журмын дагуу сонгогдсон өөр Үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх арга хэмжээ авна.
- 3) ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох журам, гэрээнд тус бүр эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

■ **Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийн удирдлага**

- 1) Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй зээлүүдийн үндсэн болон хүүгийн төлөлтийг уг дансанд цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгана. Үйлчилгээ үзүүлэгч нь учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна.
- 2) Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийг төлүүлэхдээ ТЗК-тай байгуулсан гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дотооддоо мөрдөгдөж буй Зээлийн үйл ажиллагааны журам, Зээл төлүүлэхтэй холбогдсон бусад журмыг дагаж мөрдөнө.
- 3) Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлэхгүй, эсхүл Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан тохиолдолд ТЗК нь тусгаарласан зээлийн багцтай холбоотой авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг зохих журмын дагуу сонгогдсон, өөр хэвийн үйл ажиллагаатай үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэгчийг солих арга хэмжээ авна.
- 4) ТЗК нь үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

■ **Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийн удирдлага**

- 1) Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын удирдлагатай холбоотой тайлан мэдээллийг Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад тогтмол хүргэх бөгөөд хууль болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд ТЗК-ийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа өгөх эрхтэй. Мөн зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгаж баталгаажуулсан байна.
- 2) Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг төрийн зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна.
- 3) ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд



2023 -11- 15 |

БҮРТГЭВ-02

эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.



Тайлбар

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд зээлийн багцын хөрөнгийг солих чадвар болсон нөхцөлд тусгаарласан зээлийн багцын барьцаа хөрөнгөөр үүрг гүйцэтгэл хангуулах арга хэмжээг тус тус авна.

Нөгөө талаас үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн багц солих боломжгүй болох эрсдэл харьцангуй бага гэж тодорхойлж болох юм. Тодруулбал, 2023 оны 2 дугаар улирлын байдлаар зээлийн багцын дүн 25.2, зээлийн чанар 7.5 хувьтай байна. Нөгөө талаас "Омни капитал ББСБ" ХХК, тэдгээрийн хувьцаа эзэмшигч, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь тохиромжтой этгээд буюу хууль журмын шаардлага хангасан, ажлын туршлагатай этгээдүүд байна.

3. ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Үүсэж болох эрсдэл.

- ХБҮЦ, ТЗК, оролцогч талуудад тавигдах шаардлагатай холбоотой хууль журам, зохицуулалт өөрчлөгдөх эрсдэл.

Эрсдэлийн удирдлага

- Гадаад хүчин зүйлийн эрсдэлтэй холбогдуулан ТЗК-ийн ТУЗ-ийн хурал хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллага, хуулийн фирмийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллана.
- Давагдашгүй хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлага
 - 1) Давагдашгүй хүчин зүйл бий болсон тухайгаа Үнэт цаас эзэмшигчдэд тухайн брокерын компаниар дамжуулан бичгээр мэдэгдэх, ТЗК болон Биржийн цахим хуудсаар мэдээлнэ. Тухайн мэдэгдэлд ямар байдлаар давагдашгүй хүчин зүйл үүссэн, түүний хор уршгийг бууруулах талаар авсан, эсхүл авах гэж буй арга хэмжээ, давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон хугацааг тус тус тусгасан байна.
 - 2) Давагдашгүй хүчин зүйлийн улмаас ТЗК нь Үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй нь үндсэн үүргээс чөлөөлөхгүй бөгөөд давагдашгүй хүчин зүйлийн үед ТЗК-ийн үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

Тайлбар:

Гадаад хүчин зүйлийн нөлөөлийн эрсдэлийг бууруулах, түргэн шуурхай арга хэмжээ авахад ТУЗ болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үүрэг юм. "Омни ассет ТЗК" ХХК-ийн ТУЗ нь хууль, санхүүгийн чиглэлээр олон жил туршлагатай этгээдүүд байх бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь мэргэжлийн оролцогч байгууллага байна.



2023-11-15

Үнэт цаас эзэмшигчийн эрх

БҮРТГЭВ-02

Үнэт цаас эзэмшигч нь дараах эрхтэй байна:



- Үнэт цаасыг биржийн арилжааны журмаар худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, шилжүүлэн авахыг шаардах
- Үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийг тогтоосон хугацаанд хүлээн авах, төлөхийг Үнэт цаас гаргагчаас шаардах
- Үнэт цаас эзэмших эрхээ гуравдагч этгээдэд чөлөөтэй шилжүүлж, захиран зарцуулах, арилжаалах
- Үнэт цаас эзэмшиж буй хугацаандаа Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүлээн авах, мэдээллээр хангахыг шаардах,
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах,
- ХБҮЦ эзэмшигчид нь үнэт цаас эзэмших эрхийн хувьд ижил тэгш эрхтэй байна.
- ХБҮЦ-ны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11.5, 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь хэсэгт заасан нөхцөл бий болсон бол үнэт цаас эзэмшигч нь үнэт цаасаа буцаан худалдан авахыг шаардах эрхтэй.

Үнэт цаас гаргагчийн үүрэг

ТЗК нь өөрийн хөрөнгийг өмчлөх, бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, эсхүл шинээр эхлүүлэх болон ХБҮЦ гаргах баримт бичиг, хэлцлийн баримт бичгийн дагуу үүрэг хүлээх, эсхүл хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой, эсхүл тэдгээрийг зохицуулдаг бүх хууль, журам болон зааврыг бүх талаар дагаж мөрдөх үүрэгтэй. Мөн

- ТЗК-н, эсхүл түүний өмнөөс тухай бүр гаргасан бүх мэдээлэл нь үнэн зөв, төөрөгдөл үүсгээгүй болон мэдээлэл орхигдуулаагүй байна.
- ТЗК гэрээгээр хүлээсэн үүргээ болон хэлцлийн баримт бичгийн заалтыг дагаж мөрдөх (гэрээний нөгөө тал үүргээс чөлөөлснөөс бусад тохиолдолд) болон бусад этгээдийг үүргээ гүйцэтгэхийг шаардах эрхээ цаг тухайд нь хэрэгжүүлэх.
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулахгүй байх;
- Бизнесийн үйл ажиллагааг өөрчлөх: ТЗК-н бизнесийн үйл ажиллагааг өөрчлөхгүй байх, дүрэмд тодорхой заагаагүй бизнес эрхлэх, эсхүл үйл ажиллагаанд оролцохгүй байх;
- ТЗК-н хөрөнгөд ХБҮЦ эзэмшигчдийн шаардах эрхээс өөр бусад зээлдүүлэгчийн шаардах эрх ямар ч үед үүсгэхгүй байлгах талаар боломжтой арга хэмжээнүүдийг авах;
- Зээл нь шалгуур үзүүлэлт хангасан байх: шалгуур үзүүлэлт хангаагүй зээл худалдан авахгүй байх;
- ХБҮЦ-ны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11.5, 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь хэсэгт заасан нөхцөл бий болсон бол Үнэт цаас гаргагч нь үнэт цаас эзэмшигчээс буцаан худалдан авна.



2023 -11- 15

Татвар

БҮРТГЭВ-02



Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуулийн 20.2.5 дахь заалт болон хувь хүний орлогын албан татварын 21.5 дахь заалтын дагуу нээлттэй ХБҮЦ-ны хүүгийн орлогод 5 хувийн татвар ногдуулна.



2023-11-15
ХӨРӨНГӨӨ ОРУУЛАГЧДАД ТАНИЛЦУУЛАХ МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙГ
ТАЙЛАГНАХ ХУГАЦАА, АГУУЛГА

БҮРТГЭВ-02

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмыг тус тус удирдлага болгон Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журмыг баталсан. Тодруулбал

“Омни ассет ТЗК” ХХК нь олон нийтэд хүргэх мэдээллийг нэгэн зэрэг сонирхогч бүх этгээдэд Биржийн болон Компанийн цахим хуудсаар дамжуулан тогтоосон хугацаанд мэдээлнэ. Компанийн цахим хуудсанд нийтэд тогтмол мэдээлэл хүргэх хэсэг байрших бөгөөд тус хэсгийн мэдээлэл нь Компани татан буугдах хүртэл хугацаанд байршихаар заасан.

	Мэдээллийн агуулга	Хүргүүлэх этгээд/хэлбэр	Хугацаа
1	СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын 11.3-т заасан мэдээлэл:	СЗХ болон Үнэт цаас эзэмшигчдэд цахим хэлбэрээр хүргүүлнэ.	Дараа сарын 10-ны дотор
2	Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.1.3-д заасан мэдээлэл	МХБ -д цахим хэлбэрээр	Дараа сарын 20-ны өдрийн дотор мэдээлнэ.
3	СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 11.4 болон Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.1.1-д заасан жилийн үйл ажиллагааны тайлан	Хороо, Биржид цахим болон хэвлэмэл хэлбэрээр үнэт цаас эзэмшигчид цахим хэлбэрээр	Дараа жилийн 4 дүгээр сарын 30-ны дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор
4	Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.1.2-д заасан мэдээлэл	МХБ-д цахим болон хэвлэмэл хэлбэрээр	Дараа оны 4 дүгээр сарын 30-ны дотор
5	Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.2-д заасан мэдээллийн өөрчлөлт	МХБ хэвлэмэл хэлбэрээр	Өөрчлөлт орсон тухай бүр ажлын 3 хоногт багтаан мэдэгдэнэ.



5.2 Үнэт цаасны арилжаа, захиалга өгөх заавар

БҮРТГЭВ-02

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах процессын зураглал



1 Үнэт цаасыг эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэх.

2 Олон нийтэд санал болгох

3 Захиалгын бүртгэл хийх

4 Үнэт цаасны нийлүүлэлт хийх

5 Төлбөр тооцоо хийх

6 Хөөрдөгч арилжааг эхлүүлэх

Уг процессын зураглал нь МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам болон СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам-д заасны дагуу бүтэцлэгдсэн болно.

Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар

- 1 Үнэт цаасны дансаа нээлгэх
СЗХ-нд бүртгэлтэй үнэт цаасны компаниудаас сонгон дансаа нээх
- 2 Үнэт цаасны дансанд мөнгө байршуулах заавар авах, байршуулах
Үнэт цаасны данс нь 12 оронтой байх бөгөөд брокероос уг мэдээллийг лавлах боломжтой
- 3 Захиалга өгөх
Дансаа цэнэглэсний дараа үнэт цаас худалдан авах захиалга өгөх


Мөнгө байршуулах заавар

Банкны нэр	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Дансны дугаар	**** * /данстай үнэт цаасны компаниас 12 оронтой өөрийн нэр дээрх дансаа авах/
Хүлээн авагч	Тухайн хөрөнгө оруулагчийн өөрийн нэр дээрх данс байна
Гүйлгээний утга	Нэр, Регистрийн дугаар, Омни ХБҮЦ




2023-11-15

БҮРТГЭВ-02



ҮНЭТ ЦААС ГАРГАХ
АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН
БАЙГУУЛЛАГУУД



2023-11-15

6.1 Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон байгууллагууд

БҮРТГЭВ-02



Андеррайтер:
Апекс капитал ҮЦК ХХК

Үйл ажиллагааны чиглэл :	Брокер Дилер Андеррайтер Хөрөнгө оруулалтын зөвлөх,
Үүсгэн байгуулагдсан:	2011.
Регистрийн дугаар:	5453283
Хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимп гудамж, Нью Хоризонс тауэр, 9 давхар, 901 тоот
Утас:	976-75107500
Имэйл:	investment@apex.mn

Компанийн тухай

“Апекс капитал ҮЦК” ХХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан. 2018 оноос андеррайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа идэвхжүүлсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос брокер, дилер, андеррайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг хавсран эрхэлж, санхүү хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээг үзүүлж байна.

“Апекс капитал ҮЦК” ХХК нь одоогийн байдлаар 30,000 гаруй харилцагч, хөрөнгө оруулагчтай ба 50 гаруй компанийн үнэт цаасыг гаргаж хамтран ажилласан байна. Андеррайтерийн үйлчилгээний хүрээнд компанийн IPO, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, биржийн бус зах зээлд бонд гаргах ажиллагаанд 2018 оноос хойш идэвхтэй ажиллаж байна.

Тодруулбал, “Сэнтрал экспресс си ви эс” ХК, Мандал хөрөнгө оруулалтын сан болон “Монбийф” ХК-ийн IPO ажиллагаанд үндсэн болон туслах андеррайтераар тус тус оролцсон. Мөн Монголын 2 дох хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас болох “Омни актив ТЗК” ХХК-ийн 5 тэрбум төгрөгийн ажилд үндсэн андеррайтераар ажилласан туршлагатай.

Мөн 2021 оноос хойш Биржийн бус зах зээлд 17 компанийн бондын санхүүжилтэд ажиллаад байна.

Удирдлагын мэдээлэл

Гүйцэтгэх захирал
Б.Лхамдолгор

ШУТИС-ийн КТМС-ийг Санхүү удирдлага мэргэжлээр төгссөн.
Хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалтын чиглэлээр 20-оод жил ажилласан туршлагатай.





Гэрээний тухай

“Апекс капитал ҮЦК” ХХК нь 2023 оны 5 сарын 11-ний өдөр 06/АРК/23/31 тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан. Энэхүү гэрээгээр андеррайтер нь Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой дараах ажил үйлчилгээг үзүүлхээр харилцан тохиролцсон.

Үнэт цаас гаргах бэлтгэл ажлын хүрээнд:

- Үнэт цаас гаргагч болон түүний хувьцаа эзэмшигчийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн мэдээлэлд судалгаа шинжилгээг хийж, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон СЗХ болон МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах шаардлагыг хангасан эсэхийг нягталж шалган, үнэт цаас гаргахтай холбоотой бэлтгэл ажлыг хангуулах;
- Олон нийтэд нээлттэй санал болгох хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны төлөвлөгөөг үнэт цаас гаргагчтай хамтран боловсруулж, тус төлөвлөгөөний дагуу үнэт цаас гаргах үйл ажиллагааг удирдах;
- Үнэт цаас гаргагч болон түүний хувьцаа эзэмшигчийн санхүүгийн болон бизнесийн үйл ажиллагаанд магадлан шинжилгээ хийж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүтцийг тодорхойлох;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ болон МХБ-ийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэх журам”-ын дагуу Үнэт цаасны танилцуулгыг боловсруулах;
- Эрх бүхий этгээдүүдэд үнэт цаас бүртгүүлэх өргөдөл гаргах, бүртгэлийн багц баримт бичгийг бэлтгэх, холбогдох зөвшөөрлийг авахад хүчин чармайлт гарган ажиллах.

Үнэт цаасыг олон нийтэд санал болгох ажлын хүрээнд

- Үйлчлүүлэгчтэй хамтарсан маркетингийн төлөвлөгөө боловсруулан батлах;
- Баталсан төлөвлөгөөний дагуу маркетингийн ажлын зохион байгуулалтад хамтран оролцох;
- Андеррайтер нь Үйлчлүүлэгчийн үүсгэн байгуулсан ТЗК-ийн ХБҮЦ-г нийтэд санал болгон түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах буюу Андеррайтерийн “Best effort” хэлбэрээр ажиллах;
- Анхдагч зах зээлийн арилжааг явуулах, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх.



Үйл ажиллагааны чиглэл:	Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
Үүсгэн байгуулагдсан:	2018
Регистрийн дугаар:	6351034
Хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимп гудамж, Аюуд тауэр, 14 давхар, 1404 тоот
Утас:	976-77471122
Имэйл:	Info@khanlex.mn

Компанийн тухай

Өмгөөллийн Хаанлекс Партнерс ХХН нь банк санхүү, үнэт цаас, дэд бүтэц, эрчим хүч, шүүхийн маргаан, бизнесийн болон компанийн эрх зүйн салбарт голчлон хууль зүйн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Монголын тэргүүлэх хуулийн фирмүүдийн нэг юм. Өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд өөрсдийн үйлчилгээ, мэдлэг, туршлагаа олон улсын зах зээлийн томоохон оролцогч нарт хүргэж ирсэн ба эдгээрт олон улсын хөгжлийн банк, санхүүгийн байгууллагууд, гадаадын төрийн өмчит болон хувийн салбарын тэргүүлэгч компаниуд багтдаг.

Хуулийн фирм нь Монгол Улсад хийгдсэн олон улсын шинжтэй томоохон гэрээ, хэлцлүүдэд эрх зүйн зөвлөгөө өгч, амжилттай ажилласан ба тэдгээрийн зарим нь олон улсын хэмжээнд танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Түүнчлэн, хууль зүйн зөвлөгөө өгч ажилладаг үндсэн эрх зүйн салбарууд (банк санхүү, дэд бүтэц, бизнесийн эрх зүй, шүүхийн маргаан зэрэг)-аас гадна хурдтай хөгжиж буй "ногоон санхүүжилт"-ийн эрх зүйн чиглэлээр ажилласан байдал, туршлагаараа Монгол Улсын хуулийн фирмүүдийн дунд тэргүүлэх байр суурь эзэлж байна.

Хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа явуулж буй үндсэн чиглэлийн нэг нь үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн үйлчилгээ үзүүлсэн туршлагатай. Тухайлбал, тус хуулийн фирмийн хуульчид нь Хай Би Ойл ХК, ЛэндМН ББСБ ХК, Даваанбулаг ХК, Түмэншувуут ХК, Мон-Бийф ХХК, ХаанБанк ХК, Монложистикс Холдингс ХХК зэрэг компаниудын хувьцаагаа олон нийтэд санал болгох (IPO болон FPO) ажилд хууль зүйн үйлчилгээг амжилттай үзүүлсэн ба Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкнаас Эрдэнэ Рэсурс Девелопмент Корпораци ХК-ийн хувьцаанд хөрвөх санхүүжилтийн ажилд оролцсон туршлагатай. Түүнчлэн хувьцаанаас бусад үнэт цаасны хувьд ХаанБанк ХК-аас нийтэд санал болгон гаргах Ногоон бондын хөтөлбөр, Омни Актив ТЗК болон Нөмөр Кредит Ассет ТЗК нарын МХБ-ээр дамжуулан арилжаалсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Мөнхийн үсэг ХХК болон Степпе Бэвэриж ХХК-аас хаалттай бонд тус тус гаргах төсөлд хуулийн дүгнэлт гарган, хууль зүйн үйлчилгээ үзүүлэн оролцжээ.





Тус нөхөрлөл нь Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээлийн оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр 2020 оны 06-р сарын 10-ны өдөр бүртгэгдсэн.

Удирдлагын мэдээлэл:

Гүйцэтгэх захирал
И.Учралбаяр

МУИС-ийн Хууль Зүйн Сургууль /2006-2011/
Барилга, Үл хөдлөх хөрөнгө, Төр хувийн хэвшлийн түншлэл, Төслийн санхүүжилт болон Маргаан хянан шийдвэрлэх салбарт тус фирмээс үзүүлж буй хууль зүйн үйлчилгээг хариуцан удирддаг бөгөөд салбартаа ажилласан арав гаруй жилийн туршлагатай.

Гэрээний тухай

“ХаанЛекс Партнерс” ХХН нь 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 23/002 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг “Омни ассет” ХХК-тай байгуулсан.

Гэрээний дагуу хуулийн фирм нь дараах асуудлаар дүгнэлт гаргахаар харилцан тохиролцсон байна.

- ХБҮЦ гаргахтай холбоотой хууль зүйн дүгнэлт боловсруулах
- Зээлийн багцад тавигдах хууль зүйн шаардлагыг ТЗК-тай хамтран тодорхойлох, улмаар Зээлийн багцын хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, тайлан гаргах.

Тус үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд хуулийн фирм нь шаардлагатай баримт бичигтэй танилцах, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд нийцүүлэн хууль зүйн үйлчилгээг үзүүлэх, Үйлчилгээг үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах зэрэг эрх үүрэгтэй байна. Мөн ТЗК нь үйлчилгээний талаар шаардлага, санал гаргах, үйлчилгээтэй холбоотой үнэн бодитой мэдээлэл, баримт бичгээр түргэн уурхай хангах, холбогдох асуулт, хүсэлтэд түргэн шуурхай хариу өгөх зэрэг оролцоог хангахаар тусгажээ.





Зээлийн шинжилгээ гаргагч :
“Шонхор аудит үнэлгээ” ХХК

Үйл ажиллагааны чиглэл :	Аудитын үйл ажиллагаа Хөрөнгийн үнэлгээ хийх
Үүсгэн байгуулагдсан:	2014.03.27
Регистрийн дугаар:	5821975
Хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Сүхбаатар 13, 302 барилга, 503 тоот
Утас:	99018172
Имэйл:	shonkhor.mn@gmail.com

Компанийн тухай

“Шонхор үнэлгээ аудит” ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан Аудит, нягтлан бодох бүртгэл, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ, нягтлан бодох бүртгэл, татварын зөвлөх үйлчилгээг 9 дэх жилдээ үзүүлж байгаа үндэсний компани юм. СЗХ-оос Үнэт цаасны зах зээлийн оролцогчдод аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр 2017 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 34 тоот тогтоолын дагуу бүртгэгдсэн.

Компани нь мэргэшсэн нягтлан бодогч, аудитор, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч, хөрөнгийн үнэлгээчин, хөрөнгө оруулалтын зөвлөх гэх мэт мэргэжлийн зэрэг цол, туршлагатай мэргэжилтнээр бүрдүүлсэн хамт олон юм.

Олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх болон санхүүгийн зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг компаниудад хийгдэх аудитын ажилд дараах байгууллагуудтай хамтран ажилласан туршлагатай.

- “Ашид капитал ББСБ” ХХК-ийн ХБУЦ гаргахтай холбоотой зээлийн шинжилгээ гаргах ажил, 2022 он
- “Сэндли ББСБ” ХХК-ийн олон нийтэд шинээр санал болгон хувьцаа гаргах үйл ажиллагаанд санхүүгийн тайлангийн Аудит, 2022 он
- “Сэндли ББСБ” ХХК-ийн 2023 оны анхны нээлттэй “Сэндли бонд” гаргах ажлын санхүүгийн тайлангийн аудит.

Мөн Монголын томоохон групп компаниуд болох “М Си Эс Монголиа” ХХК “М Си Эс Холдинг” ХХК “Скай резорт” ХХК “Монголиан мючүл финанс групп” ХХК “Юбикаб ХХК -уудын нэгтгэсэн санхүүгийн тайланд аудитын үйлчилгээ үзүүлсэн туршлагатай.

Удирдлагын мэдээлэл

Гүйцэтгэх захирал
Д.Шийрэв

ХААИС-ийг Эдийн засагч-Математикч мэргэжлээр төгссөн. МНББИНститутын Мэргэшсэн нягтлан бодогч, Аудитор, Үнэлгээчний эрхтэй. Мэргэжлээрээ 1998 оноос хойш ажиллаж байна.





“Шонхор аудит үнэлгээ” ХХК нь 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 23/001 тоот Тохиролцсон горимоор ажил гүйцэтгэх гэрээг “Омини ассет” ХХК-тай байгуулсан.

“Омини Ассет ТЗК” ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотойгоор хууль болон СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын шалгуур үзүүлэлтийн дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад барьцаалагдах зээлийн багцаас түүвэрлэн шалгаж, хууль журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тогтоож, зээлийн шинжилгээ гаргахаар гэрээ байгуулсан.

Зээлийн шинжилгээ гаргагч нь хууль болон журам болон олон улсын стандарт 4400-ын хүрээнд зээлийн багцын шинжилгээг гаргахдаа аудитын үйл ажиллагааны талаарх Монгол улсны хууль тогтоомж, аудитын стандартууд болон ёс зүйн дүрмийг даган мөрдөхөөр зохицуулсан байна. Тодруулбал, аудитор нь гэрээний дагуу тус зээлийн багцын шинжилгээ хийхдээ шударга, бодит, мэргэжлийн ур чадвар болон хянамгай, нууц хадгалах, мэргэжлийн төлөв байдал, техникийн стандартуудыг дагаж мөрдөн ажиллана. Мөн зээлийн шинжилгээ гаргагч нь өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын хариуцлагыг бүрэн хүлээхээр тусгажээ.

Үнэт цаас гаргагч нь зээлийн шинжилгээний үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах, аудиторын шаардсан баримт, мэдээллийг аудитороос тогтоосон хугацаанд нь гаргаж өгөх үүргийг хүлээсэн бол зээлийн шинжилгээний гүйцэтгэлд нөлөө үзүүлэх хууль, тогтоомж, холбогдох дүрмийн шаардлага, талуудын шинжилгээтэй холбоотой эрх, үүрэг, аудитор тайлбар хийх, дүгнэлт гаргах журмын талаар аудитороос мэдээлэл авах зээлийн шинжилгээний дүгнэлтийн талаар тайлбар авах эрхтэй байна.



Хөрөнгө итгэмжлэн удирдагч :
“Юү Эй Эф ассет менежмент” ХХК

Үйл ажиллагааны чиглэл :	Хөрөнгө итгэмжлэн удирдах 2021.10
Үүсгэн байгуулагдсан:	2021
Регистрийн дугаар:	2870657
Хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын төв өргөө, 10 давхар, 1005 тоот
Утас:	976 7012-2346
Имэйл:	info@uaf.mn



2023-11-15

Компанийн тухай

БҮРТГЭВ-02



Олон нийтэд нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас санал болгож байгаа үйл ажиллагаанд Хөрөнгө итгэмжлэн удирдагч болох “Юү Эй Эф ассет менежмент” ХХК нь СЗХ-ны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 473 дугаар тогтоолоор Үнэт цаасны зах зээлд Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авсан.

Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь бүтэцжүүлсэн санхүүжилтийн чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. Компанийн засаглалын олон улсын ISO 37000:2021 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчдод компанийн засаглалын зөвлөх үйлчилгээг хүргэн ажилладаг. Компани нь компанийн засаглал, санхүүгийн удирдлагаар мэргэшсэн 100 хувь хараат бус төлөөлөн удирдах зөвлөлтэй.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтэн нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийн журмын шаардлагыг хангасан, Гүйцэтгэх захирал, ХИУ үйл ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтэн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан, үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан болно.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн програмын тухай

“Юү Эй Эф ассет менежмент” ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцын Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үйлчилгээ үзүүлэгчээс тайлан мэдээлэл хүлээн авах зорилгоор вебэд суурилсан программыг хөгжүүлсэн. Энэхүү программ нь Зээлийн мэдээллийг бүртгэх буюу зээлийн барьцаа хөрөнгийн төрлөөс хамааран бүртгэл хийх, багц зээлийн эргэн төлөлтийн хуваарийг бүртгэнэ.

Ажиллаж буй төслүүдийн мэдээлэл

№	ХБҮЦ гаргагч	Огноо	Гаргасан дүн (тэрбум.төг)	ХБҮЦ-ны үлдэгдэл дүн (тэрбум.төг)	Хугацаа	Хэлцлийн зөвлөхөөр ажилласан эсэх
1	“Омни Актив ТЗК” ХХК	2022.03.04	5.00	2.50	24 сар	Үгүй
2	“Симпл Ассет ТЗК” ХХК	2022.06.23	50.00	25.00	18 сар	Тийм
3	“Бэрс Эй Би Эс Актив ТЗК” ХХК	2022.09.02	10.00	10.00	24 сар	Тийм
4	“Нөмөр Кредит Ассет ТЗК” ХХК	2022.10.18	10.00	10.00	24 сар	Тийм
5	“ЛэндМН Актив ТЗК” ХХК	2022.11.01	4.85	4.85	24 сар	Тийм
6	“Бичил Эй Би Эс Актив ТЗК” ХХК	2022.12.19	10.00	7.50	24 сар	Үгүй



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE		2023-11-15				2023.04.28			
7	"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК			9.00	9.00	24 сар	Тийм		
8	"Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК	[*]		20.00	20.00	24 сар	Тийм		
Нийт				118.85	88.85				



Удирдлагын мэдээлэл

Гүйцэтгэх захирал Х.Маргад-Эрдэнэ	МУИС-ийг Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн. Багцын удирдлага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, бүтцийн санхүүжилтийн чиглэлээр 14 жил ажиллаж байна. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ерөнхий нарийн бичгийн даргын 2020 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн 05 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ явуулах эрх авсан.
--------------------------------------	--

Гэрээний тухай

"Юү Эй Эф ассет менежмент" ХХК нь 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Хэлцлийн зөвлөхийн гэрээ мөн 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдөр Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг тус тус байгуулсан.

2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Хэлцлийн зөвлөхийн гэрээгээр Хөрөнгөө баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлэн оролцож.

2023 оны 7 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр "Юү Эй Эф ассет менежмент" ХХК нь ТЗК-ийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулж, үнэт цаасны хэлцэлтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгийн багцыг удирдах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг гүйцэтгэнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээ болон Хөрөнгө итгэмжэн удирдах журамд заасан үйл ажиллагааг өөрийн программ хангамжид суурилан тогтмол үзүүлнэ.

Багц дахь хугацаа хэтэрсэн зээлийг солих, багцыг нэмэгдүүлэх

- Зээл солих: 90 хоногоос дээш төлбөрийн зөрчилтэй зээлийг сардаа 1 удаа тооцоо нийлж солих бөгөөд солих нөхцөл үүссэн зээлийн дараах мэдээллийг бэлтгэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдээлнэ.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дээрх мэдээлэлд үндэслэн хугацаа хэтэрсэн зээлийн нийт дүнд тааруулан ТЗК-д санал болгох



Зээлүүдийн мэдээллийг програмд оруулна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-д бүртгэх зээлүүдийг сонгож Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй тооцоо нийлсэн актыг үйлдэж, холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.

- Багцыг нэмэгдүүлэх: Багц дахь зээлүүдийн эргэн төлөлтөд үндэслэн сард 1 удаа багцыг нэмэгдүүлэх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ТЗК-д нэмж санал болгох зээлүүдийн мэдээллийг програмд оруулна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-д бүртгэх зээлүүдийг сонгож Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй тооцоо нийлсэн актыг үйлдэж, холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.



Омни Капитал

Үйлчилгээ үзүүлэгч:

"Омни капитал ББСБ" ХХК

Үйл ажиллагааны
чиглэл:

1. Зээлийн үйл ажиллагаа /2016.06.10/
2. Төлбөрийн баталгаа /2016.06.10/
3. Итгэлцлийн үйл ажиллагаа /2020.01.15/
4. Факторингийн үйл ажиллагаа /2020.01.15/
5. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх /2021.10.13/

Үүсгэн байгуулагдсан:

2016.05.11

Регистрийн дугаар:

6075657

Хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал тауэр оффис барилга, 712, 713 тоот

Утас:

+976 7277-8282

Имэйл:

info@omnicapital.mn

ХБҮЦ-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсэгт зааснаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч нь үйлчилгээ үзүүлэгчээр оролцож болохоор заасны дагуу ТЗК-ийн үйлчилгээ үзүүлэгчээр "Омни капитал ББСБ" ХХК-ийг сонгохоор ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-23/014 тоот тогтоолоор баталгаажуулсан байна.

Үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа, программ хангамж болон хүний нөөцийн талаар мэдээллийг энэхүү танилцуулгын Нэгдүгээр бүлэг болох Анхны үүрэг гүйцэтгүүлэгч/үүсгэн байгуулагчийн тухай хэсэгт дурдсан.

Гэрээний тухай

Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК-тай Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ болон Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулхаар ТЗК-ийн ТУЗ-ийн 8 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-23/014 тоот тогтоолоор баталгаажуулжээ.





Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний хувьд ТЗК-ийн зээлийн багцыг цаг хугацаанд нь цуглуулан, ТЗК-д журам болон гэрээнд заасан хугацаанд шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах ажил үүргийг дараах байдлаар хэрэгжүүлхээр гэрээний батлагдсан төсөлд тусгагдсан байна.

- Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс буюу Зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэх;
- Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийн дансанд тухай бүр орж ирсэн мөнгөн хөрөнгийг уг дансанд төвлөрүүлж дараа сарын 05-ны өдөрт багтаан холбогдох авлагыг суутган Төлбөр цуглуулах данс руу шилжүүлэхл
- Зээлдэгчийн хүсэлтийн дагуу Зээлийн гэрээ, Зээлдэгчийн мэдээлэл, төлбөрийн хуваарь зэрэгт өөрчлөлт оруулсан бол Үйлчилгээ үзүүлэгч нь энэ талаарх мэдээллийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан өдөрт багтаан мэдэгдэнэ. Зээлийн гэрээнд өөрчлөлт орсон нь Зээлийн багц дахь шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон тохиолдолд ТЗК-ийн "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-д заасны дагуу арга хэмжээ авах;
- Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг тооцоолсон Зээлийн данс бүртгэлийг хөтөлж, зээлийн болон төлбөрийн мэдээллийг дараа сарын ажлын 3 өдөрт багтаан ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэн, тайлагнах;
- Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлдэгч Зээлийн эргэн төлөлтийн хугацааг хэтрүүлсэн болон төлбөл зохих хуваарьт төлбөрөөс давуулан илүү төлсөн тохиолдол бүрийг туха бүр бүртгэж, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид нэн даруй мэдээлэх ба Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу ангилж, тайлагнах;
- Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай харилцах ажилтныг тусгайлан томилох бөгөөд түүнтэй холбоо барих мэдээлэл, түүний эрх, үүрэг болон бусад шаардлагатай мэдээллийг ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлнэ.

6.2 Оролцогч талууд нь нэгдмэл сонирхол, бизнесийн холбоо хамааралтай эсэх, түүнийг мэдэгдэх

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй доор дурдсан байгууллагууд нь холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд Үнэт цаас гаргагч "Омни ассет ТЗК" ХХК болон үүсгэн байгуулагч "Омни капитал ББСБ" ХХК нарт холбогдох мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй бөгөөд эдгээр байгууллага нь Үнэт цаас гаргагч "Омни ассет ТЗК" ХХК болон үүсгэн байгуулагч "Омни капитал ББСБ" ХХК нартай аливаа байдлаар нэгдмэл сонирхолгүй, энд дурдсанаас өөрөөр бизнесийн холбоо хамааралгүй болно. Үүнд:

1. Зээлийн шинжилгээ гаргагч "Шонхор үнэлгээ аудит" ХХК





2. Хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн ХаанЛекс Партнерс" ХХН
3. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэгч "Юү Эй Эф ассет менежмент" ХХК
4. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Апекс капитал ҮЦК" ХХК

Оролцогч талуудын бизнесийн нэгдмэл сонирхол, холбоо хамааралгүй талаарх албан бичгүүдийг хавсралтаас харна уу.

Хэрэв оролцогч талуудад гэрээний дагуу мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэх үед ашиг сонирхлын зөрчил үүссэн эсхүл үүсэж болзошгүй нөхцөлд энэ талаар ТЗК-д мэдэгдэж, тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхээс татгалзана.

Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч, эсхүл тэдгээрийн ажилтнууд нь сонирхлын зөрчилтэй харилцаа үүсгэсэн, үүсгэж болзошгүй бол ТЗК болон холбогдох талуудад мэдэгдэж, мэдээлэлтэй зөвшөөрөл авч болно.

Мөн Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Хөндлөнгийн аудит, Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК-тай сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж ажиллана. Үнэт цаас гаргах ажиллагаанд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж, дараах үйлдлийг хориглоно.

- Оролцогч талуудын болон хөрөнгө оруулагчдын нууц мэдээллийг задруулах;
- Аливаа гуравдагч этгээдэд үйл ажиллагааны үр дүнгийн талаар амлалт өгөх;
- Үнэт цаас эзэмшигчид үнэт цаас, түүний эргэн төлөх ажиллагааны талаар буруу ойлголт өгөх, бодит байдлыг нуун дарагдуулах;
- Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашиг, хүсэл сонирхлын эсрэг ажиллах;
- Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг санаатайгаар буруу хэрэглэх, тайлбарлах;
- Бусад оролцогч талуудын үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулах.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-11-15
БҮРТГЭВ-02

СХ
2023 11 07 өдөр
сар 07 өдөр
БҮРТГЭВ
№ 1



**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ
“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК**

**АНДЕРРАЙТЕР
“АПЕКС КАПИТАЛ ҮЦК” ХХК**

ТУЗ-ийн Дарга
А.Батболд

Гүйцэтгэх захирал
Б.Лхамдолгор

ТУЗ-ийн гишүүн
С.Нина

Хууль, андеррайтерийн алба
П.Сэлэнгэ

ТУЗ-ийн гишүүн
Х.Хэрлэн





САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



“АПЕКС КАПИТАЛ ҮЦК” ХХК

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпийн гудамж 4, Нью горизонтс, 901 тоот
Утас: 7510-7500, И-мэйл: investment@apex.mn,
Веб: www.apex.mn

2023 / 10 / 23 # 129.
танай _____ # _____ Т

Андеррайтерийн дүгнэлт

“Апекс капитал ҮЦК” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдөр олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд “Омни ассет ТЗК” ХХК-ийн баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу оролцож байна.

Андеррайтерийн зүгээс Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн холбогдох дүрэм журмын дагуу дараах судалгаа шинжилгээ гүйцэтгэлээ.

Нэг. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч/үүсгэн байгуулагчийн тухайд

Үүсгэн байгуулагч “Омни капитал ББСБ” ХХК нь зээлийн багцаа ашиглан санхүүжилт татах зорилгоор “Омни ассет ТЗК” ХХК-ийг үүсгэн байгуулсан. Иймээс үүсгэн байгуулагчийн үйл ажиллагаа, санхүү, зээлийн багцын үзүүлэлт нь хэвийн байхаас гадна компанийн үйл ажиллагаа цаашид хэвийн үргэлжлэх нь чухал ач холбогдолтой тул дараах судалгааг гүйцэтгэв.

1.1. Үүсгэн байгуулагчийн үйл ажиллагаа

“Омни капитал ББСБ” ХХК нь 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдөр үүсгэн байгуулагдан зээл болон төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаагаар эхэлж байсан бол өдгөө 5 төрлийн тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа эрхэлж, 34,000 гаруй харилцагчтай, 6 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.


Үндсэн үйл ажиллагаа болох зээлийн үйл ажиллагааг 2020 он хүртэл уламжлалт хэлбэрээр олгодог байсан бол финтек зээлийг 2021 онд нэвтрүүлснээр компанийн цар хүрээ, хүртээмж тэлж, санхүүгийн үзүүлэлтэд эерэг нөлөөг үзүүлсэн нь сүүлийн 5 жилийн санхүүгийн тайлангийн тоо мэдээллээр илэрхийгдэж буй юм.

Мөн “Омни капитал ББСБ” ХХК нь 2021 онд “Омни актив ТЗК” ХХК-ийг үүсгэн байгуулж, 2022 онд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж байсан туршлагатай. Тус үнэт цаасны төлөлт хэвийн үргэлжилж байгаагийн зэрэгцээ хоёрдогч зах зээлийн арилжааны идэвх харьцангуй өндөр 67.99% буюу 3,399,374,990 төгрөгийн дүнгээр арилжаалагдсан байгаа нь хөрвөх чадварын үзүүлэлт өндөртэйг харуулж байна.



1.2. Үүсгэн байгуулагчийн санхүүгийн голлох үзүүлэлтүүд

“Омни капитал ББСБ” ХХК-ийн 2019 оноос хойших санхүү байдлын тайланд дүн шинжилгээ хийсэн бөгөөд санхүү байдлын тайлангийн голлох үзүүлэлтүүд дараах байдалтай байна.



Санхүүгийн голлох үзүүлэлтийг дүгнэвэл “Омни капитал ББСБ” ХХК-ийн сүүлийн 4 жилийн хөрөнгийн дундаж өсөлт 55 хувь, зээлийн дундаж өсөлт 47 хувь, цэвэр ашгийн дундаж өсөлт 32 хувьтай байна. Энэ нь салбарын дундаж өсөлтөөс 10 ба түүнээс дээш хувиар илүү үзүүлэлт юм.

1.3. Үүсгэн байгуулагчийн засаглал

“Омни капитал ББСБ” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны “Компанийн засаглал”-ын талаар баримталж буй бодлогын хүрээнд компанийн дотооддоо мөрдөх бодлого журмын баримт бичгүүдийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэн ажиллаж байна.

Тодруулбал, 2022 оноос компанийн ТУЗ-ийн орон тоог 7 гишүүнтэй байхаар нэмэгдүүлж, хараат бус 2 гишүүнийг томилсон. Ийнхүү компанийн үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүнийг бодлогын түвшинд сайжруулсан нь компанийн хараат бус, бие даасан байдлыг дээшлүүлсэн эерэг үзүүлэлт гэж харж байна. Мөн “Омни капитал ББСБ” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны Компанийн засаглалын кодексийн үнэлгээний тайлангаар Компанийн засаглалын хэрэгжилтийн үнэлгээний тэргүүлэгч ТОП-20 ББСБ-аас 2 дугаарт эрэмбэлэгдсэн болохыг дурдах нь зүйтэй.¹

Хоёр. Үнэт цаас гаргагчийн тухайд

2.1. Үнэт цаас гаргагчийн хууль эрх зүйн шаардлага хангасан байдал

“Омни ассет” ХХК нь 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилготойгоор үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлийн байгууллагад 2023 оны

Компанийн засаглалын үнэлгээний тайлан 2022 он, 10 дугаар нүүр



5 дугаар сарын 4-ний бүртгэгдсэн. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 256 тоот тогтоолоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгосон.

Үнэт цаас гаргагч идэвхтэй байх хугацааны турш үүсэж болох эрсдэлийг урьдчилан харах, түүнээс сэргийлэх, хэлцлийн зураглалд оролцож буй талууд тэдгээртэй холбоотой харилцааг тодорхой байлгах, хөрөнгийн багцын удирдлага шалгуур үзүүлэлтийг үргэлжлүүлэн хангах нөхцөлийг бий болгох, үнэт цаас эзэмшигчдийн эрхийг хангах чиглэлээр дүрэм журмыг баталж, холбогдох гэрээг байгуулжээ.

Үйл ажиллагааны журмын мэдээлэл:

- Компанийн дүрэм
- Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам
- Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам
- Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам
- Хөрөнгө итгэмжлэн удирдах журам
- Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам

Үйл ажиллагаатай холбоотой гэрээний мэдээлэл:

- Тохиролцсон горимоор ажил гүйцэтгэх гэрээ
- Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ
- Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ
- Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ
- Банктай байгуулсан данс нээх гэрээ
- Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ
- Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ
- Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ
- Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ
- Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ
- Фидуцийн барьцааны гэрээ

Дээр тусгагдсан гэрээ журмын дагуу Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хяналт тавихыг Хувьцаа эзэмшигчээс томилсон ТУЗ хэрэгжүүлэх бол зээлийн эргэн төлөлтийг цуглуулах ажиллагааг “Омни капитал ББСБ” ХХК, багцын удирдлага болох зээлийн багц солих, нэмэх, буцаан худалдах, сул чөлөөтэй эх үүсвэрийн удирдлага эзрэг асуудлыг Хөрөнгө итгэмжлэн удирдагч болох “Юү Эй Эф ассет менежмент” ХХК хариуцан ажиллахаар холбогдох гэрээг баталгаажуулсан байна.

Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын төсөөлөл

Орлогын тайлан (сая.төг)	Q0	Q1	Q2	Q3	Q4	Q5	Q6	Q7	Q8
Хүүгийн орлого		595	526	418	299	202	149	97	41
ХБҮЦ-ийн хүүгийн төлбөр		294	294	294	294	147	147	147	147
Удирдлагын зардал		3	3	3	3	3	3	3	3
Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр		77	77	71	56	35	29	24	20



ЭРӨНГИЙН ХӨРӨНГӨ
STOCK EXCHANGE

2023-11-15

БҮРТГЭВ-02

СХХ

0-2023 сар, 0 өдөр

БҮРТГЭВ

№ 01

Хэлцлийн зөвлөх үйлчилгээний төлбөр	30	-	-	-	-	-	-	-
Аудитын үйлчилгээний төлбөр	-	-	6	-	-	-	6	6
Үнэт цаас гаргалтын зардал	222	-	-	-	-	-	-	-
Маркетингийн зардал	80	-	-	-	-	-	-	-
Захиргааны үйлчилгээний төлбөр	5	5	5	5	5	5	5	5
Бусад зардал	30	-	-	-	-	-	-	-
Хөрөнгө итгэмжлэн удирдах төлбөр	15	15	15	15	15	15	15	15
Үйл ажиллагааны ашиг	(160)	132	25	(74)	(2)	(49)	(103)	(155)
Хадгаламжийн хүүгийн орлого	17	49	85	121	57	74	90	106
Татварын өмнөх ашиг	(143)	182	110	47	55	25	(13)	(49)
Татварын зардал	-	(18)	(11)	(5)	(5)	(2)	-	-
Цэвэр ашиг	(143)	164	121	52	60	27	(13)	(49)
Хуримтлагдсан ашиг	(143)	20	141	193	253	281	268	219

2.2. Үнэт цаас гаргагчийн хөрөнгө буюу багцын тойм ба ХБУЦ-ны төлбөрийн эргэн төлөлтийн найдвартай байдал

"Омни капитал ББСБ" ХХК нь үнэт цаасжуулах хөрөнгийн багцыг тасалбар болгох өдрөөр нийт 426 зээлдэгчийн 6,836,676,535 төгрөгийн үлдэгдэл бүхий 432 зээлийн гэрээг багцалсан ба багцын үзүүлэлт дараах байдалтай байна.

Багцын үндсэн үзүүлэлтүүд

Нийт зээлийн үлдэгдэл	6,836,676,535
Автомашин барьцаалсан	340,030,588
Автомашинны лизинг	4,701,301,615
Бизнесийн зээл	1,489,185,358
ҮХХ, Газар барьцаалсан-Хэрэглээ	306,158,974

Нийт анх олгосон дүн 8,627,257,000

Барьцааны дүн 13,988,020,000

Зээлийн гэрээний тоо 432

Зээлдэгчийн тоо 426

Зээлийн дундаж үлдэгдэл 15,825,640

Хамгийн том 1 зээлийн нийт багцад эзлэх % 2.1%

Хамгийн том 10 зээлийн нийт багцад эзлэх % 9.2%

Хамгийн том 50 зээлийн нийт багцад эзлэх % 12.1%

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-11-15
БҮРТГЭВ-02

2023.11.08 өдөр
БҮРТГЭВ
№01

Жигнэсэн дундаж үзүүлэлт	
Жигнэсэн дундаж хүү	3.03%
Жигнэсэн дундаж зээлийн анхны хугацаа /сар/	33.6
Жигнэсэн дундаж зээлийн үлдсэн хугацаа /сар/	25.9
Жигнэсэн дундаж LTV	60.5%
Багцын зээлийн чанар	100 хувь хэвийн

ХБҮЦ-ны эргэн төлөлтийн баталгаа болох дээрх багц нь 4 төрлийн зээлийн бүтээгдэхүүнээс бүрдэж буй бөгөөд зээлийн барьцаа хөрөнгийн төрлүүд мөн ялгаатай байгаа нь төрөлжүүлэлтийн давуу талыг үүсгэж буй юм.

Хамгийн өндөр дүн бүхий 50 зээлийн нийт багцад эзлэх хувь 12.1% хувь байгаа ба энэ нь үнийн дүнгийн хувьд бүх зээлүүд харьцангуй бага зөрүүтэй болохыг илэрхийлж байна. Дүгнэлт гаргах үеийн байдлаар багцад багтах зээлүүд нь хэвийн төлөвтэй байгаа хэдий ч хугацааны туршид чанар муудах эрсдэл бий. Хэт өндөр үнийн дүн бүхий зээлүүд багцад их орсон тохиолдолд нэг зээлийн чанар муудах үеийн сөрөг нөлөө өндөр байх юм.

Зээлийн багцын дэлгэрэнгүй мэдээлэл дор задлан үзүүлэв.

Зээлийн багцын хугацаа

Зээлийн анхны хугацаа /сар/	Зээлийн тоо		Анх олгосон дүн	
	Тоо	Хувь	Дүн	Хувь
6-15 сар	14	3%	127,600,000	1%
16-30 сар	140	32%	2,110,580,000	24%
31 - дээш	278	64%	6,389,077,000	74%
Нийт	432	100%	8,627,257,000	100%
Хамгийн их сар			48	
Хамгийн бага сар			12	
Жигнэсэн дундаж сар			33.6	

Нийт зээлийн багцын 64 хувийг 31-ээс дээш сарын хугацаатайгаар анх олгож байсан бөгөөд тус зээлийн тоо хамгийн их буюу 278 ширхэг байна. Анх олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа нь 33.6 сар.

Багцын анх олгосон хугацаа

Анх олгосон огноо	Зээлийн тоо		Анх олгосон дүн	
	Тоо	Хувь	Дүн	Хувь
2021	20	5%	415,900,000	5%
2022	190	44%	4,003,000,000	46%
2023	222	51%	4,208,357,000	49%
Нийт	432	100%	8,627,257,000	100%

(Handwritten signature and circular stamp)

(Circular stamp: ОЛИМП АСЦЕТ ХТХ)

2022-2023 онд олгосон зээл нийт багцын 95 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд үлдсэн зээлийн жигнэсэн дундаж хугацаа нь 25.9 сар байна.

Багцын анх олгосон дүн

Анх олгосон дүн /мян.төг/	Зээлийн тоо		Анх олгосон дүн	
	Тоо	Хувь	Дүн	Хувь
0-6,000	32	7%	141,300,000	2%
6,001-12,000	74	17%	727,490,000	8%
12,001-18,000	114	26%	1,756,285,000	20%
18,001-24,000	111	26%	2,306,282,000	27%
24,001-дээш	101	23%	3,695,900,000	43%
Нийт	432	100%	8,627,257,000	100%
Хамгийн их	180,000,000			
Хамгийн бага	1,500,000			
Дундаж	19,970,502			

Зээлийн багцын 7 хувийг 6-аас доос сая төгрөгийн үнийн дүн бүхий зээлүүд бүрдүүлж байгаа бол 24-өөс дээш сая төгрөгийн үнийн дүн бүхий зээл нийт багцын 23 хувийг бүрдүүлж байна.

Багцын харьцаа үзүүлэлт (LTV)

Хувиар	Зээлийн тоо	
	Тоо	Хувь
0-40%	98	23%
41-55%	88	20%
56-65%	70	16%
66-75%	120	28%
76% - дээш	56	13%
Нийт	432	100%

Багцад тавигдах шалгуур дагуу зээл, үнэлгээний харьцаа 85 хувиас хэтрэхгүй байх бөгөөд тус багцын хувьд хамгийн өндөр ЗҮХ нь 80 хувь байна. Зээлийн багцын 87 хувь буюу дийлэнх хэсгийг 75 хувиас бага ЗҮХ-тай зээлүүд бүрдүүлж байна.

Зээлийн хүүгийн тархалт

Хүүгийн хэмжээ	Зээлийн тоо		Анх олгосон дүн	
	Тоо	Хувь	Дүн	Хувь
2-3%	205	47%	4,131,757,000	48%
3.1-4%	227	53%	4,495,500,000	52%
Нийт	432	100%	8,627,257,000	100%
Хамгийн их	3.50			
Хамгийн бага	2.20			
Жигнэсэн дундаж	3.03%			

(Handwritten signature)

УЛААНБААТАР ХОТ
ОМНИАССЕТ
ХХК

РӨНГ
2023-11-15

БҮРТГЭВ-02



Зээлийн багцын 53 хувийг 3.1-4 хувийн хүүтэй зээл эзэлж байгаа бөгөөд хамгийн өндөр зээлийн хүү нь сарын 3.5 хувь, хамгийн бага зээлийн хүү нь 2.2 хувь байна.

Багцын төрөл

Багцын төрөл	Зээлийн тоо		Барьцааны үнэлгээ	
	Тоо	Хувь	Дүн	Хувь
Автомашин	367	85%	10,051,820,000	72%
Газар	7	2%	95,000,000	1%
Үл хөдлөх	55	13%	3,780,700,000	27%
Хөдлөх хөрөнгө	3	1%	60,500,000	0%
Нийт	432	100%	13,988,020,000	100%

Багцад багтсан зээлүүдийн барьцаа нь автомашин, газар, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө байгаа. Зээлийн багцын 85 хувийг автомашин барьцаалсан зээл бүрдүүлж байгаа бол 13 хувийг үл хөдлөх барьцаалсан зээл бүрдүүлж байна.

Дээрх багц бүхий зээлээс Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгох зөвшөөрөл олгосноор 6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий зээлийн багцыг "Омни ассет ТЗК" ХХК шилжүүлэн авна. Тодруулбал, хууль болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан нийт 432 зээлийг үнэт цаас гаргагч өөрийн санхүүгийн тайланд шилжүүлэн авах бөгөөд тус зээлүүдийн үндсэн төлөлт болон хүүгийн төлөлтийн орох мөнгөн урсгалаар ХБҮЦ-ны эргэн төлөлтийг гүйцэтгэнэ.

ХБҮЦ-ыг бүртгэлтэй байх хугацаанд буюу 24 сарын турш 6 тэрбум төгрөгийн зээлийн багцаас нийт 8.9 тэрбум төгрөгийн эргэн төлөлт үнэт цаас гаргагч хүлээн авахаар тооцоологдсон ба хугацааны дундуур зээлийн багц нэмж худалдан авах, сул чөлөөт хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулснаар компанийн орлого нэмэгдэх төлөвтэй байгаа нь үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлөлтийг төлөх чадвартайг илтгэж байна.

Нөгөө талаас зээлийн багцын хувьд нийт 4 төрлийн зээл, түүний барьцаа хөрөнгөөс бүрдэж байна. Үүнд, автомашин барьцаалсан зээл, автомашины лизинг, бизнесийн зээл буюу үл хөдлөх хөрөнгө, газар барьцаалсан буюу хэрэглээний зээл багтаж буй ба ийнхүү төрөлжүүлэлт хийгдсэн нь багцын эрсдэлийг бууруулах үзүүлэлт юм.

Багцын жигнэсэн дундаж LTV харьцаа 60.5 хувь ба барьцаа хөрөнгийн үнэлгээ 13,988,020,000 төгрөг буюу ХБҮЦ-ны хүү болон үндсэн төлөлтийн дүнгээс 2.04 дахин өндөр байгаа нь барьцаа хөрөнгийн дүн хангалттай өндөр түвшинд байгааг илэрхийлнэ.

Зээлийн багцын хугацааны хувьд 31 сараас дээш хугацаатай зээл дийлэнх хэсэг буюу 74 хувийг бүрдүүлж байгаагаас гадна багцын зээлүүд нь 100 хувь хэвийн зээлүүд байхаар холбогдох журмуудаар зохицуулагдсан. Үнэт цаасны хугацаа дуусах хүртэл аливаа зээлийн чанарт өөрчлөлт орсон тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Омни Капитал ББСБ" ХХК нь шалгуур хангасан өөр зээлээр солихоор зохицуулагдсан. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн 2023 оны хагас жилийн байдлаар нийт зээлийн багц нь 26.5 тэрбум төгрөг үүнээс хэвийн зээл 24 тэрбум төгрөг байна. Өөрөөр хэлбэл, үнэт цаас гаргагчийн багцад байгаа зээлийг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зүгээс зээлийн багцыг шинэчлэх хангалттай хэмжээний хөрөнгө байгаа нь үнэт цаасны эрсдэлийг бууруулж буй өөр нэг үндэслэл юм.

Гурав. Үнэт цаасжуулах хэлцлийн тухайд



“Омни ассет ТЗК” ХХК-ийн олон нийтэд санал болгон гаргаж буй Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд дараах мэргэжлийн оролцогч нар, дараах үүрэгтэйгээр оролцсон.

<p>Багцад сонгосон хөрөнгүүд нь шалгуур хангасан эсэхэд хөндлөнгийн этгээд дүгнэлт гаргасан.</p>	<p>Зээлийн шинжилгээ гаргагч “Шонхор аудит үнэлгээ” ХХК Хуулийн фирм “ХаанЛекс Партнерс” ХХН</p>	<ul style="list-style-type: none"> Зээлийн шинжилгээ гаргагч нь ТЗК-д худалдах зээлийн багцад багтаж буй зээлүүд нь Үнэт цаас гаргагчийн баталсан журам дүрмийн хүрээнд олгогдсон болон тасалбар болгон худалдах өдрөөр холбогдох санхүүгийн шаардлага, үзүүлэлтүүдийг хангасан эсэхийг тохиролцсон горимоор шалгаж дүгнэлт гаргасан”. Хуулийн фирм нь зээлийн багцад багтах зээлүүд хуулийн шалгуур хангасан эсэх талаар дүгнэлт гаргахаас гадна СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 10.4 дэх хэсэг, МХБ-ийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 2.5.5 дэх хэсэгт тус тус заасан асуудлаар дүгнэлт гаргасан.
<p>Үйлчилгээ үзүүлэгч нь эргэн төлөлтийг цуглуулж ажиллана.</p>	<p>Үйлчилгээ үзүүлэгч “Омни капитал ББСБ” ХХК</p>	<ul style="list-style-type: none"> ТЗК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр зээлийн багцын эргэн төлөлтийг цуглуулах ажлыг хариуцах бөгөөд гэрээнд заасан нөхцлийн дагуу ТЗК-ийн данс руу зээлийн эргэн төлөлтийг төвлөрүүлнэ.
<p>Үнэт цаасыг СЗХ, МХБ-д бүртгүүлэх, анхдагч арилжааг зохион байгуулах</p>	<p>Андеррайтер “Апекс капитал ҮЦК” ХХК</p>	<ul style="list-style-type: none"> Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”, МХБ-ийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу үнэт цаасны танилцуулга, хүсэлтийг боловсруулж, үнэт цаасыг бүртгүүлнэ Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн дагуу үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад санал болгох.
<p>Хөрөнгийг удирдах</p>	<p>Хөрөнгө итгэжлэн удирдагч “Юү Эй Эф ассет менежмент” ХХК</p>	<ul style="list-style-type: none"> ТЗК-ийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулалтыг бүртгэх, үнэт цаасны хэлцэлтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг гүйцэтгэнэ.

Дөрөв. Үнэт цаасны нөхцөл тогтоосон үндэслэл, үнэт цаасны нөхцөл


4.1. Үнэт цаасны нөхцөл тогтоосон үндэслэл




Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалагдсан ХБҮЦ-ны арилжаа 2021 онд нийт арилжааны 0.3 хувийг бүрдүүлж байсан бол 2022 онд уг үзүүлэлт 17.45 хувь болж өссөн үзүүлэлттэй байна. Нөгөө талаас инфляц болон бодлогын хүүгийн түвшин өндөр байгаа нь банкны хадгаламжаас өндөр өгөөжтэй, хууль эрх зүйн хувьд эрх ашгийг хамгаалсан, тогтмол хүүтэй бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ нэмэгдэх гол шалтгаан болж буй.

Иймээс үнэт цаасны хүүгийн түвшинг тогтоохдоо банкны хадгаламж болон идэвхтэй арилжаалагдаж буй ижил төрлийн бүтээгдэхүүн болох нээлттэй бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хугацаа, хүүгийн түвшинтэй харьцуулан үзэв.

Банкны хадгаламжийн хүүгийн түвшин



Нээлттэй бондын хүүгийн түвшин:



ХБҮЦ-ны хүүгийн түвшин:



2023-11-15



Зах зээлд идэвхтэй арилжаалагдаж буй нээлтэй бонд болон ХБҮЦ-ны хувьд ихэнх нь 24 сарын хугацаатай бөгөөд хугацааны дундуур үндсэн төлбөрийг хуваан төлөхөөр тодорхойлогдсон байна.

Иймээс өмнө гаргасан ХБҮЦ-ны гаргасан жишгээр буюу 24 сарын хугацаатай, хүүгийн төлбөр улирал тутам, үндсэн төлбөр 12 сард 1 удаа тэнцүү хуваан төлхөөр тогтоосон.

4.2. *Омни ассет ХБҮЦ-ны нөхцөл*

“Омни ассет ТЗК” ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг дараах нөхцөлтэйгээр Монголын хөрөнгийн бирж ХК-аар дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгож байна.

Үнэт цаас гаргагч	“Омни ассет ТЗК” ХХК;
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	“Омни капитал ББСБ” ХХК;
Үнэт цаасны төрөл	Зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас;
Үнэт цаасны тоо ширхэг	60,000 ширхэг ;
Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ	100,000 төгрөг;
Үнэт цаасны нийт дүн	6,000,000,000 төгрөг;
Үнэт цаасны хугацаа	24 сар
Үнэт цаасны хүү	19.6 хувь (жилийн)
Хүү төлөгдөх хугацаа	Улирал тутам
Үндсэн төлбөр төлөгдөх хугацаа	12 сард 1 удаа
Үнэт цаасны төлбөр төлөгдөх эх үүсвэр	Хөрөнгийн багцын зээлийн үндсэн болон хүүгийн орлого
Үнэт цаасны хүүд ногдох татвар	Хувь хүн болон ААН-д хүүгийн орлогод ногдох дүнгээс 5 хувь
Үнэт цаасны хадгалалт	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн данс
Арилжаалах зах зээл	Монголын хөрөнгийн бирж ХК

Үнэт цаас эзэмшигчийн хувьд жилийн 19.6 хувийн хүүтэй 24 сарын хугацаатай ХБҮЦ-ыг 24 сарын хугацаанд бүрэн эзэмшсэнээр татварын өмнөх өгөөж 29.93% байх бол татварын дараах бодит өгөөж 27.93% -тай байхаар байна.

Андеррайтерийн зүгээс дээр дурдсан судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр Омни ассет ХБҮЦ -ыг олон нийтэд санал болгон танилцуулах боломжтой гэж үзэж, андеррайтерийн дүгнэлт гаргалаа.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ЛХАМДОЛГОР

ХУУЛЬ, АНДЕРРАЙТЕРИЙН АЛБА

П.СЭЛЭНГЭ



2023-11-15

БҮРТГЭВ “ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах,
түүний нөхцөлийг тогтоох тухай

2023 оны 08 сарын 23-ны өдөр

№ ТУЗ-23/013

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11.2 дахь хэсэг, Компанийн дүрмийн 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн “Омни Ассет ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Омни Ассет ТЗК” ХХК нь 6,000,000,000 /зургаан тэрбум төгрөг/ төгрөгийн нэг ширхэг нь 100000 /нэг зуун мянган төгрөг/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 60,000 /жаран мянга/ ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ерөнхий нөхцөлийг энэ тогтоолын Хавсралтаар баталсугай.
3. Батлагдсан нөхцөлийн дагуу үнэт цаасны танилцуулгыг бэлтгэж, Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох байгууллагад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлэн, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгосугай.
4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг “Омни Ассет ТЗК” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



А.БАТБОЛД





“Омни ассет ТЗК” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-23/013 тоот тогтоолын Хавсралт



“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ НӨХЦӨЛ

Үнэт цаас гаргагч	“Омни ассет ТЗК” ХХК
Анхны үүрэг гүйцэтгэгч	“Омни капитал ББСБ” ХХК
Үнэт цаасны төрөл	Зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
Үнэт цаасны тоо ширхэг	60,000 ширхэг
Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
Үнэт цаасны нийт дүн	6,000,000,000 төгрөг
Хүү төлөгдөх хугацаа	Улирал тутам
Үнэт цаасны төлбөр төлөгдөх эх үүсвэр	Хөрөнгийн багцын зээлийн үндсэн болон хүүгийн орлого
Үнэт цаасны хадгалалт	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн данс
Арилжаалах зах зээл	Монголын хөрөнгийн бирж ТӨХК

ХБҮЦ-ны хугацаа	24 сар
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр төлөх давтамж	Улирал тутам
ХБҮЦ-ны хүүгийн жилийн хувь /татварын өмнөх/	19.60%
ХБҮЦ-ны хүүгийн жилийн хувь /татварын дараах/	18.62%
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр /татварын өмнөх/	(Тоо ширхэг * Нэрлэсэн үнэ * Хүүгийн жилийн хувь)/Хүүгийн төлбөр төлөх давтамж
ХБҮЦ-ны үндсэн төлбөр	Жилд 1 удаа



2023-11-15

БҮРТГЭВ-02

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулга батлах тухай

2023 оны 08 сарын 23-ны өдөр

№ ТУЗ-23/015

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. “Омни ассет ТЗК” ХХК-аас Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны танилцуулгыг хавсралтаар баталсугай.
2. Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын 5.3-т заасны дагуу “Омни ассет ТЗК” ХХК-ийн ТУЗ дарга /А.Батболд/, ТУЗ-ийн гишүүд /С.Нина, Х.Хэрлэн/ нар нь үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөвийг хариуцан баталгаажуулсугай.
3. “Омни ассет ТЗК” ХХК-ийг төлөөлөн танилцуулга хуудсанд гарын үсэг зурах эрхийг ТУЗ-ийн дарга /А.Батболд/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  А.БАТБОЛД



“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК (“КОМПАНИ”)-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 08 сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Хурлын ирц: ТУЗ-ийн гишүүн С.Нина
ТУЗ-ийн гишүүн Х.Хэрлэн
ТУЗ-ийн гишүүн А.Батболд нарын 100%-ийн ирцтэйгээр хуралдав.

Хурал болсон газар: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сэнтрал тауэр оффис,
712 тоот хурлын өрөө

Хурал эхэлсэн, дууссан: 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдөр, лхагва гариг, 09:00 цагт эхэлж, 14:00 цагт дуусав.

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. “Омни ассет ТЗК” ХХК-ийн “Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам”, “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”, “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам” болон “Үнэт цаасны төлбөр төлөх, төлбөр цуглуулах журам”-ыг батлах тухай;
2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүний нөхцөлийг тогтоох тухай;
3. Хөрөнгийн багц худалдан авах, хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг батлах тухай;
4. Үйлчилгээ үзүүлэгч, Захиргааны үйлчилгээ үзүүлэгч этгээдийг сонгох, тэдгээртэй гэрээ байгуулахыг зөвшөөрөх тухай;
5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулга батлах тухай.

Хэлэлцсэн нь:

Хэлэлцэх асуудал № 1:

“Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам”, “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”, “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам” болон “Үнэт цаасны төлбөр төлөх, төлбөр цуглуулах журам”-ыг тус тус батлахаар шийдвэрлэв.

Хэлэлцэх асуудал № 2:

“Омни ассет ТЗК” ХХК нь “Омни капитал ББСБ” ХХК-аас 6,000,000,000 /зургаан тэрбум/ төгрөгийн үнэ бүхий Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүний нөхцөлийг батлах эсэхийг хэлэлцэж, “Омни капитал ББСБ” ХХК-аас 6,000,000,000 /зургаан тэрбум/ төгрөгийн үнэ бүхий зээлийн хөрөнгө худалдан авч, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахыг зөвшөөрөв.


Хэлэлцэх асуудал № 3:

Хөрөнгийн багц худалдан авах, шалгуур үзүүлэлт батлах болон түүнтэй холбоотой гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай асуудал нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн С.Нинагийн хувьд сонирхлын зөрчилтэй хэлцэл мөн байх тул уг хэлцлийн талаар шийдвэр гаргалтад оролцохгүй болохоо мэдэгдэв. Иймд хуралд оролцсон сонирхлын зөрчилгүй гишүүд санал нэгтгэйгээр зөвшөөрч шийдвэрлэв.

Хэлэлцэх асуудал № 4:

Үйлчилгээ үзүүлэгч, Захиргааны үйлчилгээ үзүүлэгч этгээдийг сонгох, тэдгээртэй гэрээ байгуулахыг зөвшөөрөх тухай асуудлууд нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн С.Нинагийн хувьд сонирхлын





зөрчилтэй хэлцэл мөн байх тул уг хэлцлийн талаар шийдвэр гаргалтад оролцохгүй болохоо мэдэгдэв. Иймд хуралд оролцсон сонирхлын зөрчилгүй гишүүд санал нэгтгэйгээр зөвшөөрч шийдвэрлэв.

БҮРТГЭВ-02
Хэлэлцэх асуудал № 5:

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах танилцуулгыг батлах эсэхийг хэлэлцэж, танилцуулгыг батлах талаар санал нэгтгэйгээр зөвшөөрч шийдвэрлэв.

Шийдвэрлэсэн нь:

- “Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам”, “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”, “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам” болон “Үнэт цаасны төлбөр төлөх, төлбөр цуглуулах журам”-ыг тус тус батлахыг зөвшөөрөв.
- “Омни ассет ТЗК” ХХК нь 6,000,000,000 /зургаан тэрбум/ төгрөгийн нэг ширхэг нь 100,000 /нэг зуун мянган/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 60,000 /жаран мянган/ ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрөв.
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ерөнхий нөхцөлийг ТУЗ-23/013 тоот тогтоолын Хавсралтаар батлав.
- Компанийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох “Омни капитал ББСБ” ХХК-аас 6,000,000,000 /зургаан тэрбум/ төгрөгийн үнэ бүхий зээлийн багц бүхий хөрөнгө худалдан авахаар зөвшөөрсүгэй.
- Хөрөнгийн багцыг үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл, автомашин барьцаалсан зээлээс бүрдүүлэхийг зөвшөөрөв.
- Хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг ТУЗ-23/012 тоот тогтоолын Хавсралт №1, 2-оор тус тус батлав.
- Хөрөнгийн багц худалдан авахтай холбоотойгоор “Омни капитал ББСБ” ХХК-тай Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ болон Фидуцийн барьцааны гэрээг байгуулахыг ТУЗ-ийн дарга /А.Батболд/-д зөвшөөрөв.
- Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд заасан нөхцөлийн дагуу ТУЗ-23/012 тоот тогтоолын Хавсралт №1 болон №2-д заасан шалгуурыг нэгэн зэрэг хангаж байгаа хөрөнгийг шилжүүлэн авахыг ТУЗ-ийн дарга /А.Батболд/-д үүрэг болгов.
- Компанийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Компанийн толгой компани болох “Омни капитал ББСБ” ХХК-ийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан Үйлчилгээ үзүүлэгч бөгөөд Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах Захиргааны үйлчилгээ үзүүлэгч этгээдээр сонгохыг зөвшөөрөв.
- Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ, Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ, Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээг холбогдох талуудтай байгуулах бүрэн эрхийг ТУЗ-ийн дарга А.Батболдод олгов.
- “Омни ассет ТЗК” ХХК-аас Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны танилцуулгыг хавсралтаар батлав.
- Танилцуулга хуудсанд Компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг ТУЗ-ийн дарга /А.Батболд/-д олгов.


Хурлын тэмдэглэлийг баталгаажуулсан:

ТУЗ-ийн дарга А.Батболд: _____

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ТУЗ-н гишүүн С.Нина: _____

ТУЗ-н гишүүн Х.Хэрлэн: _____





Хувьцаа эзэмшигчийн 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн ХЭХ-22/001 тоот шийдвэрийн хавсралтаар батлав.



“ОМНИ АССЕТ ТЗК” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “Омни ассет ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх) нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах зориулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.
- 1.2. Компанийн оноосон нэр:
 - Монгол хэлнээ : “ОМНИ АССЕТ ТЗК” ХХК
 - Англи хэлнээ: “OMNI ASSET SPC” LLC.
- 1.3. Компанийн оршин байгаа газар:
 - Улсын нэр: **Монгол Улс**
 - Аймаг, нийслэлийн нэр: **Улаанбаатар хот**
 - Сум, дүүргийн нэр: **Сүхбаатар дүүрэг**
 - Баг, хороо, хорооллын нэр: **8-р хороо**
 - Хашаа, байшин, хаалганы дугаар: **Монгол ньюс тауэр, 402 тоот**
 - Харилцах утасны дугаар: **99795115**
- 1.4. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, түүний төлөөлөл нь дараах этгээд байна. Үүнд:

№	Нэр	Регистрийн дугаар	Хаяг/ Утасны дугаар	Хувьцаа эзэмшигчийн төлөөлөл
1	“Омни капитал ББСБ” ХХК	6075657	Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр оффис, 712-713 тоот Утас: 7277-8282	“Омни капитал ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Э.Пүрэвсүрэн

- 1.5. Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг, хариуцлага хүлээх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллана.
- 1.6. Компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь хугацаагүй байх бөгөөд энэхүү дүрмийн 8 дугаар зүйлд заасан үндэслэл тохиосон нөхцөлд даруй татан буугдана.
- 1.7. Компани нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу аливаа гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахгүй бөгөөд үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа үйлчилгээг хуульд заасан оролцогчидтой гэрээ байгуулах замаар хэрэгжүүлүүлнэ.

ХОЁР. КОМПАНИЙН ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1. Компани нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу зөвхөн баталгаат үнэт цаас гаргах зорилготой байх ба эрхлэх үйл ажиллагаа нь автомашин барьцаалсан зээлийн хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгө, хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгө (цаашид “Хөрөнгө” гэх) худалдан авах, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, үнэт цаасны эргэн төлөлтийг хийх болон тэдгээрийн дагуу хийгдэх бусад үйл ажиллагаа байна.
- 2.2. Компанийн зорилго: Компани нь зээлийн хөрөнгийг багцлан худалдан авч, тэдгээрийг



2023-11-15

БҮРТГЭВ-02



БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000271976

2023.05.04

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011851823

/ Хувийн хэргийн дугаар /

8356327

/ Регистрийн дугаар /

Омни ассет

Хязгаарлагдмал хариуцлагатай
компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

23/01

/ дугаар /

2023.04.25

/ он, сар, өдөр /

82990

/ Код /

Бизнесийн зөвлөгөө өгөх

/ Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

10,000.00

/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, 11-р хороолол, Н Тауэр оффис 402 тоот, Утас1: 72778282,
Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР

/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ

/ тэмдэг /



С.БААСАНДУЛАМ

/ гарын үсэг /



Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл



Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Чүлтэмжамц овогтой Даваасүрэн-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2023.05.04	С.Баасандулам
2	Аръяасүрэн овогтой Батболд-г ТУЗ-ийн дарга-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2023.07.06	Ш.Очирсүрэн
3	Гишүүн 3 нэмэгдэж 0 хасагдаж Гишүүн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2023.07.06	Ш.Очирсүрэн
4	77300 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа шинээр бүртгэв. 82990 Бизнесийн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг хассаныг бүртгэв.	2023.07.06	Ш.Очирсүрэн



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000271976



Хувьцаа эзэмшигчийн 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн ХЭХ-22/001 тоот шийдвэрийн хавсралтаар батлав.



“ОМНИ АССЕТ ТЗК” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ


- 1.1. “Омни ассет ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх) нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах зориулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.
- 1.2. Компанийн оноосон нэр:
 - Монгол хэлнээ : “ОМНИ АССЕТ ТЗК” ХХК
 - Англи хэлнээ: “OMNI ASSET SPC” LLC.
- 1.3. Компанийн оршин байгаа газар:
 - Улсын нэр: Монгол Улс
 - Аймаг, нийслэлийн нэр: Улаанбаатар хот
 - Сум, дүүргийн нэр: Сүхбаатар дүүрэг
 - Баг, хороо, хорооллын нэр: 8-р хороо
 - Хашаа, байшин, хаалганы дугаар: Монгол ньюс тауэр, 402 тоот
 - Харилцах утасны дугаар: 99795115
- 1.4. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, түүний төлөөлөл нь дараах этгээд байна. Үүнд:

№	Нэр	Регистрийн дугаар	Хаяг/ Утасны дугаар	Хувьцаа эзэмшигчийн төлөөлөл
1	“Омни капитал ББСБ” ХХК	6075657	Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр оффис, 712-713 тоот Утас: 7277-8282	“Омни капитал ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Э.Пүрэвсүрэн


- 1.5. Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг, хариуцлага хүлээх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллана.
- 1.6. Компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь хугацаагүй байх бөгөөд энэхүү дүрмийн 8 дугаар зүйлд заасан үндэслэл тохиосон нөхцөлд даруй татан буугдана.
- 1.7. Компани нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу аливаа гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахгүй бөгөөд үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа үйлчилгээг хуульд заасан оролцогчидтой гэрээ байгуулах замаар хэрэгжүүлүүлнэ.

ХОЁР. КОМПАНИЙН ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1. Компани нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу зөвхөн баталгаат үнэт цаас гаргах зорилготой байх ба эрхлэх үйл ажиллагаа нь автомашин барьцаалсан зээлийн хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгө, хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгө (цаашид “Хөрөнгө” гэх) худалдан авах, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, үнэт цаасны эргэн төлөлтийг хийх болон тэдгээрийн дагуу хийгдэх бусад үйл ажиллагаа байна.
- 2.2. Компанийн зорилго: Компани нь зээлийн хөрөнгийг багцлан худалдан авч, тэдгээрийг



өөрийн хөрөнгө болон санхүүгийн тайлан тэнцэлд тусгах бөгөөд худалдан авсан зээлийн хөрөнгийн багцын төлбөрийг төлөх үүднээс зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргана.



- 2.3. **БҮРТГЭВ.02** Компани нь энэхүү дүрмийн 2.1-т заасан зорилго болон хуульд нийцүүлэн дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:
- 2.3.1. Зээлийн хөрөнгө худалдаж авах;
 - 2.3.2. Зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах;
 - 2.3.3. Зээлийн хөрөнгө худалдаж авах болон зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотойгоор гэрээг байгуулах;
 - 2.3.4. Баталгаат үнэт цаас гаргах, түүний төлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх болон бусад гэрээг байгуулах;
 - 2.3.5. Гэрээ болон компанийн байгуулсан бусад баримт бичигт заасан компанийн аливаа үүргийг гүйцэтгэх, эрх болон эрхээ хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;
 - 2.3.6. Бизнесийн үйл ажиллагааны явцад үүсэх хүүгийн болон бусад санхүүгийн эрсдэлийг удирдах үүднээс дериватив болон валютын ханшийн гэрээ ашиглах;
 - 2.3.7. Мөнгөн хөрөнгийг Санхүүгийн зохицуулах хороо ("Хороо" гэх)-оос хориглоогүй санхүүгийн хэрэгсэлд эрсдэл үр өгөөжийг тооцоолж зохистой түвшинг харгалзан байршуулах;
 - 2.3.8. Хууль болон дүрэмд заасан бусад.
- 2.4. Компанийн хориглох үйл ажиллагаа:
- 2.4.1. Энэхүү дүрмийн 2.3-д зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэх;
 - 2.4.2. Баталгаат үнэт цаасыг худалдсанаас олсон орлогоос эргүүлэн төлөх нөхцөлтэйгөөр бусдаас зээл авах;
 - 2.4.3. Хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулах;
 - 2.4.4. Хорооны зөвшөөрөлгүйгээр Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах
 - 2.4.5. Компанийн гаргасан баталгаат үнэт цаас төлөгдөж дуусаагүй байх үед Хорооноос зөвшөөрснөөс бусад тохиолдолд өөрийн хувьцаа эзэмшигчид ногдол ашиг төлөх, эсхүл аливаа бусад хэлбэрээр ногдол ашиг хуваарилах;
 - 2.4.6. Үнэт цаас гаргах өргөдөл, үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зардлыг төлөхтэй холбоотой хууль зөрчиж, хөрөнгө оруулагчийн эрх ашигт хохиролтой гэрээ хэлцэл байгуулж, эсхүл зах зээлийн ханшаас өндөр үнэ тогтоох;
 - 2.4.7. Хууль, холбогдох журамд заасан бусад.

ГУРАВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

- 3.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 10,000,000 (арван сая) төгрөг ба нэг бүр нь 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 10,000 (арван мянган) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.
- 3.2. Компанийн хувьцаа эзэмшигч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Компанийн эсрэг өөрийн гаргасан шаардлага, эсхүл түүний өмнө Компанийн хүлээх аливаа үүрэг, хариуцлагатай холбоотойгоор ямар нэгэн хууль зүйн маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх, Компанид хариуцлага хүлээлгэхээр санал гаргах буюу санал өгөх, эсхүл Дүрмийн 8.2-р заалтад зааснаас бусад тохиолдолд Компанийг татан буулгахаар хүсэлт гаргаж үл болно.
- 3.3. Компани болон Компанийн хувьцаа эзэмшигч нь Хорооноос зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах, эсхүл шилжүүлэх эрхгүй.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Компани нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хуулийн этгээдийн эрхийг эдэлж, үүргийг хүлээх ба Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай



- 4.2. Компани нь өөрийн бэлгэдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий гамга тэмдэг хэрэглэнэ.
- 4.3. Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуульд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана. Энэхүү үүргээ гуравдагч этгээдтэй гэрээ байгуулах замаар гуравдагч этгээдээр гүйцэтгүүлнэ.
- 4.4. Компани нь Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу татвар ногдох орлогоо тодорхойлж, албан татвараа сайн дураар төлнө.
- 4.5. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.
- 4.6. Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд тус тус заасны дагуу Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилон ажиллуулна.
- 4.7. Компани нь Компанийн тухай хуульд зүйлд заасан баримт бичгийг хадгалах, хувьцаа эзэмшигчдийн шаардлага болон бусад эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах ба тэдгээрийг баримт бичгийг архивд шилжүүлнэ.

ТАВ. КОМПАНИЙН ХАРИУЦЛАГА

- 5.1. Компани нь улсын бүртгэлд бүртгүүлэхээс өмнө иргэний эрх зүйн харилцаанд бие даан оролцохыг хориглоно. Энэхүү заалтыг зөрчсөний улмаас бусдад гэм хор учруулсан бол буруутай этгээд гэм хорыг арилгана.
- 5.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигч нь Баталгаат үнэт цаасаар хүлээсэн төлбөрийн үүрэг бүрэн төлөгдөж дуусах хүртэлх хугацаанд тусгай зориулалтын компанийн хөрөнгөтэй холбоотой шаардлага гаргах эрхгүй болно.

ЗУРГАА. КОМПАНИЙН УДИРДЛАГА

- 6.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид “ХЭХ” гэх/ байх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ болон бусад асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна. Компанийн ХЭХ-ын бүрэн эрхийг Хувьцаа эзэмшигчийн ТУЗ хэрэгжүүлнэ.
- 6.2. Компанийн ХЭХ-ийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ шийдвэр гарснаас хойш 10-аас доошгүй хоногийн дараа хуралдуулна.
- 6.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөө цагт компанийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл хэрэгжүүлнэ.
- 6.4. Компанийн ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг удирдаж, хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй байна. ТУЗ нь өөрийн үйл ажиллагаандаа ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баримтална.
- 6.4.1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 3 гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна.
- 6.4.2. Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журамд заасан шаардлагыг хангасан байна.





6.4.3. Компанийн ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлсөн, эсхүл аливаа шалтгаанаар гишүүний эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр нөхөн сонгоно.

2023.11.15
6.4.4. Компанийн ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 6.4.4.1. Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах;
- 6.4.4.2. Компанийн хөрөнгийг хадгалж, хамгаалах;
- 6.4.4.3. Эрх бүхий байгууллагаас Хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр Компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх,
- 6.4.4.4. Компанийн хөрөнгийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшил, удирдлагад шилжүүлэх. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулснаас хойш хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.
- 6.4.4.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх үүргийн дагуу хяналт тавих,
- 6.4.4.6. Энэхүү Дүрэмд заасан Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах,
- 6.4.4.7. Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллаас бусад төлбөр, зардлын төсвийг батлах,
- 6.4.4.8. Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, шаардлагатай бол тэдгээрийг солих санал гаргах,
- 6.4.4.9. Компани нь өөрийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр хүлээсэн үүргээ чанд мөрдөж, гүйцэтгэж байгаад хяналт тавьж, хангуулах,
- 6.4.4.10. Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хэрэгжүүлэх,
- 6.4.4.11. Компанийн хөрөнгийн бүртгэлийг хянаж, хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалж ажиллах;
- 6.4.4.12. Компанийн нээлттэй болон хаалттай хүрээнд санал болгон гаргасан үнэт цаасны танилцуулгын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;
- 6.4.4.13. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, хөрөнгө оруулагчид хүргэх тогтоосон болон тухай бүр мэдээлэх мэдээллийн үнэн зөв, баталгаат байдалд хяналт тавьж ажиллах;
- 6.4.4.14. Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, аудитор болон хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг томилох, солих, Компанийг төлөөлөн тэдгээртэй гэрээ байгуулах;
- 6.4.4.15. Хөрөнгийг бүртгэлээс хасах, нэмэх.
- 6.4.4.16. Компанийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Хороо болон Монголын Хөрөнгийн биржийн журам болон Компанийн дүрэм, Компанийн дотооддоо дагаж мөрдөж буй журам, зааварт заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.
- 6.4.5. Компанийн ТУЗ нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн даргын санаачилгаар, эсхүл ТУЗ-ийн гишүүдийн олонхийн санал, эсхүл Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санал, шаардлагаар ээлжит бус хурлыг хуралдуулж болно.
- 6.4.6. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор хурлын ирцийг бүрдүүлэх ба ТУЗ-ийн шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн санал нэгтэй шийдвэрээр батлагдана.
- 6.4.7. ТУЗ нь эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно. ТУЗ нь эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлаар телеконференци, видеоконференци хийх замаар саналаа солилцон, хэлэлцэж, болно. Эчнээ санал хураалтаар шийдвэр гаргах үед саналаа



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-11-15
БҮРТГЭЭГЧ

СЭХ
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

саналын хуудсаар өгнө. Саналын хуудсыг цахим хэлбэрээр хүргүүлж болох ба энэ тохиолдолд саналын хуудсанд ТУЗ-ийн гишүүд нь тоон гарын үсэг зурсан байна.

6.4.8. ТУЗ-ийн гишүүн нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд тооцогдох бөгөөд тус хуулийн 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

- 6.4.9. Компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийг төлөөлж аливаа баримт бичигт ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна.
- 6.4.10. ТУЗ болон түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь Компани Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан үеэс эхлэн Компани татан буугдах буюу ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан үндэслэлээр бүрэн эрхийг дуусгавар болгох хүртэл хугацаанд үргэлжилнэ.

ДОЛОО. КОМПАНИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 7.1. ТУЗ нь Хорооноос баталсан журамд заасан шаардлагад нийцсэн Хөндлөнгийн аудиторыг сонгоно.
- 7.2. Компанийн бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Хөрөнгө итгэмжлэн удирдагч компанитай байгуулсан гэрээний үндсэн дээр хариуцах ба үнэн зөв тайланг Санхүүгийн тайланг компанийн ТУЗ-д заавал танилцуулна.
- 7.3. Компани нь Санхүүгийн тайланг хувьцаа эзэмшигч болон хуулиар шаардсан эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.
- 7.4. Компани нь санхүүгийн жил тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл байна.
- 7.5. Компани нь нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг болон бүртгэлийг хадгалж, хувьцаа эзэмшигч болон хуулиар шаардсан эрх бүхий бусад этгээдэд танилцуулахаар санхүүгийн тайланг бэлтгэнэ.
- 7.6. Компани нь санхүүгийн тайлангаа бүртгэх, хөтлөх, тайлагнахдаа Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг баримтлана.
- 7.7. Компанийн бэлтгэсэн нягтлан бодох бүртгэл хөтлөлт болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.

НАЙМ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

- 8.1. Зээлийг багцлах болон худалдан авсны үндсэн дээр зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах, худалдахтай холбоотой аливаа эрсдэл нь Компани болон анхны үүрэг гүйцэтгүүлэгч, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгө оруулагч болон тухайн гэрээний тал болсон бусад этгээд бүртэй байгуулсан гэрээ болон бусад баримт бичгээр зохицуулна.

ЕС. КОМПАНИЙГ ТАТАН БУУЛГАХ

- 9.1. Компанийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан үндэслэлээр татан буулгана. Хорооноос шийдвэрлэснээс бусад дараах тохиолдолд ХЭХ-ын шийдвэрээр Компанийг татан буулгана. Үүнд:
 - 9.1.1. Компани үүсгэн байгуулагдсан зорилгоо бүрэн биелүүлж, Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг бүрэн төлж дууссан;



- 9.1.2. Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн түүний анхны үнийн 20 хувьд хүрсэн тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон багцыг буцаан худалдсан;
- 9.1.3. Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан.
- 9.2. Компанийг татан буулгахтай холбоотой асуудлыг Компани татан буулгах ажиллагааны журмаар нарийвчлан зохицуулна.

АРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 10.1. Энэхүү дүрмийг Монгол хэлээр хоёр (2) хувь үйлдэв.
- 10.2. Компанийн дүрэм нь Хорооноос Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зөвшөөрөл олгож, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.
- 10.3. Энэхүү дүрмийг батлах, түүний хүчин төгөлдөр байдал, дүрмийг хэрэгжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах зэрэг тус дүрэмтэй холбоотой асуудлууд Монгол Улсын холбогдох хуулиар зохицуулагдана.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

“ОМНИ КАПИТАЛ ББСБ” ХХК -ийн
нэрийн өмнөөс гарын үсэг зурсан:


ТУЗ-ийн дарга Э.Пүрэвсүрэн

2023-11-15

БҮРГ
№



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 315/58

2023 оны 06 сарын 30
... оны ... сарын ... өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 сарын 30 өдрийн 256 дугаар тогтоолоор

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК

-д

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах

үйл

ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА
“Тамга”



Д.БАЯРСАЙХАН

Энэхүү гэрчилгээ нь
хавсралтын хамт хүчинтэй

2023 -11- 15
БҮРТГЭВ-02

Үр дүнгийн тайлан



“Омни ассет ТЗК” ХХК-д

Бид “Омни ассет” ХХК-ийн төлөвлөж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотойгоор 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан гэрээгээр харилцан тохиролцсон горимуудыг хийж гүйцэтгэлээ. Горимын хүрээнд “Омни ассет” ХХК-ийн багцад орсон зээлүүдийг шинжилж, тэдгээрээс олонлогоо төлөөлөхүйц зээлүүдийг түүвэрлэж, сонгогдсон зээлүүд нь шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг холбогдох баримт бичигт тулгуурлан шалгасан болно.

Бид энэхүү гэрээт ажлыг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай” журмын хүрээнд, Холбогдох Үйлчилгээний Олон Улсын Стандарт 4400, Тохиролцсон горимоор ажил гүйцэтгэх гэрээний дагуу хийж гүйцэтгэлээ.

Дээрх горимууд нь Аудитын Олон Улсын Стандарт, Нягтлах Гэрээт Ажлын Олон Улсын Стандартын дагуу хийгдэх аудит эсвэл нягтлах ажил биш бөгөөд зөвхөн түүврээр авсан зээлүүдэд л зөвхөн анхаарал хандуулсан бөгөөд ямар нэг материаллаг мэдээлэл орхигдсон эсэх талаар баталгаа илэрхийлээгүй болно.

Хэрэв Аудитын Олон Улсын Стандарт эсвэл Нягтлах Гэрээт Ажлын Олон Улсын Стандартын дагуу зээлүүдэд нэмэлт горим эсвэл аудит болон нягтлах ажил гүйцэтгэсэн бол та бүхэнд тайлагнахуйц бусад асуудлууд бидний анхааралд өртөх магадлалтай байж болно.

Бидний бэлтгэсэн тайлан нь зөвхөн дээр дурьдсан зориулалтаар бэлтгэгдсэн бөгөөд бусад этгээдтэй хуваалцах зорилгоор ашиглагдахгүй болно. Энэхүү тайлан нь зөвхөн тодорхойлсон зээл болон түүхэн мэдээллийн сантай холбоотой бөгөөд санхүүгийн тайлан болон бусад санхүүгийн мэдээлэлтэй хамааралгүй болно.

Гүйцэтгэсэн:

“Шонхор үнэлгээ Аудит” ХХК



Захирал Д.Шийрээв,



2023 -11- 15

1.2 Шалгуур үзүүлэлтүүд

БҮРТГЭВ-02



Зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур

- Тасалбар болгох өдрөөр хэвийн ангилагдсан зээл байх
- Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх;
- Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх;
- Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх;
- Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 85%-с хэтрэхгүй байх.

Зээлдэгчид тавигдах шалгуур

- Монгол Улсын нутаг дэвсгэрт тогтвортой оршин суудаг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байх;
- Банк, санхүүгийн байгууллагад чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;
- Өр орлогын харьцаа (ӨОХ) нь татварын дараах орлогын 80%-с илүүгүй байх;
- Зээл олгосон шалгуур нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо мөрддөг шалгуур үзүүлэлтэд нийцсэн байх;

Худалдах жагсаалтад багтсан мэдээллийн тасалбар болгосон өдөр нь 2023 оны 8 дугаар сарын 22-ны өдөр болно.

1.3 Эх олонлог болон түүвэрлэлт

Сонголт:

2023 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар ирүүлсэн 6,836,676.53 мян.төгрөгийн дүн бүхий 432 зээлийн жагсаалтанд 95%-ийн итгэлцлийн түвшин, 5% -ийн хүлээгдэж буй алдааны түвшин, 5%-ийн алдааны хязгаар гэсэн параметрт үндэслэн санамсаргүй түүврийн аргаар сонгоход хамгийн багадаа 16 зээл сонгохоор гарч байна. Бидний хувьд зээлийн бүтээгдэхүүний ангилал, тэдгээрийн тухайн болон нийт багцдаа эзлэх хувийн жин , хугацаа, хүүний болон зээлийн дүн зэргийг харгалзан 58 зээлэнд горим гүйцэтгэхэд нийт олонлогоо хангалттай төлөөлж чадна гэж үзэж сонгон авсанаар түүвэрт 1,065,097.92 мян.төгрөгийн үлдэгдэл дүн бүхий 58 зээлийг хамруулан нягтлах ажил хийж гүйцэтгэлээ. Түүврийг сонгоходоо “Омни ассет” ХХК-тай тохиролцсоны дагуу дараах үзүүлэлтүүдийг харгалзсан.

Шалгуур үзүүлэлт 1: Багц нь 4 төрлийн зээлийн бүтээгдэхүүнд хуваагдаж байгаа тул зээлийн бүтээгдэхүүн тус бүрээс түүвэрт оруулах

Шалгуур үзүүлэлт 2: Багцад орсон зээлүүдийн хугацаа, тухайн багцдаа эзэлж буй хувийн жинг харгалзан урт, дундаж, богино хугацаатай зээл тус бүрээс сонгох



Шалгуур үзүүлэлт 3: Багцын хүүгийн түвшинг суурь болгож тухайн багцдаа эзэлж буй хувийн жинг харгалзан өндөр, дундаж бага дүнтэй зээл тус бүрээс сонгох,

Шалгуур үзүүлэлт 4: Автомашины лизинг, автомашин барьцаалсан зээл нь нийт зээлийн багцын 68.8%-ийг эзэлж байгаа тул тэдгээр зээлийн бүтээгдэхүүнээс төлөөлж чадах хувиар хамруулах зарчмыг баримталсан.

Хүснэгт №1

мян.төг

Итгэлцлийн түвшин	95%
Хүлээгдэж буй алдааны түвшин	5%
Алдааны дээд хязгаар	5%
Олонлог	6,836,676.53
Түүврийн интервал	1,065,097.92
Хамгийн бага шаардагдах түүврийн тоо	16
Нийт түүврийн хэмжээ	58
Түүвэр дэх хамгийн өндөр үлдэгдэл дүнтэй зээл	61,784.42
Түүвэр дэх хамгийн бага үлдэгдэл дүнтэй зээл	1,259.1



Хоёрдугаар хэсэг: Түүвэр эзэлүүдэд гүйцэтгэсэн горим, үр дүн, шалгуур үзүүлэлт хангасан байдал

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-11-15
БҮРТГЭВ

СЗХ
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ
№ 31
SHONKBOB
Bastimale-8-oidit

Хүснэгт №2

Захиалагчийн шалгуурууд	Тохиролцсон горим	Шалгуур хангасан эсэх	Гүйцэтгэсэн горимын үр дүн
Зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур			
Тасалбар болгох өдрөөр хэвийн ангилагдсан зээл байх	Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 998 дугаар тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-д заасны дагуу 30 хоногоос дээш хэтрээгүй хэвийн зээл болохыг тулган баталгаажуулах.	Тийм	2023 оны 8 дугаар сарын 22-ны өдрөөр тасалбар болгон худалдагдаж буй нийт 432 зээлийн мэдээллийг программаас татан авсан. Нийт багцын мэдээллийг төлөөлөх түүврийг сонгосон. Тасалбар болгосон өдрөөр түүврийн багц дахь зээлүүд хэвийн ангилалтай байгаа болохыг Зээлийн дансны хуулга болон зээлийн гэрээний зээл эргэн төлөх хуваарьтай тулган баталгаажуулсан.
1			
Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх;	Зээл нь Монгол төгрөгөөр баглагдаж, олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл эсэхийг тодорхойлох	Тийм	Зээлийн гэрээ болон зээлийн дансны хуулгатай тулган шалгасан. Зээлийн гэрээний хянахад зээлүүд нь Монгол төгрөгөөр олгогдож, Монгол төгрөгөөр эргэн төлөгдөж байна.
2			
Зээлийн эргэн төлөлтийн хуваарьг зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх;	Зээлийн гэрээ болон зээлийн эргэн төлөлтийн хуваарь, зээлдэгчийн дансны хуулга руу тулган баталгаажуулах.	Тийм	Зээлийн гэрээ болон зээлийн эргэн төлөлтийн хуваарь, хуваарийн дагуу төлөгдөж байгаа эсэхийг шалгахад түүвэрт орсон зээлүүд хуваарийн дагуу төлөгдөж байна. Зээлийн хугацааны эцэст гэхэд төлөгдөж дуусахаар тооцологдсон байна.
3			
Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх;	Зээл нь хэвийн төлөлттэй эсэхийг тодорхойлох	Тийм	Зээлийн төлөлтийн хуваарийг эргэн төлөлтийн байдлыг дансны хуулгатай тулган шалгасан. Түүвэрт орсон зээлүүдээс 1 зээл хуваарьт хугацаанаасаа өмнө илүү төлөлттэй байна.
4			
Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 85%-с хэтрэхгүй байх.	Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 85%-с хэтрэхгүй тодорхойлох.	Тийм	Зээл үнэлгээний харьцаа нь нийт зээлийн хувьд 1-ээс 80 хувийн хооронд байгаа бөгөөд түүвэрт хамрагдсан зээлдүүдийн хувьд 12-оос 80 хувийн хооронд байна.
5			

АНГИЛАГЧИЙН ШАЛГУУРУУД
2.1 Тохиролцсон горимын шалгуур хангасан байдал

Зээлдэгчид тавигдах шалгуур	
6	<p>Монгол Улсын нутаг дэвсгэрт тогтвортой оршин суудаг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байх;</p> <p>Зээлдэгч нь 18-с дээш настай, Монгол улсын иргэн мөн болохыг Монгол улсын иргэний үнэмлэх болон адилтгах бичиг баримт руу тулган шалгах.</p> <p>Зээлдэгч нь зээл олгосон өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй эсэхийг Монгол банкны Зээлийн мэдээллийн сангийн лавлагаагаар шалгах.</p> <p>Өр орлогын харьцаа (ӨОХ) нь татварын дараах орлогын 80%-с илүүгүй байгаа эсэхийг шалгах</p>
7	<p>Зээл олгох үед банк санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй байх.</p> <p>Өр орлогын харьцаа (ӨОХ) нь татварын дараах орлогын 80%-с илүүгүй байх</p>
8	<p>Зээл олгосон шалгуур нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо шалгуур үзүүлэлтэд нийцсэн байх;</p>
9	<p>Зээл олгосон шалгуур нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо мөрддөг шалгуур үзүүлэлтэд нийцэж байна. Тухайлбал, “Омни капитал ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны А /004 дугаар тушаалаар шинэчлэн баглагдсан Зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөлд бүтээгдэхүүн тус бүрд орлого нотлох баримтыг харгалзан зээлдэгчийн төлбөрийн чадварыг харгалзан зээл олгохоор заасан.</p>

Тухайн багцын хувьд эрх зүйн бүрэн чадамжтай болохыг хүчин төгөлдөр иргэний үнэмлэхийн хуулбар, Төрийн цахим мэдээллийн сангийн лавлагаагаар баталгаажуулсан. “Омни капитал ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны ТУЗ 22/20 дугаар тогтоолоор батлагдсан Зээлийн бодлогын 3.2.1 дэх заалтыг дагаж мөрдөж ажилласан байна.

Түүвэрт хамрагдсан зээлдэгчид зээлийн мэдээллийн сангийн лавлагаагаар хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй байна.

ӨОХ тооцсон байдлыг татвар, шимтгэлийн дараах цалингийн болон бизнесийн орлого, ЗМС дах бусад зээлийн өрийн үлдэгдлийн төлөлт, сарын зээл төлөлтийн дүн зэргийг гарган ӨОХ-ны томъёогоор давтан гүйцэтгэж шалгасан.

Зээл олгосон шалгуур нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо мөрддөг шалгуур үзүүлэлтэд нийцэж байна. Тухайлбал, “Омни капитал ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны А /004 дугаар тушаалаар шинэчлэн баглагдсан Зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөлд бүтээгдэхүүн тус бүрд орлого нотлох баримтыг харгалзан зээлдэгчийн төлбөрийн чадварыг харгалзан зээл олгохоор заасан.

Handwritten signature



2.2 Мэдээллийг үндсэн баримттай тулгах

Уг горимын зорилго нь Худалдах жагсаалт дахь түүвэр зээлүүдийн мэдээлэл нь зээл хүсэгчээс ирүүлсэн анхан шатны баримт, Төрийн цахим мэдээллийн сангийн ХУР лавлагаагаарх мэдээлэл, Зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл, Өр орлогын харьцаа, Барьцаа хөрөнгийн харьцаа зэрэг зээл төлөлтөд учирч болох эрсдэлийн үзүүлэлтүүдийн тооцоолол зэрэгтэй таарч буй эсэхийг тулган шалгах юм.

Харилцан тохирсон горимуудад ашигласан мэдээлэл болон боломжит баримтжуулах баримт бичиг нь дараах байдалтай байна:

Хүснэгт №3

#	Мэдээлэл	Үндсэн баримт	
1	Зээлийн дугаар	Зээлийн гэрээ, Төрийн мэдээллийн сангаас авсан лавлагаа, Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгийг өмчлөлд шилжүүлэх гэрээ /фидуци/, Зээлийн өргөдлийн маягт, Зээлдэгчийн зээлийн судалгааны тэмдэглэл, Нотариатчаар батлуулсан худалдах, худалдан авах гэрээ, Зээл төлөлтийг харуулсан хуулга, зээл төлөлтийн хуваарь	
2	Зээлдэгчийн овог, нэр		
3	Зээлдэгчийн регистрийн дугаар		
4	Зээлдэгчийн хаяг		
5	Зээлдэгчийн ажил эрхлэлт		
6	Хамтран үүрэг гүйцэтгэгчийн мэдээлэл		
7	Зээлийн хэмжээ		
8	Зээлийн хүү		
9	Зээлийн нэмэгдүүлсэн хүү		
10	Зээлийн хугацаа		
11	Зээлийн төрөл		
12	Зээлийн зориулалт		
13	Зээл олгосны шимтгэл		
14	Зээл олгосон огноо		
15	Зээл төлөгдөж дуусах огноо		
16	Зээлийн сарын төлбөр		
17	Зээлийн үлдэгдэл		Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгийг өмчлөлд шилжүүлэх гэрээ /фидуци/, Нотариатчаар батлуулсан худалдах, худалдан авах гэрээ, Зээлийн барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээний судалгаа, Барьцааны гэрээг эрх бүхий этгээдэд бүртгүүлсэн эсэх, Зээлийн өргөдлийн маягт, Зээлийн дүн
18	Зээлийн барьцаа		
19	Зээл үнэлгээний харьцаа	Зээлдэгчийн зээлийн үнэлгээний тайлан /зээлийн өргөдлийн маягт/, Төрийн мэдээллийн сангаас авсан лавлагаа,	
20	Зээлдэгчийн нас		
21	Зээлдэгчийн хүйс	Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа	
22	Зээлдэгчийн ангилал		
23	Идэвхитэй зээлийн тоо		
24	ЗМС дээрх зээлийн нийт үлдэгдэл		



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE



25	Сард төлөх бусад зээлийн төлбөр	
26	Зээлдэгчийн орлого БҮРТГЭВ-02	Төрийн мэдээллийн сангаас авсан НДШ төлөлтийн талаарх тодорхойлолт, Бизнесийн орлогыг нотлох баримтууд
27	Өр орлогын харьцаа	Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа, Төрийн мэдээллийн сангаас авсан НДШ төлөлтийн талаарх тодорхойлолт, Орлого нотлох баримтууд, тэдгээрийн тооцоолол



2023-11-15

БҮРТГЭВ-02

Хүснэгт №4

2.3 Түүвэр зээлүүдэд хийж гүйцэтгэсэн тохиролцсон горимуудын үр дүн

1. Түүвэр зээлүүдийн хувьд мэдээллийг үндсэн баримттай тулгаж шаардлага хангасан эсэхийг үнэлэх ажлын хүрээнд зээлийн хувийн хэрэг дээр гүйцэтгэсэн ажлын хураангуй

Тэмдэглэгээ
 ✓ Шалгуур хангасан
 × Шалгуур хангаагүй

д/д	Зээлийн ID дугаар	Зээлийн хувийн хэргүүд дээр гүйцэтгэсэн ажлын хураангуй																											
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	
1	202111-436	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
2	202111-473	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
3	202112-495	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
4	03-202201-013	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
5	202201-087	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
6	202201-109	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
7	03-202204-130	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
8	202205-265	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
9	202205-279	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
10	03-202205-167	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
11	03-202206-185	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	×	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
12	03-202206-186	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
13	3Г-202206-101	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
14	202207-376	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
15	202210-472	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
16	03-202211-305	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
17	03-202211-	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓

2023.11.08
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

SHONKHOR 01
estimate & audit

Тэмдэглэгээ

✓ Шалгуур хангасан

× Шалгуур хангаагүй

Хүснэгт №5

д/д	Зээлийн гэрээний дугаар	Тохиролцсон горимууд								
		1	2	3	4	5	6	7	8	9
1	202111-436	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
2	202111-473	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
3	202112-495	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
4	03-202201-013	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
5	202201-087	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
6	202201-109	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
7	03-202204-130	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
8	202205-265	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
9	202205-279	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
10	03-202205-167	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
11	03-202206-185	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
12	03-202206-186	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
13	ЗГ-202206-101	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
14	202207-376	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
15	202210-472	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
16	03-202211-305	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
17	03-202211-321	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
18	03-202212-325	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
19	03-202301-002	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
20	11721	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
21	11724	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
22	12007	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
23	12112	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
24	12115	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
25	12117	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
26	12119	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
27	12120	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
28	12121	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
29	12131	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
30	12137	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
31	12217	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
32	12141	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
33	12146	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
34	12151	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
35	12152	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
36	12153	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
37	12154	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓



38	12155	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
39	12169	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
40	12170	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
41	12173	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
42	12174	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
43	12176	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
44	12179	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
45	12181	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
46	12182	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
47	12184	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
48	12185	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
49	12186	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
50	12187	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
51	12188	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
52	12189	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
53	12190	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
54	12208	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
55	12211	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
56	12213	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
57	12435	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
58	202302-024	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓

Handwritten signature and circular stamp of the Mongolian Stock Exchange.

SHONKHOR estimate & audit 01
Circular stamp of SHONKHOR estimate & audit.

2.4 Зээлийн баримт бичгүүдэд хийж гүйцэтгэсэн ажлууд болон зээлийн нийт багцын шинжилгээний нэгдсэн дүгнэлт



Анхны үүрэг гүйцэтгүүлэгч “Омни капитал ББСБ” ХХК-ийн зээлийн үйл ажиллагаандаа

- Зээлийн удирдлагын бодлого
- Зээлийн бодлого
- Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл
- Зээлийн хорооны ажиллах журам
- Зээлийн үйл ажиллагааны журам гэсэн баримт бичгүүдийг ТУЗ, Гүйцэтгэх захирлын тушаалаар батлан мөрдөж байгаа бөгөөд зээлийн хувийн хэрэг болон зээл олгогдсон байдлыг эдгээр бодлого, журам, бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцлийн дагуу тулгаж шалгасан.


Зээлийн шинжилгээний үр дүнгээр багцад орсон 6,836,676.53 мян.төгрөгийн дүн бүхий 432 зээлийн жагсаалтад шинжилгээний ажил хийж гүйцэтгэлээ.

Багцад орсон нийт зээлийн мэдээлэл, түүнд хийсэн шинжилгээний ажлыг нэгтгэн дүгнэвэл дараахь байдалтай байна. Үүнд:

1. Нийт зээлийн багц нь 4 төрлийн бүтээгдэхүүнд хуваагдаж байгаа ба Автомашин барьцаалсан зээл 5 хувь, Автомашины лизинг 68.8 хувь, Бизнесийн зээл 21.7 хувь, Үл хөдлөх хөрөнгө газар барьцаалсан хэрэглээний зээл 4.5 хувийг тус тус эзэлж байна. Зээлүүдийн хувьд үл хөдлөх хөрөнгө, автомашин барьцаалан зээл олгодог. Түүвэрт хамрагдсан зээлүүд бүгд батлагдсан хуваарийн дагуу хугацаандаа төлөгдөж байна.
2. Нийт зээлийн багцыг ерөнхий байдлаар задалж үзвэл хувьд анх олгосон зээлийн дундаж нь 19,970.5 мян.төгрөг. Хамгийн бага нь 1,500.0 мян.төгрөг, хамгийн өндөр нь 180,000.0 мян.төгрөгийн дүнтэй байна. Харин зээлийн багцын одоо байгаа үлдэгдлийн дундаж дүн нь 15,825.6 мян.төгрөг байгаа бөгөөд хамгийн бага нь 835.3 мян.төгрөг, хамгийн өндөр нь 179,566.5 мян.төгрөгийн дүнтэй байна.
3. Нийт зээлийн багцын хувьд зээл анх олгосон хугацаа 4 зээлдэгч 48 сар, 1 зээлдэгч 37 сар, үлдсэн 427 зээлдэгчийн хувьд 6 сараас 36 сарын хугацаатай зээл авсан байна. Зээл анх олгосон дундаж хугацаа 32.1 сар байна.
4. Нийт багцад орсон зээлүүдийн хувьд 2021 оны 185,076.0 мян.төгрөгийн дүн бүхий 20 зээл, 2022 оны 2,824,886.3 мян.төгрөгийн дүн бүхий 190 зээл, 2023 онд олгогдсон 3,826,714.2 мян.төгрөгийн дүн бүхий 222 зээлийн үлдэгдлүүд байна.
5. Зээл үнэлгээний харьцаа нь нийт зээлийн хувьд 1-ээс 80 хувийн хооронд байгаа бөгөөд түүвэрт хамрагдсан зээлүүдийн хувьд 12-оос 80 хувийн хооронд байна.



2023-11-15



6. Нийт зээлийн багцын хувьд ӨОХарьцааны дундаж 35 хувь, хамгийн бага нь 1 хувь, хамгийн их нь 70 хувь байна. Харин түүвэрт хамрагдсан зээлүүдийн хувьд энэ харьцаа 2-оос 65 хувийн хооронд байна.
Энэ нь Омни капитал ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны ТУЗ 22/20 дугаар тогтоолоор батлагдсан Зээлийн бодлогын 6.2.2.3-д “Зээлдэгчийн сард төлөх зээлийн төлбөр болон зээлийн хүүгийн нийт дүн нь өрхийн орлогын 70 хувиас хэтрэхгүй байх” заалттай нийцэж байна.
7. Багцад хамрагдсан зээлдэгчийн хувьд зээл олгох үед давхардсан тоогоор нийт 88 хувь нь банк, санхүүгийн байгууллагад ямар нэг идэвхтэй зээлтэй ба үүнээс 9.7 хувь нь моргэйжийн зээлийн үлдэгдэлтэй байсан байна.
8. Хүүгийн хэмжээг тооцохдоо Бүтээгдэхүүн Үйлчилгээний Ерөнхий нөхцөлд заасны дагуу бүтээгдэхүүний төрөл бүрт харгалзуулан тогтоосныг үндэслэн гүйцэтгэх захирлын тушаалаар нэгдсэн байдлаар зохицуулдаг. Багцын хувьд зээлийн хүүний түвшин хамгийн бага нь 2.2 хувь, хамгийн өндөр 3.5 хувь, хүүгийн дундаж 3.03 хувь байна.
9. Зээлийн ажилтнууд зээлдэгчдийн нас хүйсийн мэдээллийг систем рүү оруулахдаа анхаарах шаардлагатай.

Тайланг бэлтгэсэн огноо
2023 оны 8 дугаар сарын 23-ны өдөр





АГУУЛГА

1. Удиртгал болон дүгнэлтийн хүрээ	4
1.1 Хууль зүйн дүгнэлт.....	4
1.2 Дүгнэлтийн хүрээ	4
1.4 Дүгнэлт гаргахад ашигласан баримт бичиг	5
1.5 Хязгаарлалт.....	5
1.6 Мэдэгдэл	6
2. Нэр томъёо ба товчилсон үгийн тайлбар	8
3. Хууль зүйн дүгнэлт.....	9
3.1. ТЗК-ийг үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн, холбогдох шийдвэр, тусгай зөвшөөрөл, гэрчилгээ, дүрэм зэрэг нь хүчин төгөлдөр эсэх талаар	9
3.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар.....	11
3.3. ТЗК-ийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журам, зааврууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар	13
3.4. Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулсан болон ТЗК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх талаар	18
3.5. Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар	24
3.6. Хөрөнгийн багц дахь хөрөнгийн төрөл бүрээс хамааруулан санамсаргүй түүврийн аргаар сонгох замаар үнэт цаас гаргагчаас тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлт хангаж буй эсэх талаар.....	26
3.7. Багцын хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрээ, хэлцэлд үүргийн гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгасан эсэх талаар	34
Хавсралт № 1	36
“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ААС ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БУЙ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАГДСАН МЭДЭЭЛЭЛ ҮНЭН ЗӨВ, ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ	36
Хавсралт № 2	81
“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК БОЛОН “ОМНИ КАПИТАЛ ББСБ” ХХК-ИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ҮНЭН ЗӨВ БӨГӨӨД ХУУЛЬД НИЙЦСЭН ЭСЭХ ТУХАЙ ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ	81
Хавсралт №3	93



2023 -11- 15
БҮРТГЭВ-02

2023.11.08
Ор сар өдөр
БҮРТГЭВ
№ 11

“ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗЭЭЛИЙН БАГЦЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ЯВЦАД ГАРСАН
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН АНХААРАХ АСУУДАЛ,
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ЖАГСААЛТ” 93

Хавсралт №4 94

“САНАМСАРГҮЙ ТҮҮВРИЙН АРГААР СОНГОСОН ЗЭЭЛИЙН БАГЦЫН ЖАГСААЛТ” 94

Хавсралт № 5 97

ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙГООР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС
АВСАН ЛАВЛАГАА, БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ..... 97

Хавсралт № 6 105

ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙГООР “ОМНИ АССЕТ ТЗК” ХХК,
ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГААС ХҮЛЭЭН АВСАН БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ 105





1. Удиртгал болон дүгнэлтийн хүрээ

1.1 Хууль зүйн дүгнэлт

Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН (цаашид “ХаанЛекс”, эсхүл “бид” гэх) нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ны 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 338 тоот тогтоолын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх этгээдээр бүртгэгдсэн ба *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6-д заасны дагуу* үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх тухай дүгнэлт (цаашид “Дүгнэлт” гэх) гаргах бүрэн эрхтэй болно. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Монгол Улсын хуулийн этгээд болох “Омни Ассет ТЗК” ХХК (РД:8356327) (цаашид “ТЗК” эсхүл “**Үнэт цаас гаргагч**” гэх)-аас хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Дүгнэлт гаргуулах тухай хүсэлт тавьсны дагуу Үнэт цаас гаргагч болон ХаанЛекс нар нь 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 23/002 тоот “Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулсан ба уг гэрээний дагуу энэхүү Дүгнэлтийг гаргасан болно.

1.2 Дүгнэлтийн хүрээ

Үнэт цаас гаргагчаас хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой энэхүү Дүгнэлтийг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ны 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 360 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам (цаашид “СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам” гэх)-ын 10.4 дэх хэсэг, Монголын хөрөнгийн бирж ТӨХК (цаашид “МХБ” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 2020/07 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам” (цаашид “МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам” гэх)-ийн 2.5.5-д заасан агуулгын хүрээнд бэлтгэсэн.

ХаанЛекс нь энэхүү Дүгнэлтийг боловсруулах үед хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээний актаар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд бэлтгэсэн бөгөөд гадаад улсын хууль тогтоомж, хэм хэмжээг тайлбарлах, хэрэглэх асуудал багтаагүй болно.

Хууль тогтоомжоор СЗХ-ны бүрэн эрхэд хамааруулсан болон СЗХ-оос зөвшөөрөл олгосон аливаа асуудлаар ХаанЛекс нь дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргаагүй.

Дүгнэлтэд дурдагдаж буй эрх бүхий байгууллагын лавлагаа, тодорхойлолтод үндэслэн хийж буй Дүгнэлтийн хамаарах хугацаа нь тухайн лавлагаа тодорхойлолтын огноогоор хязгаарлагдана. Тухайн тодорхойлолтын огнооноос хойших үйл явдалд ХаанЛекс нь дүгнэлт хийгээгүй бөгөөд бидний зүгээс ямар нэгэн баталгаа гаргахгүй болно.



2023 -11- 15

БҮРТГЭВ-02



1.4 Дүгнэлт гаргахад ашигласан баримт бичиг

Энэхүү Дүгнэлтийг зөвхөн дараах баримт бичиг, мэдээлэл (цаашид “Баримт бичиг” гэх)-д үндэслэн боловсруулсан болно. Үүнд:

- ХаанЛексийн хүсэлтийн дагуу Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн, энэ Дүгнэлтийн Хавсралт № 6-д жагсаасан баримт бичгүүд;
- Энэ Дүгнэлтийг гаргахтай холбоотойгоор төрийн холбогдох байгууллагаас авсан бөгөөд тус Дүгнэлтийн Хавсралт № 5-д жагсаасан лавлагаа, тодорхойлолтууд.

1.5 Хязгаарлалт

Энэхүү Дүгнэлт нь хөндлөнгийн, хууль зүйн дүн шинжилгээ хийсэн баримт бичиг бөгөөд аливаа гуравдагч этгээдийн өмнө эрх, үүрэг, хариуцлага үүсгэхгүй, аливаа гуравдагч этгээдэд ашигтай байх, эсхүл давуу байдлыг бий болгох мэдээлэл, баталгаа өгөх зорилгогүй ба хууль зүйн туслалцаа зөвлөгөө өгсөнд тооцогдохгүй.

Дүгнэлтийг зөвхөн энд дурдагдсан зорилгоор боловсруулсан бөгөөд Үнэт цаас гаргагч нь өөр бусад зорилгоор ашиглах, биднээс тухайлан олгосон зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно.

Дүгнэлт гаргах явцад Үнэт цаас гаргагч болон бусад холбогдох этгээд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан зэрэг нөхцөлд үүсэх үр дагаврыг ХаанЛекс хариуцахгүй.

Үнэт цаас гаргагч болон холбогдох бусад этгээдээс ирүүлсэн лавлагаа, тодорхойлолт, албан бичиг зэргийн огноо нь харилцан адилгүй өөр байгаа бөгөөд тэдгээр баримт бичигт үндэслэн тухайн асуудлаар бидний гаргасан дүгнэлтийн хугацаа нь мөн холбогдох баримт бичгийн огноогоор хязгаарлагдана.

Энэхүү Дүгнэлтийг энд дурдсан хүрээ хязгаарын дотор зөвхөн хууль зүйн асуудлаар бэлтгэсэн бөгөөд Бид үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зах зээлийн мэдээ, бизнес, эдийн засаг, санхүү гэх мэт хуульчаас өөр тусгай мэргэжил, мэргэшил шаардагдах асуудлаар, зээлийн гэрээ, Фидуцийн гэрээ, барьцааны гэрээнд дурдагдсан аливаа тоон болон технологийн мэдээллийн талаар дүгнэлт гаргах эрхгүй, тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй буюу хариуцлага хүлээхгүй болно.

Зээлийн багцаас санамсаргүй түүврийн аргаар сонгон авсан зээлүүд, тэдгээрийн хувийн хэрэгт авагдсан материалын хүрээнд дүн шинжилгээ хийсэн (хянаж үзээгүй бусад зээлийн талаар дүгнэлт гаргаагүй) ба сонгосон зээлүүдээс бусад зээлтэй холбоотой асуудлаар хариуцлага хүлээхгүй.

Бидний хийсэн ажил энэхүү тайланд тусгагдсан зээлийн багцын шалгуур үзүүлэлтийн хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүх баримт бичиг, гэрээ төлөвлөгөө, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, тэдгээрийг судалсан гэх амлалтыг энэхүү судалгаа шинжилгээтэй холбоотойгоор бид гаргахгүй болно.



2023-11-15
БҮРТГЭВ-02



Энэхүү тайланд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Тийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь тухайн баримт бичиг нь холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон, эсхүл бусад байдлаар хувийн хэрэгт байхгүй болсон байж болно.

Фидуцийн болон барьцаа хөрөнгийн эдэлгээ, чанар байдал, ашиглалт болон биет байдлын доголдлын талаар бид мэдэхгүй, тэдгээрийн болон түүний эзэмшлийн талаарх нөхцөл байдлыг тогтоохгүй болно.

1.6 Мэдэгдэл

Бид энэхүү Дүгнэлтийг Үнэт цаас гаргагч, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдээс ирүүлсэн баримт бичгүүд болон төрийн холбогдох байгууллагад хандаж авсан лавлагаа, тодорхойлолтуудад үндэслэж бэлтгэсэн болно.

Бид энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа дараах төсөөлөл буюу хүлээн зөвшөөрөл (assumption) дээр үндэслэсэн. Үүнд:

- (i) Баримт бичгүүд дэх огноо, гарын үсэг, тамга, тэмдэг нь үнэн зөв, хүчин төгөлдөр, зохих шаардлага хангасан;
- (ii) Баримт бичгийн хуулбарыг хүлээн авсан бол тэр нь эх хувийн үнэн зөв, бүрэн хуулбар мөн;
- (iii) Хэрвээ бид Баримт бичгийн төслийг хүлээн авсан бол уг баримт бичиг нь тус төслийн дагуу үйлдэгдэнэ;
- (iv) Зээлийн хувийн хэргийн бүрдэл, түүнд авагдсан баримт материал нь хүчин төгөлдөр, Зээлдүүлэгчээс нэмэлт хавсаргах материал байхгүй;
- (v) Бидэнд ирүүлсэн Баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт ороогүй, эсхүл тэдгээр нь хүчингүй болоогүй;
- (vi) Зээлдэгчийн эдийн засгийн байдал, өр төлбөртэй эсэх, холбогдох бусад баримт бичиг нь үнэн зөв, тэдгээр баримтуудыг бүрэн шалгасны үндсэнд зээл олгосон, санхүүгийн тооцоолол нь зохих шаардлагыг хангасан;
- (vii) Фидуцийн болон барьцаа хөрөнгийн үнэлгээ, эрхийн болон биет байдлын доголдолгүй эсэх, мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
- (viii) Тасалбар болгох өдрийн байдлаар мэдэгдээгүй, хүчин төгөлдөр байсан нөхцөл байдал нь тасалбар болгосон өдрөөс хойш өөрчлөгдөж, бий болсон нөхцөл байдалд хариуцлага хүлээхгүй;
- (ix) Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, түүний ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан мэдээлэл нь үнэн зөв, бодитой бөгөөд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, дүн шинжилгээний явцад танилцуулаагүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд үүсэх хариуцлагыг ХаанЛекс хүлээхгүй;



2023 -11- 15
БҮРТГЭВ-02

2023 11 07 өдөр
БҮРТГЭВ
№ 01

- (x) ТЗК болон бусад оролцогч талууд нь Баримт бичгийг үйлдэх бүрэн эрхтэй бөгөөд түүнийг зохих журмын дагуу үйлдсэн буюу байгуулсан ба түүгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ;
- (xi) Аливаа этгээд нь санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдлээрээ төөрөгдүүлэх, хууран мэхлэх үйл ажиллагаанд оролцоогүй. Аливаа этгээд нь энэхүү тайлангийн аливаа хэсгийг буруу болгох ямарваа үйл ажиллагаанд оролцоогүй буюу оролцохгүй;
- (xii) Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан болон хавсаргагдсан андеррайтер, аудитор болон бусад мэргэжлийн оролцогчдын гаргасан судалгаа, дүгнэлт, тайлан, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;
- (xiii) Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан үйл баримт, мэдээлэл нь ирээдүйд хэрэгжих тохиолдолд тус үйл баримт, мэдээлэл нь хуулийн дагуу зохих ёсоор биелэгдэнэ;

Үнэт цаас гаргагч, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүд, бусад эрх бүхий байгууллага болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтнуудаас ирүүлсэн баримт, мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр.





2. Нэр томьёо ба товчилсон үгийн тайлбар

Дүгнэлтэд хаалтад тодорхойлсноос гадна дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

"Анхны үүрэг гүйцэтгүүлэгч" гэж "Омни капитал ББСБ" ХХК-ийг;

"МХБ" гэж "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийг;

"МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам" гэж МХБ-ийн ТУЗ-ийн 2020 оны 2020/06 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг;

"ИХ" гэж Монгол Улсын Иргэний хуулийг;

"СЗХ" гэж Санхүүгийн зохицуулах хороог;

"СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам" гэж СЗХ-ны 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 360 тоот тогтоолын хавсралтаар баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ыг;

"ТУЗ" гэж төлөөлөн удирдах зөвлөлийг;

"УБЕГ" гэж Улсын бүртгэлийн ерөнхий газрыг.





3. Хууль зүйн дүгнэлт

3.1. ТЗК-ийг үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн, холбогдох шийдвэр, тусгай зөвшөөрөл, гэрчилгээ, дүрэм зэрэг нь хүчин төгөлдөр эсэх талаар

ТЗК-ийг үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн, холбогдох шийдвэр, гэрчилгээ, дүрэм зэрэг нь хүчин төгөлдөр эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгав:

(i) ТЗК-ийг үүсгэн байгуулсан этгээд нь түүнийг байгуулах эрх бүхий субъект мөн эсэх?

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т зааснаар тусгай зориулалтын компанийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон СЗХ-оос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулах боломжтой байдаг. ТЗК-ийг үүсгэн байгуулсан "Омни капитал ББСБ" ХХК нь СЗХ-ны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 210 дугаар тоот тогтоолын дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан СЗХ-нд бүртгэлтэй аж ахуй нэгж байна. Иймд ТЗК-ийг үүсгэн байгуулсан этгээд нь хуулийн дээрх шалгуурыг хангаж байх тул баталгаат үнэт цаас гаргах тусгай зориулалтын компанийг үүсгэн байгуулах эрх бүхий этгээд мөн байна.

(ii) ТЗК-ийг үүсгэн байгуулах үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэх, тусгай зөвшөөрөл нь хүчинтэй эсэх?

"Омни капитал ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 23/05 тоот тогтоолын дагуу Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдаж, 2023 оны 5 дугаар сарын 04-ны өдөр УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгэгдсэн байна. "Омни капитал ББСБ" ХХК, түүний хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хуулийн 13.2, 62.1.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу дээрх шийдвэрийг гаргах бүрэн эрхтэй болно.

Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2.34 дэх хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа нь СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаа байна. Үнэт цаас гаргагчид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тухай хүсэлтийг СЗХ-нд 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 1/1699 тоот албан бичгээр гаргасны дагуу тус үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг СЗХ-оос 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 256 тоот тогтоолоор Үнэт цаас гаргагчид олгосон байна.





Тус тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ТЗК нь эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн өөрчлөлт болон шинэчилсэн дүрмийг 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдөр УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар бүртгүүлсэн байна. Иймд ТЗК-ийг үүсгэн байгуулах үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн дагуу явагдсан бөгөөд тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байна.

(iii) ТЗК-ийн гэрчилгээ нь хүчин төгөлдөр эсэх?

ТЗК-ийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 000271976 тоот гэрчилгээ нь улсын бүртгэгчийн тамга, тэмдгээр баталгаажсан байх бөгөөд түүнд тусгагдсан мэдээлэл нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанд тусгагдсан мэдээлэлтэй нийцэж байх тул хүчин төгөлдөр гэж үзлээ.

/Жич: ТЗК-ийн дүрэм хүчин төгөлдөр эсэх тухай дүгнэлтийн дэлгэрэнгүйг 3.3 дахь хэсгээс үзнэ үү./

Иймд Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн материалын хүрээнд ТЗК-ийг үүсгэн байгуулах болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлэх ажиллагаа нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн бөгөөд ТЗК-ийн холбогдох шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм нь хүчин төгөлдөр байна гэж дүгнэлээ.





3.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар

СЗХ-ны 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 256 тоот тогтоолоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлыг ТЗК-д олгосон бөгөөд ТЗК-ийн ТУЗ нь 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдөр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүний нөхцлийг тогтоох тухай 23/013 тоот тогтоолыг баталсан. Тус тогтоолоор ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс 6,000,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий зээлийн хөрөнгийн багцыг худалдан авч, дараах нөхцөлөөр хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

Үнэт цаас гаргагч	“Омни ассет ТЗК” ХХК
Анхны үүрэг гүйцэтгэгч	“Омни капитал ББСБ” ХХК
Үнэт цаасны төрөл	Зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
Үнэт цаасны тоо ширхэг	60,000 ширхэг
Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
Үнэт цаасны нийт дүн	6,000,000,000 төгрөг
Хүү төлөгдөх хугацаа	Улирал тутам
Үнэт цаасны төлбөр төлөгдөх эх үүсвэр	Хөрөнгийн багцийн зээлийн үндсэн болон хүүгийн орлого
Үнэт цаасны хадгалалт	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн данс
Арилжаалах зах зээл	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК
ХБҮЦ-ны хугацаа	24 сар
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр төлөх давтамж	Улирал тутам
ХБҮЦ-ны хүүгийн жилийн хувь/татварын өмнөх/	19.60%
ХБҮЦ-ны хүүгийн жилийн хувь/татварын дараах/	18.62%
ХБҮЦ-ны хүүгийн жилийн хувь/татварын өмнөх/	(Тоо ширхэг * нэрлэсэн үнэ * Хүүгийн жилийн хувь)/Хүүгийн төлбөр төлөх давтамж
ХБҮЦ-ны үндсэн төлбөр	Жилд 1 удаа





Уг шийдвэр нь Компанийн тухай хуулийн 76.1.5 дахь хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 7.2 болон 7.3 дахь хэсэг, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын холбогдох зохицуулалтад тус тус нийцсэн байна.





3.3. **ТЗК-ийн дүрэм** үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журам, зааврууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар

Үнэт цаас гаргагчаас заавал батлах дүрэм, журмыг МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.2.12-т заасан байдаг бөгөөд Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь тус журамд нийцүүлэн ТЗК-ийн үйл ажиллагаанд ашиглагдах дүрэм, журмын жагсаалтыг 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн албан бичгээр бидэнд ирүүлсэн. Уг албан бичигт дараах дүрэм, журмууд багтсан байна. Үүнд:

- (i) “Омни ассет ТЗК” ХХК-ийн дүрэм;
- (ii) ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;
- (iii) Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам;
- (iv) Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын үйл ажиллагааны журам;
- (v) Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам;
- (vi) Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам;
- (vii) Хөрөнгө итгэмжлэн удирдах журам;
- (viii) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам.

ТЗК-ийн дүрэм болон дээр дурдсан журмуудыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг дараах байдлаар нэг бүрчлэн шалгалаа. Тодруулбал:

I. ТЗК-ийн дүрэм

ТЗК-ийн дүрмийг тус компанийн хувьцаа эзэмшигчийн 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 23/01 тоот шийдвэрийн хавсралтаар баталсан нь Компанийн тухай хуулийн 17.1 болон 62.1.1-т заасан шаардлагыг хангаж байна. Түүнчлэн уг дүрмийг УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдөр бүртгүүлсэн тул Компанийн тухай хуулийн 17.9-д заасны дагуу хүчин төгөлдөр гэж үзэж болохоор байна.

ТЗК-ийн дүрэм нь нийт 9 зүйлтэй бөгөөд зүйл тус бүр нь дараах харилцааг зохицуулсан байна. Үүнд:

- (i) *Нэгдүгээр зүйл: Компанийн зорилго, бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ, компанийн хаяг, үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл, түүнчлэн баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан тохиолдолд татан буугдах тухай;*
- (ii) *Хоёрдугаар зүйл: Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэл;*
- (iii) *Гуравдугаар зүйл: Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;*





- (iv) Дөрөвдүгээр зүйл: Компанийн эрх, үүрэг;
- (v) Тавдугаар зүйл: Компанийн хариуцлага;
- (vi) Зургаадугаар зүйл: Компанийн удирдлага, тэдгээрийн бүрэн эрх;
- (vii) Долдугаар зүйл: Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт;
- (viii) Наймдугаар бүлэг: Компанийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл;
- (ix) Есдүгээр зүйл: Компанийг татан буулгах үндэслэл, журам;
- (x) Аравдугаар зүйл: Дүрмийн хувь болон дүрмийн хүчин төгөлдөр болох үндэслэл, зохицуулах хууль.

Агуулгын хувьд компанийн дүрэм нь Компанийн тухай хуулийн 16.2 болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.9-д заасан шаардлагыг тус тус хангасан байх ёстой. ТЗК-ийн дүрэм нь уг хуулийн шаардлагуудыг хангаж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байна.

II. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам

ТЗК-ийн ТУЗ-ийн 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн №23/007 тоот шийдвэрийн хавсралтаар ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баталсан байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 76.1.13 дахь хэсэгт заасан шаардлагад нийцэж байна.

Энэхүү журам нь нийт 6 зүйлтэй бөгөөд тэдгээр нь дараах харилцааг зохицуулсан байна. Үүнд:

- (i) Нэгдүгээр зүйл: Журмын зорилго, ТУЗ-ийн үйл ажиллагааг зохицуулах хууль, журмууд;
- (ii) Хоёрдугаар зүйл: ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, гишүүнд тавигдах шаардлага;
- (iii) Гуравдугаар зүйл: ТУЗ-ийн бүрэн эрх, зохион байгуулалт;
- (iv) Дөрөвдүгээр зүйл: ТУЗ-ийн хурлын зар хүргэх, хуралд оролцох, санал өгөх, хурлын хүчин төгөлдөр байдал болон шийдвэр гаргалт;
- (v) Тавдугаар зүйл: ТУЗ-ийн гишүүний ажлын нөхцөл, хангамж;
- (vi) Зургаадугаар зүйл: ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын хүчин төгөлдөр болох нөхцөл болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах.

ТЗК-ийн үйл ажиллагааны журам нь Компанийн тухай хуулийн 75-82 дугаар зүйл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.8, СЗХ-ны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын 2.1 дэх хэсгийн тайлбар 1 дэх хэсэг, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3 дугаар зүйлд заасан шаардлагыг тус тус хангасан байвал зохих бөгөөд Хуулийн фирм нь журмыг хянаад эдгээр зохицуулалтад нийцсэн байна гэж дүгнэлээ.

III. Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам





ТЗК-ийн Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох тухай журам нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 23/002 тоот тогтоолоор батлагдсан байх бөгөөд энэ нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3 дугаар зүйл, ТЗК-ийн дүрмийн 6.4.4.14, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.3.2 дахь хэсэгт тус тус нийцэж байна.

Уг журмаар хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шаардлага, тэдгээрийг сонгох, солих журам, тэдгээртэй байгуулах гэрээний нөхцөлтэй холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд Хуулийн фирм нь эдгээр зохицуулалтыг нэг бүрчлэн хянаад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, 33.2.3 дахь хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19, 20, 40 дүгээр зүйл, Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 4, 7, 8 дугаар зүйл, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.2.12.2, дэх хэсэгт тус тус нийцсэн гэж дүгнэлээ.

IV. Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын үйл ажиллагааны журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-23/003 тоот тогтоолоор “Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын үйл ажиллагааны журам”-ыг баталсан байна. СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.4, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.3.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь энэхүү журмыг батлах бүрэн эрхтэй байх тул хуульд нийцэж байна.

Тус журам нь зээлдэгч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч болон гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэл, тэдгээрийг удирдах, урьдчилсан сэргийлэх арга хэмжээ, эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээтэй холбоотой харилцааг зохицуулсан нийт 6 зүйлээс бүрдэж байх бөгөөд эдгээр нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 41.1, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.2.12.4 болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагын хүрээнд буюу эдгээртэй зөрчилдөхгүй байна. Иймд энэхүү журмыг хууль тогтоомжид нийцсэн гэж дүгнэлээ.

V. Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-23/003 тоот тогтоолоор Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журмыг баталсан байх ба ТЗК-ийн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.3.5 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ нь энэхүү журмыг батлах бүрэн эрхтэй байна. Тус журам нь нийт 6 зүйлтэй бөгөөд ТЗК-иас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөхтэй холбоотойгоор ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан нь Хөрөнгөөр





баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19, 20 дугаар зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр зүйл болон бусад зүйл, заалтыг зөрчөөгүй бөгөөд холбогдох хуульд нийцсэн байна.

VI. Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам

Тус журмыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-23/003 тоот тогтоолоор баталсан байх бөгөөд ТЗК-ийн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.3.4 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ нь энэхүү журмыг батлах бүрэн эрхтэй байна. Уг журмаар Хөрөнгө оруулагч, Үнэт цаас эзэмшигч нарт компанийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд тэдгээр нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1 дэх хэсэг болон Долоодугаар бүлгийн Нэгдүгээр дэд бүлэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20.2.3 дахь хэсэг, 39 дүгээр зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 11-р зүйл, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг, СЗХ-ны 2019 оны 72 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам”-ын холбогдох зүйл, заалтад заасантай тус тус нийцсэн байна.

VII. Хөрөнгө итгэмжлэн удирдах журам

Тус журмыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-23/003 тоот тогтоолоор баталсан байх бөгөөд СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын холбогдох хэсэг, ТЗК-ийн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.3.8 дахь хэсэгт тус тус заасны дагуу ТУЗ нь энэхүү журмыг батлах бүрэн эрхтэй байна. Хөрөнгө итгэмжлэн удирдах журам нь нийт 6 зүйлтэй байх бөгөөд Үнэт цаас гаргагчийн гаргаж буй баталгаат үнэт цаасны баталгаа болох хөрөнгийн багцад буй хөрөнгийг солих, нэмэгдүүлэх, буцаах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журмын заалтууд нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл, 12.11.5, 12.13, 15 дугаар зүйл, 18.2 дахь хэсэг, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журамд тус тус заасан шаардлагуудыг зөрчөөгүй байх тул холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

VIII. Монго үгаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам





СЗХ-ны "Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг зөвшөөрөл бүртгэлтэйгээр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-ын 1.2.1, 2.1.1.2, 3.1.2.1 дэх хэсэг, СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.6-д тус тус заасны дагуу Үнэт цаас гаргагч нь "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үйл олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх чиглэлээр тавигдах шаардлага, ёс зүйн шалгуур зэргийг тусгасан бодлого, журам"-тай байх шаардлагатай. Уг шаардлагын дагуу ТЗК-ийн ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 23/002 тоот тогтоолоор уг журмыг баталсан байх бөгөөд энэхүү журам нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.





3.4. Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулсан болон ТЗК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх талаар

Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээд гэдэгт “МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.5.5.3.-т заасны дагуу дараах этгээдийг хамруулан авч үзлээ. Үүнд:

- (i) андеррайтер;
- (ii) анхны үүрэг гүйцэтгүүлэгч;
- (iii) үйлчилгээ үзүүлэгч;
- (iv) хөрөнгө итгэмжлэн удирдагч.

ТЗК нь 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн албан бичгээр ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотойгоор байгуулагдсан болон байгуулах гэрээнүүдийн жагсаалтыг ирүүлсэн бөгөөд тус жагсаалтад тусгагдсан гэрээ, хэлцэл тус бүрийг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг доорх байдлаар шалгалаа. Үүнд:

I. Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ

Үнэт цаас гаргагч нь ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-23/012 тоот тогтоолын дагуу хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг тогтоон, уг шалгуур үзүүлэлтийг хангасан зургаан тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий зээлийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авахаар, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-23/034 тоот тогтоолын дагуу Үнэт цаас гаргагчаас баталсан хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангасан зургаан тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий зээлийн багцыг Үнэт цаас гаргагчид худалдахыг тус тус зөвшөөрсөн байна.

Дээрх тогтоолыг үндэслэн Үнэт цаас гаргагч болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нар нь 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг байгуулсан байна. Тус гэрээний тусгай нөхцөлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгон арилжих ажиллагаа амжилттай хийгдэж 6,000,000,000 төгрөг буюу түүнээс дээш дүнгээр хөрөнгө оруулалт босгосон өдөр Үнэт цаас гаргагч нь хэлцэл биелэх үнийг төлөх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь гэрээний зүйл буюу Хөрөнгийн багцыг шилжүүлэн өгөхөөр тохиролцсон байх бөгөөд энэ төрлийн болзол тавьж хийсэн хэлцлийг байгуулж болохыг Иргэний хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгээр зөвшөөрдөг.

Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний Ерөнхий нөхцөлийн 6 дугаар зүйлд худалдах, худалдан авах гэрээний зүйл Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид шилжсэнээр Хөрөнгийн багц дахь зээлийн гэрээнүүдээс үүсэх бүхий л эрх Үнэт цаас гаргагчид шилжих тухай зохицуулсан байна. Түүнчлэн мөн зүйлийн 2 дахь хэсгийн дагуу Хөрөнгийн багцад хамаарах Барьцааны гэрээнүүд болон түүнтэй холбоотой шаардах эрхийг





Үнэт цаас гаргагчид шилжүүлж байгаа буюу Үнэт цаас гаргагч нь Барьцааны гэрээнүүдийн барьцаалагч талын эдлэх бүхий л эрхийг эдэлж, бусад үүрэг гүйцэтгүүлэгчдээс тэргүүн ээлжид барьцааны зүйлээс шаардлагаа хангуулах талаар мөн тусгасан байна. Ийнхүү зохицуулсан нь Иргэний хуулийн 123 дугаар зүйлийн 123.2 дахь хэсэг болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт тус тус нийцэж байх тул энэ зохицуулалтын дагуу Хөрөнгийн багц дахь Барьцааны гэрээнүүдийн шаардах эрх Үнэт цаас гаргагчид шилжих бүрэн боломжтой байна.

Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ болон түүний салшгүй хэсгүүд нь агуулгын хувьд Монгол Улсын Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын холбогдох зүйл, заалтад нийцсэн байх бөгөөд талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажсан байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан гэж үзлээ. Иймд уг гэрээ нь хууль тогтоомжид нийцсэн гэж дүгнэлээ.

II. Фидуцийн барьцааны гэрээ

Үнэт цаас гаргагч (“Барьцаалагч”) болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч (“Барьцаалуулагч”) нар нь 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Фидуцийн барьцааны гэрээг байгуулсан байна.

Фидуцийн барьцааны гэрээ нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох бөгөөд Үнэт цаас гаргагчийн хувьд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэг болон 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу их хэмжээний бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэлд тус тус тооцогдохоор байна. Иймд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-23/034 тоот тогтоол, Үнэт цаас гаргагч нь 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 23/012 тоот тогтоолоор тус тус Фидуцийн барьцааны гэрээ байгуулахыг зөвшөөрч шийдвэрлэсэн байх тул хуульд заасан журмын дагуу байгуулагдсан гэж үзэх боломжтой байна.

Энэ гэрээгээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлэх Хөрөнгийн багцад буй хөдлөх эд хөрөнгө буюу фидуцийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжсэн автомашинуудыг Үнэт цаас гаргагчид барьцаалуулахтай холбогдох харилцааг зохицуулсан байх бөгөөд хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээнд заавал тусгах нөхцөлүүдийг бүрэн тусгасан байх тул Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт нийцсэн байна. Түүнчлэн агуулгын хувьд Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны хуулийн холбогдох зүйл, заалтад нийцсэн байх ба талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажсан байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан гэж үзлээ. Иймд уг гэрээ нь хууль тогтоомжид нийцсэн байна.





III. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.4, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.5.4-д тус тус заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулах шаардлагатай байдаг ба ТЗК-ийн ТУЗ нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.4.5, ТЗК-ийн дүрмийн 6.4.4.14, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.4.2-д тус тус заасны дагуу энэхүү гэрээг байгуулах, батлах шийдвэрийг гаргах бүрэн эрхтэй болно. ТЗК-ийн ТУЗ нь 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 23/009 тоот тогтоолоор Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК (цаашид “Хөрөнгө итгэмжлэн удирдагч” гэх)-тай байгуулах зөвшөөрлийг ТЗК-д олгосон байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс, гэрээний дагуу хамтран ажиллах зарчим, талуудын эрх, үүргийг зохицуулсан байх бөгөөд гэрээ нь үндсэн хэсгээс гадна 16 зүйл бүхий ерөнхий нөхцөл, 3 зүйл бүхий тусгай нөхцөлөөс бүрдсэн байна. Хуулийн фирм нь энэхүү гэрээний зохицуулалтуудыг нэг бүрчлэн хянан үзэхэд тэдгээр нь Монгол Улсын Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 8 дугаар зүйл, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.7 заалтыг тус тус зөрчөөгүй, холбогдох хууль тогтоомжид нийцсэн гэж дүгнэлээ.

IV. Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ

ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.4-д заасны дагуу энэхүү гэрээг байгуулах шаардлагатай байдаг ба ТЗК-ийн ТУЗ нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.12, ТЗК-ийн дүрмийн 6.2.7.3, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.4.5, 3.5.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу ТЗК-ийн нэрийн өмнөөс энэхүү гэрээг байгуулах шийдвэрийг гаргадаг. ТЗК-ийн ТУЗ нь 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 23/014 тоот тогтоолоор Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээг үйлчилгээ үзүүлэгч болох “Омни капитал ББСБ” ХХК (энэхүү хэсэгт цаашид “Үйлчилгээ үзүүлэгч” гэх) болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нартай байгуулах зөвшөөрөл олгосон байна.

Тус гэрээ нь нийт 9 зүйлтэй бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, Зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн төлөлтөд хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас эдгээр үйл ажиллагаанд тавих хяналт, Үнэт цаас гаргагчаас үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Гэрээний заалтууд нь Монгол Улсын Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 7 дугаар зүйл, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.7 дахь хэсэг болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.





V. Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ

ТЗК-ийн ТУЗ-ийн 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-23/006 тоот тогтоолын дагуу Хөндлөнгийн аудитын үйлчилгээ үзүүлэгчээр “Шонхор үнэлгээ аудит” ХХК-г сонгож, гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрхийг ТУЗ-ийн дарга А.Батболдод олгосон байна. ТУЗ нь СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.4.5, ТЗК-ийн дүрмийн 6.4.4.14, 7.1 ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3.4.5 -д тус тус заасны дагуу ТЗК-ийн гэрээ байгуулах шийдвэр гаргах бүрэн эрхтэй байна. Энэхүү гэрээгээр Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 40.1, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 10.1-т заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд жилд нэгээс доошгүй удаа хийх хөндлөнгийн аудитын хяналт, шалгалттай холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд энэ нь Аудитын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомжид нийцэж байна.

VI. Тохиролцсон горимоор ажил гүйцэтгэх гэрээ

Үнэт цаас гаргагч болон “Шонхор үнэлгээ аудит” ХХК нар нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад зориулсан зээлийн багц нь Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн шалгуур үзүүлэлтүүдэд нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргах зорилгоор 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдөр №23/001 23/46 тоот “Тохиролцсон горимоор ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулсан байна. Тус гэрээ нь Аудитын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомжид нийцэж байна.

Түүнчлэн “Шонхор үнэлгээ аудит” ХХК нь Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.3, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 10.2 болон Үнэт цаасны бүртгэлийн журмын 11.4 дэх хэсэгт тус тус заасан шаардлагыг хангаж байгаа аудитын компани болох нь түүний улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх тухай СЗХ-ны 2017 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 34 дүгээр тогтоол зэргээр нотлогдож байна.

VII. Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ

Үнэт цаас гаргагч болон Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН нар нь 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 23/002 тоот “Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулсан бөгөөд уг гэрээгээр Үнэт цаас гаргагчаас хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгон нээлттэй гаргахтай холбоотой хууль зүйн дүгнэлт гаргах, Зээлийн багц нь хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хууль зүйн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан бэлтгэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулсан байна. Дээрх гэрээ нь Монгол Улсын Иргэний хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 10.1 болон 10.4 дэх хэсэг, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2.5.5, 2.7 дахь хэсэг болон холбогдох хуульд нийцсэн байна.





Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой хөндлөнгийн хууль зүйн дүгнэлт гаргах бүрэн эрхтэй бөгөөд үүнд харшлах шалтгаан байхгүй болох нь түүний үүсгэн байгуулах баримт бичиг, улсын бүртгэлийн гэрчилгээ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Улсын бүртгэлийн ерөнхий газар”-ын <http://opendata.burtgel.gov.mn/> хаягт заасан нээлттэй мэдээлэл, Санхүүгийн зохицуулах хорооны 338 тоот тогтоол болон Баталгаа гаргах тухай албан бичгээр нотлогдоно.

VIII. Андеррайтерын үйлчилгээ үзүүлэх гэрээ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үнэт цаас гаргагч болон “Апекс капитал ҮЦК” ХХК нарын хооронд 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 23/003 тоот “Андеррайтерын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулсан байна. Тус гэрээгээр Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, андеррайтер нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад шаардлагатай судалгаа шинжилгээ хийх, үнэт цаасыг олон нийтэд нээлттэй санал болгох ажлыг удирдан зохион байгуулах, үүнтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулсан ба талуудын эрх, үүрэг, хариуцлага, гүйцэтгэх ажил үйлчилгээ, үнэ, хугацаа зэргийг багтаасан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн бүртгэлийн журмын 2.4, 2.7-д заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд холбогдох хуульд нийцсэн байна.

Түүнчлэн “Апекс капитал ҮЦК” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, 2011 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн ТЗ 301/62 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээнээс үзвэл андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журмын дагуу андеррайтерын үйл ажиллагааг эрхлэн, дээрх гэрээг байгуулах эрхтэй этгээд байна.

IX. Хэлцлийн зөвлөхийн гэрээ

Хэлцлийн зөвлөх үйлчилгээний гэрээг Үнэт цаас гаргагч болон “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК нар нь 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан байна. Тус гэрээ нь ТЗК-ийг үүсгэн байгуулах, зохицуулалттай үйл ажиллагааны хүрээнд үнэт цаас гаргах, хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх ажилд хэлцлийн зөвлөхөөс зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулсан байх ба энэхүү гэрээний агуулга болон зохицуулалтууд нь Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан хуулийн агуулгад харшлаагүй байх тул хуульд нийцсэн гэж дүгнэлээ.

X. Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 23/014 тоот шийдвэрийн дагуу ТЗК болон “Омни капитал ББСБ” ХХК нар нь 2023 оны 7 дугаар сарын





25-ны өдөр “Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулсан байна. Тус гэрээгээр ТЗК-ийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой захиргааны үйлчилгээ үзүүлэх ажлыг захиргааны үйлчилгээ үзүүлэгч хийж гүйцэтгэх, ТЗК нь ажлын хөлсийг төлөхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлсон байх бөгөөд эдгээр нь Монгол Улсын Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.4, 12.12.5 дахь хэсэг, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.4.5 болон 7.3 дахь хэсэгт тус тус нийцсэн байна.

XI. Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ

Үнэт цаас гаргагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нарын хооронд 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээг байгуулсан байна. ТЗК-ийн ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 23/014 тоот тогтоолоор тус гэрээг байгуулахыг зөвшөөрсөн Бөгөөд гэрээнд дурдсанаар ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгч нарын хооронд байгуулсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний 2.3-т заасан зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларах зээлийн төлбөрийг (буюу орлогыг) барьцаалах, ТЗК-ийн ХБҮЦ-ны төлбөрийг төлөх зорилгоор ТЗК-ийн Төлбөр цуглуулах дансанд тохирсон хугацаанд үл маргах журмаар шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Хуулийн фирм нь энэхүү гэрээг нэг бүрчлэн хянаад Иргэний хууль болон Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн холбогдох заалтад тус тус нийцсэн байна гэж дүгнэлээ.





3.5. Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар

Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээд гэдэгт дараах этгээдийг хамааруулан авч үзсэн болно. Үүнд:

- (i) андеррайтер;
- (ii) анхны үүрэг гүйцэтгүүлэгч;
- (iii) үйлчилгээ үзүүлэгч;
- (iv) хөрөнгө итгэмжлэн удирдагч;
- (v) зээлийн шинжилгээ гаргагч аудитор;
- (vi) хуулийн фирм.

Ашиг сонирхлын зөрчил байгаа эсэхийг тогтоохын тулд мөн Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан нөхцөл байдал үүссэн эсэх мөн ТЗК, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүд нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.3 болон Банкны тухай хуулийн 3.1.2-г заасан холбоотой этгээдүүд эсэхийг тогтоон шалгах шаардлагатай ба үүнийг дараах байдлаар гүйцэтгэсэн болно. Үүнд:

- (i) Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч болох “Омни капитал ББСБ” ХХК-иас 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 1/2038 тоот албан бичгээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.3 болон Банкны тухай хуулийн 3.1.2-г заасан холбоотой этгээдийн жагсаалтыг бидэнд ирүүлсэн болно. Уг албан бичигт дурдсан этгээдүүдэд андеррайтер, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн аудитор болон хуулийн фирм нар нь байхгүй буюу тэдгээр нь холбоотой этгээдүүд биш болно.
- (ii) Үнэт цаас гаргагч болон “Омни капитал ББСБ” ХХК-аас андеррайтер, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн аудитор болон хуулийн фирмтэй санхүүгийн болон санхүүгийн бус нэгдмэл ашиг сонирхолгүй тухайгаа дор дурдсан албан бичгээр бидэнд ирүүлсэн болно. Үүнд:
 - “Омни ассет ТЗК” ХХК-ийн 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 23/006 тоот Баталгаа;
 - “Омни капитал ББСБ” ХХК-ийн 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 1/1464 тоот Баталгаа.
- (iii) Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүд нь Үнэт цаас гаргагчтай санхүүгийн болон санхүүгийн бус нэгдмэл ашиг сонирхолгүй тухай дор дурдсан албан бичгийг бидэнд ирүүлсэн. Үүнд:
 - “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК-ийн 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 23/29 тоот албан бичиг;
 - “Шонхор үнэлгээ аудит” ХХК-ийн 2023 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 23/53 тоот албан бичиг;



2023-11-15
БҮРТГЭВ-02

СЗХ
2023-11-08 өдөр
БҮРТГЭВ
№ 1

- “Апекс Капитал ҮЦК” ХХК-ийн 2023 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 178 тоот албан бичиг;
- Омгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН-ийн 2023 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн У/23/239 тоот албан бичиг.

Дээрхээс дүгнэвэл үйлчилгээ үзүүлэгч этгээдээс бусад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүдийн хооронд ашиг сонирхлын зөрчил үүсээгүй байна.

Үйлчилгээ үзүүлэгч этгээд болох “Омни капитал ББСБ” ХХК нь Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч байх тул хуульд заасны дагуу холбогдох этгээдүүд байх боловч Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19.8-д заасны дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэж болохоор байна.



УДААНГААТАР ХОТ
ОМНИ АССЕТ
ХХК



3.6. Хөрөнгийн багц дахь хөрөнгийн төрөл бүрээс хамааруулан санамсаргүй түүврийн аргаар сонгох замаар үнэт цаас гаргагчаас тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлт хангаж буй эсэх талаар

Хуулийн хөндлөнгийн шинжээчийн үйлчилгээ үзүүлэх ажлын даалгаврын хүрээнд ХаанЛекс нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч (цаашид “Зээлдүүлэгч” гэх)-ийн автомашины зээлийн хөрөнгө, үл хөдлөх эд хөрөнгийн барьцаагаар баталгаажсан зээлийн хөрөнгө бүхий нийт 432 зээлийн багцаас тасалбар болгох өдөр (буюу 2023 оны 7 дугаар сарын 06-ны өдөр)-ийн байдлаар 11%-ийг буюу 47 зээлийг санамсаргүй түүврийн аргаар сонгон, Үнэт цаас гаргагчаас тавь сан хуулийн шалгуур үзүүлэлтийг (цаашид “Хуулийн шалгуур үзүүлэлт” гэх) хангаж буй эсэхэд хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээ (цаашид “Дүн шинжилгээ” гэх) хийж, Дүн шинжилгээний дүгнэлт (цаашид “Дүгнэлт” гэх) гаргасан болно.

Ингэхдээ бид энэхүү дүгнэлтийн “Удиртгал ба дүгнэлтийн хүрээ” хэсэгт заасан зарчмыг баримтлан зээлийн хувийн хэргийг нэг бүрчлэн шалган, дор дурдсан хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцэж буй эсэхэд дүгнэлт хийж, холбогдох алдаа дутагдлыг илрүүлэн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэн, засаж ирүүлсний эцэст хөндлөнгийн дүн шинжилгээ гаргасан болно (Дүн шинжилгээний явцад илэрсэн зөрчил, шийдвэрлэлтийн жагсаалтыг Хавсралт № 3-т тусгав).

№	Хуулийн шалгуур үзүүлэлт
1.	Зээлийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.
2.	Фидуцийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.
3.	Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.
4.	Фидуцийн гэрээний дагуу автомашиныг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн байх, холбогдох бүртгэлийг хийлгэсэн байх, үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжинд хангуулах боломжтой байх.
5.	Фидуцийн зүйл, үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний барьцаа хөрөнгө нь хуульд заасны дагуу төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө биш байх.
6.	Тасалбар болгох өдрийн байдлаар фидуцийн зээлийн гэрээ, үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээний үүрэг дуусгавар болоогүй, үүрэг гүйцэтгэгчийн хувьд аливаа сөрөг шаардлага гаргаагүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх.
7.	Зээлдэгч нь эрх зүйн бүрэн чадамжтай эсэх.





8.	Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгуулсан байх
9.	Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь Үнэт цаас гаргагчийн эзэмшилд шилжих боломжтой бөгөөд эрхийн доголдолгүй байх.
10.	Зээлийн гэрээнд заасны дагуу зээлийг зээлдэгчийн зээлийн дансанд шилжүүлсэн, эсхүл зээлдэгч зээлийн данснаас зээлээ ашигласан байх.

Түүврийн аргаар сонгон авсан 47 зээл нь хуулийн шалгуур үзүүлэлтүүдийг дараах байдлаар хангаж байна. Үүнд:

Шалгуур үзүүлэлт №1. Зээлийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.

Зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлдэгчидтэй байгуулсан 47 зээлийн гэрээнд Зээлдүүлэгчийн гүйцэтгэх захирлаас Зээлдүүлэгчийг төлөөлж гэрээ байгуулах эрх олгогдсон этгээд болон зээлдэгчид (зарим тохиолдолд хамтран зээлдэгчид) гарын үсэг зурж, Зээлдүүлэгчийн тамга дарагдаж, нотариатаар гэрчлэгдэн, Иргэний хууль (“ИХ”)-ийн 451 дүгээр зүйлийн 451.2 дахь хэсэгт зааснаар бичгээр байгуулагдсан нь тэдгээр зээлийн хувийн хэрэгт авагдсан байна.

Фидуцийн зээлийн гэрээ, үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээнүүд нь Зээлдүүлэгчийн гүйцэтгэх захирлын 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн А/01 дүгээр тушаал, 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн А/005 дугаар тушаалаар тус тус батлагдсан стандарт гэрээний нөхцөлийн дагуу байгуулагдсан байх бөгөөд зээлийн гэрээний нөхцөл бүрт агуулгын хувьд дүн шинжилгээ хийхэд ИХ-ийн 56.1.1, 202.1 дэх хэсэгт заасан зээлийн гэрээ, эсхүл түүний хэсэг нь (ИХ-ийн 61.1, 202.5) хүчин төгөлдөр бус гэж тооцогдох нөхцөл бүрдээгүй, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (“БЭБХЭМХМХШЗҮАгХ”)-д заасан шаардлагуудыг хангасан, хүчин төгөлдөр гэж үзэхээр байна.

Гэвч Гүйцэтгэх захирлын 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн А/005 тоот тушаалаар “Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээ”-ний загварт өөрчлөлт оруулахдаа тус зээлийн гэрээний “Тав” дахь хэсэгт зээлийг төлөх болон үүргийн биелэлтийг хангахдаа фидуцийн гэрээ байгуулна гэж дурдсан нь агуулгын хувьд алдаатай байх хэдий ч тус зээлийн гэрээний хамтаар “Үл хөдлөх хөрөнгийн Барьцааны гэрээ” байгуулсан нь Зээлдүүлэгчийн “Зээлийн бодлого”-ын 6.3.1-д “ББСБ нь барьцааны зүйлгүйгээр зээл олгохгүй” гэж, 5.1.1.2-г “Иргэдийн зээл ... барьцаа, баталгааг харгалзан хэрэглээ болон бизнесийн зээл олгоно” гэж тус тус заасантай нийцсэн бөгөөд талууд үүргийн гүйцэтгэлийг хангах барьцааны аргыг тохиролцсон, зээлийн гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй гэж үзэв.

Түүнчлэн Фидуцийн зээлийн гэрээний 5.4 дэх хэсэгт “Зээлдэгч зээл, зээлийн хүүгийн төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, үүргээ биелүүлээгүй тохиолдолд эд хөрөнгө өмчлөлд





шилжүүлэх /фидуци/ гэрээнд заагдсан эд хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах”, Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээний 5.5 дахь хэсэгт “Зээлдэгч нь Барьцааны гэрээгээр бусад үүрэг гүйцэтгүүлэгчдээс тэргүүн ээлжинд үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар өөрийн хууль ёсны өмчлөлийн хөрөнгөө зээлийн барьцаанд тавьж барьцаалуулах” гэх зэргээр зээлийн гэрээнд үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг тусгажээ.

Мөн зээлийн гэрээнүүдэд “Зээлийг энэхүү хуваарьт заасан хугацаанд төлж барагдуулаагүй тохиолдолд зээлийн хугацаа хэтэрсэн өдрөөс эхлэн “нэмэгдүүлсэн хүү төлөх”, “Нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээг үндсэн хүүгийн 20%-аар тооцох”-оор тус тус заасан нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид учирч болзошгүй аливаа эрсдэл, хохирлоос хамгаалж, зээлдэгчдээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахад чиглэсэн байна.

Иймд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн гэрээнүүд нь хүчин төгөлдөр, гэрээ хуульд заасан шаардлагад нийцсэн бөгөөд Талуудын гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх шалгуурыг хангасан байна гэж дүгнэлээ.

Шалгуур үзүүлэлт №2. Фидуцийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.

ХаанЛекс нь нийт түүвэрлэн авсан зээлийн багцад хамаарах 39 фидуцийн гэрээ шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийсэн болно.

Фидуцийн гэрээнүүд нь Иргэний хуулийн 235.5 дахь хэсэгт заасан бичгээр байгуулагдах шаардлагын дагуу байгуулагдсан, гэрээнд зээлдэгч буюу үүрэг гүйцэтгэгчид, мөн Зээлдүүлэгчийн гүйцэтгэх захирлаас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр эрх бүхий этгээд Зээлдүүлэгчийн төлөөлж гарын үсэг тус тус зурсан ба Зээлдүүлэгчийн тамга дарагдаж, нотариатаар гэрчлэгдсэн байна.

Мөн гэрээнүүд нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн гүйцэтгэх захирлын 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан стандарт гэрээний нөхцөлөөр байгуулагдсан байх бөгөөд гэрээний нөхцөл бүрт агуулгын хувьд дүн шинжилгээ хийхэд ИХ-ийн 56.1.1, 202.1 дэх хэсэгт зааснаар фидуцийн гэрээ, эсхүл түүний аль нэг хэсэг (ИХ-ийн 61.1, 202.5) хүчин төгөлдөр бусад тооцогдох нөхцөл бүрдээгүй байна.

Фидуцийн гэрээний 2.8 дахь хэсэгт үүрэг хүлээгч нь хөрөнгийн хууль ёсны өмчлөгч бөгөөд өмчлөх эрхтэй холбоотой аливаа маргаан байхгүй болохыг баталж, 2.6 дахь хэсэгт фидуцийн зүйлд даатгалын тохиолдол бий болсон бол төлбөрийг Зээлдүүлэгч хүлээн авах, 2.9 дэх хэсэгт үүрэг хүлээгч нь хөрөнгийн ашиглалт, эзэмшилтэй холбоотой шаардлагатай засвар, үйлчилгээг хийх, хөрөнгийн үнэлгээг бууруулахгүй байх, 5.1 дэх хэсэгт зээлдэгч зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд Зээлдүүлэгч нь хөрөнгийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлж, хөрөнгийг хураан авах, цааш худалдан борлуулах замаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрхтэй байх, 4.2.6 дахь хэсэгт хөрөнгийг борлуулсан орлогоор зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд үүрэг хүлээгчээс нэмэлт хөрөнгө гаргуулах, үлдэгдэл төлбөрийг үүрэг хүлээгчээр төлүүлэх эрхтэй байхаар





тус тус зохицуулсан нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид учирч болзошгүй эрсдэл, хохирлоос хамгаалсан байна.

Иймд фидуцийн гэрээнүүд нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх хуульд заасан шалгуурыг хангаж байна.

Шалгуур үзүүлэлт №3. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.

Зээлийн багцад хамаарах, түүвэрлэн авсан 8 үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхэд тус гэрээнүүд нь ИХ-ийн 156.1 дэх хэсэгт заасан бичгээр байгуулагдах шаардлагын дагуу байгуулагдсан, гэрээнд зээлдэгч буюу үүрэг гүйцэтгэгчид, мөн Зээлдүүлэгчийн гүйцэтгэх захирлаас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр эрх бүхий этгээд Зээлдүүлэгчийг төлөөлж тус тус гарын үсэг зурсан ба Зээлдүүлэгчийн тамга дарагдаж, нотариатаар гэрчлэгдсэн байна.

Мөн гэрээнүүд нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн гүйцэтгэх захирлын 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар батлагдсан стандарт гэрээний нөхцөлөөр байгуулагдсан байх бөгөөд зээлийн гэрээний нөхцөл бүрт агуулгын хувьд дүн шинжилгээ хийхэд ИХ-ийн 56.1.1, 202.1 дэх хэсэгт зааснаар Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ, эсхүл түүний аль нэг хэсэг (ИХ-ийн 61.1, 202.5) хүчин төгөлдөр бусад тооцогдох нөхцөл бүрдээгүй байна.

Түүвэрлэн авсан 8 үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний дагуу барьцаалуулагчийн орон сууц, хувийн сууц болон газар өмчлөх эрхийг барьцаалсан байх ба ИХ-ийн 156.2 дахь хэсэг, Үл хөдлөх эд хөрөнгө барьцааны тухай ("ҮХЭХБтХ") хуулийн 12.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу тэдгээр барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгүүлж, улсын бүртгэгчийн тамга дарагдсан нь зээлийн хувийн хэрэгт авагдсан байна.

Мөн гэрээнд талуудын нэр, оршин суугаа /оршин байгаа/ газар, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг тодорхой дурдаж, гэрээний 1.1, 1.2 дахь заалтад холбогдох зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийн биелэлтийг хангах зорилгоор хөрөнгө барьцаалж байгаа талаар, 4.2 дахь заалтад зээлийн гэрээний үүргээ зөрчсөн, үүргээ биелүүлээгүй зэрэг нөхцөл бий болсон үед үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулах талаар тус тус зохицуулсан байх тул ИХ-ийн 156.2 дахь хэсэг, ҮХЭХБтХ-ийн 11.1-д заасан барьцааны гэрээний агуулгын шаардлагыг хангагдсан гэж үзлээ. Мөн зарим гэрээгээр барьцааны эрхийг гэрчлэхээр талуудын тохиролцсоны дагуу үйлдсэн барьцаалбар нь ҮХЭХБтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан агуулгын шаардлагыг хангаж байна.

Иймд үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээнүүд нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх хуульд заасан шалгуурыг хангаж байна.





Шалгуур үзүүлэлт №4. Фидуцийн гэрээний дагуу автомашиныг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн байх, холбогдох бүртгэлийг хийлгэсэн байх, үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжинд хангуулах боломжтой байх.

Фидуцийн гэрээний хувьд ИХ-ийн 235 дугаар зүйлийн 235.1 дэх хэсэгт заасны дагуу фидуцийн зүйл (буюу автомашин)-ийг үүрэг гүйцэтгүүлэгч (буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч)-ийн өмчлөлд шилжүүлснээр үүрэг гүйцэтгэгч үүргээ хугацаандаа биелүүлээгүй тохиолдолд өмчлөлд шилжүүлсэн эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгч бодитойгоор гаргуулан авч, үүрэг гүйцэтгүүлэгчээс үүргийн гүйцэтгэлийг хангуулах нөхцөл бүрддэг.

Үүнийг баталгаажуулах зорилгоор Хаанлекс нь “Авто тээврийн үндэсний төв”-өөс гаргуулж авсан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн “Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа” (одоо эзэмшиж байгаа)-г шүүж үзэхэд түүвэрлэн авч, шинжилгээ хийсэн 36 фидуцийн гэрээний зүйл болох автомашинууд нь Зээлдүүлэгчийн өмчлөлд бүрэн шилжсэн байх ба холбогдох бүртгэлийг хийлгэсэн байна.

“Шалгуур үзүүлэлт 3”-г дурдсанчлан үл хөдлөх эд хөрөнгө буюу орон сууц, хувийн сууц, газар өмчлөх эрхийн хувьд улсын бүртгэлийн байгууллагад барьцааг бүртгүүлснээр шаардлага хангагдана.

Иймд фидуцийн гэрээний дагуу автомашиныг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн, холбогдох бүртгэлийг хийлгэж, үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжинд хангуулах боломжийг бүрдүүлж тус шаардлагыг хангасан байна.


Шалгуур үзүүлэлт №5. Фидуцийн зүйл, үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний барьцаа хөрөнгө нь хуульд заасны дагуу төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө биш байх.

Түүвэрлэгдсэн 47 зээлд хамаарах фидуцийн зүйл, барьцаа хөрөнгүүд нь хуульд заасан төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө биш байх шаардлагатай бөгөөд барьцаа хөрөнгүүдийн хувьд үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээгээр орон сууц, хувийн сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө, газар өмчлөх эрхийг барьцаалсан, фидуцийн гэрээний дагуу автомашинаар үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулсан байна.

ҮХЭХБтХ-ийн 9.6 дахь хэсэгт барьцаалуулахыг хориглосон хөрөнгүүдийг заасан байх бөгөөд түүврээр авч үзсэн 8 зээлийн барьцаа үл хөдлөх эд хөрөнгүүд нь эдгээрт хамаарахгүй байна.

Түүнчлэн, фидуцийн гэрээний зүйлийн хувьд хуулиар тодорхой хязгаарлалт тогтоогоогүй, гагцхүү ИХ-ийн 235.1 дэх хэсэгт зааснаар хөдлөх эд хөрөнгө байх шаардлага тавигдсан байх бөгөөд автомашин энэхүү шаардлагыг хангаж байна.





Иймд түүврээр шинжилгээ хийсэн фидуцийн зүйл, үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний барьцаа хөрөнгө нь хуульд заасны дагуу төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө биш байх шаардлага хангасан байна.

Шалгуур үзүүлэлт №6. Тасалбар болгох өдрийн байдлаар фидуцийн зээлийн гэрээ, үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээний үүрэг дуусгавар болоогүй, үүрэг гүйцэтгэгчийн хувьд аливаа сөрөг шаардлага гаргаагүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх.

Энэхүү хуулийн шалгуурын хүрээнд Хаанлекс нь түүвэрлэсэн 47 фидуцийн зээлийн гэрээ, үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээний зээлдэгч тус бүрийн хувийн хэргийг судалж үзсэн. Тасалбар болгох өдрийн байдлаар дээрх гэрээнүүд хугацаанаас өмнө дуусгавар болоогүй буюу зээлдэгчдээс зээлийн төлбөрөө хугацаанаас өмнө толж дуусгах хүсэлт ирүүлээгүй, зээлдэгч нар гэрээний үүргээс татгалзах, зээлдэгчидтэй харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох эрх үүсээгүй эсхүл энэхүү эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй, зээлдэгч нар гэрээний үүргээс татгалзаагүй, талуудын гэрээний үүрэг хүчинтэй хэвээр хэрэгжиж байгаа ба фидуцийн зүйл болох автомашин, барьцааны зүйл устаж үгүй болоогүй, бодитоор байгаа болно. Үүнийг мөн баталгаажуулан, Зээлдүүлэгчээс 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 1/1972 дугаар бүхий албан бичиг буюу “Батламж” ирүүлсэн.

Иймд Хаанлекс нь Тасалбар болгох өдрийн байдлаар фидуцийн зээлийн гэрээ, үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээний үүрэг дуусгавар болоогүй, үүрэг гүйцэтгэгчийн хувьд аливаа сөрөг шаардлага гаргаагүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх шалгуурыг тус тус хангасан гэж дүгнэсэн болно.


Шалгуур үзүүлэлт №7. Зээлдэгч нь эрх зүйн бүрэн чадамжтай эсэх.

ИХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно” гэж заасан ба түүвэрлэн авсан зээлийн гэрээнүүдийн хувийн хэрэгт авагдсан зээлдэгчдийн иргэний үнэмлэхийн хуулбарыг хянаж үзээд, тус зээлдэгчдийг эрх зүйн бүрэн чадамжтай гэж дүгнэж байна.

Шалгуур үзүүлэлт №8. Фидуцийн гэрээний зүйлийг даатгуулсан байх.

Зээлдүүлэгч, зээлдэгч (Үүрэг хүлээгч) нарын хооронд байгуулсан Фидуцийн гэрээний 3.2.14-т: “Үүрэг хүлээгч нь ББСБ-ын гэрээтэй даатгалын байгууллагаар жолоочийн (бүрэн) хариуцлагын даатгал болон тээврийн хэрэгслийн бүрэн даатгал хийлгүүлэх бөгөөд үүнтэй холбогдсон зардлыг бүрэн хариуцна. Үүрэг хүлээгч нь Зээлийн гэрээний үүрэг гүйцэтгээс





дуусгах хүртэл жолоочийн бүрэн хариуцлагын даатгал, тээврийн хэрэгслийн даатгалыг хүчинтэй байлгана” гэж талууд тохиролцжээ.

Зээлийн хувийн хэрэг бүрт Тээврийн хэрэгслийн даатгалын гэрчилгээ (эсхүл холбогдох гэрээ) болон Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний даатгуулагчийн мэдүүлгийн маягт авагдсан байна. Зарим тохиолдолд тухайн тээврийн хэрэгслийн даатгал хийгдсэн талаарх баримтад “Даатгалын дуусах хугацаа”-г гараар бичихдээ андуурч бичих техникийн алдаа гаргасан, мөн даатгалын гэрээний хугацаа дууссан байхад сунгалт хийсэн эсэх талаарх баримт хувийн хэрэгт авагдаагүй байсан зэргийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэж, засуулсан тул фидуцийн гэрээний зүйлүүдийг даатгалд хамруулсан байх шалгуур хангагдсан гэж үзлээ.

Шалгуур үзүүлэлт 9. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь үнэт цаас гаргагчийн эзэмшилд шилжих боломжтой бөгөөд эрхийн доголдолгүй байх.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9.2 дахь хэсэгт: “Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үед үнэт цаас гаргагчийн эзэмшилд байх бөгөөд эрхийн доголдолгүй хөрөнгө байна”, мөн хуулийн 13.2 дахь хэсэгт: “Хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлснээр тухайн хөрөнгөтэй холбоотой аливаа эрх, барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга, санхүүгийн хэрэгсэл хамт шилжсэнд тооцно” гэж тус тус заасан. Өөрөөр хэлбэл, Зээлдүүлэгчээс хөрөнгөөр баталгаажсан хөрөнгийн багцыг ТЗК-д худалдсанаар эдгээр хөрөнгийн багцыг бүрдүүлж буй зээл, фидуцийн гэрээ, барьцааны гэрээтэй холбоотой аливаа эрх ТЗК-д шилжих зохицуулалттай.

ИХ-ийн 123.2 дахь хэсэгт заасны дагуу хэрэв шаардах эрх шилжихийг хууль, гэрээгээр хориглосон, эсхүл үүргийн мөн чанарт харшлах тохиолдолд шаардах эрх шилжих боломжгүй байдаг. Түүвэрлэн шинжилгээ хийсэн 47 зээлийн хувьд Зээлдүүлэгчийн шаардах эрх гуравдагч этгээдэд шилжих боломжтой эсэхийг шалгахад Фидуцийн зээлийн гэрээний 6.3 болон 11.5, Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээний 8.6 болон 11.5 дахь заалтад тус тус “ББСБ нь хэдийд ч энэхүү гэрээгээр эдлэх эрх, хүлээсэн үүргээ дангаараа шийдэн бусдад шилжүүлэх эрхтэй” байхаар заасан байна.

Иймд Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь үнэт цаас гаргагчийн эзэмшилд шилжих боломжтой бөгөөд эрхийн доголдолгүй байна гэж дүгнэж байна.

Шалгуур үзүүлэлт №10. Зээлийн гэрээнд заасны дагуу зээлийг зээлдэгчийн зээлийн дансанд шилжүүлсэн, эсхүл зээлдэгч зээлийн данснаас зээлээ ашигласан байх.





БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 19.5 дахь хэсэгт зааснаар зээлийг зээлдэгчийн дансанд олгосноор, эсхүл зээлдэгч зээлийн данснаас зээлээ ашигласныг зээл олгосонд тооцдог зохицуулалттай.

Фидуцийн зээлийн гэрээ, Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээний 6.2.1 дэх заалтад: “Зээлийг энэхүү гэрээний 3.1.7-д заасан зориулалтын дагуу ашиглах ба зээлийг бусдад дамжуулан зээлдүүлэхгүй” гэж заасан байх ба ИХ-ийн 211.2 дахь хэсэгт “Үүргийн гүйцэтгэлийг хүлээн авах эрхгүй этгээдэд хүлээлгэн өгсөн бол гагцхүү үүрэг гүйцэтгүүлэгч зөвшөөрсөн буюу ийнхүү гүйцэтгэснээр үүрэг гүйцэтгүүлэгч ашиг олсон нөхцөлд уул үүргийг гүйцэтгэсэнд тооцно” хэмээн заасан байдаг.

Түүвэрлэн авсан зээлийн хувийн хэргүүдийг хянаж үзэхэд (i) фидуцийн зээлийн гэрээний дагуу олгож буй зээлийн мөнгөн хөрөнгийг Зээлдэгчээс автомашины борлуулагч иргэн (эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч)-д олгох хүсэлт (зөвшөөрөл) бичгээр гаргасны дагуу Зээлдүүлэгчээс зээлийг автомашины борлуулагчид шилжүүлснээр зээлдэгч автомашин худалдан авсан, (ii) үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээний дагуу зээлдэгч нарын арилжааны банк дахь харилцах данс руу зээлийг шилжүүлсэн байна. Иймд зээлийн гэрээнд заасны дагуу зээлийг зээлдэгчийн зээлийн дансанд шилжүүлсэн, эсхүл зээлдэгч зээлийн данснаас зээлээ ашигласан байх энэхүү шалгуур хангагдсан гэж дүгнэж байна.

Нэгтгэн дүгнэхэд Хөрөнгийн багц нь Үнэт цаас гаргагчаас тогтоосон дээрх хууль зүйн шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байна гэж бид дүгнэлээ.





3.7. Багцын хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрээ, хэлцэлд үүргийн гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгасан эсэх талаар

Санамсаргүй түүврийн аргаар сонгосон нийт 47 гэрээнүүд болох Фидуцийн зээлийн гэрээ, Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээ, Фидуцийн гэрээ, Үл хөдлөх эд хөрөнгө барьцааны гэрээнүүд болон тэдгээр зээлийн хувийн хэрэгт дүн шинжилгээ хийхэд уг гэрээ, хэлцлүүд нь хууль тогтоомжид нийцсэн байна.

ИХ-ийн 123.2 дахь хэсэгт “Хууль, гэрээ буюу үүргийн мөн чанарт харшлахгүй бол шаардах эрх эзэмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ шилжүүлж болно” гэж заасан ба зээлийн багцын хөрөнгөд хамаарах дээр дурдсан 47 гэрээнд үүргийн гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан зохицуулалт байхгүй бөгөөд харин Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлдэгч буюу үүрэг хүлээгчээс хамааралгүйгээр шаардах эрхээ шилжүүлэх эрхтэй байхаар тохиролцсон байна.





3.8. Үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, бусад холбогдох хууль журамд нийцэж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх

Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны танилцуулга нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 5.7, МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг тус тус хангасан байх ёстой. Үнэт цаас гаргагчийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулга нь нийт 6 бүлгээс бүрдэх бөгөөд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгад заавал тусгах суурь мэдээллийг бүрэн багтаасан байх тул холбогдох хууль журамд нийцэж байна гэж үзэж болохоор байна.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллийн үнэн зөвийг оролцогч этгээдүүдийн үүсгэн байгуулах болон бусад холбогдох баримт бичигтэй тулган шалгах, оролцогч этгээдүүд болон төрийн эрх бүхий байгууллагаас тодруулга, лавлагаа авах замаар шалгахад түүнд тусгагдсан мэдээллүүд нь тухайн баримт бичигтэй нийцэж байх тул үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээллийг үнэн зөв, хүчин төгөлдөр гэж дүгнэж байна. Дэлгэрэнгүй хууль зүйн шинжилгээ, дүгнэлтийг Хавсралт № 1-ээс үзнэ үү.

Түүнчлэн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан ТЗК болон “Омни капитал ББСБ” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнуудын талаарх мэдээлэл үнэн зөв бөгөөд хуульд нийцсэн эсэх тухай хууль зүйн шинжилгээ, дүгнэлтийг Хавсралт № 2-оос үзнэ үү.

Дүгнэлт гаргасан:



Идэрхангайн Учралбаяр
Гүйцэтгэх захирал, хуульч, нөхөрлөлийн гишүүн

2023 оны 8 дугаар сарын 24-ний өдөр



“ОМНИ АССЕТ” ХХК

“ОМНИ АССЕТ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга сонгох тухай

2023 оны 05 сарын 23-ны өдөр

№ ХЭХ-23/001

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, “Омни ассет” ХХК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Омни ассет” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Арьяасүрэн овогтой Батболд /РД: ХО74030310/-г сонгосугай.
2. ТУЗ-ийн дарга А.Батболдод Компанийн тухай хууль болон тус компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:



С.НИНА

А.БАТБОЛД

Х.ХЭРЛЭН



2023-11-15

БҮРТГЭЭХ

“ОМНИ АССЕТ” ХХК



“ОМНИ АССЕТ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 05 сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Хурлын ирц: ТУЗ-н гишүүн С.Нина
ТУЗ-н гишүүн Х.Хэрлэн
ТУЗ-н гишүүн А.Батболд
100%-ийн ирцтэйгээр хуралдав.

Хурал болсон газар: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр оффис, 712 тоот хурлын өрөө

Хурал эхэлсэн, дууссан: 2023.05.23, Пүрэв гариг, 17:00 цагт эхэлж 18:00 цагт дуусав.
Асуудлыг хэлэлцсэн: 17:00 цагт хэлэлцэж 17:31 цагт батлав.
Хурлаар хэлэлцсэн асуудал: ТУЗ-ийн даргыг шинээр томилох тухай

Хэлэлцсэн нь:

- ТУЗ-ийн даргыг шинээр томилох тухай

ТУЗ-ийн гишүүд нь:

“Омни ассет” ХХК-ийн ТУЗ шинээр байгуулагдсан тул ТУЗ-ийн гишүүдээс даргыг сонгох асуудлыг танилцуулж, хэлэлцэв.

Шийдвэрлэсэн нь:

Хэлэлцсэн асуудлын хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөл дараах шийдвэрийг санал нэгтгэйгээр гаргав.

- А.Батболдыг 2023 оны 5 сарын 23-ны өдрөөс ТУЗ-ийн даргаар сонгов.

Хурлын тэмдэглэлийг баталгаажуулсан:

ТУЗ-ийн дарга А.Батболд: _____

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ТУЗ-н гишүүн С.Нина: _____

ТУЗ-н гишүүн Х.Хэрлэн: _____



ЧХЛТэмжамц ДАВААСӨРЭН

Digitally signed by ЧХЛТэмжамц ДАВААСӨРЭН
Date: 2023.05.30 12:13:44 +08'00'

СХХ
2023 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 11

"Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар"-ын 1 дүгээр хавсралт

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчин нь дараах мэдээлэл

1. Ерөнхий мэдээлэл

Ургийн овог:	Монголмууд
Овог нэр:	Арьяасүрэн Батболд
Регистрийн дугаар:	ХО74030310
Иргэний харьяалал:	Монгол
ТЗК-д эрхлэх албан тушаал:	ТУЗ-ийн гишүүн
Оршин суугаа газрын хаяг	УБ, ХУД, 19 хороо, 24/5 байр, 62 тоот
Гар утасны дугаар	88886978
Цахим хаяг	Batbold@grandlex.mn
Эрхэлж байгаа ажил, албан тушаал	Грандлекс Партнерс ХХК хуульч
Ажлын хаяг	УБ, СБД 1-р хороо Олимпийн гудамж 3 байрны 74 тоот
Цахим хаяг	Batbold@grandlex.mn



2. Боловсрол /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар
1	23-р дунд сургууль	Бүрэн дунд	1981	1991	
2	МУИС ХЗС	Эрх зүйч	1995	1997	
3	МУИС ХЗС	Хууль зүйн ухааны магистр	1997	1999	
4	Отгонтэнгэр их сургууль	Орчуулагч багш	1991	1995	

3. Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан
1	ИАЙТи	Гүйцэтгэх захирал	2012	2014	Өөрийн хүсэлтээр
2	Монет капитал	Гүйцэтгэх захирал	2014	2015	Өөрийн хүсэлтээр
3	Ард даатгал ХК	Гүйцэтгэх захирал 2015-2017 он, үйл ажиллагаа эрхэлсэн захирал 2017-2020он	2015	2020	Өөрийн хүсэлтээр
4	Грандлекс ХХК Партнерс	Хуульч	2021	Одоог хүртэл	

Handwritten signature



2023-11-15

4. ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага бусад боловсон хүчний холбогдох этгээдийн байдал:

БҮРТГЭЭВ-02

Компанийн тухай хуулийн 89.2-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл

№	Таны хэн болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эрхэлж буй ажил, албан тушаал

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

ТУЗ-ийн гишүүн
/Албан тушаал/

Ардлаасурт Балдас
/Овог, нэр/

[Signature]
/гарын үсэг/

2023.05.23
/огноо/

[Signature]

УЛААНБААТАР ХОТ
ОЛИМПСЕТ ХХТ

2023 -11- 15
БҮРТГЭВ-02

ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ АСУУЛГА



	Асуулт	Хариулт
1.	Таны ажиллах байгууллагын нэр	Омни Ассет ТЗК ХХК
2.	Овог Нэр Өөр нэртэй байсан эсэх Хүйс (Эрэгтэй/Эмэгтэй)	Арьяасүрэн Батболд Үгүй Эрэгтэй
3.	“Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”ын 1.2-т заасан этгээдийн аль нь болох, албан тушаал? Хуулийн этгээд, Зөвлөлийн гишүүн, хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэх удирдлага, салбарын удирдлага, ажилтан, агент гэх мэт?	Омни Ассет ТЗК ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн
4.	Оршин суугаа хаяг	Хан-Уул дүүрэг, 19 хороо, 24/5 байр, 62 тоот
5.	Өнгөрсөн 10 жилийн хугацаанд оршин сууж байсан хаяг (хамаарах огноог тавих)	Өмнөхтэй ижил
6.	Төрсөн огноо Төрсөн газар (улс, аймаг, хот)	1974 оны 3 сарын 3 Хөвсгөл аймаг Эрдэнэбулган сум
7.	Иргэншил, Хэрэв гадаад улсын иргэн байсан бол иргэншил авсан төрлийг бичнэ үү. (жишээ нь, төрөлт, иргэний харьяаллаа өөрчлөх, гэрлэлт)	Монгол
8.	Регистрийн дугаар	ХО74030310
9.	Одоогийн хашиж буй албан тушаал эсвэл хийж буй ажил болон мэргэжил, сүүлийн 10 жилийн хугацаанд ажиллаж байсан байгууллага, ажил олгогчийн нэр, эрхэлдэг бизнес, хашиж байсан албан тушаал, холбогдох огноо, ажлаас гарсан огноо болон хийж байсан ажил бүрийн хувьд: i. эрхэлж байсан албан тушаалын нэр; ii. ажилд орсон огноо; iii. ажил олгогчийн нэр, хаяг; iv. тодорхойлолт гаргагчийн нэр, албан тушаал, утасны дугаар	2012- 2014 ИАЙТи (одоогийн Ард Санхүүгийн Нэгдэл) ХХК, гүйцэтгэх захирал, Ч.Ганхуяг, 88887392 2014-2015 Монет Капитал (одоогийн Ард Секьюритиз УЦК), Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг, 88887392 2015-2020 Ард Даатгал ХК, гүйцэтгэх захирал, үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Г.Цогбадрах, гүйцэтгэх захирал, 88882359 2021-одоог хүртэл Грандлекс Партнерс ХХК, хуульч, С.Халиунаа, гүйцэтгэх захирал, 99116916

(Handwritten signature)

★★★ АЛБАНЫ НУУЦ





18.	Таныг эсвэл таны ажиллаж байгаа эсвэл захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байсан бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийг төрийн, мэргэжлийн эсвэл бусад зохицуулагч байгууллага шалгаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
19.	Та албан тушаалаасаа чөлөөлөгдөх, ажлаасаа халагдах эсвэл таныг мэргэжлээрээ ажиллахыг хориглож байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
20.	Эрх бүхий этгээд эсхүл шүүхээс таныг дампуурсан гэж үзэж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
21.	Эрх бүхий шүүхийн шийдвэрийн дагуу та төлбөл зохих, төлөх ёстой өрөө төлөхгүй байсан удаа байгаа юу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй

22.	Бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийг байгуулах, хянах, удирдахтай холбоотойгоор эрх бүхий шүүхээс танд тэрхүү байгууллага, компани, гишүүний өмнөөс залилан, эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан хэрэг, бусад албан тушаалын гэмт хэрэгт иргэний эсвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
23.	Таныг ажиллаж байх хугацаанд эсвэл ажиллахаа больсноос хойш нэг жилийн дотор таны захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байсан бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийг хүчээр татан буулгах эсвэл зээлдүүлэгчидтэйгээ тохиролцох, зөвшилцөх эсвэл зээлдүүлэгчид нь төлбөрөө буцаан аваагүй эсвэл бүгдийг нь хараахан буцаан аваагүй байхад худалдааг зогсоож байсан тохиолдол гарч байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
24.	Таны захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байсан бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийн эрхийг цуцлах, хүчингүй болгож байсан уу?	Үгүй
25.	Ажил үүргээ гүйцэтгэхдээ та бусад этгээдэд журам, чиглэл өгөх үүрэгтэйгээр ажиллах уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй

а) Миний бие дээр мэдүүлсэн мэдээллийг бүрэн дүүрэн, үнэн зөв болохыг баталж байна. Түүнчлэн, миний бие дээр заасан асуултын хариултын бүрэн дүүрэн байдалд нөлөөлөх аливаа материаллаг өөрчлөлтийг 21 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлэх үүрэг хүлээж байна.

Огноо: 2023.05.19

Гарын үсэг:

★★★ АЛБАНЫ НУУЦ





"Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар"-ын 1 дүгээр хавсралт

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчин нь дараах мэдээлэл

1. Ерөнхий мэдээлэл

Ургийн овог:	Урианхай
Овог нэр:	Сосор Нина
Регистрийн дугаар:	БЮ84112701
Иргэний харьяалал:	Монгол
ББСБ-д эрхлэх албан тушаал:	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Зээл эрхэлсэн захирал
Оршин суугаа газрын хаяг	УБ хот, ХУД, 3-р хороо, Хос өргөө хотхон, 296-3 тоот
Гар утасны дугаар	99041127
Цахим хаяг	Nina@omnicapital.mn
Эрхэлж байгаа ажил, албан тушаал	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Зээл эрхэлсэн захирал
Ажлын хаяг	УБ хот, СБД, 8-р хороо, Монгол ньяс тауэр, 403 тоот
Цахим хаяг	Nina@omnicapital.mn



2. Боловсрол /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элсэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар
1	Өлзийт дээд сургууль	Банкны эдийн засаг	2002	2006	D200603749
2	СЭЭС-МВА	Бизнесийн удирдлага	2016	2018	E20186454

3. Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан
	Хас банкинд	Зээлийн мэргэжилтэн	2006.05		Хувийн
	Хас банкинд	Зээлийн менежер			Хувийн
	Хас банкинд	Зээлийн эрдэлийн шинжээч		2017.05	Хувийн
	Омни капитал ББСБ ХХК-д	Эдийн засагч	2017.08	2018.04	
	Омни капитал ББСБ ХХК-д	Гүйцэтгэх захирал	2018.04	2022.08	
	Омни капитал ББСБ ХХК-д	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Зээл эрхэлсэн захирал	2022.09	-	



2023-11-15

БҮРТГЭВ-02

СЭХ
он 2023 сар 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2022 оны 6 дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ АСУУЛГА

/Журмын 1.2-т заасан этгээдийн хувийн мэдээллийн асуулга/

	Асуулт	Хариулт
1.	Таны ажиллаж буй байгууллагын нэр	"Омни капитал ББСБ" ХХК
2.	Овог: <i>Cosor</i> Нэр: <i>Нина</i> Өөр нэртэй байсан эсэх Хүйс (Эрэгтэй/Эмэгтэй)	Үгүй
3.	"Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-ын 1.2-т заасан этгээдийн аль нь болох, албан тушаал? Хуулийн этгээд, Зөвлөлийн гишүүн, хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэх удирдлага, салбарын удирдлага, ажилтан, агент гэх мэт?	Үгүй
4.	Оршин суугаа хаяг	ХУД-ийн 15-р хороо Стадион оргил /17011/ махатма ганди гудамж 131 байр 1907 тоот
5.	Өнгөрсөн 10 жилийн хугацаанд оршин сууж байсан хаяг (хамаарах огноог тавих)	ХУД-ийн 3-р хороо үйлдвэрчдын гудамж Хос өргөө хотхон 296 байрны 13 тоот
6.	Төрсөн огноо Төрсөн газар (улс, аймаг, хот)	1984 он Баян-Өлгий хот
7.	Иргэншил, Хэрэв гадаад улсын иргэн байсан бол иргэншил авсан төрлийг бичнэ үү. (жишээ нь, төрөлт, иргэний харьяаллаа өөрчлөх, гэрлэлт)	Монгол
8.	Регистрийн дугаар	БЮ84112701





<p>Одоогийн хашиж буй албан тушаал эсвэл хийж буй ажил болон мэргэжил, сүүлийн 10 жилийн хугацаанд ажиллаж байсан байгууллага, ажил олгогчийн нэр, эрхэлдэг бизнес, хашиж байсан албан тушаал, холбогдох огноо, ажлаас гарсан огноо болон хийж байсан ажил бүрийн хувьд:</p> <p>i.эрхэлж байсан албан тушаалын нэр; ii.ажилд орсон огноо; iii.ажил олгогчийн нэр, хаяг; iv.тодорхойлолт гаргагчийн нэр, албан тушаал, утасны дугаар</p> <p>i.эрхэлж байсан албан тушаалын нэр; ii.ажилд орсон огноо; iii.ажил олгогчийн нэр, хаяг; iv.тодорхойлолт гаргагчийн нэр, албан тушаал, утасны дугаар</p> <p>9. i.эрхэлж байсан албан тушаалын нэр; ii.ажилд орсон огноо; iii.ажил олгогчийн нэр, хаяг; iv.тодорхойлолт гаргагчийн нэр, албан тушаал, утасны дугаар</p> <p>i.эрхэлж байсан албан тушаалын нэр; ii.ажилд орсон огноо; iii.ажил олгогчийн нэр, хаяг; iv.тодорхойлолт гаргагчийн нэр, албан тушаал, утасны дугаар</p> <p>i.эрхэлж байсан албан тушаалын нэр; ii.ажилд орсон огноо; iii.ажил олгогчийн нэр, хаяг; iv.тодорхойлолт гаргагчийн нэр, албан тушаал, утасны дугаар</p>	<p>Зээлийн газрын захирал албан тушаал, 2017 онд орсон Омни капитал ББСБ Ч.Эрэлхэг, Гүйцэтгэх захирал 99073620</p> <p>Зээлийн эрсдэлийн шинжээч, 2006-2017 Хасбанк Захирал Оюун-Эрдэнэ</p>
<p>10. Та одоо бүртгэгдсэн байгууллагын– (a)захирал эсвэл хянагч уу? (b)сүүлийн 10 жилийн хугацаанд захирал эсвэл хянагчаар ажиллаж байсан уу? (тохиолдол бүр болон бизнесийн төрлийн хувьд үүсгэн байгуулагдсан улсын нэрийг бичих)</p>	<p>Үгүй</p>
<p>11. Санхүүгийн байгууллагад эзэмшдэг хувь эзэмшлийн мэдээлэл (одоогийн болон сүүлийн 10 жилийн хугацаанд) (a)компанийн нэр (b)үүсгэн байгуулагдсан улс (c)эзэмшлийн хувь (d)бизнесийн төрөл</p>	<p>байхгүй</p>
<p>12. (a)эзэмшсэн боловсрол, төгссөн жил (b)боловсролын зэрэг</p>	
<p>13. Төрийн байгууллагын аливаа тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл хүссэн өргөдөлд татгалзсан хариу авч байсан эсэх?</p>	<p>Үгүй</p>





2023 - 11
БҮРТГЭВ

14.	Иргэний эсвэл цэргийн эрх бүхий шүүхээс таныг хэрэгт буруутгаж байсан эсэх (а)тухайн хэргийг сүүлийн 10 жилийн дотор давтан үйлдсэн байхаас бусдаар бол насанд хүрээгүй буюу 18 нас хүрээгүй байхдаа үйлдсэн хэрэг эсвэл (б)тээврийн хэрэгслийн ашиглалт, өмчлөлтэй холбоотой хялбаршуулсан байдлаар шийдсэн хэргээс бусад)? Тийм бол хүлээлгэсэн хариуцлага, шийтгүүлсэн бол шийтгэл хүлээлгэсэн огноо, ногдуулсан хэрэг, торгуулийн талаар дэлгэрэнгүй бичих	Үгүй
15.	Таныг санхүүгийн болон санхүүгийн бус байгууллага, виртуал хөрөнгө гаргагч, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан мөрдөн шалгаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих	Үгүй
16.	Та хамаарагддаг, хамаарагдаж байсан мэргэжлийн байгууллагаас танд шийтгэл, сахилгын шийтгэл ногдуулах эсвэл муу үнэлгээ өгөх эсвэл та нөхцөл тавьсан мэргэжлийн үнэмлэхтэй байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	
17.	Танаас залилан, луйвар эсвэл ижил төстэй хэргийн шүүх хурал, хэрэг хянан хэлэлцэх ажиллагаанд шинжээч, гэрчийн хувиар бус өөр этгээдийн хувиар нотлох баримт гаргаж өгөхийг шаардаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
18.	Таныг эсвэл таны ажиллаж байгаа эсвэл захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байсан бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийг төрийн, мэргэжлийн эсвэл бусад зохицуулагч байгууллага шалгаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
19.	Та албан тушаалаасаа чөлөөлөгдөх, ажлаасаа халагдах эсвэл таныг мэргэжлээрээ ажиллахыг хориглож байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
20.	Эрх бүхий этгээд эсхүл шүүхээс таныг дампуурсан гэж үзэж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
21.	Эрх бүхий шүүхийн шийдвэрийн дагуу та төлбөл зохих, төлөх ёстой өрөө төлөхгүй байсан удаа байгаа юу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
22.	Бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийг байгуулах, хянах, удирдахтай холбоотойгоор эрх бүхий шүүхээс танд тэрхүү байгууллага, компани, гишүүний өмнөөс залилан, эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан хэрэг, бусад албан тушаалын гэмт хэрэгт иргэний эсвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
23.	Таныг ажиллаж байх хугацаанд эсвэл ажиллахаа больсноос хойш нэг жилийн дотор таны захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байсан бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийг хүчээр татан буулгах эсвэл зээлдүүлэгчидтэйгээ тохиролцох, зөвшилцөх эсвэл зээлдүүлэгчид нь төлбөрөө буцаан аваагүй эсвэл бүгдийг нь харахан буцаан аваагүй байхад худалдааг зогсоож байсан тохиолдол гарч байсан уу?Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй



СЭХ
он 2023 сэр 11. 08 өдөр
БҮРТГЭВ
№ 31

2023 24.11.11	Таны захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байсан бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийн эрхийг цуцлах, хүчингүй болгож байсан уу?	Үгүй
25.	Ажил үүргээ гүйцэтгэхдээ та бусад этгээдэд журам, чиглэл өгөх үүрэгтэйгээр ажиллах уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй


а) Миний бие дээр мэдүүлсэн мэдээллийг бүрэн дүүрэн, үнэн зөв болохыг баталж байна. Түүнчлэн, миний бие дээр заасан асуултын хариултын бүрэн дүүрэн байдалд нөлөөлөх аливаа материаллаг өөрчлөлтийг 21 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлэх үүрэг хүлээж байна.

Огноо:



Гарын үсэг:





"Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар"-ын 1 дүгээр хавсралт

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчин нь дараах мэдээлэл

1. Ерөнхий мэдээлэл

Ургийн овог:	Мөнх
Овог нэр:	Хүрэлбаатар Хэрлэн
Регистрийн дугаар:	УХ95020413
Иргэний харьяалал:	Монгол
ТЗК-д эрхлэх албан тушаал:	ТУЗ-ийн гишүүн
Оршин суугаа газрын хаяг	Булган Тэшиг 5-р баг, Жаргалант
Гар утасны дугаар	99994734
Цахим хаяг	kherlenkhurelbaatar@gmail.com
Эрхэлж байгаа ажил, албан тушаал	Борлуулалтын менежер
Ажлын хаяг	
Цахим хаяг	Kherlen_kh@golomtbank.com



2. Боловсрол /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар
1	Булган аймгийн Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургууль	Дунд	2002	2010	
2	Kings Kids сургууль	Бүрэн дунд	2010	2012	
3	Монгол улсын их сургууль	Түүх (Бакалавр)	2012	2016	
4	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль	Санхүү менежмент (Магистр)	2020	2022	

3. Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан
1	Smart Visa Consulting	Зөвлөх	2018/01/02	2019/03/26	
2	Голомт банк	Борлуулалтын менежер	2019/03/27	Одоог хүртэл	
				-	



2023-11-15

БҮРГЭЭВ-02

4. ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага бусад боловсон хүчний холбогдох этгээдийн байдал:

Компанийн тухай хуулийн 89.2-г заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл

№	Таны хэн болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эрхэлж буй ажил, албан тушаал

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

1. М.З. Чинзориг /Албан тушаал/ 2. Х.Х.Эрхтэн /Овог, нэр/ 3. А.Хүрэн /гарын үсэг/ 4. /огноо/



Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2022 оны 6 дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ АСУУЛГА

/Журмын 1.2-т заасан этгээдийн хувийн мэдээллийн асуулга/

	Асуулт	Хариулт
1.	Таны ажиллаж буй байгууллагын нэр	“Омни Ассет” ХХК
2.	Овог Нэр Өөр нэртэй байсан эсэх Хүйс (Эрэгтэй/Эмэгтэй)	Хүрэлбаатар Хэрлэн Үгүй Эрэгтэй
3.	“Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын 1.2-т заасан этгээдийн аль нь болох, албан тушаал? Хуулийн этгээд, Зөвлөлийн гишүүн, хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэх удирдлага, салбарын удирдлага, ажилтан, агент гэх мэт?	ТУЗ-ийн гишүүн
4.	Оршин суугаа хаяг	Хан-уул Дүүрэг, 17-р хороо, 132-249 тоот
5.	Өнгөрсөн 10 жилийн хугацаанд оршин сууж байсан хаяг (хамаарах огноог тавих)	Баянзүрх дүүрэг, 26-р хороо, 722-19 тоо (2012-2023)
6.	Төрсөн огноо Төрсөн газар (улс, аймаг, хот)	1995/02/04 Монгол улс, Улаанбаатар хот
7.	Иргэншил, Хэрэв гадаад улсын иргэн байсан бол иргэншил авсан төрлийг бичнэ үү. (жишээ нь, төрөлт, иргэний харьяаллаа өөрчлөх, гэрлэлт)	Монгол
8.	Регистрийн дугаар	УХ95020413



2023-11-15

<p>Одоогийн хашиж буй албан тушаал эсвэл хийж буй ажил болон мэргэжил, сүүлийн 10 жилийн хугацаанд ажиллаж байсан байгууллага, ажил олгогчийн нэр, эрхэлдэг бизнес, хашиж байсан албан тушаал, холбогдох огноо, ажлаас гарсан огноо болон хийж байсан ажил бүрийн хувьд:</p> <p>i.эрхэлж байсан албан тушаалын нэр; ii.ажилд орсон огноо; iii.ажил олгогчийн нэр, хаяг; iv.тодорхойлолт гаргагчийн нэр, албан тушаал, утасны дугаар</p> <p>i.эрхэлж байсан албан тушаалын нэр; ii.ажилд орсон огноо; iii.ажил олгогчийн нэр, хаяг; iv.тодорхойлолт гаргагчийн нэр, албан тушаал, утасны дугаар</p> <p>9. i.эрхэлж байсан албан тушаалын нэр; ii.ажилд орсон огноо; iii.ажил олгогчийн нэр, хаяг; iv.тодорхойлолт гаргагчийн нэр, албан тушаал, утасны дугаар</p> <p>i.эрхэлж байсан албан тушаалын нэр; ii.ажилд орсон огноо; iii.ажил олгогчийн нэр, хаяг; iv.тодорхойлолт гаргагчийн нэр, албан тушаал, утасны дугаар</p> <p>i.эрхэлж байсан албан тушаалын нэр; ii.ажилд орсон огноо; iii.ажил олгогчийн нэр, хаяг; iv.тодорхойлолт гаргагчийн нэр, албан тушаал, утасны дугаар</p>	<p>1)</p> <p>a) Зөвлөх b) 2018 c) Smart Visa consulting, Улаанбаатар хот d) Шилэбат, Гүйцэтгэх захирал e) 99107955</p> <p>2)</p> <p>a) Гэрээт борлуулагч, Теллер, Шууд борлуулалтын менежер, Борлуулалтын менежер b) 2019 c) Голомт банк, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг d) Лхагвасүрэн, Хэлтсийн захирал, 88117415</p>
<p>10. Та одоо бүртгэгдсэн байгууллагын– (a)захирал эсвэл хянагч уу? (b)сүүлийн 10 жилийн хугацаанд захирал эсвэл хянагчаар ажиллаж байсан уу? (тохиолдол бүр болон бизнесийн төрлийн хувьд үүсгэн байгуулагдсан улсын нэрийг бичих)</p>	<p>Үгүй</p>
<p>11. Санхүүгийн байгууллагад эзэмшдэг хувь эзэмшлийн мэдээлэл (одоогийн болон сүүлийн 10 жилийн хугацаанд) (a)компанийн нэр (b)үүсгэн байгуулагдсан улс (c)эзэмшлийн хувь (d)бизнесийн төрөл</p>	<p>Байхгүй</p>
<p>12. (a)эзэмшсэн боловсрол, төгссөн жил (b)боловсролын зэрэг</p>	<p>Санхүү менежмент, 2022 Магистр</p>
<p>13. Төрийн байгууллагын аливаа тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл хүссэн өргөдөлд татгалзсан хариу авч байсан эсэх?</p>	<p>Үгүй</p>



2023-11-15

БҮРТГЭЭ-02



14.	Иргэний эсвэл цэргийн эрх бүхий шүүхээс таныг хэрэгт буруутгаж байсан эсэх (а) тухайн хэргийг сүүлийн 10 жилийн дотор давтан үйлдсэн байхаас бусдаар бол насанд хүрээгүй буюу 18 нас хүрээгүй байхдаа үйлдсэн хэрэг эсвэл (б) тээврийн хэрэгслийн ашиглалт, өмчлөлтэй холбоотой хялбаршуулсан байдлаар шийдсэн хэргээс бусад)? Тийм бол хүлээлгэсэн хариуцлага, шийтгүүлсэн бол шийтгэл хүлээлгэсэн огноо, ногдуулсан хэрэг, торгуулийн талаар дэлгэрэнгүй бичих	Үгүй
15.	Таныг санхүүгийн болон санхүүгийн бус байгууллага, виртуал хөрөнгө гаргагч, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан мөрдөн шалгаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих	Үгүй
16.	Та хамаарагддаг, хамаарагдаж байсан мэргэжлийн байгууллагаас танд шийтгэл, сахилгын шийтгэл ногдуулах эсвэл муу үнэлгээ өгөх эсвэл та нөхцөл тавьсан мэргэжлийн үнэмлэхтэй байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
17.	Танаас залилан, луйвар эсвэл ижил төстэй хэргийн шүүх хурал, хэрэг хянан хэлэлцэх ажиллагаанд шинжээч, гэрчийн хувиар бус өөр этгээдийн хувиар нотлох баримт гаргаж өгөхийг шаардаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
18.	Таныг эсвэл таны ажиллаж байгаа эсвэл захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байсан бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийг төрийн, мэргэжлийн эсвэл бусад зохицуулагч байгууллага шалгаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
19.	Та албан тушаалаасаа чөлөөлөгдөх, ажлаасаа халагдах эсвэл таныг мэргэжлээрээ ажиллахыг хориглож байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
20.	Эрх бүхий этгээд эсхүл шүүхээс таныг дампуурсан гэж үзэж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
21.	Эрх бүхий шүүхийн шийдвэрийн дагуу та төлбөл зохих, төлөх ёстой өрөө төлөхгүй байсан удаа байгаа юу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
22.	Бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийг байгуулах, хянах, удирдахтай холбоотойгоор эрх бүхий шүүхээс танд тэрхүү байгууллага, компани, гишүүний өмнөөс залилан, эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан хэрэг, бусад албан тушаалын гэмт хэрэгт иргэний эсвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй



2023-11-15
БҮРТГЭВ-02



23.	Таныг ажиллаж байх хугацаанд эсвэл ажиллахаа больсноос хойш нэг жилийн дотор таны захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байсан бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийг хүчээр татан буулгах эсвэл зээлдүүлэгчидтэйгээ тохиролцох, зовилцох эсвэл зээлдүүлэгчид нь толбороо буцаан аваагүй эсвэл бүгдийг нь хараахан буцаан аваагүй байхад худалдааг зогсоож байсан тохиолдол гарч байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй
24.	Таны захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байсан бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийн эрхийг цуцлах, хүчингүй болгож байсан уу?	Үгүй
25.	Ажил үүргээ гүйцэтгэхдээ та бусад этгээдэд журам, чиглэл өгөх үүрэгтэйгээр ажиллах уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	Үгүй

а) Миний бие дээр мэдүүлсэн мэдээллийг бүрэн дүүрэн, үнэн зөв болохыг баталж байна. Түүнчлэн, миний бие дээр заасан асуултын хариултын бүрэн дүүрэн байдалд нөлөөлөх аливаа материаллаг оорчлолтийг 21 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлэх үүрэг хүлээж байна.

Огноо: 2023.05.30

Гарын үсэг: *[Signature]*





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИЧИГ
MONGOLIAN STOCK EXCHANGE

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Омни Капитал ББСБ ХХК
(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

Тайлант хугацаа:
2023.01.01 - 2023.06.30

Үзүүлэлт	(төгрөгөөр)
1 - Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	
1.1 - Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	60,740,160,018.04
1.1.1 - Зээлийн хүүгийн орлого	5,259,905,393.30
1.1.2 - Үнэт цаасны хүүгийн орлого	26,972,176.71
1.1.3 - Факторингийн үйлчилгээний хүүгийн орлого	19,289,687.67
1.1.4 - Харилцах дансны хүүгийн орлого	0.00
1.1.5 - Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого	11,916,509.36
1.1.6 - Санхүүгийн түрээсийн орлого	0.00
1.1.7 - Гадаад валютын арилжааны орлого	0.00
1.1.8 - Үнэт цаасны арилжааны орлого	403,171,133.06
1.1.9 - Гадаад валютын арилжааны ханшийн зөрүү	529,530.88
1.1.10 - Үнэт цаасны үнэлгээний зөрүү	0.00
1.1.11 - Итгэлцлийн үйлчилгээний орлого	10,301,313,836.29
1.1.12 - Мөнгөн гуйвуулгын орлого	0.00
1.1.13 - Картын үйлчилгээний орлого	0.00
1.1.14 - Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	0.00
1.1.15 - Санхүүгийн түрээсийн орлого	0.00
1.1.16 - Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	193,605,666.75
1.1.17 - Хүүгийн орлогын буцаалт	0.00
1.1.18 - Бусад үйлчилгээний орлого	44,523,456,084.02
1.2 - Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	60,874,868,230.87
1.2.1 - Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	7,289,573,647.38
1.2.2 - Төслийн зээлийн санхүүжилтын хүүгийн зардал	0.00
1.2.3 - Өрийн бичгийн хүүд төлсөн мөнгө	898,799,259.24
1.2.4 - Хүүгийн зардлын буцаалт	0.00
1.2.5 - Үндсэн ба нэмэгдэл цалин	582,721,481.47
1.2.6 - Ажилтнуудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	0.00
1.2.7 - Нийгмийн даатгал,эрүүл мэндийн даатгалын зардал	54,648,511.84
1.2.8 - Албан томилолт, сургалтын зардал	60,980,229.47
1.2.9 - Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	279,715,865.37
1.2.10 - Шатахуун, холбоо, интернэт, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	90,909,380.82
1.2.11 - Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	16,174,866.75
1.2.12 - Татвар, даатгалын төлсөн мөнгө	377,716,933.01
1.2.13 - Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	92,119,477.10
1.2.14 - Үнэт цаас болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан м	0.00
1.2.15 - Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	0.00
1.2.16 - Факторингийн болон түүнтэй холбоотой авлага барагдуулахтай холбогдон гарсан	580,000,000.00
1.2.17 - Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан мөнгө	8,307,520,817.97
1.2.18 - Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаатай холбогдон гарсан мөнгө	0.00
1.2.19 - Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	202,540,099.00
1.2.20 - Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	3,240,000.00
1.2.21 - Ногдол ашгаар олгосон мөнгө	0.00





ХАРИЛЦАГЧИЙН ДАНСНЫ ХУУЛГА

2023-11-15

БҮРТГЭС-02



Огноо/Date: 2023.05.12

Шилжүүлгийн мэдэгдэл/Transaction report

Журналын №/Journal №: 612265

Системийн огноо/System Date: 2023.07.20 12:47:58

Харилцагчийн дугаар/Customer №: 1000043139

Нэр/Name: ОМНИ КАПИТАЛ ББСБ

Дт	Дансны дугаар/Account №	Нэр/Name:	Дүн/Amount:	Ханш/Rate:
	MN930030003096013691	ОМНИ КАПИТАЛ ББСБ	10,000,000.00 MNT	1.00
/ арван сая төгрөг /				
Кт	Банкны дугаар/Bank №:	Банкны нэр/Bank Name:	Дүн/Amount:	Ханш/Rate:
	30	30 - КАПИТРОН БАНК	10,000,000.00 MNT	1.00
	Дансны дугаар/Account №:	Нэр/Name:		
	MN660030003000124051	ОМНИ АССЕТ		

Гүйлгээний утга/Transaction description:
ЕВ -Омни Капитал ББСБ-с авлага үүсгэв

Харилцагч танд баярлалаа/Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified

Салбар, тооцооны төв/ Branch, sub-branch:

Банкны ажилтны гарын үсэг/Signature:

Банкны ажилтны тамга/Stamp:

_____ Он/Year(YYYY) _____ Сар/Month(MM) _____ Өдөр/Day(DD)

Тайлбар: Та Капитрон банкны дурын салбарт баримтаа авч очин баталгаажуулах боломжтой.





Харилцах дансны хуулга

Хяналтын ахлах ажилтан баталгаажуулснаар хүчинтэй.

Хугацаа: 2023.05.09 - 2023.07.24
 Дансны дугаар: MN660030003000124051-(MNT)
 Дансны нэр: ОМНИ АССЕТ(г)
 Эхний үлдэгдэл: 0.00
 Эцсийн үлдэгдэл: 10,103,000.00

Огноо	Харьцсан данс	Орлого	Зарлага	Үлдэгдэл	Гүйлгээний утга	Теллер	Гүйлгээний байршил
2023.05.09	MN540015002035101796	25,000.00		25,000.00	ОМНИ КАПИТАЛ ББСБ-С ШИЛЖҮҮЛЭГ /GLMTMNUB-15-ГОЛОМТ БАНК, ОМНИ КАПИТАЛ ББСБ ХХК MN540015002035101796/	10	3099
2023.05.09	3000004472300001		5,000.00	20,000.00	Омни ассет ХХК интернет банкны жилийн хураамж төлөв	31212	3000
2023.05.12	MN930030003096013691	10,000,000.00		10,020,000.00	ЕВ -Омни Капитал ББСБ-с авлага үүсгэв	2	3099
2023.05.12	3000004441010001		6,000.00	10,014,000.00	05/12 өдөр Омни ассет ХХК 2ш төлөрхойлолтын үнэ авав / дансны үлдэгдэлтэй эсж/	31212	3000
2023.05.12	MN930030003096013691	100,000.00		10,114,000.00	ЕВ -Омни Капитал ББСБ-с авлага үүсгэв	2	3099
2023.05.15	3000004441010001		6,000.00	10,108,000.00	Омни ассет ХХК 23/004 гldgy mkkmsy :gucc 2ш төлөрхойлолтын үнэ авав /дансны үлдэгдэлтэй эсж/	31212	3000
2023.06.13	3000004441010001		3,000.00	10,105,000.00	ОМНИ АССЕТ ХХК 23/007 албан тоотын дагуу дансны төлөрхойлолтын үнэ авав	31212	3000
2023.07.01	0005		2,000.00	10,103,000.00	ХАРИЛЦАХ ДАНС ХӨТӨЛСНИЙ ШИМТГЭЛ/ БАЙГУУЛЛАГА/:[2000.00MNT] /44410/	1	3099
		10,125,000.00	22,000.00				

Хэвлэсэн теллер:  





САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО-Д

14253 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Усны гудамж-4, Капитрон банк
Утас: +(976) 75115555
И-мэйл: info@capitronbank.mn
Вэб: www.capitronbank.mn

2023.05.15 № 23/246
танай _____ -ны № _____ -т

Дансны тодорхойлолт

ОМНИ АССЕТ ХХК /регистр: 8356327/ нь тус банканд төгрөгийн харилцах данс эзэмшдэг ба 2023 оны 05 сарын 15-ны өдрийн байдлаарх орлого зарлагын гүйлгээг үүгээр тодорхойлов.

Данс	Орлого	Зарлага
3000124051	10,125,000.00	17,000.00

Уг тодорхойлолттой холбогдуулан банк ямар нэгэн толбөрийн хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн,

УЛААНБААТАР САЛБАРЫН
ЗАХИРАЛ



Г.ГАНЧИМЭГ





ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

2020 оны 05 сарын 01-ний өдөр

Дугаар: № 40/403

Улаанбаатар хот

Энэхүү ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ-г Нэг талаас "СЛАМЕТ ГЭЛҮК" ХХК /РД: 6544193/ /цаашид "түрээслэгч" гэх/-ийг төлөөлж "N TOWER" оффисын барилгын оффис хариуцсан менежер Ц.Ундармаа, Нөгөө талаас "ОМНИ КАПИТАЛ" ББСБ /РД: 60756571/ /цаашид "түрээслүүлэгч" гэх/-ийг төлөөлж _____ ажилтай Ч.Даваасүрэн дараахь зүйлийг харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хуулийн 318-р дугаар зүйлд заасныг удирдлага болгон байгуулав.

1. Ерөнхий нөхцөл

- 1.1. **Гэрээний зорилго.** Талууд харилцан зөвшилцөж холбогдох хууль тогтоомж, дүрмийн дагуу /Монгол улсын иргэний хуулийн 318, 319, 320, 324, 325, 326-р зүйл/ эрх эдэлж, үүрэг хүлээн СБД, 8-р хороо, 11 дүгээр хороолол /14193-Их тойруу 43/ хаягт байрлах "Сламет гэлүк" ХХК өмчийн оффис үйлчилгээний зориулалттай "N Tower" барилгын 4 дүгээр давхар 403 тоот өрөөний талбайг түрээслэх, түрээслүүлэх харилцааг зохицуулахад оршино
- 1.2. **Гэрээний хугацаа:** Гэрээний хугацаа / 12 / сар байна.
- 1.3. Энэхүү гэрээг 2020 оны 05-р сарын 01-ний өдрөөс эхлэн 2021 оны 05 -р сарын 01 -ны өдөр хүртэл 1 жилийн хугацаагаар байгуулав.
- 1.4. Аль нэг талаас цуцлах зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд дээрх хугацааг нэг жилээр сунгасанд тооцно.
- 1.5. Энэхүү гэрээний 1.3 заалтын дагуу гэрээний хугацаа дуусмагц хоёр тал харилцан тохиролцож гэрээг сунгана.
- 1.6. **Түрээсийн үнэ:** Нэг м.кв талбайн түрээсийн үнийг 16,500 ₮ төгрөг /НӨАТ багтсан/ байхаар тооцно. Түрээсийн талбайн нийт хэмжээ 46.3 мкв байна. Түрээсийн төлбөрийн нийт дүн сард 763.950 (долоон зуун жаран гурван мянга есөн зуун тавин) төгрөг байна.
- 1.7. **Төлбөр:** Түрээсийн төлбөрийг сар бүрийн 05-ны дотор ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК-ны "СЛАМТЕТ ГЭЛҮК" ХХК эзэмшигчтэй 470032291 тоот дансанд шижлүүлнэ.
- 1.8. Түрээслэгч энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болж, 05-р сарын 01-ний өдрөөс эхлэн түрээсийн төлбөрийг тооцож эхэлнэ.
- 1.9. Түрээсийн барьцаа төлбөрийг түрээсийн нэг сарын төлбөртэй тэнцүү хэмжээгээр гэрээнд гарын үсэг зурсан өдөр ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК банк "СЛАМТЕТ ГЭЛҮК" ХХК эзэмшигчтэй 470032291 тоот дансанд шилжүүлнэ.
- 1.10. Түрээсийн үнэнд түрээсийн байрны ашиглалттай холбоотой дулаан, цэвэр ус, ариутгал татуургийн төлбөрүүд багтсан болно.
- 1.11. Гэрээний биелэлт, бусад асуудлаар талууд улирал бүр дүгнэж болно.

2. Түрээслүүлэгчийн эрх, үүрэг

- 2.1. Түрээсийн байрны ашиглалт, ариун цэвэр, нийтийг хамарсан цэвэрлэгээ, хог хаягдал, түрээсийн төлбөртэй холбоотой асуудлаар түрээслэгчид хүсэлт шаардлага тавина.





- 2.2. Төвлөрсөн хангагч байгууллагын хэвийн доголдолгүй ажиллагаатай үед цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, утсан холбоогоор бүрэн хангана. *Жич: Жил бүрийн 10-р сарын 01-ээс дараа оны 05-р сарын 01 өдөр хүртэл дулаанаар хангана.*
- 2.3. Түрээслэгч тал түрээсийн төлбөрөө тохирсон хугацаанаас хожимдуулсан тохилдолд хожимдсон хоног тутамд сарын төлбөрийн 0.5% тэнцэх алданги тооцон авах эрхтэй.
- 2.4. Түрээсийн талбайд түрээслэгч хэлбэр, дизайн, тасалгаа гаргах, ханын өнгө солих зэрэг ажилуудыг гаргасан зураг төслийн дагуу түрээслүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу өөрийн зардлаар хийх боломжтой, энэ үйлдэл нь түрээсийн хугацаа дуусахад буцаан анхны нөхцлөөс дордуулахгүйгээр хүлээлгэж өгнө.
- 2.5. Түрээслүүлэгч түрээсийн давхар бүрийн лифтний урдах зай талбайн цэвэрлэгээг хариуцна.
- 2.6. Түрээслүүлэгч түрээсийн гэрээг цуцлах зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгаан үүсвэл гэрээг цуцлахаас 1 сарын өмнө түрээслэгч талд мэдэгдэх үүрэг хүлээнэ. Энэ тохиолдолд барьцаа төлбөрийг Түрээслэгч талд бүрэн гаргаж өгнө.
- 2.7. Түрээслүүлэгч түрээслэгчийн үйл ажиллагаанд шаардлагатай хурд бүхий интернетийн үйлчилгээг хангахад шаардагдах дотор болон гадна холболтын шугам, төхөөрөмжөөр хангана.
- 2.8. Түрээслүүлэгч түрээслэгчийн түрээслэж байгаа талбайн цахилгааны тоолуурыг байршуулж өгөх үүрэгтэй. Цахилгааны тоолуур байршуулж өгсөн өдрөөс эхлэн тоолуурын заалтаар цахилгааны төлбөрийг тооцож эхлэх болно.
- 2.9. Түрээслэгчийн дотоод үйл ажиллагаанд оролцохгүй, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлд саад болохгүй байх үүрэгтэй.
- 2.10. Түрээслэгч тал гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах хүсэлт гаргасан тохиолдолд түрээслүүлэгч тал өөрт учирсан бодит хохирлын зардлыг барьцаа мөнгөнөөс суутгах авах эрхтэй.
- 2.11. Түрээслэгч түрээсийн хугацаанд түрээслүүлэгч талаас зээлдүүлэн ашиглуулж буй тавилга хэрэгсэл тоног төхөөрөмжийг ариг гамтай хэрэглэх, эвдрэл гэмтэл учруулсан тохиолдолд нөхөн төлөх үүрэг хүлээнэ.
3. **Түрээслэгчийн эрх, үүрэг**
 - 3.1. Түрээслүүлэгчийн цагийн хуваарьт захирагдахгүйгээр үйл ажиллагаагаа явуулах.
 - 3.2. Түрээсийн байрны өөрийн эзэмшлийн давхар бүрийн хонгилын хананд түрээслүүлэгчтэй зөвшилцсөний дагуу хаяг сурталчилгааны самбар байрлуулах эрхтэй.
 - 3.3. Түрээсийн байрны цахилгаан, дулаан, цэвэр бохир усны хангалттай холбоотой аливаа асуудлыг цаг тухайд нь засварлуулах эрхтэй
 - 3.4. Түрээсийн байрыг зориулалтын дагуу ариг гамтай, цэвэр үзэмжтэй бүрэн бүтэн байдлыг хангаж ашиглах, түрээсийн талбайд үүссэн хог хаягдлыг хонгил болон ариун цэврийн өрөөнд байршуулахгүй өөрсдийн хүчээр хог хаягдлын цэгт хүргэнэ.
 - 3.5. Хот, дүүрэг, төр захиргааны байгууллагын зүгээс тавьсан шаардлага аливаа зохион байгуулалттай үйл ажиллагаанд МУ-н иргэн, ААН-ийн үүрэг хариуцлагыг ухамсарлан оролцоно.
 - 3.6. Түрээслэгч, түүний ажилтнууд, гэрээт гүйцэтгэгч, түрээслэгчдийн зочдын аюулгүй ажиллагаа зөрчсөн үйлдлээс түрээслүүлэгчийн өмчид галын аюул учирах, ариун цэврийн өрөө, цэвэр бохир усны шугам, дулааны шугам, цахилгаан холболтыг гэмтээсэн, эвдсэн нөхцөлд үүссэн хохирлыг үл маргах журмаар газар дээр нь засварлах, сэргээх, шинэчлэх үүргийг хүлээж хэрэв өөрсдийн хүчээр асуудлыг шийдэх боломжгүй бол түрээслүүлэгчээр гүйцэтгүүлж гарсан зардлыг төлж барагдуулна.
 - 3.7. Түрээслэгч харилцааны утсан холбоо, интернетийн үйлчилгээний төлбөрийг аливаа тайлбаргүйгээр цаг хугацаанд нь барагдуулах үүргийг хүлээнэ.
 - 3.8. Түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр дур мэдэн барилга байгууламжийн хийц хэсэгт өөрчлөлт оруулах, барилгын засварын ажил хийх, сантехникийн болон цахилгаан, дулаан, утсан холбооны шугам зэрэг инженерийн шугам шүлжээнд өөрчлөлт хийхийг хориглох ба буруутай үйлдлээс шалтгаалан Түрээслүүлэгч, бусад түрээслэгч нарын үйл ажиллагаанд хохирол учруулбал хохирлыг бүрэн барагдуулна.
 - 3.9. Түрээсийн байранд хийгдсэн хөрөнгө оруулалт нь ямагт түрээслэгчийн өмчлөлд байх бөгөөд түрээсийн гэрээ цуцлагдсан, дуусгавар болсон тохиолдолд хөрөнгөө салгаж авах бүрэн эрхтэй. Хөрөнгө салган авч түрээсийн байрыг хүлээлгэж өгөхдөө гэрээний салшгүй хэсэг болох байр хүлээлцсэн тухай анхны акт, баримтыг үндэслэн анхны байдлаас дордуулахгүйгээр хүлээлгэж өгнө. (Паркетан шалны чанараас шалтгаалсан элэгдэл хорогдолд хариуцлага хүлээхгүй.)



- 3.10. Түрээслэгч өөрийн хүсэлтээр гэрээг цуцлах эрхтэй. Ингэхдээ гэрээг цуцлах тухай мэдэгдлээ албан ёсоор 1 сарын өмнө түрээслүүлэгчид мэдэгдэх ба гэрээний хугацаа дуусахаас өмнө цуцлах хүсэлт гаргавал барьцааны төлбөр буцаахгүй болно.
- 3.11. Түрээслэгч, Түрээслүүлэгчийн гадна, дотор холболтын шугам, төхөөрөмжийг ашиглан телефон, интернет, ТВ-ийн холболтыг өөрийн нэрээр үйлчилгээнд хамрагдаж гэрээ байгуулан ашиглана.
- 3.12. Түрээслэгч нь түрээслэж буй өрөөн дотроо ариун цэврийн өрөөтэй бол цэвэрлэгээг түрээслэгч тал өөрөө хариуцна.
- 4. Хориглох зүйлс**
 - 4.1. Түрээслэгч нь түрээсийн байрыг зориулалтын бусаар ашиглахыг хориглоно.
 - 4.2. Түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад давхар түрээслүүлэхийг хориглоно.
 - 4.3. Гэрээнд оролцогч талууд нь аливаа үндэслэлгүйгээр уг гэрээг цуцлахыг хориглоно.
 - 4.4. Гэрээнд оролцогч талууд харилцан бие биеийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.
 - 4.5. Түрээсийн байранд архи, тамхи огт хэрэглэхгүй.
 - 4.6. Түрээсийн байранд тэсэрч дэлбэрэх, үнэр үүсгэх, хортой бодис оруулах, хадгалах, хэрэглэхийг хориглоно.
- 5. Давагдашгүй хүчин зүйлс**
 - 5.1. Давагдашгүй хүчин зүйл гэдэгт хоёр талын урьдаас таамаглаагүй, мэдээгүй бөгөөд түүнийг шийдвэрлэхэд нэн бэрхшээлтэй нөхцөл байдлыг ойлгож үзнэ. Давагдашгүй хүчин зүйлд байгалийн гай гамшиг, дайн байлдаан, Засгийн газрын тогтоол, журам, нийгмийн зөрчил мөргөлдөөн, дайралт халдлага орох ба эдгээр зүйлээр хязгаарлагдахгүй байна. Аль ч тал нь нөгөө талаасаа ямар нэгэн хэлбэрээр гарсан давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалж үүргээ биелүүлэхэд учирсан саадтай холбоотойгоор алданги, торгууль шаардах эрхгүй.
 - 5.2. Давагдашгүй хүчин зүйлд өртсөн аль нэг тал нөгөө талдаа хуанлийн долоо (7) хоногийн дотор үүссэн нөхцөл байдал, хэвийн байдалд ороход шаардагдах хугацааны талаар бичгээр мэдэгдэнэ. Давагдашгүй хүчин зүйл үүссэн хугацаанд тухайн талын гэрээгээр хүлээсэн үүргийг зогсоох ба энэхүү хугацаагаар гэрээг сунгана.
 - 5.3. Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас нотолсон баримтыг гаргуулж авна.
- 6. Гэрээ дуусгавар болох**
 - 6.1. Гэрээний хугацаа дуусахад талууд харилцан хүлээсэн үүргээ биелүүлснээр энэхүү гэрээ дуусгавар болно.
- 7. Харилцан хүлээх хариуцлага, гэрээ цуцлах үндэслэл**
 - 7.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл хэсэгчлэн биелүүлсэн тохиолдолд дараах хариуцлагыг хүлээнэ. Үүнд:
 - 7.2. *Түрээслэгч:*
 - 7.2.1. Түрээсийн төлбөрөө хугацаанд нь төлбөгүй тохиолдолд хугацаа хожимдсон хоног тутамд сарын түрээсийн үнийн дүнгийн 0.5% тэнцэх хэмжээний алдангийг түрээслүүлэгчид төлнө
 - 7.2.2. Түрээсийн байрыг зөвшөөрөлгүйгээр бусдад давхар түрээслүүлсэн, шилжүүлсэн зориулалтын бусаар ашиглах, түрээсийн төлбөрийг удаа дараа саатуулах нь гэрээг цуцлах шууд үндэслэл болох ба энэ тохиолдолд 2.6 заалт үйлчлэхгүй.
 - 7.3. *Түрээслүүлэгч:*
 - 7.3.1. Түрээслүүлэгч гэрээгээ хүндэтгэх бус учир шалтгаанаар гэрээний 2.6-д заасан үйлдлийг хийлгүйгээр гэрээг бие даан цуцалж түрээслэгчийн үйл ажиллагааг зогсоовол нэг бүтэн сарын түрээсийн төлбөрийг үл маргах журмаар нөхөн төлнө.
 - 7.3.2. Түрээслүүлэгч гэрээгээр хүлээсэн цахилгаан, дулаан, цэвэр ус, ариутгал татуургын системийн төлбөрийг саатуулснаас системийн хангалт доголдрвол үйл ажиллагааг саатуулсан хоног дутам сарын түрээсийн үнийн дүнгийн 0.5% тэнцэх торгуулийг түрээслэгчид төлнө.
- 8. Хууль хэрэглэх, маргаан шийдвэрлэх**
 - 8.1. Энэхүү гэрээ нь Монгол улсын хууль тогтоомжийг үндэслэн хийгдсэн бөгөөд түүний дагуу зохицуулагдана. Хуульд өөрөөр заагаагүй бол гэрээний заалтыг нэн тэргүүнд баримтална.
 - 8.2. Гэрээний үүргийн биелэлтийн явцад үүссэн маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Зөвшилцөлд үл хүрэх тохиолдолд Монгол улсын шүүх маргааныг эцэслэн шийдвэрлэнэ.





3
ОМНИЙ АРСЭТ
XXI



9. Бусад
- 9.1. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэх бөгөөд тус бүр ижил хүчинтэй байна.
 - 9.2. Гэрээний хугацаа дуусахад гэрээнд оролцогч аль нэг тал гэрээг дуусгавар болгох тухай санал гаргаагүй. Түрээслэгч түрээсийн байранд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах тохиолдолд түрээсийн гэрээг энэ гэрээний хугацаагаар сунгасанд тооцно.
 - 9.3. Гэрээний нэмэлт. Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй, нэмэлт өөрчлөлт оруулах саналаа аль нэг тал нөгөө талдаа нэг сарын өмнө бичгээр хүргүүлнэ. Нэмэлт өөрчлөлтийг бичгээр хийх бөгөөд талууд гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Нэмэлт гэрээ нь энэ гэрээний салшгүй хэсэг болно.
 - 9.4. Түрээсийн төлбөрийг зах зээл дээрхи үнийн өөрчлөлтөөс шалтгаалан бууруулах, өсгөх талаар талууд харилцан тохиролцож болно. /гэрээний хугацаанд гэрээний үнийн дүнд өөрчлөлт орохгүй/
 - 9.5. Мэдэгдэл. Гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захидлууд нь бичгийн хэлбэрээр байх бөгөөд доорхи хаягаар хүргэгдсэн үед тухайн баримтыг хүлээн авсанд тооцно.
 - 9.6. 2020 оны 05-р сарын 01-ний өдрийн энэхүү гэрээнд талууд гарын үсэг зуран зөвшөөрөгдсөнөөр гэрээ байгуулагдсанд тооцно.
 - 9.7. Түрээсийн байрны хүлээлцсэн тухай акт, баримтууд энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд мөн адил хүчин төгөлдөр акт байх болно.

Гэрээг байгуулсан:

Түрээслүүлэгч талыг төлөөлж:
“N TOWER” барилгын оффис хариуцсан
менежер: Ц.Ундармаа

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 11-р
хороолол, 14193-Их тойруу 43, N
Tower байшин, 1-р давхар, 101 тоот
Утас: 91090160; 99876056
email: lkhagvamaa03@gmail.com
undarmaa2912@gmail.com

Түрээслэгч талыг төлөөлж:

Ажилтан:



Хаяг:

Утас: 99073610 99795115



Батлав: 2023-11-15
“СЛАМЕТ ГЭЛҮК” ХХК -ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.НОМИНТУШИГ



20/403-ТООТ ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭНИЙ ХУГАЦААГ СУНГАХ ТУХАЙ НЭМЭЛТ ГЭРЭЭ

2021 оны 05-р сарын 01-ний өдөр

Дугаар: 21/403

Улаанбаатар хот

Энэхүү ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ-г

Нэг талаас / РД: 6075657 / тоот регистрийн дугаартай “ОМНИ КАПИТАЛ” ББСБ нь түрээслэгч гэх ” Нөгөө талаас ” Сүхбаатар 8-р хороо, 11-р хороолол, 14139 - Их тойруу 43, “Н” тауэр байшин “СЛАМЕТ ГЭЛҮК” ХХК / РД: 6544193 / /цаашид “Түрээслүүлэгч / гэх, нар хамтад нь “Талууд” гэх 2020 оны 05-р сарын 01-ний өдөр байгуулсан “Ажлын байрны” зориулалтаар байр түрээслэх 20/403 тоот гэрээний нөхцөлд гэрээний хугацааг сунгах зорилгоор нэмэлт оруулав . Үүнд:

1. 2020 оны 05-р сарын 01-ний өдөр байгуулсан “Ажлын байрны” зориулалтаар талбай түрээслэх 20/403 тоот гэрээний хугацааг гэрээнд заасан 9.2 дахь заалтын дагуу гэрээнд нэмэлт оруулж 2021 оны 05-р сарын 01-ний өдрөөс 2022 оны 05-р сарын 01-ний өдрийг хүртэл сунгав.
2. Түрээслэгч нь 46,3 мкв /Дөчин зургаа арваны гурав/ талбайн түрээсийн төлбөрт 1 /нэг/ сард 856,550 /Найман зуун тавин зургаан мянга таван зуун тавь/ төгрөг төлнө.
3. Талууд энэхүү гэрээний нэмэлтийг 2021 оны 05-р сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.
4. Гэрээнд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан өдрөөс хүчин төгөлдөр болох ба үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.
5. Энэхүү нэмэлт гэрээг байгуулсан нь үндсэн гэрээний бусад зүйл заалтын хэрэгжилтэд нөлөөлөхгүй болно.

Гэрээг байгуулсан:

Түрээслүүлэгч талыг төлөөлж:

“N TOWER” барилгын оффис хариуцсан менежер:

Ц.Ундармаа

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 11-р хороолол, 14193-Их тойруу 43, N Tower байшин, 12-р давхар, 1201 тоот

Утас 99098722, 91116839

Цахим хаяг: undarmaa2912@gmail.com



Түрээслэгч талыг төлөөлж:

Ажилтан:

ОМНИ КАПИТАЛ
ББСБ ХХК

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 11-р хороолол, 14193 -Их тойруу 43, N Tower байшин, 9-р давхар

Утас: 99073610, 99795115

Цахим хаяг:



2023-11-15



Батлав:
"ОМНИ КАПИТАЛ" ББСБ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.НИНА



20/403 ТООТ ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭНИЙ ХУГАЦААГ
СУНГАХ ТУХАЙ НЭМЭЛТ ГЭРЭЭ

2022 оны 08-р сарын 04-ний өдөр

ДУГААР:22/403

Улаанбаатар хот

Энэхүү Нэмэлт гэрээ-г

Нэг талаас /РД:6075657/ тоот регистрийн дугаартай "ОМНИ КАПИТАЛ" ББСБ /цаашид Түрээслэгч гэх/ түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал С.НИНА

Нөгөө талаас /РД:6544193/ тоот регистрийн дугаартай "СЛАМЕТ ГЭЛҮК" ХХК /цаашид Түрээслүүлэгч гэх/ түүнийг төлөөлж оффис хариуцсан менежер Н.Ганчимэг нар 2020 оны 05-р сарын 01-ний өдөр байгуулсан 20/403 тоот "Түрээсийн гэрээ"-нд гэрээний 9-р зүйлийн 9.3 дахь хэсгийг үндэслэн дараах нэмэлт өөрчлөлийг оруулав. Үүнд:

1. 2020 оны 05-р сарын 01-ний өдөр байгуулсан "Түрээсийн гэрээ"-ний хугацааг 2022 оны 09-р сарын 01-ний өдрөөс 2023 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл 1 жил 4 сарын хугацаатай сунгав.
2. Түрээсийн төлбөр нь 1 м.кв-ийн үнэ 30 000 /гучин мянган төгрөг/ /НӨАТ багтсан/ бөгөөд 46,3 мкв нэг сард төлөх дүн 1,389,000 /нэг сая гурван зуун наян есөн мянган/ төгрөг байна. /Цаг үеийн нөхцөл байдлын улмаас ашиглалтийн зардал, ажилчдын цалин, хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор түрээсийн үнэд өөрчлөлт орсон тухай мэдэгдлийг урьдчилан хүргүүлсэн болно./
3. Талууд энэхүү гэрээний нэмэлтийг 2022 оны 09-р сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
4. Гэрээнд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс хүчин төгөлдөр болох ба үндсэн гэрээний салшгүй нэг хэсэг болно.
5. Энэхүү нэмэлт гэрээг байгуулсан нь үндсэн гэрээний бусад зүйл заалтын хэрэгжилтэнд нөлөөлөхгүй болно.

Түрээслүүлэгч талыг төлөөлж
"N TOWER" барилгын оффис хариуцсан
Менежер: Н.Ганчимэг

Утас: 99189340



Түрээслэгч талыг төлөөлж
Гүйцэтгэх захирал
С.НИНА

Утас:





“ОМНИ АССЕТ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Журам батлах тухай

2023 оны 05 сарын 23-ны өдөр

№ ХЭХ-23/002

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, “Омни ассет” ХХК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Омни ассет” ХХК-ийн “Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ыг Хавсралт №1, “Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам”-ыг Хавсралт №2-р тус тус шинээр баталсугай.
2. Холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /А.Батболд/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:



С.НИНА

А.БАТБОЛД

Х.ХЭРЛЭН



“ОМНИ АССЕТ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 05 сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Хурлын ирц: ТУЗ-н гишүүн С.Нина
ТУЗ-н гишүүн Х.Хэрлэн
ТУЗ-н гишүүн А.Батболд
100%-ийн ирцтэйгээр хуралдав.

Хурал болсон газар: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр оффис, 712 тоот хурлын өрөө

Хурал эхэлсэн, дууссан: 2023.05.23, Пүрэв гариг, 17:00 цагт эхэлж 18:40 цагт дуусав.
Асуудлыг хэлэлцсэн: 17:50 цагт хэлэлцэж 18:40 цагт батлав.
Хурлаар хэлэлцсэн асуудал: Журам батлах тухай

Хэлэлцсэн нь:

- “Омни ассет” ХХК-ийн “Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам” болон “Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам”-ыг батлах тухай

ТУЗ-ийн гишүүд нь:

- “Омни ассет” ХХК-ийн “Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам” болон “Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам”-ын төслүүдийг тус тус хэлэлцэв.

Шийдвэрлэсэн нь:

Хэлэлцсэн асуудлын хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөл дараах шийдвэрийг санал нэгтгэйгээр гаргав.

- “Омни ассет” ХХК-ийн “Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам” болон “Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам”-ыг тус тус батлав.

Хурлын тэмдэглэлийг баталгаажуулсан:

ТУЗ-ийн дарга А.Батболд:





Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 23/002 тоот тогтоолын хавсралт №1


**“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН МӨНГӨ УГААХ,
ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ
ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**



2023-11-15



1. “Омни Ассет ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.
2. Компани нь Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.3-т зааснаар “Омни капитал ББСБ” ХХК-ийн охин компани болохын хувьд тус компанийн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын хөтөлбөр болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор баталсан холбогдох дүрэм, журам, зааврыг мөрдөн ажиллана.
3. Компани нь өөрт учирч болох мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг ойлгож, үр дүнтэй удирдах зорилгоор эрсдэлийг үнэлнэ.
4. Компани нь Зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх) гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор үнэт цаасны зах зээлд оролцогчийн хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 4.1. ХБҮЦ гаргах ажиллагаанд оролцогч талуудаас Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг дагаж мөрдөж ажиллахыг шаардах;
 - 4.2. Шаардлагатай тохиолдолд ХБҮЦ гаргах ажиллагаанд оролцогч талуудаас мэдээлэл, тайлан, баталгаа гаргуулан авах.
5. Компани нь энэхүү Журмын 3-т заасан чиг үүргээ Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөр дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд ТУЗ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дараах чиг үүрэгтэй оролцоно. Үүнд:
 - 5.1. Бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журмыг батлах;
 - 5.2. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн түвшинтэй уялдуулан дотоод хяналтын хөтөлбөрийг шинэчлэх;
 - 5.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр Компанийн эрсдэлийн түвшнийг тодорхойлж, эрсдэл үүссэн тохиолдолд арилгах, бууруулах талаар арга хэмжээ авахыг ХБҮЦ гаргах ажиллагаанд оролцогч холбогдох талуудаас шаардах, хэрэгжилтэд хяналт тавих.
6. ТУЗ нь мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХБҮЦ гаргах үйл ажиллагаанд оролцогчдоос дараах баталгааг гаргуулан авч болно. Үүнд:
 - 6.1. Хөрөнгө оруулагчийн оруулсан хөрөнгийн хууль ёсны эх үүсвэрээс оруулсан эсэхийг тодруулах зорилгоор андеррайтер компаниас Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нийцүүлэн Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны дотоод журмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаарх баталгаа;
 - 6.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авсан хөрөнгийн багц нь хууль тогтоомжоор заасан шаардлагыг хангасан эсэх, аливаа эрсдэл үүссэн эсэхийг хянах зорилгоор анхны үүрэг гүйцэтгэгчээс харилцагчийг таньж мэдэх ажиллагааг явуулсан эсэх талаар тайлан, эсхүл баталгаа;
 - 6.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг удирдахдаа хуулиар зөвшөөрөгдсөн арга хэлбэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг тодруулах зорилгоор хөрөнгө итгэмжлэн удирдагчаас баталгаа;
 - 6.4. Үйлчилгээ үзүүлэгч нь хууль тогтоомж, гэрээнд заасан арга хэлбэрийн хүрээнд үйлчилгээ



үзүүлж байгаа эсэхийг тодруулах зорилгоор үйлчилгээ үзүүлэгчээс баталгаа;

6.5. Зээлийн багцын шинжилгээ гаргах аудитын байгууллага, хуулийн дүгнэлт гаргах хуулийн фирм болон хөндлөнгийн аудитораас Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нийцүүлэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод журмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаарх баталгаа.

7. Компани нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авч, Улсын бүртгэлийн байгууллагад бүртгэл хийлгэсэн өдрөөс эхлэн энэхүү Журмыг мөрдөж эхэлнэ.
8. Энэхүү журамд оруулах нэмэлт өөрчлөлтийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.
9. Компани нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой энэ журамд тусгагдаагүй бусад асуудлаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, Монголбанкнаас баталсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам болон төрийн эрх бүхий этгээдээс баталсан холбогдох бусад журмын зохицуулалтыг дагаж мөрдөнө.
10. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой хууль тогтоомж, журмыг зөрчсөн буруутай этгээд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээнэ.

_____оОо_____



2023 -11- 15
БҮРТГЭВ-02

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын
23-ны өдрийн 23/002 тоот тогтоолын хавсралт №2

СЭХ
БҮРТГЭВ
№ 31



**ХӨНДЛӨНГИЙН АУДИТОР, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ,
ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙГ СОНГОХ, СОЛИХ
ТУХАЙ ЖУРАМ**





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 2023.11.11
БҮРТГЭВ
- 1.1. “Омни Ассет ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Хөндлөнгийн аудитор, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь холбогдох этгээдүүдэд тавигдах шаардлага, шалгуур, гэрээ байгуулах, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
 - 1.2. Компани нь хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих, тэдгээртэй гэрээ байгуулах болон холбогдох бусад үйл ажиллагаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам, Монголын хөрөнгийн биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам болон Компанийн Дүрэмд заасныг тус тус баримтлан ажиллана.

ХОЁР. ХӨНДЛӨНГИЙН АУДИТОРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1. Хөндлөнгийн аудитор нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасны дагуу ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийх эрхтэй байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2.1.1. Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;
 - 2.1.2. Компанийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь Компанитай нэгдмэл сонирхолтой этгээд биш байх, Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлага хангасан байх;
 - 2.1.3. Аудитын үйл ажиллагааг тасралтгүй 3 болон түүнээс дээш жил эрхэлсэн байх;
 - 2.1.4. Мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй 4-өөс доошгүй аудитортой байх;
 - 2.1.5. Аудиторууд тухайн аудитын байгууллагад 2-оос доошгүй жилийн хугацаанд ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн үндсэн ажилтан байх;
 - 2.1.6. Компани нь гүйцэтгэх удирдлагаас томилогдсон 2-оос доошгүй гишүүнтэй чанарын хяналтын нэгжтэй байх бөгөөд 1-ээс доошгүй нь мэргэжлийн байгууллагаас олгосон аудиторын батламжтай байх;
 - 2.1.7. Аудиторууд нь мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй байх;
 - 2.1.8. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 3.1. Үйлчилгээ үзүүлэгч нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч байж болно.
- 3.2. Үйлчилгээ үзүүлэгч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан этгээд байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 3.2.1. Банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн бусад санхүүгийн байгууллага байх;
 - 3.2.2. Үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 1 тэрбум төгрөг байх;
 - 3.2.3. Банк, санхүүгийн зах зээл дээр тасралтгүй 3 болон түүнээс дээш жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх;
 - 3.2.4. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах техникийн нөхцөлөөр хангагдсан байх;
 - 3.2.5. Хорооноос баталсан Компанийн засаглалын кодексыг үйл ажиллагаандаа мөрддөг, дотоод дүрэм, журмуудад энэ талаар тусгасан байх;
 - 3.2.6. Гурваас доошгүй гишүүдээс бүрдсэн ТУЗ-тэй байх бөгөөд тэдгээрийн гуравны нэг нь хараат бус гишүүн байх, компанийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй тайлагнадаг байх;
 - 3.2.7. ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, Компанид үйлчилгээ үзүүлэх хоёроос доошгүй мэргэжилтнүүд нь санхүүгийн зах зээл дээр тасралтгүй нэг ба түүнээс дээш жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх;
 - 3.2.8. Тусгай зөвшөөрөлтэй этгээд бол төрийн эрх бүхий байгууллагаас баталсан зохистой харьцааны шалгуурыг хангаж ажилласан, засаглал, мэдээлэл тайлагналын ил тод байдлыг хангасан этгээд байх.



2023-11-15

БҮРТГЭВ-02

3.3. Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны улмаас Компанид болон хөрөнгө оруулагч нарт хохирол учруулсан бол өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээх бөгөөд Компанитай сонирхлын зөрчил үүсгэхээс сэргийлж ажиллана.

ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 4.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгө итгэмжлэн удирдагч байхыг хориглоно.
- 4.2 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэгт заасан этгээд байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 4.2.1 Хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан байх;
 - 4.2.2 Банк, санхүүгийн зах зээлд гурваас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх;
 - 4.2.3 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг явуулахад шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан байх;
 - 4.2.4 Эрх бүхий албан тушаалтан, ХИУ үйл ажиллагааг хариуцах мэргэжилтэн нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийн журмын шаардлагыг хангасан байх;
 - 4.2.5 Гүйцэтгэх захирал, ХИУ үйл ажиллагааг хариуцсан мэргэжилтэн нь үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан байх.

ТАВ. ХӨНДЛӨНГИЙН АУДИТОР, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ, ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙГ СОНГОХ

- 5.1. Энэхүү Журамд заасан Хөндлөнгийн аудитор, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдсан шаардлагыг хангаж буй этгээдийг сонгох эсэхийг ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ. Энд дурдсан хуулийн этгээдийг сонгох шийдвэр гаргахад ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баримтална.
- 5.2. ТУЗ нь Журмын 5.1 дэх хэсэгт заасан этгээдийг сонгохдоо хууль, журам болон энэхүү Журамд заасан шаардлагыг хангаж буй эсэхэд хяналт тавьж, хараат бусаар шийдвэр гаргана.
- 5.3. Журмын 5.1 дэх хэсэгт заасан этгээдтэй байгуулах гэрээнд Компанийг төлөөлж ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна.
- 5.4. Компанид үйлчилгээ үзүүлэхээр сонгогдсон Хөндлөнгийн аудитор, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн талаар Хороонд мэдэгдэнэ.

ЗУРГАА. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 6.1. Хөндлөнгийн аудитортой байгуулах гэрээнд дараах агуулгыг заавал тусгасан байна. Үүнд:
 - 6.1.1. Компанийн үйл ажиллагаанд жилд нэгээс доошгүй удаа аудит хийх;
 - 6.1.2. Аудитын шалгалт хийх цар хүрээ нь Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 10.3 дахь хэсэгт заасныг хамарсан байх тухай;
 - 6.1.3. Үйлчилгээний хөлс;
 - 6.1.4. Талуудын эрх үүрэг;
 - 6.1.5. Талуудын хариуцлага;
 - 6.1.6. Гүйцэтгэх хугацаа;
 - 6.1.7. Үр дүнг хүлээлгэн өгөх;
 - 6.1.8. Гэрээ цуцлах үндэслэл, дуусгавар болгох журам;
 - 6.1.9. Давагдашгүй хүчин зүйлд авах талуудын авах арга хэмжээ;
 - 6.1.10. Гэрээнд хэрэглэх хэл, хэрэглэх хууль, маргаан шийдвэрлэх харьяалал.
- 6.2. Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулах гэрээнд дараах агуулгыг заавал тусгасан байна. Үүнд:
 - 6.2.1. Талуудын эрх үүрэг;
 - 6.2.1.1. Компани нь дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг бүрэн ирүүлэх үүрэгтэй болохыг;
 - 6.2.1.2. Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгийн багцад багтсан зээлийн зээлдэгч нартай

2023-11-15
БҮРТГЭЭ

СЭХ
2023 оны 11 сар 0 өдөр
ТӨЛБӨЛӨХ ГГЭВ
№ 11

- харилцах, төлбөр цуглуулах, зээлдэгчийн өмнө Компанийг үүрэгтэй болохыг;
- 6.2.1.3. Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн бүртгэл, дансанд хяналт хийж, компанид тайлагнах, тулгах үүрэгтэй болохыг;
 - 6.2.1.4. Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгийн багцад багтсан зээлийн мэдээллийг хадгалах үүрэгтэй болохыг;
 - 6.2.1.5. Үйлчилгээ үзүүлж буй этгээд нь дүгнэлт гаргахын тулд холбогдох бичиг баримтыг бүрэн судалж, зохих стандартын дагуу үйл ажиллагаа явуулах, гаргасан дүгнэлтийнхээ хариуцлагыг бүрэн хүлээх тухай;
 - 6.2.1.6. Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны улмаас Компанид болон хөрөнгө оруулагч нарт хохирол учруулсан бол өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээх бөгөөд Компанитай сонирхлын зөрчил үүсгэхээс сэргийлж ажиллана.
- 6.2.2. Цуглуулсан төлбөрийг компанид шилжүүлэх зарчим;
 - 6.2.3. Үйлчилгээний хөлс;
 - 6.2.4. Талуудын хариуцлага;
 - 6.2.5. Гэрээ цуцлах үндэслэл, журам;
 - 6.2.6. Давагдашгүй хүчин зүйлд авах талуудын авах арга хэмжээ;
 - 6.2.7. Гэрээнд хэрэглэх хэл, хэрэглэх хууль, маргаан шийдвэрлэх харьяалал.
- 6.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулах гэрээнд дараах агуулгыг заавал тусгасан байна. Үүнд:
- 6.3.1. Үйлчилгээний хөлс;
 - 6.3.2. Хөрөнгийн барьцаа, баталгаагаар хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах чиглэлээр үйлчилгээ үзүүлэгчийг шүүхэд нэхэмжлэл гаргахыг мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавих болон бусад авах шаардлагатай авах арга хэмжээний тухай;
 - 6.3.3. Үүрэг гүйцэтгэгч хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд хөрөнгө оруулагч болон компанийн эрхийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай;
 - 6.3.4. Хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гарвал энэ тухай нэн даруй ТЗКийн ТУЗ-д мэдэгдэх зохицуулалт;
 - 6.3.5. Талуудын эрх үүрэг;
 - 6.3.6. Хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гарвал энэ тухай ТУЗ-д мэдэгдэхталаар;
 - 6.3.7. Талуудын хариуцлага;
 - 6.3.8. Гэрээ цуцлах үндэслэл, журам;
 - 6.3.9. Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед талуудын авах арга хэмжээ;
 - 6.3.10. Гэрээнд хэрэглэх хэл, хэрэглэх хууль, маргаан шийдвэрлэх харьяалал.

**ДОЛОО. ХӨНДЛӨНГИЙН АУДИТОР, ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭГЧ, ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙГ
СОЛИХ**

- 7.1. Энэхүү Журамд заасан Хөндлөнгийн аудитор, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шалгуурыг хангахгүй болсон, гэрээ цуцлах үндэслэл бий болсон тохиолдолд тус тусын гэрээнд заасан журмын дагуу гэрээг цуцална.
- 7.2. Компани нь гэрээ цуцлах үндэслэл бий болсон гэж үзэж байгаа тохиолдолд цуцлах санал гаргах эсэх талаар ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ. Гэрээ цуцлах эсэх шийдвэр гаргахад ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баримтална.
- 7.3. Холбогдох этгээдтэй байгуулсан гэрээг цуцалж, дараагийн этгээдийг сонгож гэрээ байгуулахаас өмнө тухайн этгээд нь шаардлага хангаж байгаа талаарх нотлох баримтыг Хороонд хүргүүлэн зөвшөөрөл авсан байна.
- 7.4. ТУЗ нь үйлчилгээ үзүүлэх дараагийн этгээдийг сонгохдоо энэхүү Журмыг баримтална.
- 7.5. Компанийн ТУЗ нь холбогдох этгээдтэй гэрээ цуцалж байгаа тохиолдолд шинээр сонгогдсон этгээдийг ажлаа хүлээн авах хүртэл хугацаанд хуучин этгээдээс үйлчилгээг авах бөгөөд Компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангана.



2023-11-15

НАЙМ. БУСАД

- 8.1. Компани нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авч, улсын бүртгэлийн байгууллагад бүртгэл хийлгэсэн өдрөөс эхлэн энэхүү Журмыг мөрдөж эхэлнэ.
- 8.2. Энэхүү журмын нэмэлт өөрчлөлтийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.

_____ оОо _____



2023-08-08
БҮРТГЭВ-02

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Тусгай зориулалтын компанийн үйл ажиллагааны
журмуудыг батлах тухай

2023 оны 08 сарын 23-ны өдөр

№ ТУЗ-23/011

Улаанбаатар хот

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 17 дугаар зүйл, 20 дугаар зүйл, 40 дүгээр зүйл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмаар тогтоосныг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Омни ассет ТЗК” ХХК-ийн үйл ажиллагаанд ашиглагдах журмуудыг дараах хавсралтуудаар тус тус баталсугай.
 - 1.1. “Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам”-ыг Хавсралт №1
 - 1.2. “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-ыг Хавсралт №2
 - 1.3. “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам”-ыг Хавсралт №3
 - 1.4. “Үнэт цаасны төлбөр төлөх, төлбөр цуглуулах журам”-ыг Хавсралт №4.
2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож байгаа талуудад үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



А.БАТБОЛД



МОНГОЛЫН ХӨРӨНГӨЙН БЭР
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-11-15
БҮРТГЭЭ-02

СЭХ
2023 11 08
ОН СЯР ӨДӨГ
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
"ОМНИ АССЕТ ТЭК" ХХК-ийн
Төлөөлөгч Удирдах Зөвлөлийн 2023 оны ... сарын ...-ны
өдрийн дугаар тогтоолын ... хавсралт
УЛААНБААТАР ХОТ
8356327 9023060214

**ЭРСДЭЛ, СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ИЛРҮҮЛЭХ,
ҮНЭЛЭХ, УДИРДАХ ДОТООД ХЯНАЛТЫН ЖУРАМ**

Signature

УЛААНБААТАР ХОТ
"ОМНИ АССЕТ
ТЭК"
УЛААНБААТАР ХОТ
8356327

2023-11-15
1.1.

БҮРТГЭВ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ




“Омни Ассет ТЗК” ХХК (цаашид “ТЗК” гэх)-ийн Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь ТЗК-ийн зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх) гаргах, ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагч, Үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэл бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү Журамд дурдсан нэр томъёонуудыг дараах утгаар ойлгоно. Үүнд:

“Хороо”	гэж Санхүүгийн зохицуулах хороог;
“Бирж”	гэж Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийг;
“Оролцогч талууд”	Гэж ТЗК-тай гэрээ байгуулсан Хөрөнгөитгэмжлэн удирдагч, хөндлөнгийн аудит, Үйлчилгээ үзүүлэгч, Захиргааны үйлчилгээ үзүүлэгч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарыг хамтад нь;
“Зээлдэгч”	гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу зээл авч, хүүний хамт эргүүлэн төлөх төлбөрийн үүрэг хүлээсэн этгээдийг;
“Хөрөнгө итгэмжлэн удирдагч”	гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан этгээдийг;
“Үйлчилгээ үзүүлэгч”	гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан этгээдийг;
“Анхны үүрэг гүйцэтгүүлэгч”	гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан этгээдийг;
“Үнэт цаас эзэмшигч”	гэж ТЗК-ийн гаргасан ХБҮЦ-ыг худалдан авч хөрөнгө оруулсан буюу эзэмшиж буй этгээдийг;
“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”	гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.9 дэх хэсэгт заасан этгээд буюу “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийг;
“Ашиг сонирхлын зөрчил”	гэж энэхүү журмын 5.1-д тодорхойлсныг;

ХОЁР. ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛ

- 2.1. ХБҮЦ-ны төлбөр төлөхтэй холбоотой учирч болох эрсдэлийг дараах 3 байдлаар ангилна.
 - 2.1.1. Зээлтэй холбоотой эрсдэл;
 - 2.1.2. ХБҮЦ гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудтай холбоотой эрсдэл;
 - 2.1.2.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч;
 - 2.1.2.2. Үйлчилгээ үзүүлэгч;
 - 2.1.2.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч;
 - 2.1.3. Бусад гадны хүчин зүйлстэй холбоотой эрсдэл;





2023-11-1

2.1.3.1. Хууль, журам, зохицуулалт;

2.1.3.2. Давагдашгүй хүчин зүйлс.

БҮРТГЭЭ-02

ГУРАВ. ЭРСДЭЛИЙГ УДИРДАХ АРГА ХЭМЖЭЭ

- 3.1. Зээлтэй холбоотой эрсдэл.
- 3.1.1. Зээлийн эрсдэл гэдэг нь зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй улмаас үүсэх эрсдэлийг хэлнэ. Үүнд зээлдэгч зээлийн хугацаа хэтрүүлэх, төлбөрийн чадваргүй болох, Зээлдэгч эрх зүйн чадамжгүй болох, нас барах, сураггүй алга болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон байхыг ойлгоно.
- 3.1.2. Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл гэдэг нь зээлдэгч зээлээ хугацаанаас нь өмнө төлөх буюу хүлээгдэж байсан хүүгийн орлого буурах, хаагдахыг ойлгоно.
- 3.2. Зээлтэй холбоотой эрсдэлийг дараах байдлаар удирдана. Үүнд:
- 3.2.1 ТЗК нь хугацаа хэтэрсэн зээл дээр үйлчилгээ үзүүлэгч талаас зээлийг эргэн төлүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчийн дотооддоо мөрдөж буй холбогдох заавар журмын хүрээнд үйлчилгээг авч, хяналт тавьж ажиллана. Үүнтэй холбоотой зохицуулалтыг Үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгана.
- 3.2.2 ТЗК нь зээл хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл үүссэн тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг болон ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу хөрөнгийн багцад хөрөнгө нэмэх замаар арга хэмжээ авна.
- 3.3. Оролцогч талуудтай холбоотой эрсдэл.
- 3.3.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл.
- 3.3.1.1. ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан зээл шилжүүлсэн;
- 3.3.1.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг сольж нэмж чадахгүй болсон;
- 3.3.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдсан.
- 3.3.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг дараах байдлаар удирдана. Үүнд:
- 3.3.2.1. Энэхүү Журмын 3.3.1.1 дэх хэсэгт заасан эрсдэл үүсэх тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгийн багцыг солихыг шаардах, ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу эрсдэлийг удирдана.
- 3.3.2.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үйлчилгээ үзүүлэгч нь нэг этгээд бол Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь сайн дурын үндсэн дээр эсхүл хуульд заасан үндэслэлээр татан буугдах тохиолдолд түүний ТЗК-д шилжүүлсэн Багцын хөрөнгийн үлдэгдлийг зохих журмын дагуу сонгогдсон өөр Үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх арга хэмжээ авна.
- 3.3.2.3. ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох журам, гэрээнд тус бүр эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.
- 3.3.3. Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл.
- 3.3.3.1. Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийг бүрэн гүйцэд, гэрээгээр хүлээсэн хугацааны дагуу цуглуулан ТЗК-д шилжүүлэхгүй байх;
- 3.3.3.2. Үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцлах;
- 3.3.3.1. Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдсан,





дампуурсан.

2023 -11- 13
БҮРТГЭВ-02

- 3.3.4. Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг дараах байдлаар удирдана. Үүнд:
- 3.3.4.1. Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй зээлүүдийн үндсэн болон хүүгийн төлөлтийг уг дансанд цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгана. Үйлчилгээ үзүүлэгч нь учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна.
 - 3.3.4.2. Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийг төлүүлэхдээ ТЗК-тай байгуулсан гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дотооддоо мөрдөгдөж буй Зээлийн үйл ажиллагааны журам, Зээл төлүүлэхтэй холбогдсон бусад журмыг дагаж мөрдөнө.
 - 3.3.4.3. Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлэхгүй, эсхүл Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан тохиолдолд ТЗК нь тусгаарласан зээлийн багцтай холбоотой авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг зохих журмын дагуу сонгогдсон, өөр хэвийн үйл ажиллагаатай үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэгчийг солих арга хэмжээ авна.
 - 3.3.4.4. ТЗК нь үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.
- 3.3.5. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл.
- 3.3.5.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийг гэрээнд зааснаас гадуур, Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид хохиролтойгоор зүй бусаар удирдах, ашиглах;
 - 3.3.5.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцалсан;
 - 3.3.5.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь татан буугдсан, дампуурсан.
- 3.3.6. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг дараах байдлаар удирдана. Үүнд:
- 3.3.6.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын удирдлагатай холбоотой тайлан мэдээллийг Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад тогтмол хүргэх бөгөөд хууль болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд ТЗК-ийн ТҮЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа өгөх эрхтэй. Мөн зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгаж баталгаажуулсан байна.
 - 3.3.6.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг төрийн зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна.



2023-11-13

БҮРТГЭС-02



3.3.6.3. ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг бууруулах; үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

3.3.7. Хөрөнгөөр баталгаажсан Үнэт цаас гаргагч нь Оролцогч талуудтай сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж, зохих мэдэгдэл баталгаа гаргуулах, сонирхлын зөрчил үүсч болохоор нөхцөл байдал үүссэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийж, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах зэрэг холбогдох арга хэмжээ авна.

3.4. Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэл

3.4.1. ХБҮЦ, ТЗК, оролцогч талуудад тавигдах шаардлагатай холбоотой хууль журам, зохицуулалт өөрчлөгдөх эрсдэл.

3.5. Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэлийг дараах байдлаар удирдана. Үүнд:

3.5.1. Энэ журмын 3.4 дүгээр зүйлийн 3.4.1-д заасан эрсдэлтэй холбогдуулан ТЗК-ийн ТУЗ-ийн хурал хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллага, хуулийн фирмийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллана.

3.5.2. Давагдашгүй хүчин зүйлстэй холбоотой эрсдэлд дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

3.5.2.1. Давагдашгүй хүчин зүйл бий болсон тухайгаа Үнэт цаас эзэмшигчдэд тухайн брокерын компаниар дамжуулан бичгээр мэдэгдэх, ТЗК болон Биржийн цахим хуудсаар мэдээлнэ. Тухайн мэдэгдэлд ямар байдлаар давагдашгүй хүчин зүйл үүссэн, түүний хор уршгийг бууруулах талаар авсан, эсхүл авах гэж буй арга хэмжээ, давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон хугацааг тус тус тусгасан байна.

3.5.2.2. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас ТЗК нь Үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй нь үндсэн үүргээс чөлөөлөхгүй бөгөөд давагдашгүй хүчин зүйлийн үед ТЗК-ийн үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

ДӨРӨВ. ЭРГЭН ТӨЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ

4.1. ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасны дагуу эргэн төлөлтийг сайжруулах дараах арга хэмжээг авна.

4.1.1. Хөрөнгийн багцыг сайжруулах, солих;

4.1.2. Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэх;

4.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах;

4.1.4. Хөрөнгийн багцын дүнг ХБҮЦ-ны төлбөрийн төлөгдөөгүй дүнгээс багагүй байлгах.

4.2. Хөрөнгийн багц дахь зээлийн төлбөрүүдийг Үйлчилгээ үзүүлэгчийн бусад хөрөнгөөс тусад ньангид байлгах.

4.3. ТЗК-ийн төлбөр гүйцэтгэх дансанд зарлагын хязгаарлалтууд хийгдэх ба энэхүү Журмын 3.3.бдугаар зүйлийн 3.3.б.1 дэх хэсэгт заасны дагуу зохион байгуулна.

4.4. ТЗК-ийн эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээг ТЗК татан буугдах хүртэл хэрэгжүүлнэ.

4.5. ТЗК нь татан буугдах үед хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсний дараа үлдсэн зээл нь Анхны үүрэг гүйцэтгэгч буюу ТЗК-ийн үүсгэн байгуулагч-хувьцаа эзэмшигчид шилжинэ.



2023-11-15



ТАВ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ, ТЭДГЭЭРИЙГ МЭДЭГДЭХ

- 5.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн аудит, захиргааны үйлчилгээ үзүүлэгч, Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК-тай сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж ажиллана.
- 5.2. Үнэт цаас гаргах ажиллагаанд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж, дараах үйлдлийг хориглоно:
- 5.2.1. Оролцогч талуудын болон хөрөнгө оруулагчдын нууц мэдээллийг задруулах,
 - 5.2.2. Аливаа гуравдагч этгээдэд үйл ажиллагааны үр дүнгийн талаар амлалт өгөх,
 - 5.2.3. Үнэт цаас эзэмшигчид үнэт цаас, түүний эргэн төлөх ажиллагааны талаар буруу ойлголт өгөх, бодит байдлыг нуун дарагдуулах,
 - 5.2.4. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашиг, хүсэл сонирхлын эсрэг ажиллах,
 - 5.2.5. Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг санаатайгаар буруу хэрэглэх, тайлбарлах,
 - 5.2.6. Бусад оролцогч талуудын үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулах
- 5.3. ТЗК нь ХБҮЦ гаргахдаа оролцогч талуудаас ашиг сонирхлын зөрчилгүй талаарх тодорхойлолтыг авсан байна.
- 5.4. Оролцогч талуудын зүгээс холбогдох гэрээний дагуу мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэх үед ашиг сонирхлын зөрчил үүссэн эсхүл үүсч болзошгүй нөхцөлд энэ талаар ТЗК-д мэдэгдэж, тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхээс татгалзах эрхтэй.
- 5.5. Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч, эсхүл тэдгээрийн ажилтнууд нь сонирхлын зөрчилтэй харилцаа үүсгэсэн, үүсгэж болзошгүй бол ТЗК болон холбогдох талуудад мэдэгдэж, мэдээлэлтэй зөвшөөрөл авч болно.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1. Энэхүү журмыг зөрчсөнөөс холбогдон үүсэх хохирлыг буруутай ажилтан, албан тушаалтан болон оролцогч байгууллагууд барагдуулна.
- 6.2. Зөрчил гаргасан этгээдийн үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл ТЗК эрх бүхийбайгууллагад гомдол гарган шалган шийдвэрлүүлнэ.

ДОЛОО. БУСАД

- 7.1. Энэхүү Журам нь ТЗК-ийн ТУЗ-аас баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд ТЗК нь тусгай зориулалтын компанийн тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш дагаж мөрдөнө.
- 7.2. Энэхүү Журамд нэмэлт өөрчлөлт оруулахад ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн батална.





Омни Ассет ТЗК ХХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны ... сарын ...-ны
өдрийн дугаар тогтоолын ... хавсралт

ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ЖУРАМ



2023-11-15
БҮРТГЭВ-02

ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

СЗХ
2023-11-08 өдөр
БҮРТГЭВ
№ 01


- 1.1. “Омни Ассет ТЗК” ХХК (цаашид “ТЗК” гэх) -ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь ТЗК-ийн гаргаж буй зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх)-ны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцад буй хөрөнгийг солих, нэмэх, хасах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотойгоор ТЗК-ийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад оролцогчтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. ТЗК нь үйл ажиллагаандаа Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам, Монголын хөрөнгийн биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам болон энэхүү журамд заасныг тус тусбаримтлан ажиллана.

ХОЁР. ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 2.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу багцыг шилжүүлэн авсан зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл болон зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон эсхүл Журамд заасан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад өөрчлөлт оруулна.
- 2.2. Хөрөнгийн багцад дор дурдсаны дагуу дараах байдлаар өөрчлөлт оруулна. Үүнд:
 - 2.2.1. Багцын хөрөнгийг солих;
 - 2.2.2. Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;
 - 2.2.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах.
- 2.3. Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож, хөрөнгийн багцад байгаа хөрөнгийг багцаас хасаж солино. Үүнд:
 - 2.3.1. Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь Үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхүйц байна гэж ТЗК-аас үзсэн;
 - 2.3.2. Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн “Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ”-нд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн;
 - 2.3.3. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн зээл эргэн төлөх үүргээ биелүүлээгүй 90-ээс дээш хоног хэтэрсэн эсхүл;
 - 2.3.4. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болох нь тогтоогдсон бол.
- 2.4. Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:
 - 2.4.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.1-д заасны дагуу ХБҮЦ-ны хөрөнгийн багцаас орох орлого нь ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
 - 2.4.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу ТЗК нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргахаар болсон;
 - 2.4.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолд

2023 -11- 15

БҮГДЭМЭГ



нийцүүлэн үнэт цаас эзэмшигчдэд төлөх төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон.

- 2.5. Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд ТЗК нь хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана. Үүнд:
- 2.5.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Журамд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
 - 2.5.2. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш, эсхүл 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд;
 - 2.5.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд.
- 2.6. Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэхэд багцад ийнхүү нэмэгдсэн хөрөнгө нь ХБҮЦ гаргах өргөдөл, Үнэт цаасны танилцуулгад тусгагдсантай адил онцлог, шинж чанартай байна.

ГУРАВ. ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ДАРААЛАЛ

- 3.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20.2.1 болон 20.2.5-д тус тус заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийн багцад хяналт тавих ажлыг ТЗК-тай байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасны дагуу гүйцэтгэнэ.
- 3.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэгчээс өдөр бүр ирүүлсэн зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл болон Үйлчилгээ үзүүлэгчээс ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанд хуримтлуулсан хөрөнгийн үлдэгдэлд үндэслэн хөрөнгийн багцад хяналт тавина.
- 3.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багц дахь зээлүүдийн эргэн төлөлт болон Үйлчилгээ үзүүлэгчийн сарын тайланд үндэслэн энэхүү журмын 2.3 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн тохиолдолд хөрөнгийг солиход дараах арга хэмжээг авна. Үүнд:
 - 3.3.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд заасан шалгуур хангасан “орлуулах хөрөнгийн жагсаалт”-аар солино.
 - 3.3.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон орлуулах хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн программд оруулж холбогдох актыг үйлдсэнээр хөрөнгийг сольж бүртгэсэнд тооцно.
 - 3.3.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д шилжүүлсэн орлуулах хөрөнгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр хэмжээ, нь шаардлага хангахгүй хөрөнгийн үндсэн өрийн үлдэгдэл болон хуримтлагдсан хүүгийн дүнгийн нийлбэрээс зөрүүтэй тохиолдолд авлага, өглөгийг тооцоо нийлсэн актад тусгаж барагдуулна.
- 3.4. Энэхүү журмын 2.4 дэх хэсэгт заасан нөхцөл үүссэн тохиолдолд хөрөнгийг нэмэгдүүлэх дараах арга хэмжээг авна. Үүнд:
 - 3.4.1. Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт хийгдсэн мэдээлэл агуулсан Үйлчилгээ үзүүлэгчийн тайланд үндэслэн багцын хөрөнгийг нэмэгдүүлэх дүнг гаргаж, Анхны үүрэг гүйцэтгэгч болон ТЗК-нарын хооронд байгуулсан хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний тусгай нөхцөлийн 4 дүгээр зүйлд заасан шалгуур хангасан “нэмэгдүүлэх хөрөнгийн жагсаалт”-аар хөрөнгө итгэмжлэн удирдагчтай тохиролцсоны үндсэн дээр нэмэгдүүлнэ.
 - 3.4.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон нэмэгдүүлэх хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдагчийн программд оруулж холбогдох актыг үйлдсэнээр хөрөнгийг нэмэгдэж бүртгэгдсэнд тооцно.





2023-11-11
БҮРТГЭЭ-02

- 3.5. Энэхүү Журмын 2.5 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн тохиолдолд хөрөнгийг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах дараах арга хэмжээг авна. Үүнд:
 - 3.5.1. Журмын 2.5.1-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй зээлийн хөрөнгийг буцаан худалдах актыг үйлдэж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь буцаан худалдсан зээлийн холбогдох төлбөрийг ТЗК-д шилжүүлнэ.
 - 3.5.2. Журмын 2.5.2, 2.5.3-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэгчийн тайланд үндэслэн багцын хөрөнгийн үлдэгдлийг гаргаж ТЗК-ийн ТУЗ-д танилцуулж буцаан худалдах эсэхийг шийдвэрлүүлнэ.
 - 3.5.3. Журмын 3.5.2-т заасны дагуу багцыг буцаан худалдахаар шийдвэрлэсэн тохиолдолд ТЗК нь буцаан худалдах мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлнэ.
 - 3.5.4. Журмын 3.5.3-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ТЗК-тай Хөрөнгийн багцыг буцаан худалдах гэрээг байгуулж, холбогдох төлбөрийг төлнө.
- 3.6. ТЗК нь Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 11.3-т заасан мэдээлэл, тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгө оруулагчид цахим хэлбэрээр мэдээлнэ.

ДӨРӨВ. СУЛ ЧӨЛӨӨТЭЙ ЭХ ҮҮСВЭРИЙН УДИРДЛАГА

- 4.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Төлбөр цуглуулах данс дахь ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөрөөс илүү гарсан хэсэг буюу түүнд хамаарахгүй мөнгөн хөрөнгөөр ТЗК-ийн дүрэмд заасны дагуу хөрөнгө оруулалтын хэрэгслийн эрсдэл, өгөөж болон ХБҮЦ-ны холбогдох үүргийг гүйцэтгэхэд аливаа хүндрэл учрахгүй байх бүхий л бололцоог харгалзан тооцоо судалгаа хийсний үндсэн дээр дараах хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулна.
 - 4.1.1. Банкны хадгаламж;
 - 4.1.2. Засгийн газар болон Монголбанкаас гаргасан үнэт цаас ;
 - 4.1.3. Зохицуулах байгууллагаас хүлээн зөвшөөрсөн бусад.
- 4.2. ХБҮЦ-ны төлбөрийг хугацаандаа төлөх боломжийг хангах зорилгоор дээр дурдсан хөрөнгө оруулалтын дуусах хугацааг ХБҮЦ-ны төлбөр төлөх хугацаатай уялдуулан тохируулсан байна.

ТАВ. ХАРИУЦЛАГА

- 5.1. Энэхүү журмыг зөрчсөнөөс холбогдон үүсэх хохирлыг буруутай ажилтан, албан тушаалтан болон оролцогч байгууллагууд барагдуулна.
- 5.2. Зөрчил гаргасан этгээдийн үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл ТЗК нь эрх бүхий байгууллагад гомдол гарган шалган шийдвэрлүүлнэ.

ЗУРГАА. БУСАД

- 6.1. ТЗК нь ХБҮЦ гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авч, улсын бүртгэлийн байгууллагад бүртгэл хийлгэсэн өдрөөс эхлэн энэхүү Журмыг мөрдөж эхэлнэ.
- 6.2. Энэхүү журмын нэмэлт өөрчлөлтийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.
- 6.3. Журмын хавсралт: Хавсралт №1 Хөрөнгө буцаан худалдах тухай мэдэгдэл.



2023-11-15
БҮРТГЭЭ-02

ХАВСРАЛТ 1

СЭХ
2023 оны 0 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ХӨРӨНГӨ БУЦААН ХУДАЛДАХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Хэнд: Анхны үүрэг гүйцэтгүүлэгч

Тодорхойлсон нэр томъёо болон тайлбар

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч [●] болон Худалдан авагч [●] нарын хооронд [●] өдөр байгуулсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд тодорхойлсон үг ба илэрхийлэл нь энэхүү мэдэгдэлд хэрэглэгдэхдээ ижил утгатай байх бөгөөд худалдах, худалдан авах гэрээний тайлбарын талаарх бүх зүйлүүд нь энэ баримт бичигт адил хамаарна.

Санал болон хүлээн зөвшөөрөлт

Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу Худалдан авагч нь үүгээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч [●] болон Худалдан авагч [●] нарын хооронд [●] өдөр байгуулсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд дурдсан хөрөнгийг буцаан худалдан авахыг шаардаж, мэдэгдлийг хүргүүлж байна:

Буцаан худалдан авах гэрээг хэрэгжүүлэх хугацаа, нөхцөл:

Буцаан худалдан авах гэрээний огноо:

[Буцаан худалдан авах өдөр/Эргэн төлөлтийн өдөр]:

Буцаан худалдан авах дүн/зах зээлийн бодит үнэ:

Төлөөлж
Гарын үсэг зурсан
Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга
[●]



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-11-15

БҮРТГЭЭ-02



"Омни Ассет ТЗК" ХХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны ... сарын ...-ны
өдрийн дугаар тогтоолын ... хаваралт



ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ
ХҮРГҮҮЛЭХ ЖУРАМ



2023-11-15

БҮРТГЭВ-02

ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ ЖУРАМ



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “Омни Ассет ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид Компанийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Компани нь мэдээлэл хүргэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох бүртгэлийн журам”, Монголын хөрөнгийн биржийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам” болон энэхүү Журамд заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт байдлаар мэдээлэх үүрэгтэй.
- 1.3. Компани нь энэхүү Журамд заасан мэдээллийг Монгол хэл дээр хүргэх ба мэдээллийг олон нийт болон хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид өөрийн болон Биржийн цахим хуудсаар хүргэнэ. Компани шаардлагатай гэж үзвэл гадаад хэл дээр мэдээллийг давхар хүргэж болно.
- 1.4. Мэдээ, мэдээллийг үнэн зөв олон нийтэд хүргэх, үнэт цаас эзэмшигчид, эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг гэрээний үндсэн дээр хөрөнгө итгэмжлэн удирдагчаар гүйцэтгүүлнэ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид хүргэхийг хариуцан ажиллах ба Компанийн төлөөлөн удирдах зөвлөл хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хянана.
- 1.5. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгон, хэрэглэнэ.
 - 1.5.1. “Бирж” гэж үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага буюу “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК;
 - 1.5.2. “Хороо” гэж Санхүүгийн зохицуулах хороо;
 - 1.5.3. “Мэдээллийг нийтэд хүргэх” гэж Компани нь холбогдох хууль тогтоомж болон энэхүү Журамд заасан мэдээллийг Компанийн болон Биржийн цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигч нарт хүргэхийг;
 - 1.5.4. “Тогтмол мэдээлэх” Компаниас үнэт цаас эзэмшигчид болон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор энэ журамд заасан өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг бүрэн агуулсан, тодорхой хугацааны давтамжтай тайлагнах үүрэг бүхий мэдээллийг;
 - 1.5.5. “Тухай бүр мэдээлэх” гэж үйл явдал болсон өдрөөс хойш даруй энэхүү Журам, хууль тогтоомж, дүрэм журамд заасан хугацааны дотор мэдээлэхийг;
 - 1.5.6. “Дотоод мэдээлэл эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэгт заасан этгээдийг хэлнэ.

ХОЁР. МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ЖУРАМ

- 2.1. Компани нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид мэдээллийг тогтмол, цаг тухайд нь хүргэх үүрэгтэй.
- 2.2. Компани нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид мэдээллээр хангах тал дээр ижил, тэгш хандах, үйл ажиллагаандаа нээлттэй, ил тод байх зарчмыг баримтлах ба хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчтэй харилцах, хууль тогтоомжийн дагуу тогтмол мэдээ, мэдээллийг хүргэх нөхцөлийг бүрэн хангаж ажиллана.
- 2.3. Компани нь дараах мэдээллийг дор дурдсан хугацаанд холбогдох этгээдэд мэдээлэх үүрэгтэй. Үүнд:





2023-11-15
БҮРТГЭВ

- 2.3.1. Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын 11.3-т заасан мэдээллийг Хороо болон хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд дараа сарын 10-ны дотор цахим хэлбэрээр хүргүүлнэ.
- 2.3.2. Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.1.3-д заасан мэдээллийг Биржид дараа сарын 20-ны өдрийн дотор мэдээлнэ.
- 2.3.3. Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 11.4-т заасан жилийн үйл ажиллагааны тайлан болон Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.1.1-д заасан жилийн санхүүгийн тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 30-ны дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Хороо, Биржид цахим болон хэвлэмэл хэлбэрээр үнэт цаас эзэмшигчид цахим хэлбэрээр тус тус мэдээлнэ.
- 2.3.4. Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.1.2-д заасан мэдээллийг дараа оны 4 дүгээр сарын 30-ны дотор Биржид мэдээлнэ.
- 2.3.5. Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.2 болон Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 11.6-д заасан мэдээлэлд өөрчлөлт орсон бол өөрчлөгдсөн тухай бүр ажлын 3 хоногт багтаан Хороо болон Биржид мэдэгдэнэ.
- 2.3.6. Үнэт цаас гаргагч нь улирлын шинж чанартай тайланг Хороо болон Биржид цахимаар мэдэгдэх бөгөөд хагас жил тутмын болон жилийн тайланг хэвлэмэлээр мэдэгдэнэ.
- 2.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т заасан хагас жил тутам хөрөнгө оруулагч болон Хороонд хүргүүлэх хагас жил тутмын тайланд дараах мэдээллийг тусгана. Үүнд:
 - 2.4.1. Хөрөнгийн багцын үлдэгдэл;
 - 2.4.2. Хугацаандаа болон хугацаа хэтэрч төлөгдсөн үндсэн төлбөрийн хэмжээ;
 - 2.4.3. Хугацаанаасаа өмнө төлөгдсөн үндсэн төлбөрийн хэмжээ;
 - 2.4.4. Ердийн шаардлагад нийцэхгүй болсон буюу хугацаа хэтэрсэн хөрөнгийн хэмжээ;
 - 2.4.5. Хөрөнгө болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн нөхцөлд нөлөөлөхүйц бусад мэдээлэл.

ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН АРХИВЫГ БҮРДҮҮЛЭХ, ХАДГАЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1. Компани нь олон нийтэд хүргэх мэдээллийг нэгэн зэрэг сонирхогч бүх этгээдэд Биржийн болон Компанийн цахим хуудсаар дамжуулан тогтоосон хугацаанд мэдээлнэ. Компанийн цахим хуудсанд нийтэд тогтмол мэдээлэл хүргэх хэсэг байрших бөгөөд тус хэсгийн мэдээлэл нь Компани татан буугдах хүртэл хугацаанд байршина.
- 3.2. Компанийн бүхий л баримт бичгийг татан буугдах хүртэл хугацаагаар хадгалах бөгөөд хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээний үндсэн дээр энэхүү хугацаанд баримт бичгийг архивлан хадгалах ажлыг хариуцна.
- 3.3. Компани татан буугдах үед холбогдох бүхий л баримт, материалыг Компанийн үүсгэн байгуулагчид хүлээлгэн өгөх бөгөөд үүсгэн байгуулагч хүлээн авсан материалыг 10 жил хадгалсны дараа архивд хүлээлгэн өгнө.

ДӨРӨВ. БУСАД

- 4.1 Компани нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авч, улсын бүртгэлийн байгууллагад бүртгэл хийлгэсэн өдрөөс эхлэн энэхүү Журмыг мөрдөж эхэлнэ.
- 4.2 Энэхүү журмын нэмэлт өөрчлөлтийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.





Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 сарын 25-ны өдрийн ТУЗ-23/005 дугаар тогтоолын хавсралт №4



**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ,
ТӨЛБӨР ТӨЛӨХ ТУХАЙ ЖУРАМ**





ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ, ТӨЛБӨР ТӨЛӨХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 “Омни Ассет ТЗК” ХХК (цаашид “ТЗК” гэх)-ийн Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь ТЗК-аас гаргах зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх)-ны хөрөнгийн багц дахь зээлүүдийн төлбөрийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд ХБҮЦ-ны төлбөр төлөхтэй холбоотойгоор ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Төлбөр цуглуулах, төлбөр төлөх үйл ажиллагаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны №360 тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2020/06 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”, ТЗК-ийн дүрэм болон энэхүү журмыг баримтална.
- 1.3 Энэхүү Журамд дурдсан нэр томъёонуудыг дараах утгаар ойлгоно. Үүнд:
- | | |
|--------------------------------|---|
| “Анхны үүрэг гүйцэтгүүлэгч” | гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт тодорхойлсон этгээд буюу “Омни Капитал ББСБ” ХХК-ийг; |
| “Үйлчилгээ үзүүлэгч” | гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт тодорхойлсон этгээд буюу ТЗК-д үйлчилгээ үзүүлэх этгээд болох “Омни Капитал ББСБ” ХХК-ийг; |
| “Зээлдэгч” | гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу хүүгийн хамт эргүүлэн төлөх мөнгөн төлбөрийн үүрэг хүлээсэн этгээдийг; |
| “Зээл” | гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид зээлийн гэрээний дагуу олгосон мөнгөн хөрөнгийг; |
| “Зээлийн данс бүртгэл” | гэж Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацаатай нь бүртгэсэн мэдээллийг; |
| “Зээлийн эргэн төлөлт” | гэж ХБҮЦ-ны хөрөнгийн багцад багтсан Зээлийн төлөлт буюу Зээлдэгчээс Зээлийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх мөнгөн төлбөрийг; |
| “Зээлийн эргэн төлөлтийн данс” | гэж Зээлийн эргэн төлөлтийг цуглуулах зорилгоор Үйлчилгээ үзүүлэгчээс банканд нээсэн, энэ Журмын 2.3.1 дэх хэсэгт заасан дансыг; |
| “Төлбөр цуглуулах данс” | гэж энэхүү Журмын 2.2.1 дэх хэсэгт заасны дагуу Зээлийн эргэн төлөлтийн мөнгийг хүлээн авах зорилгоор банканд тусгайлан нээсэн ТЗК-ийн дансыг; |



2023-11-15

“Багцын эргэн төлөлт”

БҮРТГЭВ

СЗХ
он 2023 сар 17 өдөр
БҮРТГЭВ
№ 1

“ҮЦТХТ”

гэж Үйлчилгээ үзүүлэгчээс ТЗК-д Үйлчилгээ үзүүлэх тухай гэрээний дагуу шилжүүлж буй Зээлийн эргэн төлөлтийг;

гэж “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийг;

“Зээлийн гэрээ”

гэж Зээлдэгч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээг;

“Хөрөнгө итгэмжлэн удирдагч”

гэж “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт тодорхойлсон этгээд буюу “Юнайтед Айр Файнэнс” ХХК-ийг;

“Үнэт цаас эзэмшигч”

гэж ТЗК-ийн гаргасан ХБҮЦ-ыг худалдан авч, эзэмшиж буй этгээдийг.

ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ АЖИЛЛАГАА

- 2.1 ХБҮЦ-ны төлбөр цуглуулах ажиллагаанд ажил гүйцэтгэх гэрээний дагуу дараах этгээд оролцоно.
 - 2.1.1. ТЗК;
 - 2.1.2. Үйлчилгээ үзүүлэгч;
 - 2.1.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч;
- 2.2 Төлбөр цуглуулахад ТЗК нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
 - 2.2.1. ТЗК нь Үйлчилгээ үзүүлэгчийн Зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгөн хөрөнгийг хүлээн авах, ХБҮЦ-ны төлбөр төлөх зорилгоор Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэж, төлбөр хүлээн авах бэлэн байдлыг хангана.
 - 2.2.2. ТЗК нь ХБҮЦ-ны төлбөр цуглуулах ажиллагаанд оролцох Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбогдох гэрээг байгуулж, төлбөр цуглуулах, төлбөр хүлээн авах ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг хангасан байна.
- 2.3 Төлбөр цуглуулахад Үйлчилгээ үзүүлэгч нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
 - 2.3.1 Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс буюу Зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэнэ.
 - 2.3.2 Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийн дансанд тухай бүр орж ирсэн мөнгөн хөрөнгийг уг дансанд төвлөрүүлж дараа сарын 05-ны өдөрт багтаан холбогдох авлагыг суутган Төлбөр цуглуулах данс руу шилжүүлсэн байна.
 - 2.3.3 Зээлдэгчийн хүсэлтийн дагуу Зээлийн гэрээ, Зээлдэгчийн мэдээлэл, төлбөрийн хуваарь зэрэгт өөрчлөлт оруулсан бол Үйлчилгээ үзүүлэгч нь энэ талаарх мэдээллийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан өдөрт багтаан мэдэгдэнэ. Зээлийн гэрээнд өөрчлөлт орсон нь Зээлийн багц дахь шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон тохиолдолд ТЗК-ийн “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-д заасны дагуу арга хэмжээ авна.
 - 2.3.4 Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг тооцоолсон Зээлийн данс бүртгэлийг хөтөлж, зээлийн болон төлбөрийн мэдээллийг дараа сарын ажлын 3 өдөрт багтаан ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэн, тайлагнана.
 - 2.3.5 Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлдэгч Зээлийн эргэн төлөлтийн хугацааг хэтрүүлсэн болон төлбөл зохих хуваарьт төлбөрөөс давуулан илүү төлсөн тохиолдол бүрийг тухай

2023-11-15

БҮРТГЭВ



бүр бүртгэж, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид нэн даруй мэдээлэх ба Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Активыг ангилал, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу ангилж, тайлагнана..

- 2.3.6 Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай харилцах ажилтныг тусгайлан томилох бөгөөд түүнтэй холбоо барих мэдээлэл, түүний эрх, үүрэг болон бусад шаардлагатай мэдээллийг ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлнэ.
- 2.4 Төлбөр цуглуулахад Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
- 2.4.1 Програмаар зээлийн төлбөрийг хянана.
- 2.4.2 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгчтэй харилцах өөрийн ажилтныг тусгайлан томилох бөгөөд түүнтэй холбоо барих мэдээлэл, түүний эрх, үүрэг болон бусад шаардлагатай мэдээллийг ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлнэ.
- 2.4.3 Энэхүү журмын 3.2 дахь хэсэгт заасан гүйлгээг хийж гүйцэтгэнэ.
- 2.4.4 ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөс ХБҮЦ-ны болон ТЗК-ийн бусад төлбөрийн үүргүүдийг гүйцэтгэх боломжгүй болсон эсхүл Хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гарсан тохиолдолд энэ тухай нэн даруй ТЗК-д буюу ТЗК-ийн ТҮЗ-д мэдэгдэнэ.

ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙГ ТӨЛӨХ, ТӨЛБӨРИЙН ЗАРЦУУЛАЛТ

- 3.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөр цуглуулах данснаас зөвхөн энэхүү Журмын 3.2 дахь хэсэгт заасан зарцуулалтыг хийх талаарх арга хэмжээг авч, Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдөх төлбөрийг зориулалтын бусаар захиран зарцуулахаас сэргийлнэ.
- 3.2. ТЗК-ийн Төлбөр цуглуулах дансанд цугларсан Багцын эргэн төлөлтөөс зөвхөн дараах гүйлгээг гүйцэтгэнэ. Үүнд:
- 3.2.1. Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдөх төлбөрийг ҮЦТХТ-ийн дансруу шилжүүлэх;
- 3.2.2. Үнэт цаасны хүүгийн орлогын татвар;
- 3.2.3. Хөрөнгийн багцад хөрөнгө нэмж худалдан авах, солих, нэмэгдүүлэх;
- 3.2.4. Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах;
- 3.2.5. ТЗК-ийн төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТҮЗ” гэх)-өөс баталсан төсвийн дагуу ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий ба удирдлагын зардал.
- 3.3. Энэхүү Журмын 3.2.5-т заасан төлбөрийг дараах зардалд зарцуулна. Үүнд:
- 3.3.1. Татвар;
- 3.3.2. Төрийн болон бусад эрх бүхий байгууллагад төлөгдөх зардал;
- 3.3.3. ХБҮЦ гаргах, хадгалалттай холбоотой зардал;
- 3.3.4. Банктай холбоотой зардал;
- 3.3.5. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр;
- 3.3.6. Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр;
- 3.3.7. Хөндлөнгийн аудит болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн төлбөр;
- 3.3.8. ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий болон удирдлагын цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, үйл ажиллагааны зардал (вэб сайттай холбоотой зардал, санхүүгийн программтай холбоотой зардал, мэдээлэл хүргэхтэй холбоотой зардал, бичиг хэргийн зардал).
- 3.4. ТЗК-ийн ТҮЗ нь энэхүү Журмын 3.3 дахь хэсэгт заасан зардлын төсвийг баталж, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид мэдэгдэнэ.



2023-11-15

БҮРТГЭ

3.5. ТЗК нь энэхүү Журмын 3.2 болон 3.3 дахь хэсэгт зааснаас бусад зардал гаргахгүй бөгөөд эрх бүхий байгууллагын шийдвэр, давагдашгүй хүчин зүйлийн нөлөө болон ХБҮЦ-ны төлбөрийг төлөхөд зайлшгүй зардал гаргах шаардлага үүсвэл ТУЗ-ийн хурлаар уг асуудлыг хэлэлцэж, зөвшөөрсөн тохиолдолд ТУЗ-ийн тогтоолд заасан хэмжээгээр уг зардлыг нэмж гаргана.



ДӨРӨВ. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД ХБҮЦ-НЫ ТӨЛБӨР ТӨЛӨХ

- 4.1. ТЗК нь ҮЦТХТ-тэй ХБҮЦ хадгалуулах, ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэх зорилгоор гэрээ байгуулна.
- 4.2. Анхдагч зах зээлийн арилжаа явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх өдрөөс эхлэн хүүг тооцож эхэлнэ. Хүүгийн төлбөрийг 365 хоногоор тооцож 4.3-т заасан хуваарийн дагуу төлнө.
- 4.3. ХБҮЦ-ны үндсэн болон хүүг дараах байдлаар тооцож төлнө. Үүнд:

ХБҮЦ-ны хугацаа	24 сар
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр төлөх давтамж	Улирал тутам
ХБҮЦ-ны хүүгийн жилийн хувь /татварын өмнөх/	19.6%
Татварын хувь	5.0%
ХБҮЦ-ны хүүгийн жилийн хувь /татварын дараах/	18.62%
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр /татварын өмнөх/	(Тоо ширхэг * Нэрлэсэн үнэ * Хүүгийн жилийн хувь)/Хүүгийн төлбөр төлөх давтамж
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр /татварын дараах/	Татварын өмнөх хүүгийн төлбөр * (1-Татварын хувь хэмжээ)
ХБҮЦ-ны үндсэн төлбөр	Жилд 1 удаа

- 4.4 Үнэт цаас эзэмшигчдэд ХБҮЦ-ны төлбөрийг дараах дарааллын дагуу төлнө. Үүнд:
- 4.4.1 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ҮЦТХТ-тэй байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-нд заасан хуваарийн дагуу Үнэт цаас эзэмшигчдийн жагсаалтыг ҮЦТХТ-өөс хүлээн авна.
- 4.4.2 ХБҮЦ-ны төлбөрийг ҮЦТХТ-өөс ирсэн Үнэт цаас эзэмшигчдийн нэрсийн дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч тооцооллыг хийсний дагуу ТЗК нь шилжүүлэх бөгөөд 4.4.1-д заасан хугацаанаас хойш Үнэт цаас эзэмшигч солигдсон бол төлбөрийг өмнөх Үнэт цаас эзэмшигч авна.
- 4.4.3 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь журмын 4.4.1 дэх хэсэгт заасан хугацаагаар Үнэт цаас эзэмшигчийн жагсаалт, эзэмшиж буй ХБҮЦ-ны тоо, төлбөрийн хуваарийн тооцоолол хийж, Үнэт цаас эзэмшигч тус бүрээр төлөгдөх төлбөрийн тооцоог гаргана. Баталгаажуулсан тооцоог ҮЦТХТ-д тус тус хүргүүлнэ.
- 4.4.4 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тооцоо гаргахдаа татварын өмнөх болон дараах байдлаар гаргах бөгөөд ТЗК нь татварыг хассан дүнгээр ҮЦТХТ рүү шилжүүлж, үнэт цаас эзэмшигчийн нэрээр холбогдох татварыг суутган тайлагнана.
- 4.4.5 ТЗК нь ХБҮЦ-ны төлбөрийг ҮЦТХТ дэх ТЗК-ийн үнэт цаасны дансанд төлбөр төлөхөөс өмнө байршуулж, ҮЦТХТ-өөс тооцоололд заасны дагуу Үнэт цаас эзэмшигч нарт хуваарьт өдөр төлбөрийг шилжүүлнэ.
- 4.4.6 Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдөх хуваарь, үнийн дүнгийн тооцооллыг алдсан, Үнэт цаас эзэмшигчийн мэдээллийг буруу бичсэн зэрэг төлбөр тооцоотой холбоотой алдаа гарсан бол нэн даруй алдааг засах арга хэмжээ авна. Хэрэв Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн гаргасан алдаанаас болж Үнэт цаас эзэмшигч, ТЗК болон бусад этгээдэд хохирол учирсан бол хохирлыг



2023 -11- 15

БҮРТГЭВ-02

Хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.



ТАВ. ТӨЛБӨР ТӨЛӨХ ДАРААЛАЛ

- 5.1. ХБҮЦ-ны болон ТЗК-аас гарах бусад зардлыг дараах дарааллын дагуу төлнө. Үүнд:
 - 5.5.1. ТЗК-ийн татварын төлбөр;
 - 5.5.2. ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар;
 - 5.5.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр, үүргийн гүйцэтгэлийн хангуулахтай холбоотой зардал;
 - 5.5.4. Үйлчилгээ үзүүлэгчийн шимтгэл, зардал;
 - 5.5.5. Аудитын зэрэг бусад мэргэжлийн оролцогчид, үйлчилгээ үзүүлсэн этгээдийн үйлчилгээний төлбөр;
 - 5.5.6. ТУЗ-ийн гишүүдэд олгох хөлс;
 - 5.5.7. ХБҮЦ-ны хүүгийн төлбөр;
 - 5.5.8. ХБҮЦ-ны үндсэн төлбөр;
 - 5.5.9. Журамд заасан бусад зардал.
- 5.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдсөн өдрөөс 3 хоногийн дотор ТЗК-ийн “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-д заасны дагуу ХБҮЦ-ны төлбөр төлсөн тухай мэдээллийг хүргэнэ.
- 5.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдсөн өдрөөс хойш 3 хоногийн дотор Үнэт цаас эзэмшигчдийн жагсаалт, эзэмшиж буй ХБҮЦ-ны тоо, Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдсөн төлбөр, татварын дүн зэргийг ТЗК-ийн ТУЗ-д мэдээлнэ.

ЗУРГАА.ХАРИУЦЛАГА

- 6.1. Энэхүү журмыг зөрчсөнөөс үүсэх хохирлыг буруутай ажилтан, албан тушаалтан болон журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээнд заасан тохиолдолд тухайн оролцогч байгууллага болох ТЗК, Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Үйлчилгээ үзүүлэгч барагдуулна.
- 6.2. Зөрчил гаргасан этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл ТЗК эрх бүхий байгууллагад гомдол гарган, шалгуулан, шийдвэрлүүлнэ.

ДОЛОО. БУСАД

- 7.1. Энэхүү журам ТУЗ-өөс баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд ХБҮЦ-ийг бүртгүүлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- 7.2. Энэхүү журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн батална.

оОо



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Тусгай зориулалтын компанийн үйл ажиллагааны
журам батлах тухай

2023 оны 07 сарын 25-ны өдөр

№ ТУЗ-23/007

Улаанбаатар хот

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 17 дугаар зүйл, 20 дугаар зүйл, 40 дүгээр зүйл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмаар тогтоосныг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ** нь:

1. “Омни ассет ТЗК” ХХК-ийн үйл ажиллагаанд ашиглагдах журмыг хавсралтаар баталсугай.
 - 1.1. “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”
2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож байгаа талуудад үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



А.БАТБОЛД



2023-11-15

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК

СЭХ
2023 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 07 сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Хурлын ирц: ТУЗ-н гишүүн С.Нина
ТУЗ-н гишүүн Х.Хэрлэн
ТУЗ-н гишүүн А.Батболд 100%-ийн ирцтэйгээр хуралдав.

Хурал болсон газар: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр оффис, 712 тоот хурлын өрөө

Хурал эхэлсэн, дууссан: 2023 оны 07 сарын 25-ны өдрийн 11:00 цагаас эхэлж 13:00 цагт дуусав.

Хурлаар хэлэлцсэн асуудал: Журам батлах тухай

Хэлэлцсэн нь:

- “Омни ассет” ХХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг батлах тухай

ТУЗ-ийн гишүүд нь:

- “Омни ассет” ХХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын төслийг хэлэлцэв.

Шийдвэрлэсэн нь:

Хэлэлцсэн асуудлын хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөл дараах шийдвэрийг санал нэгтгэж гаргав.

- “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг батлав.

Хурлын тэмдэглэлийг баталгаажуулсан:

ТУЗ-ийн дарга А.Батболд: _____

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:


ТУЗ-н гишүүн С.Нина: _____

ТУЗ-н гишүүн Х.Хэрлэн: _____





Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 23/007 тоот тогтоолын хавсралт



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**



2023-11-15

БҮРТГЭВ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ



- 1.1 “Омни ассет ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь Зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх) гаргахтай холбоотойгоор үүсгэн байгуулагдсан Компанийн төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү Журам нь Монгол Улсын Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-оос баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”, Монголын хөрөнгийн биржээс баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”, Компанийн дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.
- 1.3 Энэхүү Журмаар зохицуулагдаагүй Компанийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан гэрээгээр нарийвчлан зохицуулна.
- 1.4 Энэхүү журмыг ТУЗ батлах бөгөөд батлагдсан өдрөөс эхлэн ТУЗ нь үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

ХОЁР. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

- 2.1 ТУЗ нь 3 гишүүнтэй байх ба нийт гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн олонх нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч, тэдгээрийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болон гэр бүлийн гишүүн байхыг хориглоно.
- 2.2 ТУЗ нь ТУЗ-ийн дарга болон гишүүдээс бүрдэнэ.
- 2.3 ТУЗ-ийн даргыг хуралд оролцож буй бусад гишүүдийн олонхын саналаар сонгоно.
- 2.4 Нарийн бичгийн даргын ажлыг гэрээний үндсэн дээр ТЗК-ийн үүсгэн байгуулагч гүйцэтгэнэ.
- 2.5 ТУЗ-ийн гишүүн нь дор дурдсан шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:
 - 2.5.1 Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан;
 - 2.5.2 Эдийн засаг, эрх зүй, нягтлан бодох бүртгэл, банк, санхүү, хөрөнгийн зах зээлийн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, тухайн салбарт 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
 - 2.5.3 СЗХ-оос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх;
 - 2.5.4 Өөр бусад 3-аас дээшгүй Компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаагүй байх.
- 2.6 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт заасан шалгуурыг хангасан байна.
- 2.7 ТУЗ-ийн гишүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгох бөгөөд нэр дэвшигчийг санал хураалтын ердийн аргаар сонгоно.
- 2.8 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч этгээд нь дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:
 - 2.8.1 Анкет;
 - 2.8.2 Боловсрол эзэмшсэн байдлын гэрчилгээ, дипломын хуулбар;
 - 2.8.3 Иргэний үнэмлэхийн хуулбар;
 - 2.8.4 Компанийн засаглалын сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар;
 - 2.8.5 Бусад шаардлагатай баримт бичиг.
- 2.9 ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон этгээдтэй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллах гэрээг байгуулна.
- 2.10 ТУЗ-ийн гишүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Компанийн дүрэмд заасан үндэслэлээр компани татан буугдах хүртэл хугацаатай томилно. ТУЗ-ийн гишүүн болон хувьцаа эзэмшигчдийн бичгээр гаргасан саналыг үндэслэн дараах тохиолдолд ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгоно. Үүнд:
 - 2.10.1 Хоёр болон түүнээс дээш сарын хугацаагаар үүргээ гүйцэтгэх боломжгүй тухай гишүүний бичгээр өгсөн санал, эрүүл мэндийн шалтгаанаар ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;
 - 2.10.2 Гишүүн өөрөө хүсэлт гаргасан;
 - 2.10.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд дараалан 3 удаа оролцоогүй, эсхүл нэг жилд хуралдсан нийт хурлын 1/3 болон түүнээс дээш тоогоор оролцоогүй болохыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон;



2023-11-

СҮАТГЭ

- 2.10.4 ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байх хугацаандаа эдийн засаг, албан тушаалын, санхүү, татвар, үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой эрүүгийн болон захиргааны шийтгэл хүлээсэн болох нь тогтоогдсон;
- 2.10.5 Хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлын зөрчилтэй байгууллагад давхар ажил эрхэлсэн, эсхүл гэрээт үүрэг гүйцэтгэгч болсон нь тогтоогдсон;
- 2.10.6 Хуульд заасан бусад нөхцөл байдал үүссэн.
- 2.11 ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлсөн буюу түүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлаас дуусгавар болгосон тохиолдолд энэ Журамд заасны дагуу нэр дэвшүүлж шинэ гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгож батлах ба уг өөрчлөлттэй холбоотой мэдээллийг шийдвэр гарснаас хойш ажлын гурав хоногийн дотор СЗХ-д мэдэгдэнэ.



ГУРАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 3.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах асуудлаар ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 3.1.1 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- 3.1.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг батлах.
- 3.2 Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ нь Компанийн үйл ажиллагаанд хяналт тавина. ТУЗ-ийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал хэлбэртэй байна.
- 3.3 ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг удирдах, хянах ажлын хүрээнд дараах журмыг батална. Үүнд:
- 3.3.1 ХБҮЦ-ны хөрөнгийн багцыг сонгох шалгуур үзүүлэлтийг батлах;
- 3.3.2 Хөндлөнгийн аудитор, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам;
- 3.3.3 Хөрөнгө итгэмжлэн удирдах журам;
- 3.3.4 Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх тухай журам;
- 3.3.5 Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх журам;
- 3.3.6 Эрсдэл сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод, хяналтын журам;
- 3.3.7 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;
- 3.3.8 Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах тухай журам;
- 3.3.9 Компанийн үйл ажиллагаанд шаардлагатай бусад дүрэм, журам.
- 3.4 ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх гуравдагч этгээдтэй дараах гэрээг байгуулна. Үүнд:
- 3.4.1 Хөрөнгө худалдан авахтай холбоотой гэрээг анхны үүрэг гүйцэтгэгчтэй байгуулах;
- 3.4.2 ХБҮЦ гаргах ажиллагааны хамтран оролцогч болох Андеррайтер, Хуулийн нөхөрлөл, Зээлийн шинжилгээ гаргах аудит, Хөрөнгө итгэмжлэгдэн удирдагч нартай гэрээ байгуулах;
- 3.4.3 СЗХ, Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон бусад байгууллагын өмнө Компанийг төлөөлөн өргөдөл, хүсэлт, гаргах, шаардлагатай гэрээ байгуулах;
- 3.4.4 Компанийн нэрийн данс нээлгэх, холбогдох гэрээ байгуулах;
- 3.4.5 Хууль болон Компанийн дүрмээр хориглоогүй, шаардлагатай бусад гэрээ хэлцэл байгуулах.
- 3.5 ХБҮЦ гаргахтай холбоотой асуудлаар ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 3.5.1 ХБҮЦ гарган татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн зарцуулалттай танилцах, эх үүсвэрийг үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу зарцуулахыг шаардах;
- 3.5.2 Хөрөнгө оруулагч харилцагчдын эрх ашгийг хамгаалах, хөрөнгийн бүртгэлийг хянах;
- 3.5.3 Хөрөнгө итгэмжлэгдэн удирдагч нь хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гаргасан тохиолдолд шаардлагатай холбогдох арга хэмжээг авах үүнтэй холбоотой шийдвэр гаргах;
- 3.5.4 Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, хөндлөнгийн аудитыг сонгох;



2023-11-19

БҮРТГЭВ

СЗХ
2023-11-08 өдөр
БҮРТГЭВ

- 3.5.5 Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний дагуу тогтмол тайлан хүлээх авах, тэдгээрийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих;
- 3.5.6 ХБҮЦ гаргах ажиллагаа болон оролцогчидтой холбоотой бусад арга хэмжээ, үүнтэй холбоотой шийдвэр гаргах;
- 3.5.7 СЗХ-д хүргүүлэх Үнэт цаасны танилцуулгад ТУЗ-ийн дарга, гишүүд гарын үсэг зурж, мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах, Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан, эсхүл эрх бүхий байгууллагаас үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг түдгэлзүүлсэн, хязгаарласан тохиолдолд тэдгээрийг солих;
- 3.5.8 Хөрөнгийг бүртгэлээс хасах, нэмэх;
- 3.5.9 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах, хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээлэл тайлангийн үнэн зөв байдалд хяналт тавих;
- 3.5.10 Компанийн дүрэм, ХБҮЦ гаргах өргөдөл, баталгаат Үнэт цаасны танилцуулгад заасан шаардлагын биелэлтийг хангуулах;
- 3.5.11 Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит болон санхүүгийн тайлантай танилцах, хэлэлцэх болон хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах;
- 3.5.12 Хөрөнгө оруулагчдаас болон эрх бүхий зохицуулах төрийн байгууллагаас хүсэлт ирүүлсэн даруйд холбогдох мэдээллийг тэдгээрт цаг тухайд нь хүргэх.

3.6 ТУЗ нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 3.6.1 Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангах, хангуулах;
- 3.6.2 Компанийн дүрэм, Үнэт цаасны танилцуулга, ХБҮЦ гаргах, Компани байгуулагдсан гэдэгт баталгаа гаргах;
- 3.6.3 Компанийн хөрөнгийг хадгалж хамгаалах;
- 3.6.4 Хөрөнгө оруулагч болон бусад эрх бүхий этгээдэд мэдээллийг тогтмол цаг тухайд нь хүргэх;
- 3.6.5 Үнэт цаасны танилцуулгад тусгасан шаардлагын биелэлтийг хангах;
- 3.6.6 Хууль, журам болон энэхүү дүрэмд заасан бусад үүрэг;

3.7 ТУЗ-ийн дарга дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

- 3.7.1 ТУЗ-ийн ажлыг зохион байгуулж, ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлаар гишүүд үзэл бодлоо чөлөөтэй солилцох, нээлттэй хэлэлцэх, гишүүдэд чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- 3.7.2 ТУЗ-ийн хурлыг даргалах, санал хураалтыг явуулах, хурлаар хэлэлцэх асуудал бүрээр шийдвэр гаргах ажлыг зохион байгуулах;
- 3.7.3 Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оруулах ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг бэлтгэх ажлыг зохион байгуулан хэрэгжүүлэх;
- 3.7.4 Хууль болон энэ журамд заасан эрх, үүргийг бусад гишүүдийн адил эдлэх;
- 3.7.5 ТУЗ-ийн даргыг түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын, эсхүл ТУЗ-ийн томилсон гишүүн гүйцэтгэнэ.

3.8 ТУЗ-ийн гишүүн дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

- 3.8.1 Аливаа шийдвэр гаргахаас өмнө шаардлагатай мэдээлэлтэй танилцах;
- 3.8.2 ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаанд тогтмол, идэвхтэй оролцох;
- 3.8.3 ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлаар өөрийн авсан мэдээлэл, мэдлэг боловсрол, ажлын туршлагад тулгуурлан үндэслэл бүхий санал өгөх;
- 3.8.4 ТУЗ-ийн хуралд биечлэн оролцох бөгөөд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас биечлэн оролцох боломжгүй, эсхүл хоцорч оролцох тохиолдолд энэ талаар ТУЗ-ийн дарга болон нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэх;
- 3.8.5 Ашиг сонирхлын зөрчил илэрсэн тохиолдолд энэ талаараа нэн даруй мэдэгдэх;
- 3.8.6 ТУЗ-ийн дарга болон гишүүд нь нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг Компанид гаргаж өгөх;
- 3.8.7 ТУЗ-ийн гишүүд нь хурлын тогтоол болон тэмдэглэлд Компанийн байранд хүрэлцэн ирж гарын үсэг зурж, баталгаажуулах үүрэгтэй.
- 3.8.8 ТУЗ-ийн гишүүд хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг гаргуулах эрхтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн



2023-11-15

мэргэжилтэн, шинжээчийн дүгнэлт, зөвлөмж саналыг Компанийн зардлаар гаргуулан авч болно.

3.9 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь энэ Журмын 3.8 дахь хэсэгт зааснаас гадна дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

- 3.9.1 Компанийн дүрэм, журамд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хяналт тавьж, ТУЗ-ийн зарим үйл ажиллагааг хараат бусаар баталгаажуулах;
 - 3.9.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүсэлт гаргах замаар биечлэн оролцож, ТУЗ-ийн зарим шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан тухайгаа мэдээлэх, Хувьцаа эзэмшигчдээс асуусан асуултад хариу өгөх, тайлбар хийх;
- 3.10 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн зүгээс тавих хяналтыг үр ашигтай байлгах, гарч болзошгүй сонирхлын зөрчлийг зөв зохистой шударга шийдвэрлэх, хувьцаа эзэмшигчдээс хараат бус байж, шаардлагатай тохиолдолд тэдэнд зөвлөмж, зөвлөгөө өгнө.

ДӨРӨВ. ТУЗ-ИЙН ХУРАЛ

- 4.1 ТУЗ-ийн үйл ажиллагааны үндсэн зохион байгуулалтын хэлбэр нь хурал байна. ТУЗ-ийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.
- 4.2 ТУЗ нь Компанийн дүрмийн 4.4.5-д заасны дагуу хуралдах хурлын хуваарийг батална.
- 4.3 ТУЗ-ийн ээлжит хурлыг улирал тутамд нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, Анхны үүрэг гүйцэтгэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч, эсхүл ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар ээлжит бус хурлыг хуралдуулж болно.
- 4.4 ТУЗ-ийн хурлыг биечилсэн болон цахим хэлбэрээр хуралдуулж болно.
- 4.5 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн биечлэн хуралдах хурлын зарыг ажлын 3 хоногийн өмнө тухайн хурлаар хэлэлцэх асуудал, холбогдох мэдээлэл, материалын хамт ТУЗ-ийн гишүүдийн ТЗК-ийн цахим шуудан /цаашид “албаны и-мэйл” гэх/-ийн хаягаар хүргүүлнэ.
- 4.6 ТУЗ-ийн хурлыг Монгол хэлээр явуулна. Хурлын тэмдэглэлийг Монгол хэлээр хөтөлж баталгаажуулна.
- 4.7 ТУЗ-ийн хурлаар аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүн бүр саналын нэг эрхтэй байна.
- 4.8 ТУЗ-ийн хурал гишүүд 100 хувь оролцооноор хүчин төгөлдөр болох бөгөөд ТУЗ-ийн шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар хүчин төгөлдөр болно.
- 4.9 Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ТУЗ-ийн хуралд биечлэн оролцоогүй гишүүдийн ТУЗ-ийн хурал эхлэхээс өмнө бичгээр, эсхүл цахимаар ирүүлсэн саналыг үндэслэн хурлын ирц бүрдүүлэх, санал хураалтын үр дүнг тооцож болно.
- 4.10 ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь хуралд биечлэн оролцох боломжгүй болсон хэдий ч тэдгээр нь хурал эхлэхээс өмнө саналаа ирүүлсэн байх тохиолдолд ТУЗ-ийн үлдсэн гишүүний саналаар ТУЗ-ийн хурлыг хуралдуулж болно.
- 4.11 ТУЗ-ийн гишүүд хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хурлыг цахим хэлбэрээр хуралдуулж болно. Цахим хурлыг дараах байдлаар явуулна. Үүнд:
 - 4.11.1 Нарийн бичгийн дарга нь энэхүү Журмын 4.3 дахь хэсэгт заасан этгээдийн хүсэлтийн дагуу ТУЗ-ийн даргын зөвшөөрлөөр ТУЗ-ийн цахим хурлыг зарлаж, хурлын материал, шийдвэрийн төсөл, санал өгөх хугацааг ТУЗ-ийн гишүүдийн албаны и-мэйл хаягаар хүргүүлнэ. ТУЗ-ийн дарга цахим хурлыг хуралдуулахаас татгалзсан тохиолдолд биечилсэн хурлаар асуудлыг шийдвэрлэнэ.
 - 4.11.2 Цахим хурлаар хэлэлцэж буй асуудлын хүрээнд ТУЗ-ийн гишүүд хурлын зар хүргүүлснээс хойш ажлын 3 хоногийн дотор цахим хурлыг зайнаас (мэдээллийн технологи, программ хангамж ашиглан) зохион байгуулна. ТУЗ-ийн гишүүдийн санал асуулгыг тус мэдээллийн технологи, программ хангамжийн дагуу цахимаар явуулах ба ТУЗ-ийн гишүүд “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” гэх агуулгыг илэрхийлсэн саналын аль нэгийг сонгох замаар шийдвэр гаргалтад оролцоно.
 - 4.11.3 Нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн гишүүдийн цахимаар ирүүлсэн саналыг нэгтгэн, ТУЗ-ийн гишүүдийн ирүүлсэн саналын дагуу ТУЗ-ийн цахим хурлын шийдвэрийг бэлтгэн, албажуулна.
 - 4.11.4 ТУЗ-ийн цахим хурлын шийдвэрийг хурлын тэмдэглэлийн хамт хурлын материалд хавсаргана.
 - 4.11.5 Цахим хурлын тэмдэглэлд хуралдсан огноо, хурлаар хэлэлцсэн асуудал, гишүүдийн

2023-11-15

БҮРТГЭЛЭЛ

ирүүлсэн саналын агуулга, гишүүд саналаа өөрийн албаны и-мэйл хаягаас явуулсан гэдгийг нотлох баримт болон гаргасан шийдвэрийг тусгана.



4.11.6 Цахим хурлын тэмдэглэлийг хурлын тэмдэглэлтэй нэгэн адил үзнэ.

- 4.12 ТУЗ нь эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болох бөгөөд ТУЗ-ийн хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тохиолдолд хурлын мэдэгдэл, хэлэлцэх асуудал болон холбогдох материалыг саналын хуудасны хамтаар хурал хуралдахаас ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ.
- 4.13 ТУЗ-ийн гишүүд эчнээ санал хураалтын мэдэгдэл болон саналын хуудсыг хүлээж авснаас хойш ажлын 3 хоногийн дотор саналаа ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан ТУЗ-ийн даргад хүргүүлнэ. Саналын хуудсыг цахим хэлбэрээр хүргүүлж болно. Хэрэв ТУЗ-ийн гишүүн энэ хугацаанд багтаан саналаа ирүүлээгүй тохиолдолд түүнийг тухайн асуудлаар түдгэлзсэн санал ирүүлсэнд тооцно.
- 4.14 ТУЗ-ийн хурлын шийдвэр нь Тогтоол хэлбэртэй байх бөгөөд хуралд оролцсон ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 4.15 Биечилсэн ТУЗ-ийн хурлын тэмдэглэл нь хураангуй байх бөгөөд нарийн бичгийн дарга зөвхөн хурлаар хэлэлцсэн асуудлаар хөтөлнө. Биечилсэн ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хурал хийснээс хойш ажлын 5 өдрийн дотор бэлэн болгож хуралд оролцсон гишүүд нь хүрэлцэн ирж тэмдэглэлд гарын үсэг зурна.
- 4.16 ТУЗ-ийн хурлын дарга тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцах бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн бичгээр ирүүлсэн саналыг хурлын тэмдэглэлд хавсаргана.
- 4.17 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:
 - 4.17.1 хурал хуралдсан газар, өдөр, цаг,
 - 4.17.2 хуралд оролцсон гишүүд,
 - 4.17.3 хурлаар хэлэлцсэн асуудал,
 - 4.17.4 санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн,
 - 4.17.5 гаргасан шийдвэр.
- 4.18 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн нь тухайн хурлаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.
- 4.19 ТУЗ-ийн дарга болон гишүүд нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд тооцогдох бөгөөд мөн хуулийн 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.
- 4.20 Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажилтан авч ажиллуулахгүй ба ХБҮЦ гаргахтай холбоотой үйлчилгээг гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулагч болон бусад гуравдагч этгээдээр гүйцэтгүүлнэ. ТУЗ нь Компанийг төлөөлж гэрээ байгуулна.

ТАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ АЖЛЫН НӨХЦӨЛ, ХАНГАМЖ

- 5.1 Компани нь компанийн хувьцаа эзэмшигчийн ажлын байранд үйл ажиллагаа явуулах бөгөөд албан ёсны хаяг нь “Омни капитал ББСБ” ХХК-ийн үйл ажиллагаа явуулж байгаа салбарын хаяг байна.
- 5.2 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн гишүүнээс урьдчилан мэдэгдсэн тохиолдолд хурлын материал, шаардлагатай мэдээ, мэдээлэлтэй танилцах боломжтой ажлын байр гаргаж өгөх үүрэгтэй.
- 5.3 Үүсгэн байгуулагч нь ТУЗ-ийн гишүүн бүрд цахим шуудангийн хаяг нээж өгөх бөгөөд тухайн албан ёсны хаягаар харилцаж ажиллана.
- 5.4 Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, журам, татварын гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, санхүүгийн болон хууль зүйн баримт бичиг болон холбогдох бусад бүхий л баримт бичиг, Компанийн тамга тэмдэг, Компанид хамааралтай бусад эд хөрөнгө, зүйл, хогшил нь хувьцаа эзэмшигчийн ажлын байранд зохих бүртгэлтэйгээр хадгалагдана.
- 5.5 ТУЗ-ийн гишүүдийн цалинг улирал бүр ТУЗ-ийн хуралд оролцсон эсэхийг харгалзан тооцож олгож болох бөгөөд олгох тохиолдолд Компанийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.4-т заасны дагуу холбогдох төсвийг Компанийн зардалд тусгаж, ХЭХ-аас батална. Цалин, урамшууллын нийт төсвийн зарцуулалтад ХЭХ-аас хяналт тавина.
- 5.6 ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг Компани хариуцах бөгөөд ХЭХ-аас баталснаас бусад зардлыг Компанийн ТУЗ-ийн гишүүн өөрөө хариуцна.



2023-11-15

БҮРТГЭВ

ЗУРГАА. БУСАД

СЭХ
2023 сар 13 өдөр
БҮРТГЭВ
№ 11

- 6.1 Энэхүү журам Компанийн ТУЗ-өөс баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 6.2 Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд уг нэмэлт, өөрчлөлт нь Компанийн Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

...ооо...



7



2023 -11- 15

БҮРТГЭВ

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК



“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК (“КОМПАНИ”)-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хөрөнгийн багц худалдан авах, хөрөнгийн
багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг батлах тухай

2023 оны 08 сарын 23-ны өдөр

№ ТУЗ-23/012

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь хэсэг, 76.1.17 дахь хэсэг, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмаар тогтоосныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох “Омни капитал ББСБ” ХХК-аас 6,000,000,000 /зургаан тэрбум/ төгрөгийн үнэ бүхий зээлийн багц бүхий хөрөнгө худалдан авахаар зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгийн багцыг үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл болон автомашин барьцаалсан зээлээс бүрдүүлэхийг зөвшөөрсүгэй.
3. Хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг Хавсралт №1, 2-оор тус тус баталсугай.
4. Хөрөнгийн багц худалдан авахтай холбоотойгоор “Омни капитал ББСБ” ХХК-тай Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ болон Фидуцийн барьцааны гэрээг байгуулахыг ТУЗ-ийн дарга /А.Батболд/-д зөвшөөрсүгэй.
5. Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд заасан нөхцөлийн дагуу Хавсралт №1 болон №2-д заасан шалгуурыг нэгэн зэрэг хангаж байгаа хөрөнгийг шилжүүлэн авахыг ТУЗ-ийн дарга /А.Батболд/-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА



А.БАТБОЛД





"Омни ассет ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-23/012 тоот тогтоолын Хавсралт №2



“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙ ХУДАЛДАН АВАХ ХӨРӨНГИЙН БАГЦАД ТАВИГДАХ ХУУЛИЙН ШАЛГУУР

Шалгуур үзүүлэлт 1. Зээлийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх;

Шалгуур үзүүлэлт 2. Фидуцийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх;

Шалгуур үзүүлэлт 3. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх;

Шалгуур үзүүлэлт 4. Фидуцийн гэрээний дагуу автомашиныг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн байх, холбогдох бүртгэлийг хийлгэсэн байх, үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжинд хангуулах боломжтой байх;

Шалгуур үзүүлэлт 5. Фидуцийн зүйл болон үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний барьцаа хөрөнгө нь хуульд заасны дагуу төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө биш байх;

Шалгуур үзүүлэлт 6. Тасалбар болгох өдрийн байдлаар фидуцийн зээлийн гэрээ болон үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн гэрээний үүрэг дуусгавар болоогүй, үүрэг гүйцэтгэгчийн хувьд аливаа сөрөг шаардлага гаргаагүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;

Шалгуур үзүүлэлт 7. Зээлдэгч нь эрх зүйн бүрэн чадамжтай эсэх;

Шалгуур үзүүлэлт 8. Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгуулсан байх;

Шалгуур үзүүлэлт 9. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь үнэт цаас гаргагчийн эзэмшилд шилжих боломжтой бөгөөд эрхийн доголдолгүй байх;

Шалгуур үзүүлэлт 10. Зээлийн гэрээнд заасны дагуу зээлийг зээлдэгчийн зээлийн дансанд шилжүүлсэн, эсхүл зээлдэгч зээлийн данснаас зээлээ ашигласан байх.





ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 15 өдөр

№ 11-23/034

Улаанбаатар хот

ХӨРӨНГИЙН БАГЦ ХУДАЛДАХ ТУХАЙ

“Омни капитал ББСБ” ХХК-ийн (“Компани”) Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаас Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Омни ассет ТЗК” ХХК-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох “Омни капитал ББСБ” ХХК-аас 6,000,000,000 /зургаан тэрбум/ төгрөгийн үнэ бүхий зээлийн багц бүхий хөрөнгө худалдахыг зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгийн багцыг үл хөдлөх хөрөнгө болон автомашин барьцаалсан зээлээс бүрдүүлэхийг зөвшөөрсүгэй.
3. Худалдах хөрөнгийн багц дахь зээлүүд нь “Омни ассет ТЗК” ХХК-аас ирүүлсэн хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангасан байхыг зөвшөөрсүгэй.
4. Хөрөнгийн багцыг худалдах худалдан авах гэрээнд компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Ч.Эрэлхэг/-д олгосугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын алба /О.Бямбабаяр/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  ЭЛПҮРЭВСҮРЭН





Омни Капитал

Баян Еср Оюуны/Увч-Болууллага



**“ОМНИ КАПИТАЛ ББСБ” ХХК-ИЙН ТУЗ-ИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 08 сарын
23-ны өдөр

№:

Улаанбаатар хот

Хурлын ирц:

ТУЗ-н дарга Э.Пүрэвсүрэн
ТУЗ-н гишүүн Ч.Эрэлхэг
ТУЗ-н гишүүн Ч.Даваасүрэн
ТУЗ-н гишүүн Г.Ууганбаяр
ТУЗ-н гишүүн Ч.Батгэрэл
ТУЗ-ийн гишүүн Д.Энхбаяр
Дотоод аудитор О.Бямбабаяр
Хуульч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга П.Урангоо
100%-ийн ирцтэйгээр хуралдав.

Хурал болсон газар:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр
оффис, 7 давхар, 712 тоот хурлын өрөө

Хурал эхэлсэн, дууссан:

2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 15:00 цагт эхэлж 17:00
цагт дуусав.

Асуудлыг хэлэлцсэн:

15:00 цагт хэлэлцэж, 17:00 цагт дуусав.

Хурлаар хэлэлцсэн асуудал: Хөрөнгийн багц худалдах тухай

Хэлэлцсэн нь:

Хөрөнгийн багц худалдан авах болон түүнтэй холбоотой гэрээ байгуулах зөвшөөрөл олгох
тухай асуудал нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Э.Пүрэвсүрэн, Ч.Эрэлхэг, Ч.Даваасүрэн,
Г.Ууганбаяр нарын хувьд сонирхлын зөрчилтэй хэлцэл мөн байх тул уг хэлцлийн талаар
шийдвэр гаргалтад оролцохгүй болохоо мэдэгдэв. Иймд хуралд оролцсон сонирхлын зөрчилгүй
гишүүд санал нэгтгэйгээр зөвшөөрч шийдвэрлэв.

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Ч. Эрэлхэгийн танилцуулснаар “Омни ассет ТЗК” ХХК-ийн
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Анхны үүрэг
гүйцэтгүүлэгч болох “Омни капитал ББСБ” ХХК-аас 6,000,000,000 /зургаан тэрбум/ төгрөгийн
үнэ бүхий зээлийн багц бүхий хөрөнгө худалдах эсэх асуудлыг хэлэлцэв.

Шийдвэрлэсэн нь:


Хэлэлцсэн асуудлын хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөл санал нэгтгэйгээр дараах шийдвэрийг
гаргав.

- “Омни ассет ТЗК” ХХК-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох “Омни капитал ББСБ” ХХК-аас 6,000,000,000 /зургаан тэрбум/ төгрөгийн үнэ бүхий зээлийн багц бүхий хөрөнгө худалдахыг зөвшөөрөв.
- Хөрөнгийн багцыг үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл, автомашин барьцаалсан зээлээс бүрдүүлэхийг зөвшөөрөв.
- Худалдах хөрөнгийн багц дахь зээлүүд нь “Омни ассет ТЗК” ХХК-аас ирүүлсэн хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангасан байх.
- Хөрөнгийн багцыг худалдах худалдан авах гэрээнд компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Ч.Эрэлхэг/-д олгов.

Хурлын тэмдэглэлийг баталгаажуулсан:

ТУЗ-ийн дарга Э.Пүрэвсүрэн:






Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ТУЗ-ийн гишүүн Ч.Даваасүрэн: 


ТУЗ-ийн гишүүн Ч.Эрэлхэг: 

ТУЗ-ийн гишүүн Ч.Батгэрэл: 

ТУЗ-ийн гишүүн Г.Ууганбаяр: 

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга П.Урангоо: 





ОГНОО

2023 оны 08 сарын 23-ны өдөр

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК
(“Үнэт цаас гаргагч”)

ба

“ОМНИ КАПИТАЛ ББСБ” ХХК
(“Анхны үүрэг гүйцэтгүүлэгч”)

ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар:23/011

УЛААНБААТАР ХОТ



2023-11-15

БҮРГЭЭГЭЭР

Энэхүү Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г дор дурдсан оролцогч талуудын хооронд Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журамд заасныг удирдлага болгон



- (1) “Омни Капитал ББСБ” ХХК Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр оффис, 7 давхар 712 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн 6075657 дугаартай, улсын бүртгэлийн 9015003126 дугаартай (цаашид “Анхны үүрэг гүйцэтгүүлэгч” эсхүл “ББСБ” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ч.Эрэлхэг;
- (2) “Омни Ассет ТЗК” ХХК Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 11-р хороолол, Н тауэр, 402 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн 8356327 дугаартай, улсын бүртгэлийн 9011851823 дугаартай (цаашид “Үнэт цаас гаргагч”, эсхүл “ТЗК” гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга А.Батболд,

Дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

- (1) Энэхүү Гэрээгээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид энэхүү Гэрээнд заасан Шалгуур үзүүлэлтийг хангасан зээлийн авлагын эрх, түүнд дагалдах эрхүүдийг худалдах, Үнэт цаас гаргагч нь хэлэлцэн тохиролцсон үнийг төлөх болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- (2) Үнэт цаас гаргагч нь Хэлцэл биелэх өдөр дор дурдсан Зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрх (хамтад нь “Хөрөнгө” гэх)-үүдийг багц болгон худалдан авч (цаашид “Хөрөнгийн багц” гэх), гэрээнд заасан үнийг төлөх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцыг энэхүү Гэрээнд заасан солих, хөрөнгийн багцыг гэрээнд заасан үндэслэлээр нэмэх нөхцөлтэйгөөр худалдахаар тохиролцов.
- (3) Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ үнэнч шударгаар биелүүлж, харилцан бие биеийн ашиг сонирхлыг хүндэтгэх, Гэрээгээр тохиролцсон анхны тохиролцоог тууштай хадгалах бөгөөд зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх)-ны үргэлжлэх хугацаанд талууд Хөрөнгө оруулагч /Үнэт цаас эзэмшигч/-ийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж идэвхтэй, шуурхай, бүтээлчээр хамтран ажиллана.
- (4) Энэ Гэрээний хүчин төгөлдөр болон ХБҮЦ-ны үргэлжлэх хугацаанд хууль тогтоомж, энэхүү Гэрээ, бусад гэрээ, дүрэм, журамд заасан үндэслэлээр Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулж болно.
- (5) Гэрээний хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “Гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - a. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - b. Гэрээний тусгай нөхцөл;
 - c. Гэрээний хавсралт №1 - Хөрөнгийн жагсаалт;
 - d. Гэрээний хавсралт №2 - Хөрөнгөд тавих ерөнхий шалгуур;
 - e. Гэрээний хавсралт №3 – Барьцааны гэрээнүүд, түүнд хамаарах Барьцааны зүйл;
 - f. Бусад шаардлагатай баримт бичиг.
- (6) Энэ Гэрээ нь Хөрөнгийг худалдах, худалдан авахтай холбоотой талуудын эцсийн тохиролцоо болох тул урьд үйлдсэн энэ талаарх бусад хэлцлийг бүрэн орлоно.
- (7) Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлүүд зөрчилдвөл тусгай нөхцөлийг баримтална.





(8) — Гэрээтэй холбоотой асуудлаар талууд албан бичгээр болон шуудан, мэйл, утсаар харилцана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ:

**“ОМНИ КАПИТАЛ БЭСБ”
ХХК-ийн ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ч.ЭРЭЛХЭГ**



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:

**“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ийн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА А.БАТБОЛД**



2023-11-15

11-11-2023

СЗХ

2023 оны 01 сар 01 өдөр

БҮРГГЭВ

№ 01

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Нэр томъёо ба Тайлбар

Энэхүү Гэрээнд заасан дараах нэр томъёог тус бүр дор дурдсан утгаар нэг мөр ойлгоно.

“**Анхдагч зах зээлийн арилжаа**” гэж Монголын Хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн арилжааг;

“**ХБҮЦ**” гэж Үнэт цаас гаргагчийн арилжаалах Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үнэт цаасыг;

“**Барьцааны гэрээнүүд**” гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Зээлдэгч нарын хооронд байгуулагдсан эд хөрөнгийн барьцааны гэрээ;

“**Зээлийн баримт бичгүүд**” гэж ББСБ-аас Зээлдэгчид зээл олгосон зээлийн гэрээ, зээлийн хувийн хэрэг, бусад баримт бичгүүдийг;

“**Зээлийн данс бүртгэл**” гэж Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацааны дарааллаар бүртгэсэн мэдээллийг;

“**Зээлийн эргэн төлөлт**” гэж Зээлдэгчийн сар тутамд зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх зээлийн үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүүг;

“**Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх**” гэж Зээлдэгч сар тутам төлөх зээлийн эргэн төлөлтийн хуваарь дахь төлөх дүнгээс илүү дүнгээр зээлийн үлдэгдлээс хэсэгчлэн, эсхүл бүрэн төлөхийг;

“**Үйлчилгээ**” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу ББСБ нь ТЗК-тай байгуулсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд хөрөнгөтэй холбоотой төлбөр цуглуулан шилжүүлэхтэй холбоотойгоор үзүүлж буй үйлчилгээг;

“**Үнэт цаасны танилцуулга**” гэж Үнэт цаас гаргагчаас ХБҮЦ-ыг олон нийтэд танилцуулж, арилжаалах зорилгоор холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан танилцуулгыг;

“**Хөрөнгө**” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 3.1.1 дэх хэсэгт заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн мөнгөн урсгал бий болгосон зээлийн хөрөнгө, түүнийг дагалдах аливаа эрхүүдийг;

“**Хөрөнгийн багц**” гэж энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 1 дүгээр зүйлд заасан, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид худалдсан Хөрөнгийг;

“**Хөрөнгийн жагсаалт**” гэж энэхүү Гэрээний хавсралт 1-д заасан, худалдаж байгаа хөрөнгийн жагсаалтыг;

“**Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах**” гэж хөрөнгийн багц дахь хөрөнгө нь Шалгуур үзүүлэлтийг хангаагүй, эсхүл гэрээнд заасан үндэслэл бий болсон тохиолдолд тухайн хөрөнгийг солих буюу шинээр хөрөнгө нэмж авах үйл ажиллагааг;

“**Хэлцэл биелэх өдөр**” гэж Үнэт цаас гаргагч гэрээний ерөнхий нөхцөлийн 3-д заасны дагуу ББСБ-д Хэлцэл биелэх үнийг төлж, Хөрөнгийн багцыг өөрт бүрэн шилжүүлэн авсан өдрийг;

“**Хэлцэл биелэх үнэ**” гэж энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 2.1 дэх хэсэгт заасан үнийг;

“**Шаардлага хангахгүй хөрөнгө**” гэж Шалгуур үзүүлэлтийг хангахгүй хөрөнгийг;

“**Шалгуур үзүүлэлт**” гэж Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор батлагдсан, энэхүү Гэрээний хавсралт 2-д заасан, Хөрөнгөд тавих хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийг тус тус ойлгоно.



2023-11-15

БҮРТГЭЭ

2. Хөрөнгө худалдах үндсэн нөхцөл



- 2.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13.2-т зааснаар ТЗК нь Хөрөнгийг шилжүүлэн авснаар тухайн Хөрөнгөтэй холбоотой аливаа эрх, барьцаа, фидуци, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга, санхүүгийн хэрэгсэл хөрөнгөтэй хамт шилжүүлсэнд тооцно.
- 2.2. Худалдах хөрөнгийн хэмжээг Хэлцэл биелэх өдрийн байдлаар Хөрөнгийн багц дахь Зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр дүнгээр тооцох бөгөөд уг дүн нь гэрээний тусгай нөхцөлийн 2.1-д заасан Хэлцэл биелэх үнийн дүнтэй тэнцүү байна.
- 2.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчид Хөрөнгийг худалдан шилжүүлэх жагсаалт үйлдэн шилжүүлэх бөгөөд Хөрөнгийн жагсаалтыг энэхүү Гэрээний Хавсралт №1-ээр батална.
- 2.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийг солих, нэмж худалдах болон буцаан худалдан авч болох нөхцөлтэйгөөр худалдаж байгаа болно.
- 2.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11, 14.3-т заасны дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо Хөрөнгийн багцыг бүртгэсэн өдөр уг багцад орсон Хөрөнгийг ТЗК-ийн өмчлөлд шилжсэнд тооцно.
- 2.6. Талууд Хөрөнгийн багцыг шилжүүлэхдээ Гэрээний тусгай нөхцөлийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан актыг зурж хүлээлгэн өгч, авна.
- 2.7. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгө шилжсэнтэй холбоотойгоор тухайн зээлдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах, зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийхгүй байх үүрэгтэй ба Үйлчилгээ үзүүлэх гэрээгээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд зээлдэгчийн зээлтэй холбоотой зээл олгогчийн хувьд хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээ, үйлчилгээг зээлдэгчид үзүүлэх үүрэгтэй.
- 2.8. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлийн данс бүртгэлийг хадгалж хөтлөх, үнэт цаас гаргагчтай тулган баталгаажуулах болон хөрөнгө солих, зээлийн баримт бичгийг үнэт цаас гаргагчид хүргүүлэх, хүлээн авах зэргээр Хөрөнгөтэй холбоотой ажиллагааг хариуцан гүйцэтгэх, Үнэт цаас гаргагчтай харилцах эрх бүхий ажилтныг томилж, уг ажилтны мэдээллийг Үнэт цаас гаргагчид өгөх үүрэг хүлээнэ.

3. Гэрээний үнэ

- 3.1. Үнэт цаас гаргагч нь Хэлцэл биелэх өдөр уг гэрээний Тусгай нөхцөлийн 2.1-д заасан Хэлцэл биелэх үнийг төлнө.
- 3.2. Үнэт цаас гаргагч нь Анхдагч зах зээлийн арилжааны хугацаа дуусахад хөрөнгө оруулалтын хэмжээ Хэлцэл биелэх үнэд хүрсэн тохиолдолд Анхдагч зах зээлийн арилжаа дууссанаас хойш Хэлцэл биелэх өдөрт багтаан төлбөрийг энэхүү Гэрээний Тусгай нөхцөлийн 6.1-д заасан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн төлбөр хүлээн авах дансанд шилжүүлнэ.


4. Хэлцэл биелэх дүнд хүрэхгүй байх тохиолдолд авах арга хэмжээ

- 4.1. Үнэт цаас гаргагч нь Анхдагч зах зээлийн арилжааны хугацаанд Хөрөнгө оруулалтаас босгосон дүн нь Хэлцэл биелэх дүнд хүрээгүй тохиолдолд хэлцлийг амжилтгүй болсон гэж үзэх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийг Үнэт цаас гаргагчид шилжүүлэхгүй.
- 4.2. Гэрээний 4.1-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө оруулагчдаас цугларсан хөрөнгийг буцаан олгох ажиллагааг хийнэ.
- 4.3. Үнэт цаас гаргагч нь энэхүү Гэрээ болон бусад гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс бусад тохиолдолд Хөрөнгө оруулалт Хэлцэл биелэх дүнд хүрээгүйн



2023-11-15

улмаас Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид учирсан аливаа хохирлыг хариуцахгүй бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ХБҮЦ гаргахтай холбогдуулан гаргасан аливаа зардлуудыг хариуцна.



5. Зээлийн данс бүртгэл хөтлөх, баримт бичгийг хадгалах

- 5.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дахь зээлийн данс бүртгэлийг өөрийн бусад зээлээс тусад нь данс бүртгэл үүсгэн хадгалах бөгөөд санхүүгийн тайлан тэнцлийг тусад нь хөтөлж холбогдох баримт бичгийг өөрийн оффис дээр хадгална. Үүнд:
 - 5.1.1. Зээлдэгчээс гаргасан хүсэлт, захидал харилцаа;
 - 5.1.2. Холбогдох бусад.
- 5.2. Үнэт цаас гаргагч болон түүнд хөрөнгө итгэмжлэн удирдах болон аудитын үйлчилгээ үзүүлэгч, мөн бусад эрх олгогдсон этгээд хэдийд ч Зээлийн болон хөрөнгийн багцын баримт бичгүүдэд бүхэлд нь болон хэсэгчлэн шалгалт хийх эрхтэй.
- 5.3. Үнэт цаас гаргагч нь дээрх шалгалтыг хийх зорилгоор Зээлийн баримт бичгүүдийг авах тухай ББСБ-д мэдэгдсэнээс хойш ажлын 3 хоногт багтаан ТЗК-д хүргүүлэх эсхүл ажлын байран дээрээ ажлын цагаар томилогдсон ажилтныг ажиллах боломжоор хангах үүргийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хүлээнэ.
- 5.4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тайланг хүлээн авч хянан баталгаажуулна.

6. Барьцааны зүйл, барьцааны эрхийг хэрэгжүүлэх

- 6.1. Энэхүү Гэрээний 2.5-д заасны дагуу Хөрөнгийн багц Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д шилжсэнээр Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн гэрээнүүдээс үүсэх бүхий л эрх (үүнд, шаардах эрх, барьцаа, фидуци, баталгаа, үүргийн гүйцэтгэлийг хангах аливаа бусад арга, санхүүгийн хэрэгсэл зэрэг орно) ТЗК-д шилжинэ.
- 6.2. Дээрх 6.1 дэх заалтын дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцад хамаарах Барьцааны гэрээнүүд болон түүнтэй холбоотой шаардах эрхийг Үнэт цаас гаргагчид шилжүүлж байгаа буюу Үнэт цаас гаргагч нь Барьцааны гэрээнүүдийн Барьцаалагч талын эдлэх бүхий л эрх (үүнд, шаардах эрх, одоо болон ирээдүйд үүсэх эд хөрөнгийн эрх, орлого, үр шим хүртэх зэрэг эрх орно)-ийг эдэлж, бусад үүрэг гүйцэтгүүлэгчдээс тэргүүн ээлжид барьцааны зүйлээс шаардлагаа хангуулна. Үүнтэй холбоотойгоор Үнэт цаас гаргагчид дараах нөхцөлийн дагуу барьцааны эрх шилжинэ. Үүнд:
 - 6.2.1. **Барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ:** Барьцаагаар хангагдах шаардлага нь Хөрөнгийн багцыг бүрдүүлж байгаа зээлийн үндсэн төлбөр, хүүгийн авлага, түүнд холбогдох эрхүүд, барьцааны зүйлийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэхтэй холбоотой гарсан шүүхийн зардал, барьцааны зүйлийг арчлан хамгаалахад гарсан зардал уг эд хөрөнгөтэй холбоотойгоор төлсөн татвар хураамж, төлбөр болон зээлдүүлэгчид учирсан бусад хохирлын нийлбэрээр тодорхойлогдоно.
 - 6.2.2. **“Барьцааны зүйл”** гэж энэ Гэрээний Хавсралт №3 (“Барьцааны гэрээнүүд, түүнд хамаарах Барьцааны зүйл”)-д заасан хөрөнгүүд болон тэдгээрт хамаарах эрхийг;
 - 6.2.3. **Барьцаа хөрөнгийн жагсаалтад өөрчлөлт оруулах:** Энэ Гэрээ болон Үнэт цаас гаргагчийн гаргасан журамд заасны дагуу Хөрөнгийн багцад өөрчлөлт орсон, солигдсон тохиолдолд барьцаа хөрөнгийн жагсаалтад өөрчлөлт оруулах замаар барьцааны зүйлд өөрчлөлт оруулна.





6.2.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд Барьцааны зүйлийг аливаа хэлбэрээр бусад этгээдийн өмчлөлд шилжүүлэхгүй байх, барьцаалахгүй байх, тийнхүү шилжүүлэхээр амлахгүй байх үүрэгтэй.

7. Үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах

- 7.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээг энэхүү Гэрээнд заасан Хэлцэл биелэх өдөр байгуулна.
- 7.2. Үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу ББСБ нь хөрөнгийн багц дахь зээлийн эргэн төлөлтийг Зээлдэгчдээс цуглуулан үнэт цаас гаргагчид сар тутамд сарын төлбөрийн хуваарьт өдөр шилжүүлэх, ТЗК нь үйлчилгээний төлбөр болон шимтгэлийг төлөх үүрэг хүлээнэ.
- 7.3. Энэхүү Гэрээгээр зохицуулаагүй үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой харилцааг Үйлчилгээ үзүүлэх гэрээ болон ТЗК-ийн Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журамд заасныг баримтална.

8. Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах

- 8.1. Хөрөнгийн багцад дараах байдлаар өөрчлөлт оруулна. Үүнд:
 - 8.1.1. Шилжүүлэн авсан хөрөнгө нь Шалгуур үзүүлэлтийг хангаж чадаагүй, эсхүл энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 7 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцааж, Гэрээний тусгай нөхцөлийн 4 дүгээр зүйлд заасан шаардлага хангасан өөр хөрөнгөөр сольж өгөхийг шаардах эрхтэй.
 - 8.1.2. Энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 8 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгийг нэмэгдүүлнэ.
- 8.2. Гэрээний ерөнхий нөхцөлийн 8.1-д заасны дагуу Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тохиолдолд гэрээний Хавсралт №1-д заасан Хөрөнгийн жагсаалтад өөрчлөлт оруулах бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Хөрөнгийн багцыг солих буюу нэмж, энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 10.3-т заасны дагуу Хөрөнгийн багц шилжүүлэх акт үйлдэж Талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж баталгаажуулснаар Хөрөнгийн жагсаалтад өөрчлөлт орсон гэж үзнэ.
- 8.3. Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулахтай холбоотой бусад харилцаанд ТЗК-ийн “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-аар тогтоосон зарчмыг баримтална.

9. Хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах

- 9.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид Хөрөнгийг буцаан худалдахдаа энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 9 дүгээр зүйлд заасан нөхцөл үүссэн тохиолдолд ТЗК-ийн “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-аар тогтоосон зарчмын дагуу буцаан худалдана.
- 9.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийг буцаан худалдаж авах чадваргүй байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь уг Хөрөнгийг бусад гуравлагч этгээдэд худалдах эрхтэй. Үнэт цаас гаргагч нь гуравлагч этгээдэд Хөрөнгө худалдсантай холбоотойгоор үүсэж болох хохирлыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах эрхтэй бөгөөд түүнд учирсан аливаа хохирлыг Үнэт цаас гаргагч хариуцахгүй болно.

10. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч зөрчил гаргах, түүнийг шийдвэрлэх


- 10.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх,



2023-11-15

БҮРТГЭЭ-02

Хөрөнгө оруулагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх үйлдэл, эс үйлдэхгүй гаргасан тохиолдолд Гэрээний зөрчилд тооцно.



- 10.2. Гэрээний тусгай нөхцөлийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан ноцтой зөрчил гаргасан нь ТЗК-ийн зүгээс Гэрээний ерөнхий нөхцөлийн 6.1 дэх хэсэгт заасан барьцааны эрхээ хэрэгжүүлэх үндэслэл болох бөгөөд хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдах эрхтэй болно.
- 10.3. Гэрээний Тусгай нөхцөлийн 13 дугаар зүйлийн 13.1-т зааснаас бусад гэрээ зөрчсөн үйлдэл гаргасан бөгөөд Үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаанд уг зөрчлийн арилгаагүй бол ноцтойгоор гэрээний үүргийг зөрчсөнтэй адилтган үзэж болно.

11. Маргаан шийдвэрлэх

- 11.1. Энэхүү гэрээ байгуулагдах үндсэн зорилго болон ХБҮЦ гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн гэрээний үүргийн зөрчилтэй холбоотойгоос бусад тохиолдолд аливаа байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх шүүх арбитрт болон төрийн байгууллагад гомдол нэхэмжлэл гаргах болон бусад арга хэмжээ авахгүй байх, төлбөр нэхэмжлэхгүй байх үүрэг хүлээнэ. Үнэт цаас гаргагчийн эсрэг татан буулгах, дампуурлын хэрэг эхлүүлэхгүй байх зэрэг байдлаар маргаан үүсгэхийг хориглоно.
- 11.2. Талууд хууль болон бусад дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс үүссэн хохирол, төлбөр цуглуулах үйлчилгээ, энэхүү гэрээтэй холбоотой гарсан аливаа маргааныг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.
- 11.3. Хэрэв зөвшилцөх аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

12. Гэрээ хүчин төгөлдөр болох

- 12.1. Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 12.2. Гэрээг дөрвөн хувь үйлдэх бөгөөд эдгээр нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нэг хувь, Үнэт цаас гаргагч хоёр хувь, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид нэг хувийг тус тус хадгалуулна.

13. Гэрээний хугацаа

- 13.1. Энэхүү гэрээ нь байгуулагдсан үеэс эхлэн талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дуусгавар болох хүртэл буюу Үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дуусган Үнэт цаас гаргагчийг татан буулгах хүртэл хүчин төгөлдөр байна.
- 13.2. ХБҮЦ-ны хугацаа дуусахаас өмнө Анхны үүрэг гүйцэтгүүлэгч ХБҮЦ-ыг буцаан худалдан авсан тохиолдолд хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно.
- 13.3. ХБҮЦ-ны хугацаа нь анхдагч зах зээлийн арилжаа дууссан өдрөөс эхлэн 24 сар байна.
- 13.4. Энэхүү Гэрээний дагуу Хөрөнгийг үнэт цаас гаргагч худалдан авч Хөрөнгөд суурилсан ХБҮЦ гаргаж, олон нийтэд арилжаалсан тохиолдолд аль нэг талын санаачилгаар гэрээг цуцлах эрхгүй байна.

14. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал

- 14.1. Талуудын урьдчилан таамаглах, даван туулах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл (дайн, гал түймэр, үер, газар хөдлөлт, ажил хаялт, гоц халдварт өвчин, хорио цээр) нь гэрээний үүргийн биелэлтэд шууд нөлөөлсөн нотлогдсон бол Талууд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөгдөнө. Энэ үед



2023-11-15

БҮРТГЭЭ-02

гэрээний үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

СЭХ
2009-17 сар өдөр
БҮРТГЭЭ
№ 31

- 14.2. Энэхүү Гэрээний ерөнхий нөхцөлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу ийнхүү хариуцлагаас чөлөөлөх үндэслэл нь МҮХАҮТ-аас олгосон гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлын гэрчилгээ байна.
- 14.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсон ба үүний улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тухайгаа нотлох үүрэг хүлээнэ.
- 14.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн талаар тухайн цаг үед нь нөгөө талдаа мэдэгдээгүй бол ирээдүйд уг нөхцөл байдлыг үндэслэл болгох эрхгүй.

15. Бусад заалт

- 15.1. Энэхүү гэрээнд Монгол хэлийг ашиглана. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах баримт бичиг нь энэ хэл дээр байна.
- 15.2. Энэхүү гэрээг ойлгох, тайлбарлах, хэрэглэхдээ Монгол Улсын хууль тогтоомжийг баримтална.
- 15.3. Талуудын аль нэг нь гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдэх бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулж талууд гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 15.4. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд гэрээний нэгэн адил үйлчилнэ.
- 15.5. Энэхүү Гэрээний ерөнхий нөхцөлийн 8.2-т заасны дагуу Гэрээний хавсралт №1-д оруулсан нэмэлт өөрчлөлтөд Гэрээний ерөнхий нөхцөлийн 15.3-д заасан журмыг баримтлахгүй байж болох бөгөөд энэ нь Гэрээний хавсралт №1-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.
- 15.6. Энэхүү Гэрээ нь Талуудын холбогдох эрх залгамжлагчид мөн адил үйлчилнэ.
- 15.7. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан “эрх хүлээн авагч” нь хөрөнгө болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад шаардлагатай бүх арга хэмжээ авч, ТЗК-ийн нийт хөрөнгө, санхүүгийн тайлан, тэнцэл, баримт бичиг, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг зэргийг хүлээн авч Үнэт цаас гаргагчийн эрх залгамжлагчаар тооцогдоно.
- 15.8. Хууль ёсны эрх залгамжлагчдаас бусад этгээдэд үүргийг шилжүүлэхийг хориглоно.
- 15.9. Гэрээний ерөнхий нөхцөлийн 15.7-д заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд энэхүү гэрээг хэрэгжүүлэхээр байгуулсан бусад гэрээнүүд хүчин төгөлдөр байна.
- 15.10. Талууд нь энэхүү Гэрээ байгуулагдсантай холбоотойгоор олж мэдсэн гэрээний тусгай нөхцөлийн 14.1-д заасан нууц мэдээ, мэдээлэл, баримт бичгийн нууцлалыг хадгалах ба хувийн болон бусад зорилгоор ашиглахгүй, Үнэт цаас гаргагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх аливаа хэлбэрээр бусдад задруулахгүй, тараахгүй байх үүрэгтэй. Нууц мэдээллийг талууд гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн хугацаанд хадгална.
- 15.11. Талууд хууль тогтоомж төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад нууц мэдээллийг бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр аливаа этгээдэд задруулах хэрэглэх эсхүл өөр бусад зорилгоор ашиглахыг хориглоно.
- 15.12. Гэрээний ерөнхий нөхцөлийн 15.10-15.11 заасныг зөрчиж, нууц мэдээллийг задруулсан тал нөгөө талдаа яаралтай мэдэгдэж, буруутай этгээд нь нууц мэдээллийг задруулснаас үүсэх аливаа хохирлыг бие даан хариуцна.



2023-11-15

СЭРТГӨТ-02

15.13. Холбогдох хуулийн дагуу энэхүү Гэрээний аливаа заалт хууль бус, хүчингүй, хэрэгжүүлэх боломжгүйд тооцогдвол:

- (a) тус заалт нь бүрэн салгах боломжтой;
- (b) тус хууль бус, хүчингүй болон хэрэгжих боломжгүй заалт нь өмнө энэхүү Гэрээний заалт байгаагүйд тооцогдох бол;
- (c) гэрээний бусад заалтууд хүчинтэй хэвээр байх бөгөөд тус хүчингүй, хууль бус болон хэрэгжих боломжгүй заалт нь ямар нэг байдлаар Гэрээний бусад заалтад нөлөөлөхгүй.

15.14. Талуудын хооронд энэхүү Гэрээний зүйлтэй холбоотой асуудлаар өмнө нь хэлэлцэгдэж байсан хэлцэл, харилцан ойлголцлын санамж бичиг, урьдчилсан нөхцөлүүд, Гэрээ болон бусад хэлэлцээр (Бичгээр болон амаар хийгдсэн эсэхээс үл хамааран бүх харилцаа холбоог үүнд хамааруулна) байгаа бол тэдгээрийг энэхүү Гэрээ бусад хэлэлцээрийн баримт бичгийн хамт орлох бөгөөд энэхүү Гэрээ нь (аливаа нэмэлт өөрчлөлт болон бусад Хэлэлцээрийн баримт бичгийн хамт) үүний дагуу зохицуулагдаж буй асуудлын хувьд талуудын хооронд хийгдсэн цорын ганц нэгдмэл гэрээнд тооцогдоно.



2023-11-13

БҮРТГЭЭ-02

СЭХ
он 2023 сар 11 өдөр
БҮРТГЭВ
М 1

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Худалдах хөрөнгө, түүнд хамаарах эрхүүд

- 1.1. Хэлцэл биелэх өдрийн байдлаар Зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл нь энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 2.1-д заасан үнийн дүнтэй тэнцэх хэмжээний Хөрөнгө болон түүнд холбогдох эрхүүдийг хамтад нь худалдана.
- 1.2. Хөрөнгө болон түүнд холбогдох эрхүүд гэдэгт дор дурдсан эрхийг ойлгоно.
 - 1.2.1. Хөрөнгийн жагсаалтад тусгагдсан зээлийн хувьд зээлдүүлэгчийн авлагын болон бусад бүхий л эрхүүд;
 - 1.2.2. Зээлтэй холбоотойгоор болон гэрээний биелэлтийг хангах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эдлэх бүхий л эрхийг эдэлж, эрх бүхий байгууллага, гуравдагч этгээд, зээлдэгч болон хамтран зээлдэгч, холбоотой бусад этгээдэд холбогдуулан шаардлага гаргах эрх, шүүх, арбитраг хандан нэхэмжлэл гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх.

2. Хэлцэл биелэх үнэ

- 2.1. Хэлцэл биелэх өдрийн байдлаар хэлцэл биелэх үнэ нь **6,000,000,000.00 (зургаан тэрбум) төгрөг** байна.
- 2.2. Энэхүү дүн нь НӨАТ-гүй дүн байх бөгөөд Монгол Улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.14-т заасны дагуу НӨАТ-аас чөлөөлөгдөнө.

3. Хэлцэл биелэх өдөр

- 3.1. Талууд Анхдагч зах зээлийн арилжаа хийгдэж **6,000,000,000.00 (зургаан тэрбум) төгрөг** буюу түүнээс дээш дүнгээр хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлсэн өдрийг хэлцэл биелэх өдрөөр тогтоов.
- 3.2. Хэрэв Анхдагч зах зээлийн арилжааны хугацаа дуусахад Анхдагч зах зээлийн арилжаа **6,000,000,000.00 (зургаан тэрбум) төгрөгт** хүрээгүй тохиолдолд талууд уг хугацааг харилцан тохиролцож сунгаж болно.

4. Хөрөнгөд тавигдах шаардлага

- 4.1. Хэлцэл биелэх өдрийн байдлаар Хөрөнгө нь Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байна.
- 4.2. Хэлцэл биелэх өдрийн байдлаар энэхүү Гэрээний дагуу худалдах, худалдан авах Хөрөнгийн багц дахь Зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр нь энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 2.1-д заасан үнийн дүнтэй тэнцүү байна.

5. Хөрөнгө шилжүүлэх

- 5.1. Хэлцэл биелэх өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан гэрээний хавсралт №1-д заасан жагсаалтын дагуу хөрөнгийн багцын бүртгэлийг Үнэт цаас гаргагчид бүрэн шилжүүлнэ.
- 5.2. Зээлийн бүртгэлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагч тус бүр хөтлөх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн бусад зээлээс салгаж тусад нь бүртгэлийг хөтөлнө.

6. Гэрээний үнийг төлөх дансны мэдээлэл



2023-11-15

БҮРТГЭЭ-02

6.1. Үнэт цаас гаргагч нь гэрээний төлбөрийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Капитрон банкны 3096014129 тоот “Омни Капитал ББСБ” ХХК нэртэй дансанд шилжүүлнэ.

СЗХ
2023-11-08 өдөр
БҮРТГЭЭ-02
№ 1

7. Хөрөнгө солих үндэслэл

7.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд тухайн хөрөнгийг Шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож, Гэрээний тусгай нөхцөлийн 4 дүгээр зүйлд заасан шаардлага хангасан өөр хөрөнгөөр солих замаар багцаас хасна. Үүнд:

- 7.1.1. Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхүйц байна гэж ТЗК-иас үзсэн;
- 7.1.2. Багц дахь хөрөнгө нь энэхүү Гэрээний хавсралт №2-т заасан Шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон;
- 7.1.3. Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн энэхүү Гэрээнд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн;
- 7.1.4. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 90-ээс дээш хоног хэтэрсэн, эсхүл Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болох нь үндэслэл бүхий бол.

7.2. Хөрөнгийн багц солихтой холбоотой харилцаанд ТЗК-ийн ТУЗ-аас баталсан “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-ыг баримтална.

8. Хөрөнгө нэмж худалдан авах үндэслэл:

8.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд багцын хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:

- 8.1.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангахгүй буюу ХБҮЦ-ны хөрөнгийн багцаас орох орлого нь ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
- 8.1.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу ТЗК нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт ХБҮЦ гаргахаар болсон;
- 8.1.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолд нийцүүлэн үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон;
- 8.1.4. Хууль буюу гэрээнд заасан бусад.

8.2. Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэх, нэмж худалдан авахтай холбоотой харилцаанд ТЗК-ийн ТУЗ-аас баталсан “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-ыг баримтална.

9. Хөрөнгийн багцыг буцаан худалдах нөхцөл:

9.1. Анхны үүрэг гүйцэтгэгч нь дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд багцын хөрөнгийг буцаан худалдан авна. Үүнд:

- 9.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээнд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
- 9.1.2. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн тохиолдолд;
- 9.1.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд.

10. Хөрөнгийн багц шилжүүлэх акт

10.1. Хэлцэл биелэх үнийг төлсөн өдөр ББСБ нь Зээлийн данс бүртгэлийг ТЗК-д шилжүүлж, Хөрөнгийн багцыг хүлээлгэн өгөх актыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үнэт цаас гаргагч нар нь Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэгчийг

2023-11-15 оролцуулан үйлдэнэ.

10.2. Энэ Гэрээний ерөнхий нөхцөлийн 9 дүгээр зүйлд зааснаар Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэгч нар Хөрөнгийн багц хүлээлгэн өгөх актыг Үнэт цаас гаргагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийг оролцуулан үйлдэнэ.

10.3. Энэ Гэрээний ерөнхий нөхцөлийн 8 дугаар зүйлд заасны дагуу Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгийн багц шилжүүлэх актыг үйлдэж, Хөрөнгийн багцыг шилжүүлэх бөгөөд энэ тухай Үнэт цаас гаргагч болон Үйлчилгээ үзүүлэгчид тус тус мэдэгдэнэ.

10.4. Энэ Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлд заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэх тул тусгай нөхцөлийн 10.3-т зааснаар мэдэгдэхгүй байж болно.

11. Хөрөнгөтэй холбоотой баталгаа

11.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгөтэй холбоотой дараах баталгааг Үнэт цаас гаргагчид гаргаж байна. Үүнд:

11.1.1. Хөрөнгийн багц дахь хөрөнгө нэг бүр нь хэлцэл биелэх өдрийн байдлаар хавсралтад заасан Шалгуур үзүүлэлтийг хангасан болно.

11.1.2. Энэ гэрээ болон түүнд хавсаргасан мэдээллүүд нь /гэрээ болон хавсралтад заасан хөрөнгө, тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүд, тэдгээртэй холбоотой баримт бичиг мэдээлэл/ үнэн зөв болно.

11.1.3. Хөрөнгө Үнэт цаас гаргагчид бүрэн шилжихэд ямар нэгэн хязгаарлалт байхгүй болно.

11.1.4. Хөрөнгийн багц дахь хөрөнгөтэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлдэгчид төлөх аливаа өр төлбөр, Зээлийн гэрээнд зааснаас бусад нэмэлт үүрэг байхгүй болно.

11.1.5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлдэгч, Зээлдэгчийн хамаарал бүхий этгээдтэй холбоотой аливаа маргаан, гомдол, нэхэмжлэл, дампуурлын хэрэг зэргийн талаар мэдэгдэл, мэдээлэл аваагүй болно.

11.1.6. Хөрөнгийн багц дахь зээлтэй холбоотой аливаа шүүхийн маргаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээгүй болно.

11.1.7. Хөрөнгөтэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх хэрэгжих нөхцөл, эрхийн хүчин төгөлдөр байдал нь гэрээний хугацаанд бүрэн хангагдсан болно.

11.1.8. Зээлдэгч нь хөрөнгөтэй холбоотой аливаа үүргээ Хэлцэл биелэх өдөр хүртэл хэрэгжүүлж биелүүлсэн байх, үүргийн зөрчил бий болсон тохиолдолд уг зөрчлийг арилгасан, ийнхүү арилгасан зөрчлийг Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон аудитор шалган баталгаажуулах бүрэн боломжтой.

11.1.9. Хөрөнгийн багц дахь зээлийн баримт бичгүүд болон Зээлийн данс бүртгэл нь зохих ёсоор бүртгэгдсэн бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшилд байгаа. Хэлцэл биелэх өдрийн байдлаар зээл бүрийн бичиг баримт, данс бүртгэл бүрэн гүйцэд бөгөөд шинэчлэгдэж үнэт цаас гаргагчид шилжихэд бэлэн байгаа болно.


12. Үнэт цаас гаргагчид гаргасан баталгаа

12.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчид дараах баталгааг өөрийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргаж байна. Үүнд:

12.1.1. Энэхүү гэрээ болон ХБҮЦ гаргахтай холбоотой бусад холбогдох гэрээ хэлцэл түүний дотор үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулах эрх зүйн бүрэн чадамжтай бөгөөд эдгээр гэрээ хэлцлийг байгуулснаар бусад гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ болон эрх бүхий байгууллагын шийдвэр хууль тогтоомжийг зөрчөөгүй болно.

12.1.2. ББСБ нь энэ гэрээ болон бусад гэрээг байгуулах, гэрээний дагуу хөрөнгө шилжүүлэх, барьцаалах болон бусад үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л бэлтгэл ажлыг бүрэн хангаж, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдсөн





болно.

- 12.1.3. ТЗК-д худалдсан хөрөнгийн эрхийг Үнэт цаас гаргагчид шилжүүлэхэд ямар нэгэн зөрчилгүй бөгөөд тухайн эрх шилжүүлэлтийг бүртгүүлэх, дуусгавар болгоход аливаа хязгаарлалт байхгүй болно.
- 12.1.4. Хөрөнгийн багц дахь зээл бүртэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлдэгч болон бусад этгээдэд төлөх өр төлбөр байхгүй бөгөөд сарын хуваарьт төлбөртэй холбоотойгоор Зээлдэгчээс суутгал хийх эрх үүсээгүй болно.

13. Гэрээний зөрчил

- 13.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн гаргасан дараах үйлдэл, эс үйлдэхгүйг ноцтой зөрчил гэж үзнэ. Үүнд:
 - 13.1.1. ББСБ-ын гаргасан аливаа баталгаа, мэдэгдэл, гэрээнд хавсаргасан аливаа баримт бичгүүд, түүнчлэн энэхүү гэрээ хэрэгжих явцад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчид гарган өгсөн аливаа баталгаа, мэдэгдэл, тайлан мэдээлэл зэрэг нь худал, алдаатай байх;
 - 13.1.2. ББСБ-аас энэ гэрээний хөрөнгө солих зохицуулалтын хүрээнд ТЗК-д сольж өгсөн орлуулах хөрөнгө нь шаардлага хангахгүй хууль болон эрх бүхий байгууллага, Үнэт цаас гаргагчаас баталсан журамд нийцээгүй байх;
 - 13.1.3. ББСБ нь энэ гэрээнд заасан хөрөнгө сольж өгөх болон буцаан худалдан авах үүргээ биелүүлэхгүй байх;
 - 13.1.4. ББСБ-ийн ТЗК-д худалдсанаас бусад зээлийн багц байхгүй болсон.
 - 13.1.5. ББСБ төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах ажиллагаа хийгдэж эхэлсэн болон дампуурлын хэрэг үүсгэсэн;
- 13.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөрчил нь энэхүү Гэрээний 13.1.1- 13.1.5-д зааснаас бусад зөрчил байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бичгээр мэдэгдэл өгч ажлын 5 хоногт багтаан зөрчлийг арилгахыг шаардах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ хугацаанд багтаан уг зөрчлийг арилгах үүрэг хүлээнэ.

14. Нууц мэдээлэл

- 14.1. ХБҮЦ гаргах ажиллагаа болон Хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээлэл, хөрөнгийн багц болон түүний зээл, барьцаатай холбоотой зээлдэгч болон шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд, ТЗК, ББСБ-тай холбоотой аливаа мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ хэлцэл, тохиролцоо болон тэдгээрээс авч буй үйлчилгээтэй холбоотой аливаа мэдээлэл, Санхүүгийн нөхцөл байдлын тухай аливаа мэдээлэл, санхүүгийн тайлан, зах зээлийн судалгаа, хуулийн этгээдийн бүртгэл болон үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг, дүрэм журам, заавар, бодлого, гэрээ хэлцэл эдгээрт заасан нөхцөл, мэдээлэл, тоон үзүүлэлт, зураг график зэргийг нууц мэдээлэлд тооцно.
- 14.2. Дээр дурдсан нууц мэдээлэл гэдэгт нийтэд ил болгосон, эсхүл ХБҮЦ гаргах ажиллагааны хүрээнд Үнэт цаасны танилцуулгад тусгаж олон нийтэд танилцуулагдах болон холбогдох хууль журмын дагуу тодорхой этгээдүүдэд танилцуулах мэдээлэл хамаарахгүй болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ:

“ОМНИ КАПИТАЛ ББСБ”
ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ч.ЭРЭЛХЭГ



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА А.БАТБОЛД



2023-11-15

БҮРТГЭВ-02




Хөрөнгийн жагсаалт

№	Гэрээ	Зээлийн ангилал	Зээл олгосон огноо	Зээл хаагдах огноо	Олгосон зээл дүн	Зээлийн үлдэгдэл	Хугацаа	Зээлийн хүү	Барьцаа хөрөнгийн үнэлгээ
1	11864	хэвийн	4/13/2023	2025.04.13	70,000,000.00	64,575,712.9	24	3	150,000,000.0
2	ЗГ-202101-2268	хэвийн	1/25/2021	2024.01.25	9,600,000.00	2,331,823.3	36	2.9	12,000,000.0
3	ЗГ-202101-019	хэвийн	1/26/2021	2024.01.26	14,500,000.00	4,024,397.8	36	2.9	18,200,000.0
4	ЗГ-202102-042	хэвийн	2/8/2021	2024.04.15	100,000,000.00	61,722,834.0	16	2.8	80,000,000.0
5	ЗГ-202102-2301	хэвийн	2/24/2021	2024.02.24	11,400,000.00	1,056,182.0	36	2.9	16,400,000.0
6	ЗГ-202105-140	хэвийн	5/12/2021	2023.11.12	25,000,000.00	5,116,306.8	30	2.8	40,000,000.0
7	202108-292	хэвийн	8/20/2021	2024.02.20	20,000,000.00	8,005,049.4	30	2.9	45,000,000.0
8	202108-297	хэвийн	8/21/2021	2024.02.21	13,000,000.00	4,107,688.0	30	2.9	23,000,000.0
9	202109-351	хэвийн	9/28/2021	2024.08.10	10,400,000.00	4,725,147.8	36	2.9	13,000,000.0
10	202110-411	хэвийн	10/25/2021	2024.04.25	10,000,000.00	4,383,396.4	30	3.1	25,000,000.0
11	202110-416	хэвийн	10/27/2021	2024.04.27	15,000,000.00	5,766,017.7	30	3	12,000,000.0
12	202111-436	хэвийн	11/4/2021	2024.11.04	7,000,000.00	4,121,655.0	36	3.1	26,000,000.0
13	ЗГ-202111-441	хэвийн	11/9/2021	2024.05.09	30,000,000.00	13,165,816.6	30	3.1	60,000,000.0
14	202111-444	хэвийн	11/12/2021	2023.11.05	12,500,000.00	2,502,158.6	24	2.5	17,000,000.0
15	202111-459	хэвийн	11/23/2021	2024.11.23	30,000,000.00	16,401,725.8	36	2.9	60,000,000.0
16	202111-472	хэвийн	11/30/2021	2023.11.30	10,000,000.00	3,255,232.4	24	3	18,000,000.0
17	202111-473	хэвийн	11/30/2021	2023.11.25	14,400,000.00	2,904,027.6	24	2.5	18,000,000.0
18	202112-483	хэвийн	12/6/2021	2023.12.05	16,300,000.00	4,370,722.2	24	3	36,300,000.0
19	03-202112-20	хэвийн	12/7/2021	2024.12.07	59,000,000.00	38,217,120.9	36	2.9	75,000,000.0
20	03-202112-22	хэвийн	12/9/2021	2023.12.09	7,000,000.00	1,840,505.2	24	2.9	11,600,000.0
21	202112-493	хэвийн	12/13/2021	2024.06.13	9,100,000.00	4,292,607.3	30	3	13,000,000.0
22	202112-495	хэвийн	12/13/2021	2024.06.17	23,000,000.00	10,992,193.9	30	3	38,000,000.0
23	202112-500	хэвийн	12/15/2021	2024.12.15	11,200,000.00	6,787,050.2	36	2.9	18,800,000.0
24	03-202112-26	хэвийн	12/16/2021	2023.12.16	15,000,000.00	4,021,223.8	24	3	35,000,000.0
25	202201-004	хэвийн	1/5/2022	2024.01.05	11,000,000.00	3,807,779.8	24	3.1	13,000,000.0
26	202201-005	хэвийн	1/6/2022	2025.01.06	18,000,000.00	10,874,900.5	36	2.9	40,000,000.0
27	202201-013	хэвийн	1/10/2022	2024.01.10	5,000,000.00	1,505,070.3	24	3	12,000,000.0
28	202201-015	хэвийн	1/11/2022	2025.01.10	10,000,000.00	6,322,528.0	36	3	10,000,000.0
29	202201-016	хэвийн	1/11/2022	2024.01.20	6,000,000.00	2,155,559.5	24	3	20,000,000.0
30	202201-020	хэвийн	1/12/2022	2025.01.10	15,000,000.00	8,032,131.8	36	2.5	20,300,000.0
31	202201-025	хэвийн	1/13/2022	2025.01.13	16,600,000.00	12,050,095.9	36	2.5	23,800,000.0
32	202201-27	хэвийн	1/13/2022	2024.07.25	8,000,000.00	4,167,166.1	30	2.9	20,000,000.0
33	202201-029	хэвийн	1/13/2022	2025.01.13	26,400,000.00	15,809,022.9	36	2.5	33,000,000.0
34	03-202201-013	хэвийн	1/14/2022	2024.01.14	7,000,000.00	2,032,324.2	24	2.5	16,000,000.0
35	03-202201-014	хэвийн	1/15/2022	2024.07.15	8,000,000.00	3,997,877.2	30	2.9	16,000,000.0
36	202201-090	хэвийн	1/15/2022	2025.01.25	19,000,000.00	11,710,851.2	36	2.5	25,000,000.0
37	202201-038	хэвийн	1/15/2022	2025.01.17	13,000,000.00	7,935,066.4	36	2.5	16,800,000.0

[Handwritten signature]





38	202201-043	хэвийн	1/16/2022	2025.01.17	35,200,000.00	22,384,411.9	36	2.5	44,000,000.0
39	03-202201-017	хэвийн	1/17/2022	2024.01.01	15,000,000.00	3,568,422.3	24	2.5	19,000,000.0
40	03-202201-018	хэвийн	1/17/2022	2024.01.17	45,000,000.00	28,572,657.5	24	2.9	80,000,000.0
41	202201-049	хэвийн	1/18/2022	2025.01.17	14,400,000.00	8,721,152.4	36	2.5	18,000,000.0
42	03-202201-023	хэвийн	1/19/2022	2025.01.19	14,500,000.00	8,917,599.4	36	2.5	18,500,000.0
43	202201-51	хэвийн	1/19/2022	2024.12.20	26,000,000.00	15,812,687.1	36	2.5	32,800,000.0
44	202201-056	хэвийн	1/19/2022	2024.01.25	14,000,000.00	4,905,332.3	24	2.9	20,000,000.0
45	202201-066	хэвийн	1/20/2022	2025.01.20	20,900,000.00	12,702,977.9	36	2.5	26,200,000.0
46	202201-065	хэвийн	1/20/2022	2024.07.02	6,000,000.00	2,847,519.9	30	2.9	15,000,000.0
47	202201-072	хэвийн	1/21/2022	2024.07.25	7,000,000.00	4,038,464.2	30	2.9	15,000,000.0
48	202201-073	хэвийн	1/21/2022	2025.01.25	18,800,000.00	12,023,145.7	36	2.5	23,500,000.0
49	ЗГ02-2201009	хэвийн	1/21/2022	2024.07.21	13,000,000.00	6,506,829.4	30	2.9	23,000,000.0
50	03-202201-031	хэвийн	1/22/2022	2025.01.22	15,000,000.00	8,921,635.7	36	2.5	19,000,000.0
51	202201-070	хэвийн	1/22/2022	2025.01.17	17,500,000.00	10,523,830.5	36	2.5	25,000,000.0
52	03-202201-034	хэвийн	1/23/2022	2025.01.23	15,000,000.00	8,856,728.3	36	2.5	19,000,000.0
53	03-202201-029	хэвийн	1/25/2022	2025.01.25	20,000,000.00	13,586,798.2	36	3	50,000,000.0
54	03-202201-044	хэвийн	1/26/2022	2024.07.26	17,000,000.00	8,880,264.1	30	2.7	27,000,000.0
55	202201-088	хэвийн	1/26/2022	2024.07.26	15,000,000.00	8,442,536.2	30	2.9	22,000,000.0
56	202201-087	хэвийн	1/26/2022	2025.01.26	40,000,000.00	25,603,103.3	36	2.5	67,000,000.0
57	202201-086	хэвийн	1/26/2022	2025.01.26	20,200,000.00	13,398,806.1	36	2.5	25,250,000.0
58	202201-085	хэвийн	1/26/2022	2025.01.26	26,000,000.00	11,284,742.1	36	2.5	39,000,000.0
59	202201-091	хэвийн	1/26/2022	2025.01.17	27,200,000.00	16,229,174.0	36	2.5	34,000,000.0
60	03-202201-045	хэвийн	1/27/2022	2025.01.27	15,000,000.00	9,479,508.9	36	2.5	19,000,000.0
61	03-202201-046	хэвийн	1/27/2022	2024.07.27	15,000,000.00	7,923,147.5	30	2.5	19,000,000.0
62	202201-098	хэвийн	1/28/2022	2025.01.20	27,500,000.00	11,925,797.0	36	2.5	34,500,000.0
63	202201-101	хэвийн	1/29/2022	2025.01.25	15,000,000.00	9,022,566.9	36	2.5	18,500,000.0
64	202201-102	хэвийн	1/29/2022	2025.02.02	19,200,000.00	11,722,155.1	36	2.5	24,200,000.0
363	3Г-12495	БГ-12495	Toyota Prius 30	1
364	3Г-12501	БГ-12501	Toyota Prius Alpha	1
365	3Г-12513	БГ-12513	Toyota Prius XW30	1
366	3Г-12374	БГ-12374	Toyota.Prius 20	1
367	3Г-12386	БГ-12386	Toyota.Prius-Xw30	1
368	3Г-12423	БГ-12423	Toyota.Prius20	1
369	3Г-12421	БГ-12421	Toyota prius-30	1
370	3Г-12403	БГ-12403	Toyota Prius	1
371	3Г-12380	БГ-12380	TOYOTA, PRIUS 1797 CC	1
372	3Г-12404	БГ-12404	Hyundai Sonata	1
373	3Г-12408	БГ-12408	HYUNDAI, MIGHTY 3298 CC,	1
374	3Г-12411	БГ-12411	Toyota Camry	1
375	3Г-12425	БГ-12425	TOYOTA, PRIUS 1797 CC	1
376	3Г-12430	БГ-12430	TOYOTA, PRIUS 1496 CC,	1
377	3Г-12438	БГ-12438	TOYOTA, PRIUS 1496 CC	1
378	3Г-12442	БГ-12442	TOYOTA, PRIUS ALPHA 1797 CC	1
379	3Г-12445	БГ-12445	TOYOTA, PRIUS 1797 CC,	1
380	3Г-12483	БГ-12483	TOYOTA, PRIUS 1797 CC	1

L. J. J.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
43

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК



КОНГОЛЫН ХӨРӨНГӨЙН БИРЖ
“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК

2023 - - -

БҮРТГЭЛЭГ “ОМНИ АССЕТ ТЗК” ХХК (“КОМПАНИ”)-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай

2023 оны 08 сарын 23-ны өдөр

№ ТУЗ-23/014

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь хэсэг, 76.1.17 дахь хэсэг, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Компанийн толгой компани болох “Омни капитал ББСБ” ХХК-г Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан Үйлчилгээ үзүүлэгч бөгөөд Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах Захиргааны үйлчилгээ үзүүлэгч этгээдээр сонгохыг зөвшөөрсүгэй.
2. Дээрх заалтын хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор Компанийг төлөөлөн дараах гэрээг дор дурдсан талуудтай байгуулах бүрэн эрхийг ТУЗ-ийн дарга А.Батболдод олгосугай. Үүнд:

№	Гэрээний талууд	Гэрээний нэр
1	Компани болон “Омни капитал ББСБ” ХХК, “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК	Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ
2	Компани болон “Омни капитал ББСБ” ХХК	Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ
3	Компани болон “Омни капитал ББСБ” ХХК, “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК	Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ

ТУЗ-ИЙН ДАРГА



А.БАТБОЛД



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-11-15

БҮРТГЭВ-02

ОГНОО:

2023 оны 08 -р сарын 23-ны өдөр



“ОМНИ КАПИТАЛ ББСБ” ХХК
“Барьцаалуулагч”

болон

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК
“Үнэт цаас гаргагч”

“ЮУ ЭЙ ЭФ АССЕТ МЕНЕЖМЕНТ” ХХК
“Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч”

нарын хооронд байгуулсан

**ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ДАНСНЫ
БАРЬЦААНЫ ГЭРЭЭ**

Дугаар: 23/013



ЭНЭХҮҮ ГЭРЭЭГ Монгол улсын Иргэний хуулийн 13-р бүлэг, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийг үндэслэн дор дурдсан талуудын хооронд байгуулав:

ТАЛУУД:
317-02

- (1) “ОМНИ КАПИТАЛ ББСБ” ХХК (цаашид “Барьцаалуулагч” эсхүл “ББСБ” эсхүл “Үйлчилгээ үзүүлэгч” гэх);
 - (2) “ОМНИ АССЕТ ТЗК” ХХК (цаашид “ТЗК” эсхүл “Үнэт цаас гаргагч” гэх);
 - (3) “ЮУ ЭЙ ЭФ АССЕТ МЕНЕЖМЕНТ” ХХК Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн №473 дугаар тогтоолын дагуу авсан Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх)-ны Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч (цаашид “Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч” эсхүл “Барьцаалагч” гэх).
1. Энэхүү Гэрээний зорилго нь ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгч нарын хооронд байгуулсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний 2.3-т заасан Зээлийн эргэн төлөлтийн данс, уг дансанд цугларах зээлийн төлбөрийн орлогыг барьцаалах, ТЗК-ийн ХБҮЦ-ны төлбөрийг төлөх зорилгоор Зээлийн эргэн төлөлтийн данснаас ТЗК-ийн Төлбөр цуглуулах дансанд Гэрээ буюу журмаар тогтоосон хугацаанд үл маргах журмаар шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
 2. Барьцаалуулагч нь Зээлийн эргэн төлөлтийн дансыг эзэмших бөгөөд уг дансанд Зээлийн хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу худалдсан зээлүүдийн төлбөрүүдийг цуглуулан барьцаалах зөвшөөрлийг зохих журмын дагуу авсан болох, үүнээс өмнө өөр үүргийн барьцаанд тавиагүй ба бусад ямар нэг байдлаар аливаа маргаанд холбогдолгүй бөгөөд энэхүү Зээлийн эргэн төлөлтийн дансанд аливаа гуравдагч этгээдийн эдлэх эрх байхгүй болохыг үүгээр гэрчилж байна.
 3. Барьцаалуулагч нь энэхүү Гэрээний 3.1, 3.2-т заасан тохиолдолд гүйлгээ хийх зөвшөөрлийг Гэрээний Хавсралт №1-т заасан зээлийн эргэн төлөлтийн данс байршиж буй банкинд олгосон болохоо үүгээр баталж байна.
 4. Барьцааны зүйлийн талаар аливаа гуравдагч этгээдтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд Барьцаалагч нь Иргэний хуулийн 154-р зүйлд зааснаар гуравдагч этгээдээс давуу эрхтэй болохыг хүлээн зөвшөөрөв.
 5. Зээлийн эргэн төлөлтийн данс, түүнд цугларсан хөрөнгө нь Барьцаалуулагчийн бусад хөрөнгөөс тусгаарлагдсан, Барьцаалуулагчийн бусдын өмнө хүлээсэн аливаа үүрэг, төлбөрийн чадваргүй байдал, дампуурал, татан буулгах ажиллагаанаас ангид байна.

1. НЭР ТОМЬЁО БА ТАЙЛБАР

Энэхүү Гэрээний нэр томьёо хэсэгт тодорхойлсноос бусад том үсгээр бичигдсэн нэр томьёог Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээнд тодорхойлсон утгаар ойлгож тайлбарлана.

- 1.1. ТЗК болон ББСБ нарын хооронд байгуулсан Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ, Зээлийн хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ, Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нарын хооронд байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд тус тус тодорхойлсон үг болон томьёоллыг энэхүү гэрээнд адил утгаар хэрэглэнэ.
- 1.2. “Баталгаажсан өр төлбөр” гэдэгт ХБҮЦ-ны хэлцлийн дагуу Үнэт цаас гаргагчийн хүлээх, төлөх (бодитой учирсан, эсхүл учирч болзошгүй) бүх мөнгө, аливаа хэлбэрийн үүрэг, хариуцлага болон энэ гэрээнд төлөхөөр тохирсон бусад бүх мөнгийг тус тус ойлгоно.

2023-11-15

БҮРТГЭЭХ-02

СЗХ
2023 оны 11 сар 08 өдөр
БҮРЭГЭВ

1.3. “Барьцааны зүйл” гэж энэхүү гэрээний 2.1 дэх хэсэгт заасан хөрөнгө, мөн тэдгээрт заасан болон тэдгээрийн дагуу үүссэн Үнэт цаас гаргагчийн аливаа эрх, эд хөрөнгийн эрх, ашиг сонирхол, үр ашгийг ойлгоно.

1.4. “Үнэт цаас гаргалтын баримт бичиг” гэж ТЗК-ийн ХБҮЦ гаргах үйл ажиллагаатай холбоотой баталсан дүрэм, журам, бусад этгээдүүдтэй байгуулсан гэрээг ойлгоно.

2. БАРЬЦААНЫ ЗҮЙЛ

- 2.1. Барьцаалуулагч нь ТЗК-ийн Үйлчилгээ үзүүлэгчийн хувьд ТЗК-ийн хууль ёсны өмчлөлийн зээлийн хөрөнгийн багцаас төлөгдсөн зээлийн аливаа төлбөрийг Зээлийн эргэн төлөлтийн данс буюу Хавсралт №1-т заасан өөрийн эзэмшлийн дансад цуглуулах бөгөөд Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд эдгээр дансан дахь дараах хөрөнгийг Үүргийн гүйцэтгэл хангуулагчид барьцаалуулж байна.
 - (i) Зээлийн хөрөнгийн багцын бүхий л төлбөр, түүнээс олох орлого;
 - (ii) Хөрөнгийн багцын үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг хэрэгжүүлсэнтэй холбоотой аливаа орлого.
- 2.2. Үйлчилгээ үзүүлэгч татан буугдах, дампуурах, төлбөрийн чадваргүй болох зэрэг бусдын өмнө үүрэг хүлээх аливаа тохиолдолд Зээлийн эргэн төлөлтийн данс, уг данс дахь мөнгөн хөрөнгө нь эдгээр тохиолдлоос ангид байх бөгөөд Барьцаалагч, Үнэт цаас гаргагчийн шаардлага хангуулах, хангах эрх хэвээр хадгалагдана.
- 2.3. Барьцааны зүйлийн үнэлгээг сар бүрийн Үйлчилгээ үзүүлэгчийн тайланд тусгасан тухайн сард төлөгдсөн төлбөрүүдийн дүнгээр тодорхойлно.
- 2.4. Барьцааны зүйлийн үнэлгээ болон барьцаагаар хангагдах шаардлага нь энэхүү гэрээний 2.1-ийн (i), (ii)-д заасан орлогын дүнгээс хэтрэхгүй байна.
- 2.5. Барьцаалсан хөрөнгийн дүн нь барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээнээс бага байх тохиолдолд Барьцаалуулагч нь үнэлгээнээс дутсан үүргийг I өдрийн дотор нөхөж төлөх үүрэгтэй.

3. ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ

- 3.1. Барьцаалуулагч нь 2.1-ийн (i), (ii)-д заасан орлогын дүнг Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу ТЗК-д шилжүүлээгүй буюу барьцаагаар хангагдах шаардлага үүссэн тохиолдолд Барьцаалагч (Үүргийн гүйцэтгэл хангуулагч) нь Үйлчилгээ үзүүлэгч болон Зээлийн эргэн төлөлтийн данс байрлах банканд энэ тухай мэдэгдлийг бичгээр хүргүүлж, үүргийн гүйцэтгэлийг үл маргах журмаар хангуулна. Барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээ нь Гэрээний 2.1-т заасан орлогын нийлбэрээр тодорхойлогдно.
- 3.2. Үйлчилгээ үзүүлэгч нь Энэхүү гэрээний 3.1.-д заасан мэдэгдлийг хүлээн авмагц банканд бичгээр мэдэгдэл хүргүүлж мэдэгдэлд дурдсан мөнгөн хөрөнгийг Барьцаалуулагчийн харилцах данснаас Үүргийн гүйцэтгэл хангуулагчийн мэдэгдэлд дурдсан “Омни Ассет ТЗК” ХХК-ийн Капитрон банкны 3000124051 тоот харилцах дансанд ажлын 8 цагийн дотор шилжүүлэхэд онцгойлон анхаарч ажиллана.
- 3.3. Үүргийн гүйцэтгэл хангуулагч нь Банкинд энэхүү гэрээний 3.1-д дурдсан мэдэгдлийг хүргүүлэхдээ дараах зүйлсийг тодорхой тусгана. Үүнд:
 - 3.3.1. Барьцаалуулагчийн төлөх баталгаажсан өр төлбөрийн дүн,
 - 3.3.2. “Омни Ассет ТЗК” ХХК-ийн төлбөр хүлээн авах дансны мэдээлэл
- 3.4. Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчийн бүрэн эрх.
 - 3.4.1. Албадан хэрэгжүүлэх үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга: Зөрчлийн тохиолдол бий болоход, энэхүү гэрээгээр үүссэн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг албадан хэрэгжүүлнэ.
 - 3.4.2. Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчийн бүрэн эрх: Хэрэв үүргийн гүйцэтгэлийг албадан хангуулах бол Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч энэхүү гэрээний дагуу

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХХК
2

8. ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХАНГУУЛАГЧИЙН ХАРИУЦЛАГА



8.1.1. Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчийн хариуцлага: Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч нь аливаа төлбөр хүлээн авах эрх бүхий этгээдүүдийн өмнө ХБҮЦ-ны мөнгөн хөрөнгийн эх үүсвэрээс өөр аливаа бусад хөрөнгөөр хариуцлага хүлээхгүй.

8.2. Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчийн эрхийг албадан хэрэгжүүлэх: Энэ гэрээний дагуу Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчийн эрхийг албадан хэрэгжүүлэх зорилгоор Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч, эсхүл Эрх хүлээн авагчаас тухай бүр гүйцэтгэхийг шаардаж болох бүхий л зүйлийг Үнэт цаас гаргагч хийж гүйцэтгэх, эсхүл гүйцэтгүүлэхийг зөвшөөрөх ба тухайн зорилгоор Үүргийн гүйцэтгэлийг хангуулагчаас шаардсан үед Үнэт цаас гаргагчийн нэрийг ашиглахыг зөвшөөрнө.

9. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

9.3. Үүргийн гүйцэтгэлийг хангуулагч энэ гэрээгээр байгуулсан үйл ажиллагаа бүрэн дууссан гэж үзвэл энэ гэрээгээр бий болгосон үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг чөлөөлнө.

9.4. Энэхүү гэрээ нь байгуулагдсан үеэс эхлэн талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дуусгавар болох хүртэл буюу ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дуусган Үнэт цаас гаргагчийг татан буугдах өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

10. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

10.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас тухайлбал (дайн, гал түймэр, үер, газар хөдлөлт, ажил хаялт, гоц халдварт өвчин, хөл хорио гэх мэт) зэрэг нөхцөл байдал нь гэрээний үүргийн биелэлтэд шууд нөлөөлсөн нотлогдсон бол талууд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөгдөнө. Энэ үед гэрээний үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

10.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсон ба үүний улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тухайгаа нотлох үүрэг хүлээнэ.

10.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн талаар тухайн цаг үед нь нөгөө талдаа мэдэгдээгүй бол ирээдүйд уг нөхцөл байдлыг үндэслэл болгох эрхгүй.

11. ГЭРЭЭНД АШИГЛАХ ХЭЛ

11.1. Энэхүү гэрээнд Монгол хэлийг ашиглана. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах баримт бичиг нь энэ хэл дээр байна.

12. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

12.1. Талуудын аль нэг нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдэж, харилцан зөвшилцөнө.

12.2. Талууд харилцан зөвшилцсөн гэрээний нэмэлт өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн холбогдох зөвшөөрөл авснаар нэмэлт өөрчлөлтийг зөвхөн бичгээр байгуулж, талууд гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

12.3. Гэрээний нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд Гэрээний нэгэн адил үйлчилнэ.



13. ДАГАЖ МӨРДӨХ ХУУЛЬ ТОГТООМЖ

- 13.1. Энэ гэрээ болон түүнд дурдсан талуудын эрх, үүргийг Монгол Улсын хуулийн дагуу тайлбарлана.
- 13.2. Энэ гэрээнд холбогдуулан, эсхүл түүнээс үүдэн гарах аливаа хууль зүйн ажиллагааг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлэх, тэдгээр шүүхийн харьяаллаар хэрэг шийдвэрлүүлэхийг эргэж буцалтгүй зөвшөөрч байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ:

“ОМНИ КАПИТАЛ ББСБ” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ч.ЭРЭЛХЭГ



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК
ТУЗ-ИЙН ДАРГА
А.БАТБОЛД



БАРЬЦААЛАГЧ, ҮҮРГИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙГ
ХАНГУУЛАГЧ:

“ЮУ ЭЙ ЭФ АССЕТ
МЕНЕЖМЕНТ” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Х.МАРГАД-ЭРДЭНЭ



БАРЬЦААНЫ ЗҮЙЛ БОЛОХ ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ДАНСНЫ ЖАГСААЛТ

№	Эргэн төлөлтийн данс байршиж буй банкны нэр	Эргэн төлөлтийн дансны дугаар
1	Хаан банк	5037639471
2	Хаан банк	5028931114
3	Хас банк	5002164143




YUL ANGRAATAR KOT
OMNI ACCET
LLC
6

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023 -11- 15

БҮРТГЭВ-02



ЗАХИРГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 08-р сарын 23-ны өдөр

“ОМНИ КАПИТАЛ ББСБ” ХХК

болон

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК

Гэрээний дугаар:23/012

УЛААНБААТАР





Энэхүү ЗАХИРГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ (цаашид “Гэрээ” гэх) -г Монгол Улсын Иргэний хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн холбогдох зүйл заалтыг удиртгал болгон сайн дурын үндсэн дээр 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдөр дор дурдсан талууд

Нэг талаас:

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр оффис, 7 давхар, 712 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн 6075657 дугаартай “Омни капитал ББСБ” ХХК (цаашид “Захиргааны үйлчилгээ үзүүлэгч” эсхүл “ББСБ” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал **Ч.ЭРЭЛХЭГ**;

Нөгөө талаас:

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, 11-р хороолол, Н тауэр, 402 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн 8356327 дугаартай “Омни ассет ТЗК” ХХК (цаашид “Үнэт цаас гаргагч” эсхүл “ТЗК” гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга **А.БАТБОЛД** нар


дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Гэрээний зорилго нь Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой Захиргааны үйлчилгээ үзүүлэх ажлыг Захиргааны үйлчилгээ үзүүлэгч хийж гүйцэтгэх, ТЗК нь ажлын хөлсийг төлөхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлоход оршино.

2. ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

- 2.1. Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь дараах үйлчилгээг ТЗК-д үзүүлнэ.
- 2.1.1. ТЗК-ийн Хувьцаа эзэмшигчийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулах;
- 2.1.2. ТЗК-ийн бичиг хэргийн хөтлөлт буюу албан бичиг хүлээж авах, илгээх;
- 2.1.3. ТЗК-ийн мөнгөн хөрөнгөөс шаардлагатай мөнгөн гүйлгээг хийж гүйцэтгэхэд Хөрөнгө итгэмжлэн удирдагч (цаашид “ХИУ” гэх)-д хяналт тавих, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах;
- 2.1.4. ТЗК-ийн нэрийн өмнөөс зээлийн хүүгийн төлбөрийн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтыг зээлдэгчид хүргүүлэх;
- 2.1.5. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ мэдээллийг ХИУ-д тухай бүр хүргүүлэх;
- 2.1.6. ТЗК-ийн олон нийтэд хандсан цахим хуудасны хөгжүүлэлт, хөтлөлтийн ажлыг хариуцах;
- 2.1.7. ТЗК-ийн жилийн үйл ажиллагааны тайлангийн аудитад бэлтгэх, талуудаас баримт бичиг цуглуулж, хөндлөнгийн аудитад хүлээлгэн өгөх, буцаан авах, хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хүлээн авч ТУЗ болон ХИУ-д хүргүүлэх;
- 2.1.8. Жил бүрийн үйл ажиллагааны төсвийн төслийг бэлтгэж ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах;
- 2.1.9. ХБҮЦ-ны хэлцлийн гэрээ болон журамд өөрчлөлт оруулах тохиолдолд тэдгээрийн төслийг бэлтгэн, нэгтгэн баталгаажуулах, ХИУ-д хүлээлгэн өгөх;
- 2.1.10. ХБҮЦ-ны багц дахь зээлийн хөрөнгийн буюу үл хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, дуусгавар болгох ажлыг зохион байгуулах;
- 2.1.11. ТЗК-ийн хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлангийн мэдээллийг нэгтгэж, ХИУ-д хүргүүлэх;
- 2.1.12. Зээлдэгчийн зээлийн үүрэг, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой асуудлаар ТЗК-иас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөх; Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон холбогдох бусад журмаар ТЗК-ийн ТУЗ-ийн эрх хэмжээнд хамааруулсан, ТЗК-ийн байгуулсан гэрээ болон баталсан журмаар зохицуулагдаагүй бусад захиргааны шинжтэй ажлыг гүйцэтгэх.



- 2.2. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээний 2.1-д заасан нөхцөл болон ТЗК, эсхүл түүний дотоод өгсөн бичгээр өгсөн зааварчилгаанд дурдсан нөхцөлийн дагуу үйл ажиллагаа явуулна.
- 2.3. Үйлчилгээ үзүүлэгч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон ТЗК-тай байгуулсан гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ямагт ТЗК болон хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулна.
- 2.4. ТЗК-ийн байгууллагын тэмдэг, улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, Тусгай зөвшөөрөл санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан зэрэг баримт бичгийг Захиргааны үйлчилгээ үзүүлэгч өөрийн ажлын байранд хадгалах бөгөөд аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хадгалах үүргийг хүлээж энэ талаар ХИУ, ТУЗ-д баталгаа гаргана.

3. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

- 3.1 Гэрээгээр үзүүлэх үйлчилгээний хөлсийг сарын 1,500,000.00 (нэг сая таван зуун мянга) төгрөг байхаар талууд харилцан тохиролцов.
- 3.2 Үйлчилгээний хөлсийг Захиргааны үйлчилгээ үзүүлэгчийн нэхэмжлэхэд үндэслэн Капитрон банкны 3096014129 тоот Омни Капитал ББСБ ХХК нэртэй дансанд сар бүрийн 15-нд багтаан, уг өдөр ажлын бус өдөр байвал дараагийн ажлын өдөрт багтаан шилжүүлнэ.
- 3.3 Энэхүү үйлчилгээний хөлсөнд ажиллах хүчний зардал, Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах зардал, материалын зардал, тээвэр, татвар хураамж, дотоодын урсгал зардал болон уг ажлыг хийхэд шаардлагатай бүхий л зардлууд багтсан болно.
- 3.4 Талууд харилцан тохиролцож гэрээний хүрээнд үзүүлэх үйлчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тухайн өөрчлөлт нь ХИУ-ийн үйл ажиллагаанд аливаа хүндрэл үүсгэхгүй байх талаар анхаарна.

4. БАТАЛГАА МЭДЭГДЭЛ

- 4.1. Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээний үүргийг гүйцэтгэх бүрэн чадамжтайгаа илэрхийлэн ТЗК-д дараах баталгааг гаргаж байна. Үүнд:
- 4.1.1. Үйлчилгээг эрхлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон техникийн нөхцөлөөр бүрэн хангагдсан.
- 4.1.2. Байгууллагын зүй зохист удирдлагын зарчим буюу компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрддөг, дотоод дүрэм, журмуудад энэ талаар тусгасан;
- 4.1.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-аар тогтоосон Захиргааны үйлчилгээ үзүүлэгчид тавигдах бусад бүхий л шаардлагыг хангасан болно.
- 4.2. Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон ТЗК-тай байгуулсан гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ямагт ТЗК болон хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулна.

5. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛГОХ

- 5.1. Захиргааны үйлчилгээ үзүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол тусгай зориулалтын компани нь гэрээг цуцалж, шинэ Захиргааны үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулах эрхтэй.
- 5.2. Гэрээг цуцалсан тохиолдолд түүнээс хойш 5 хоногийн дотор дараагийн этгээдийг сонгоно. Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээнд заасан үүргээ шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлнэ.
- 5.3. Үйлчилгээ үзүүлэх гэрээг цуцалсан тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь тусгай зориулалтын компанийн сонгож, гэрээ байгуулсан үйлчилгээ үзүүлэгчид дараах зүйлийг үнэ төлбөргүй шилжүүлнэ:
- 5.3.1. хөрөнгөтэй холбоотой мөнгөн хөрөнгө;
- 5.3.2. нягтлан бодох бүртгэлийн баримт, санхүүгийн тайлан зэрэг бүх материалын эх хувийг цахим хувийн хамт.
- 5.4. Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны улмаас ТЗК болон хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр тэдний өмнө хариуцлага хүлээх бөгөөд бөгөөд ТЗК-тай сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж ажиллана.



6. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 6.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас тухайлбал (дайн, гал түймэр, үер, газар хөдлөлт, ажил хаялт, гоц халдварт өвчин) зэрэг нөхцөл байдал нь гэрээний үүргийн биелэлтэд шууд нөлөөлсөн нотлогдсон бол талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөгдөнө. Энэ үед гэрээний үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 6.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсон ба үүний улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тухайгаа нотлох үүрэг хүлээнэ.
- 6.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн талаар тухайн цаг үед нь нөгөө талдаа мэдэгдээгүй бол ирээдүйд уг нөхцөл байдлыг үндэслэл болгох эрхгүй.

7. НУУЦ МЭДЭЭЛЭЛ

- 7.1. Үнэт цаас гаргах ажиллагаа болон Хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээлэл, хөрөнгийн багц болон түүний зээл, барьцаатай холбоотой зээлдэгч болон шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд, ТЗК, ББСБ-тай холбоотой аливаа мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ хэлцэл, тохиролцоо болон тэдгээрээс авч буй үйлчилгээтэй холбоотой аливаа мэдээлэл, Санхүүгийн нөхцөл байдлын тухай аливаа мэдээлэл, санхүүгийн тайлан, зах зээлийн судалгаа, хуулийн этгээдийн бүртгэл болон үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг, дүрэм журам, заавар, бодлого, гэрээ хэлцэл тэдгээрт заасан нөхцөл, мэдээлэл, тоон үзүүлэлт, зураг график зэргийг нууц мэдээлэлд тооцно.
- 7.2. Дээр дурдсан нууц мэдээлэл гэдэгт нийтэд ил болгосон, эсхүл үнэт цаас гаргах ажиллагааны хүрээнд Үнэт цаасны танилцуулгад тусгаж олон нийтэд танилцуулагдах болон холбогдох хууль журмын дагуу тодорхой этгээдүүдэд танилцуулах мэдээлэл хамаарахгүй болно.
- 7.3. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга, Биржид хүргүүлсэн бичиг баримт, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт зэрэг үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой бүхий л бичиг баримтыг Биржийн бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш арван жилийн хугацаанд хадгална. Үнэт цаас гаргагч татан буугдах үед эрх залгамжлагч, хувьцаа эзэмшигч эсхүл төрийн архивд гэрээний үндсэн дээр шилжүүлэн хадгалуулна.
- 7.4. Талууд хууль тогтоомж төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад нууц мэдээллийг бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр аливаа этгээдэд задруулах хэрэглэх эсвэл өөр бусад зорилгоор ашиглахыг хориглох бөгөөд ийнхүү задруулснаас үүдэн нөгөө талдаа учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

8. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1. Энэхүү гэрээ байгуулагдах үндсэн зорилго болон үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Хөрөнгө оруулагчдын эрх ашиг хамгаалах зорилгоор Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн гэрээний үүргийн зөрчилтэй холбоотойгоос бусад тохиолдолд аливаа байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх шүүх болон холбогдох төрийн байгууллагад гомдол нэхэмжлэл гаргах болон бусад арга хэмжээ авахгүй байх, төлбөр нэхэмжлэхгүй байх үүрэг хүлээнэ.
- 8.2. Талууд хууль болон бусад дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс үүссэн хохирол, төлбөр цуглуулах үйлчилгээтэй холбоотой гарсан аливаа маргааныг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ. Хэрэв зөвшилцөх аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

9. БУСАД ЗҮЙЛ

- 9.1. Энэхүү гэрээг Монгол хэл дээр 4 хувь үйлдэх бөгөөд Захиргааны үйлчилгээ үзүүлэгчид нэг хувь, Үнэт цаас гаргагчид хоёр хувь, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид нэг хувийг тус тус хадгалуулна.
- 9.2. Гэрээг талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.3. Талуудын аль нэг нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа ажлын 5 өдрийн өмнө мэдэгдэх бөгөөд нэмэлт өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулж талууд гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.



9.4. Гэрээний гүйцэтгэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд гэрээний нэгэн адил үйлчилнэ.

МОНГОЛЫН БЛОК ЭХЧИЙН
MONGOLIAN BLOCK EXCHANGE

2023-11-15



ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**“ОМНИ КАПИТАЛ ББСБ” ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

Нэр: Ч.ЭРЭЛХЭГ

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



**“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

Нэр: А.БАТБОЛД

Албан тушаал: ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:





ОГНОО

2023 оны 08 сарын 23-ны өдөр

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК
(“Үнэт цаас гаргагч”)

ба

“ОМНИ КАПИТАЛ ББСБ” ХХК
(“Үйлчилгээ үзүүлэгч”)

ба

“ЮУ ЭЙ ЭФ АССЕТ МЕНЕЖМЕНТ” ХХК
(“Хөрөнгө итгэмжлэн удирдагч”)

ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар:23/014

УЛААНБААТАР ХОТ



Энэхүү Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г дор дурдсан оролцогч талуудын хооронд Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны №360 тоот тогтоолоор батлагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны №2020/06 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журамд заасныг тус тус удирдлага болгон дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.


- (1) **“ОМНИ КАПИТАЛ ББСБ” ХХК**, Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр оффис, 7 давхар, 712 тоот албан ёсны хаягт байрлах 6075657 тоот регистрийн дугаартай хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “**Үйлчилгээ үзүүлэгч**” эсхүл “**ББСБ**” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ч.Эрэлхэг;
- (2) **“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК**, Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 11-р хороолол, Н тауэр, 402 тоот албан ёсны хаягт байрлах **8356327** тоот регистрийн дугаартай хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “**Үнэт цаас гаргагч**”, эсхүл “**ТЗК**” гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга А.Батболд;
- (3) **“ЮУ ЭЙ ЭФ АССЕТ МЕНЕЖМЕНТ” ХХК** Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын төв өргөө 10 давхар, 1005 тоот албан ёсны хаягт байрлах 2870657 тоот регистрийн дугаартай (цаашид “**Хөрөнгө итгэмжлэн удирдагч**” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Х.Маргад-Эрдэнэ.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Гэрээгээр Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас гаргах зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх)-ны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, Зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас уг үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлоход оршино.
- 1.2. Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөр цуглуулах үйл ажиллагаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны №360 тоот тогтоолоор батлагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны №2020/06 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам, ТЗК-ийн “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам”, ТЗК-ийн “Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам”-аар тогтоосон хэм хэмжээг баримтлахаар Талууд хүлээн зөвшөөрсөн болно.
- 1.3. Үнэт цаас гаргагчид Санхүүгийн зохицуулах хорооноос ХБҮЦ бүртгэх зөвшөөрөл олгосноор Үйлчилгээ үзүүлэгч болон Үнэт цаас гаргагч нар нь энэхүү Гэрээнд заасан үүргийг хэрэгжүүлэх үндэслэл бий болно.
- 1.4. Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.4.1. **“Анхны үүрэг гүйцэтгүүлэгч”** гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт тодорхойлсон этгээд буюу Үйлчилгээ үзүүлэгчийг;
 - 1.4.2. **“Зээл”** гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид зээлийн гэрээний дагуу олгосон мөнгөн хөрөнгийг;

2023-11-13

БҮРТГЭВ-02



- 1.4.3. “Зээлдэгч” гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу зээлийг хүүгийн хамт эргүүлэн төлөх мөнгөн төлбөрийн үүрэг хүлээсэн этгээдийг;
- 1.4.4. “Зээлийн эргэн төлөлт” гэж ТЗК-ийн гаргасан ХБҮЦ-ны хөрөнгийн багцад багтсан Зээлийн төлөлт буюу Зээлдэгчээс Зээлийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх мөнгөн төлбөрийг;
- 1.4.5. “Зээлийн данс бүртгэл” гэж Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацаатай нь бүртгэсэн мэдээллийг;
- 1.4.6. “Төлбөр цуглуулах данс” гэж ТЗК-ийн Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журмын 2.2.1 дэх хэсэгт заасны дагуу цуглуулсан төлбөрийг хүлээн авахаар Капитрон банканд тусгайлан нээсэн 3000124051 тоот дансыг;
- 1.4.7. “Багцын эргэн төлөлт” гэж Үйлчилгээ үзүүлэгчээс ТЗК-д Үйлчилгээ үзүүлэх тухай гэрээний дагуу шилжүүлж буй Зээлийн эргэн төлөлтийг;
- 1.4.8. “Үнэт цаас эзэмшигч” гэж Компанийн гаргасан ХБҮЦ-ыг худалдан авч, эзэмшиж буй этгээдийг;
- 1.4.9. “Хөрөнгө” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт заасныг буюу ТЗК-ийн гаргах ХБҮЦ-ны хөрөнгийн багцад багтсан зээлийг.

ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ АЖИЛЛАГАА

- 2.1. Төлбөр цуглуулах үйл ажиллагаа нь төлбөр буюу Зээлийн эргэн төлөлтийг цуглуулах, ТЗК-д Багцын эргэн төлөлтийг шилжүүлэх гэсэн 2 үе шаттай байна.
- 2.2. Багцын эргэн төлөлтийг цуглуулахдаа Зээлийн эргэн төлөлтийн графикийг үндэслэх бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК-д энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр багц дахь зээлүүдийн эргэн төлөлтийн хуваарийг гаргаж өгнө.
- 2.3. Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК-ийн хөрөнгийн багцыг бүрдүүлж буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс буюу Зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулна. Үйлчилгээ үзүүлэгч нь хуримтлагдсан Зээлийн эргэн төлөлт болох Багцын эргэн төлөлтийг дараа сарын 05-ны өдрийн дотор Төлбөр цуглуулах дансанд шилжүүлнэ. Хэрэв Багцын эргэн төлөлтийг шилжүүлэх өдөр нь амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдрийн дотор шилжүүлнэ.
- 2.4. Зээлийн эргэн төлөлтийн данс, түүний мөнгөн хөрөнгийг Үнэт цаас гаргагч болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нар нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчид бие даасан гэрээний дагуу барьцаалуулна.
- 2.5. Үйлчилгээ үзүүлэгч нь Багцын эргэн төлөлтийн төлбөрийг шилжүүлэхдээ энэхүү Гэрээний 3.2-д заасны дагуу үйлчилгээний хөлсийг хасаж тооцон, төлбөрийг шилжүүлэх ба ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын 2.4.1-д заасан үндэслэлээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хөрөнгийн багцыг хуулийн шаардлагад нийцүүлэн нэмэгдүүлж, авлага үүсгэсэн тохиолдолд уг авлагыг хасаж, үлдэгдлийг тооцон дараа сарын төлбөрт шилжүүлнэ.
- 2.6. Гэрээний 2.5-д заасны дагуу шилжүүлэг хийхэд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журмыг баримтална.
- 2.7. Үйлчилгээ үзүүлэгч нь шилжүүлсэн Багцын эргэн төлөлтийг тооцоолсон Зээлийн данс бүртгэлийг тухай бүр хөтөлж, зээлийн болон төлбөрийн мэдээллийг дараа сарын ажлын 3 хоногт багтаан ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлнэ.
- 2.8. Холбогдох данс, бүртгэлд зөрүү гарсан бол зөрүүг илрүүлсэн өдрөөс хойш ажлын 1 өдрийн дотор Үйлчилгээ үзүүлэгч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай тооцоо нийлж, алдааг засах арга хэмжээ авна.
- 2.9. Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн данс бүртгэлийн тайланг сар бүрийн сүүлд нэгтгэн гаргаж, дараагийн сар эхэлснээс хойш ажлын 3 өдрийн дотор Үнэт цаас гаргагч болон хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлнэ.



- 2.10. Үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай харилцах албан тушаалтныг томилон ажиллуулна.
- 2.11. Хөрөнгийн багцтай холбоотой баримт бичиг, мэдээллийг Үйлчилгээ үзүүлэгч хадгална.
- 2.12. Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлүүдтэй холбоотой мэдээллийг хадгалах программ хангамжтай байна.
- 2.13. ТЗК нь дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:
- 2.13.1. ТЗК нь Төлбөр цуглуулах дансыг харилцагч банкинд нээлгэж, Багцын эргэн төлөлтийг хүлээн авахтай холбоотой бэлтгэл ажлыг хангах;
 - 2.13.2. Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээний дагуу Багцын эргэн төлөлтийг хүлээн авах;
 - 2.13.3. Энэхүү гэрээний 3.1-д заасан үйлчилгээний хөлсийг төлөх;
 - 2.13.4. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүгээр дамжуулан Үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих болон үйл ажиллагааны нөхцөлийг бичгээр зааварчлан чиглүүлэх чиг үүрэгтэйгээр оролцох;
 - 2.13.5. Хууль тогтоомжид заасан бусад.
- 2.14. Үйлчилгээ үзүүлэгч нь дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:
- 2.14.1. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү Гэрээний нөхцөл болон ТЗК, эсхүл Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас түүнд бичгээр өгсөн зааварчилгаанд дурдсан нөхцөлийн дагуу үйлчилгээг үзүүлнэ;
 - 2.14.2. Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгийн багцад багтсан зээлийн Зээлдэгч, үүрэг гүйцэтгэгч нартай харилцах, төлбөр цуглуулах, зээл төлүүлэх арга хэмжээг өөрийн холбогдох Зээлийн эрсдэлийг удирдах журамд заасны дагуу хэрэгжүүлэх, зээлдэгчийн өмнө ТЗК-г төлөөлж, зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд ТЗК-д шилжүүлэх, бүртгэх, тайлагнах;
 - 2.14.3. Зээлдэгчийн хүсэлтийн дагуу Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулсан бол Үйлчилгээ үзүүлэгч нь энэ талаарх мэдээллийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан өдөрт багтааж мэдэгдэнэ. Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноор Хөрөнгөд багтсан Зээлийн багцын шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон тохиолдолд ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу арга хэмжээ авна;
 - 2.14.4. Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгийн багцад багтсан зээлийн мэдээллийг хадгалах, ТЗК, Хөрөнгө итгэмжлэгдсэн удирдагчийн хууль ёсны шаардлагаар ТЗК-тай холбоотой аливаа дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, мэдээллээр хангах, өөрийн гаргасан дүгнэлтийг холбогдох баримтыг бүрэн судалж, зохих стандартын дагуу үйл ажиллагаа явуулж, гаргасан дүгнэлтийн хариуцлагыг бие даан хариуцна;
 - 2.14.5. Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ТЗК болон Үнэт цаас эзэмшигчдэд хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр тэдний өмнө хариуцлага хүлээнэ;
 - 2.14.6. ТЗК-ийн нэрийн өмнөөс зээлийн хүүгийн төлбөрийн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтыг Зээлдэгчид хүргүүлнэ;
 - 2.14.7. Хууль тогтоомжид заасан бусад.
- 2.15. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:
- 2.15.1. Багцын эргэн төлөлтийг хянана;
 - 2.15.2. ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгчтэй харилцах ажилтныг томилох бөгөөд түүнтэй холбоо барих мэдээлэл, түүний эрх, үүрэг болон бусад шаардлагатай мэдээллийг ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлнэ.

2023-11-15

БҮРТГЭВ


ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС



- 3.1. Энэхүү Гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгчид сар бүр төлөх үйлчилгээний хөлс нь Зээлдэгчээс Зээлийн эргэн төлөлтийг цуглуулан, ТЗК-д шилжүүлсэн Зээлийн эргэн төлөлтийн дүнгийн 2.5 хувьтай тэнцүү байхаар талууд тохиролцов.
- 3.2. Энэ Гэрээний дагуу тухайн сард гүйцэтгэсэн үйлчилгээний хөлсийг Үйлчилгээ үзүүлэгч болон ТЗК нарын үйлдсэн тооцоо нийлсэн актад үндэслэн дараа сарын 05-ны өдөрт багтаан ТЗК-д шилжүүлэх Багцын эргэн төлөлтийн дүнгээс суутган, үлдэгдэл төлбөрийг ТЗК-д шилжүүлнэ. ТЗК нь ийнхүү үйлчилгээний хөлсийг суутган авах зөвшөөрлийг энэхүү Гэрээгээр олгосон болно.
- 3.3. Энэхүү үйлчилгээний хөлсөнд Үйлчилгээ үзүүлэгчийн зээлийн төлбөр цуглуулахтай холбоотой ажиллах хүчний зардал, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах зардал, материалын зардал, тээвэр, татвар хураамж, дотоодын урсгал зардал, зээлтэй холбоотой зээлийн хяналт, маргаан, түүнийг шийдвэрлэх явцын зардал, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон бусад ажлыг хийхэд шаардлагатай бүхий л зардлууд багтсан болно.
- 3.4. Зайлшгүй шаардлагаар гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээний хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Төлбөрийг Үнэт цаас эзэмшигчдэд төлөхөд хүндрэл үүсгэхээр нэмэлт, өөрчлөлтийг энэхүү Гэрээнд оруулахыг хориглоно.

ДӨРӨВ. БАТАЛГАА МЭДЭГДЭЛ

- 4.1. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү Гэрээний үүргийг гүйцэтгэх бүрэн чадамжтайгаа илэрхийлэн ТЗК-д дараах баталгааг гаргаж байна. Үүнд:
 - 4.1.1. Банк, санхүүгийн зах зээлд тасралтгүй 3-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай байна;
 - 4.1.2. Үйлчилгээг эрхлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр бүрэн хангагдсан;
 - 4.1.3. Хорооноос баталсан компанийн засаглалын кодексыг үйл ажиллагаандаа мөрдөж, холбогдох дүрэм, журамдаа энэ талаар тусгасан байна;
 - 4.1.4. 3-аас доошгүй ТУЗ-ийн гишүүнтэй, тэдгээрийн 1/3 нь хараат бус гишүүн байх, тэдгээрийн болон компанийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй тайлагнадаг байна;
 - 4.1.5. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай зэрэг хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг буюу явуулна;
 - 4.1.6. ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ТЗК-д үйлчилгээ үзүүлж буй хоёроос доошгүй мэргэжилтнүүд нь санхүүгийн зах зээл дээр тасралтгүй 1 ба түүнээс дээш жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай;
 - 4.1.7. Хувь нийлүүлсэн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр бүрдүүлсэн бөгөөд түүний доод хэмжээ нь СЗХ-оос тогтоосон хэмжээг хангасан;
 - 4.1.8. Тусгай зөвшөөрөлттэй этгээд бол төрийн эрх бүхий байгууллагаас баталсан зохистой харьцааны шалгуурыг хангаж ажилласан, засаглал, мэдээлэл тайлагналын ил тод байдлыг хангасан;
 - 4.1.9. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-аар тогтоосон Үйлчилгээ үзүүлэгчид тавигдах бусад бүхий л шаардлагыг хангасан болно.
- 4.2. Үйлчилгээ үзүүлэгч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон ТЗК-тай байгуулсан гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ямагт ТЗК болон хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулна.



ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛГОХ



- 2023-11-15
БҮРТГЭВ
- 5.1. Энэхүү Гэрээг талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос ХБҮЦ-ыг бүртгэх зөвшөөрөл олгосноор хүчин төгөлдөр болно.
 - 5.2. Энэхүү Гэрээ нь Гэрээний 5.1-д заасны дагуу хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дуусгавар болох хүртэл буюу ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дуусган, Үнэт цаас гаргагчийг татан буугдах өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.
 - 5.3. Үйлчилгээ үзүүлэгч уг Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор, бүрэн гүйцэтгээгүй бол ТЗК нь Гэрээг цуцалж, шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулах эрхтэй.
 - 5.4. Гэрээг цуцалсан тохиолдолд түүнээс хойш 5 хоногийн дотор дараагийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгоно. Шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд Үйлчилгээ үзүүлэгч Төлбөр цуглуулах үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх үүрэгтэй ба ТЗК-аас нэмэлт төлбөр шаардах эрхгүй байна.

ЗУРГАА. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 6.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал (дайн, гал түймэр, үер, газар хөдлөлт, ажил хаялт, гоц халдварт өвчин зэрэг) нь гэрээний үүргийн биелэлтэд шууд нөлөөлсөн нь нотлогдсон бол талууд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөгдөнө. Энэ үед гэрээний үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдсонд тооцно.
- 6.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэж, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тухайгаа нотлох үүрэг хүлээнэ.
- 6.3 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн талаар тухайн цаг үед нь нөгөө талдаа мэдэгдээгүй бол ирээдүйд уг нөхцөл байдлыг үндэслэл болгох эрхгүй.

ДОЛОО. НУУЦ МЭДЭЭЛЭЛ

- 7.1 ХБҮЦ гаргах ажиллагаа, Хөрөнгийн багц болон түүний зээл, барьцаатай холбоотой Зээлдэгч болон шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээдтэй холбоотой аливаа мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцэл, тохиролцоо болон тэдгээрээс авч буй үйлчилгээтэй холбоотой аливаа мэдээлэл, Үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн нөхцөл байдлын тухай аливаа мэдээлэл, санхүүгийн тайлан, зах зээлийн судалгаа, журам, заавар, бодлого, гэрээ хэлцэл эдгээрт заасан нөхцөл, мэдээлэл, тоон үзүүлэлт, зураг график зэргийг нууц мэдээлэлд тооцно.
- 7.2 Дээр дурдсан нууц мэдээлэл гэдэгт нийтэд ил болсон, эсхүл ХБҮЦ гаргах ажиллагааны хүрээнд Үнэт цаасны танилцуулгад тусгагдаж олон нийтэд танилцуулсан мэдээлэл хамаарахгүй болно.
- 7.3 Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга, Биржид хүргүүлсэн бичиг баримт, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт зэрэг үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой бүхий л бичиг баримтыг Биржийн бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш арван жилийн хугацаанд хадгална. Үнэт цаас гаргагч татан буугдах үед эрх залгамжлагч, хувьцаа эзэмшигч эсхүл төрийн архивд гэрээний үндсэн дээр шилжүүлэн хадгалуулна.
- 7.4 Талууд хууль тогтоомжийн дагуу төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан шаардсанаас

бусад тохиолдолд нууц мэдээллийг бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр аливаа этгээдэд задруулах, эсвэл өөр бусад зорилгоор ашиглахыг хориглох бөгөөд ийнхүү задруулснаас үүдэн нөгөө талдаа учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1 Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагч энэ гэрээний үүргээ зөрчсөнөөс бусад тохиолдолд аливаа байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх шүүх, арбитр болон төрийн байгууллагад гомдол, нэхэмжлэл гаргах болон бусад арга хэмжээ авахгүй байх, төлбөр нэхэмжлэхгүй байх үүрэг хүлээнэ.
- 8.2 Энэ гэрээтэй холбостой аливаа маргааныг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ. Хэрэв зөвшилцөх аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1. Энэхүү Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд талууд Гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.
- 9.2. Гэрээ, түүнд холбогдох баримт бичиг нь Монгол хэл дээр байна.
- 9.3. Энэхүү Гэрээг ойлгох, тайлбарлах, хэрэглэхдээ Монгол Улсын хууль тогтоомжийг баримтална.
- 9.4. Талуудын аль нэг нь гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдэх бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.5. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг бөгөөд гэрээний нэгэн адил үйлчилнэ.
- 9.6. Гэрээг дөрвөн хувь үйлдэх бөгөөд эдгээр нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нэг хувь, Үнэт цаас гаргагч хоёр хувь, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид нэг хувийг тус тус хадгална. Холбогдох хуулийн дагуу энэхүү Гэрээний аливаа заалт хууль бус, хүчингүй, хэрэгжүүлэх боломжгүйд тооцогдвол Гэрээний бусад заалтад нөлөөлөхгүй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ:

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:

ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН
УДИРДАГЧ:

“ОМНИ КАПИТАЛ БЕСБ” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ч.ЭРЭЛХЭГ

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК
ТУЗ-ИЙН ДАРГА
А.БАТБОЛД

“ЮУ ЭЙ ЭФ АССЕТ
МЕНЕЖМЕНТ” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Х.МАРГАД-ЭРДЭНЭ



Handwritten signature



2023-11-15

БҮРТГЭЛИЙН



“ОМНИ АССЕТ” ХХК

“ОМНИ АССЕТ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ШИЙДВЭР

Оролцогч талуудыг батлах тухай

2023 оны 05 сарын 04-ны өдөр

№ ХЭХ-23/002

Улаанбаатар хот

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11.4, 20 дугаар зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Омни ассет” ХХК-аас Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангах зорилгоор оролцогч талуудаар дараах байгууллагуудыг сонгож, гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.
 - a. Зээлийн багцын шинжилгээ гаргагчаар “Шонхор үнэлгээ аудит” ХХК
 - b. Андеррейтераар “Апекс капитал ҮЦК” ХХК
 - c. Хуулийн дүгнэлт гаргагчаар “ХаанЛекс Партнерс” ХХН
2. “Омни ассет” ХХК-ийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Ч.Даваасүрэн/-д олгосугай.

“ОМНИ АССЕТ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ
“ОМНИ КАПИТАЛ ББСБ” ХХК-ИЙН ТУЗ-ИЙН ДАРГА ХХК Э.ПҮРЭВСҮРЭН



2023-11-15

БҮРТГЭВ-02



АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 5-р сарын 11-ний өдөр

“ОМНИ КАПИТАЛ БЭСБ” ХХК
(Үүсгэн байгуулагч)

“ОМНИ АССЕТ” ХХК
(Үнэт цаас гаргагч)

Болон

“АПЕКС КАПИТАЛ ҮЦК” ХХК
(Андеррайтер)

Гэрээний дугаар: 06/АРК/23/...*21/003*

06/АРК/23/31

Үйлчлүүлэгч



1

Андеррайтер



ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

1. НЭР ТОМЬЁО.....	5
2. ТАЛУУДЫН ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ.....	5
3. ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ.....	6
4. ҮЙЧЛҮҮЛЭГИЙН ЭРХ, ҮҮРЭГ.....	7
5. АНДЕРРАЙТЕРИЙН ЭРХ, ҮҮРЭГ.....	8
6. ТӨЛБӨР, ЗАРДАЛ.....	9
7. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛОХ.....	10
8. ХАРИУЦЛАГА.....	10
9. НУУЦ ХАДГАЛАХ, ДОТООД МЭДЭЭЛЭЛ.....	11
10. БУСАД.....	11

Үйлчлүүлэгч



2

Андеррайтер





**НЭГ ТАЛААС
ҮЙЛЧЛҮҮЭЛГЧ:**

"ОМНИ КАПИТАЛ БЭСБ" ХХК (цаашид "Үүсгэн байгуулагч" гэх), Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр оффис, 712 тоот хаягт байрладаг, 6075657 регистрийн дугаартай, 9015003126 бүртгэлийн дугаартай, Монгол Улсад бүртгэлтэй компанийг төлөөлж, Гүйцэтгэх захирал албан тушаалтай Ч.Эрэлхэг

"ОМНИ АССЕТ" ХХК (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх), Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, N тауэр оффис, 402 тоот хаягт байрладаг 8356327 регистрийн дугаартай, 9011851823 бүртгэлийн дугаартай, Монгол Улсад бүртгэлтэй компанийг төлөөлж, Гүйцэтгэх захирал албан тушаалтай Ч.Даваасүрэн

**ГУРАВДАГЧ ТАЛААС
АНДЕРРАЙТЕР:**

"АПЕКС КАПИТАЛ ҮЦК" ХХК (цаашид "Андеррайтер" гэх), Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-4, Нью Хоризонс оффис, 901 тоот хаягт байрладаг, 5453283 тоот регистрийн дугаартай Монгол улсад бүртгэлтэй компани, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал албан тушаалтай Б.Лхамдолгор;

ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Талууд дараах гэрээний ерөнхий нөхцөлүүдийг харилцан тохиролцов.

1. Гэрээний зорилго нь Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан тусгай зориулалтын компанийн зөвшөөрөл авч, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах, Андеррайтер нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад шаардлагатай судалгаа шинжилгээ хийх, үнэт цаасыг олон нийтэд нээлттэй санал болгох ажлыг удирдан зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
2. Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ үнэнч шударгаар биелүүлж, үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, харилцан бие биенийхээ ашиг сонирхлыг хүндэтгэх, гэрээгээр тохиролцсон анхны тохиролцоог тууштай хадгалах, шуурхай, бүтээлчээр хамтран ажиллана.
3. Үнэт цаас гаргагчийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжаалахад шаардлагатай судалгаа шинжилгээ хийх, танилцуулга бэлдэх Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс холбогдох зөвшөөрөл авах, стратегийн хөрөнгө оруулагч, мэргэжлийн хөрөнгө оруулагч болон олон нийтэд танилцуулах замаар үнэт цаасыг худалдан борлуулах Андеррайтерийн үйлчилгээ үзүүлнэ.
4. Талууд хамтран ажиллахдаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржийн журам зааврыг дагаж мөрдөх ба гэрээгээр зохицуулаагүй бусад асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.
5. Энэ гэрээний үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд Талууд өөрөөс шалтгаалах бүхий л хүчин чармайлтыг гаргаж ажиллана.

Үйлчлүүлэгч

3



6. Гэрээнд Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар гэрээг байгуулж, Андеррайтерийн үйлчилгээ, үйл ажиллагаа эхэлсэнд тооцно.
7. Гэрээг 6 сарын хугацаатай байгуулах ба Гэрээний 3.1-т заасан ажиллагааг бүрэн гүйцэтгэснээр дуусгавар болно. Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржийн зөвшөөрөл төлөвлөсөн хугацаанаас хоцорч гарах, Үнэт цаас гаргагчаас хугацаа хоцрох зэрэг Андеррайтерийн үйл ажиллагаанаас хамаарахгүй хүчин зүйлийн шалтгаанаар хойшилсон тохиолдолд энэхүү зүйлд заасан хугацаа хамаарахгүй.

Үйлчлүүлэгч



4

Андеррайтер





Талууд энэхүү гэрээний ерөнхий нөхцөлд заасан харилцан тохиролцоог гүйцэтгэхдээ гэрээний тусгай нөхцөлд зааснаар хамтран ажиллана.

1. Нэр томьёо

- 1.1. “ТЗК” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасан тусгай зөвшөөрөл бүхий хязгаарлагдмал хариуцлагатай компанийг ойлгоно;
- 1.2. “ХБҮЦ” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д зааснаар тодорхойлох ба энэхүү гэрээнд дурдагдах хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төрөл нь баталгаат үнэт цаас байна.
- 1.3. “Үйлчлүүлэгч” гэж Үүсгэн байгуулагч болон Үнэт цаас гаргагч нарыг хамтад гэж ойлгоно.
- 1.4. “Үнэт цаас гаргагч” гэж нийтэд санал болгон хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахаар СЗХ-д бүртгүүлэх хүсэлт гаргаж буй хуулийн этгээдийг;
- 1.5. “Хөрөнгө оруулагч” гэж МХБ-ээр дамжуулан арилжаалах үнэт цаас худалдан авагч иргэн, хуулийн этгээд буюу Үйлчлүүлэгчийн ТЗК-ийн олон нийтэд санал болгон гаргасан ХБҮЦ-г эзэмшигч этгээдийг;
- 1.6. “Андеррайтерийн үйл ажиллагаа” гэж энэхүү гэрээний 3.1-д заасан андеррайтерийн гүйцэтгэх ажлыг;
- 1.7. “Нууц мэдээлэл” гэж Талууд хоорондоо солилцсон аливаа төрлийн нийтэд ил болоогүй мэдээлэл, ноу-хау, бизнесийн чухал мэдээлэл, төлөвлөгөө, харилцагчийн мэдээлэл, санхүүгийн мэдээлэл зэрэг баримт бичиг, мэдээлэл байх ба нууц гэсэн сануулгатай мэдээллийг;
- 1.8. “Анхдагч зах зээлийн арилжааг амжилттай хэрэгжүүлэх” гэж анхдагч зах зээл дээрээс татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийг амжилттай бүрдүүлэх;
- 1.9. “СЗХ” гэж Санхүүгийн Зохицуулах Хороог;
- 1.10. “МХБ” гэж олон нийтэд шинээр санал болгох үнэт цаасыг гаргах бирж болох Монголын Хөрөнгийн Биржийг;
- 1.11. “ҮЦТХТ” гэж “Үнэт цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-ийг;
- 1.12. “Эрх бүхий этгээд” гэж СЗХ, МХБ, ҮЦТХТ зэрэг нээлттэй зах зээлд ХБҮЦ гарган арилжаалахтай холбоотой ажилд зохицуулагчийн үүрэгтэй оролцож байгаа болон бусад төрийн эрх бүхий байгууллагыг тус тус ойлгоно;
- 1.13. “Үнэт цаасны танилцуулга” гэж үнэт цаасны захиалга авах, худалдах зорилгоор үнэт цаас гаргагч болон Андеррайтерийн зүгээс холбогдох хууль, тогтоомжид заасан журмын дагуу Хороо, Биржид үнэт цаасыг бүртгүүлэх, Хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг агуулсан танилцуулга, баримт бичгийн иж бүрдлийг.

2. Талуудын харилцан хүлээх нийтлэг эрх, үүрэг

- 2.1. Талууд хамтран ажиллахдаа Талуудын бизнесийн нэр хүнд, хууль ёсны эрх ашгийг харилцан хүндэтгэнэ.
- 2.2. Талууд хамтын ажиллагаандаа хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг нэн тэргүүнд чухалчлан үзнэ.
- 2.3. Талууд нийтэд санал болгон гаргах ХБҮЦ-ны хүүгийн хэмжээг танилцуулга бэлтгэх үеийн зах зээл, бодлогын хүүгийн түвшин зэрэг хамааралтай нөхцөл байдлыг судалсаны үндсэн дээр тодорхойлно.
- 2.4. Талууд энэ гэрээний дагуу ажлыг гүйцэтгэх явцад компанийг төлөөлөн оролцох эрх бүхий ажилтныг томилох бөгөөд дараах этгээдүүд байна.

Үйлчлүүлэгч

5

Андеррайтер

Үйлчлүүлэгч:

1. Нэр: Г.Ууганбаяр
Албан тушаал: Хөрөнгө оруулалтын газрын захирал
Утас: 99908733
Имэйл: uuganbayar@omnicapital.mn
2. Нэр: П.Урангоо
Албан тушаал: Хуулийн зөвлөх
Утас: 89149328
Имэйл: urangoo@omnicapital.mn

Андеррайтер:

2. Б.Батбаяр
Албан тушаал: Санхүүгийн шинжээч
Утас: 89241236
Имэйл: bbatbayar@apex.mn
2. П.Сэлэнгэ
Албан тушаал: Хуульч
Утас: 89118684
Имэйл: selenge@apex.mn

- 2.5. Талууд нээлттэй санал болгох үнэт цаасыг олон нийтэд сурталчлах, худалдан борлуулах үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө оруулагчдад зайлшгүй хүргэх шаардлагатай мэдээллээс бусад бизнесийн болон байгууллагын нууцад хамаарах мэдээллийн нууцыг чандлан хадгалах үүрэгтэй.
- 2.6. Үнэт цаасыг харилцагчаас ирүүлсэн мэдээлэл, бусад хараат бус мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн боловсруулсан, эрх бүхий байгууллагаас олон нийтэд нээлттэй санал болгох зөвшөөрөл олгосон танилцуулгад тусгагдсан мэдээллийн дагуу олон нийтэд сурталчлан худалдан борлуулна.

3. Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ

3.1. Андеррайтер нь энэхүү гэрээний хүрээнд Үнэт цаас гаргагч компанид дараах ажил үйлчилгээг гүйцэтгэж өгнө.

3.1.1. **Бэлтгэл үе шат**

- 1) Үйлчлүүлэгчээс ирүүлсэн мэдээллийн үндсэн дээр судалгаа шинжилгээ хийх;
- 2) ХБҮЦ гаргах ажлын төлөвлөгөө боловсруулахад хамтран ажиллах;
- 3) Баталгаат үнэт цаасны хүүгийн хэмжээ, төлөлтийн хуваарийг гаргахад санал гаргах;
- 4) Баталгаат үнэт цаас гаргахад шаардлагатай судалгаа, шинжилгээ хийж, үнэт цаасны танилцуулга бэлдэх;
- 5) Андеррайтер нь үнэт цаас гаргагчтай тохиролцсоны үндсэн дээр нийтэд санал болгон гаргах ХБҮЦ-ыг анхдагч зах зээлд байршуулах, захиалга бүрдүүлэх аргачлалын талаар Үйлчлүүлэгчтэй хамтран тогтооно;
- 6) Андеррайтер нь нийтэд санал болгон ХБҮЦ бүртгүүлэхэд үнэт цаасны танилцуулга бэлтгэх, хууль, аудитын үйлчилгээ үзүүлэгчийн дүгнэлт, бусад шаардагдах баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллана;
- 7) ХБҮЦ-ийг олон нийтэд санал болгон гаргахад Хороо болон Биржид бүртгүүлэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах ажиллагааг зохион байгуулна.

3.1.2. **Хөрөнгө оруулагчдад**

- 1) Үйлчлүүлэгчийн үнэт цаасыг олон нийтэд сурталчлах маркетингийн төлөвлөгөөг боловсруулахад хамтран ажиллах, өөрийн сувгаар сурталчлах, шаардлагатай

Үйлчлүүлэгч

6

Андеррайтер



танилцуулга, видео контент болон бусад олон нийтийн сурталчилгааны материал бэлтгэхэд санал гаргах, түгээх, компанийн бренд, олон нийтэд хандсан PR (public relation)-д стратегийн түвшинд энэхүү хэсэгт заасан байдлаар хамтран ажиллах;

- 2) Үйлчлүүлэгчтэй хамтарсан маркетингийн төлөвлөгөө боловсруулан батлах;
- 3) Баталсан төлөвлөгөөний дагуу маркетингийн ажлын зохион байгуулалтад хамтран оролцох;
- 4) Үйлчлүүлэгчээс ирсэн мэдээллийн хүрээнд хөрөнгө оруулагч, харилцагч нарт үнэт цаас санал болгон хөрөнгө оруулагчидтай биечлэн, онлайн хэлбэрээр уулзалт хийх;
- 5) Олон нийтэд танилцуулах ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнөх хугацаанд стратегийн хөрөнгө оруулагч болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад танилцуулах;
- 6) Маркетинг сурталчилгаанд Үйлчлүүлэгчтэй хамтарсан төлөвлөгөөний дагуу дараах байдлаар хамтран ажиллах.
 - a. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэт цаасны талаар тайлбар, мэдээлэл өгөхөд хамтран оролцох;
 - b. Үнэт цаас гаргагч нь өөрийн бэлтгэн боловсруулсан хэвлэмэл материал, постер, видео контент, сурталчилгааны самбарт Андеррайтерийн логог байршуулах;
 - c. Road show-ны үеэр зохион байгуулагдах олон нийтийн арга хэмжээ, сошиалаар түгээх подкаст, ярилцлагад хамтран оролцох;
 - d. Бусад.

3.1.3. Үнэт цаас борлуулах

- 1) Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн Хороонд бүртгэгдсэн үнэт цаасны танилцуулгад тусгасан арга хэлбэрээр нийтэд санал болгон анхдагч зах зээлд арилжаална.
- 2) Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны дансыг Андеррайтераар дамжуулан нээлгэх ба үнэт цаасны нийлүүлэлтийг Андеррайтераар дамжуулан гүйцэтгэнэ.
- 3) Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах ХБҮЦ-ыг анхдагч зах зээлд санал болгож, байршуулах төлөвлөгөөг хамтран боловсруулсны үндсэн дээр анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах, анхдагч зах зээлийн арилжааны тайланг Эрх бүхий этгээдүүдэд хүргүүлэх, Эрх бүхий этгээдийн зөвшөөрлийн дагуу хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх.

4. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

4.1. Үйлчлүүлэгчийн эрх

- 4.1.1. Андеррайтерийн үйл ажиллагааны явцын талаар бүрэн мэдээлэл авч, үйлчилгээний явц, үр дүнд өөрийн зүгээс тайлбар санал өгөх;

Үйлчлүүлэгч

7

Андеррайтер



2023
4.1.2. Гэрээний зорилгыг амжилтад хүргэхийн тулд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхийг шаардах, заавар зөвлөгөө, чиглэлийг хүргүүлэх, биелүүлэхийг шаардах;

4.1.3. Андеррайтерийн үйлчилгээний явц, үр дүн, тайланг тухай бүр хүлээн авч, шаардлагатай тохиолдолд хурал, уулзалтыг зохион байгуулах;

4.2. Үйлчлүүлэгчийн үүрэг

4.2.1. Үйлчлүүлэгч нь үйл ажиллагаа, үйлчилгээ, санхүүгийн нөхцөл байдал, бусадтай байгуулсан гэрээ хэлцэл болон бусад бодит байдлын талаар Андеррайтерт үнэн зөв мэдээлэх үүрэг хүлээнэ. Үүнд:

(i) Бизнес төлөвлөгөө, үр ашгийн тооцоо;

(ii) Үйл ажиллагаа явуулах зах зээлийн мэдээлэл, тоо баримт;

(iii) Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын талаар мэдээлэл;

(iv) Толгой компани болон зэргэлдээ компаниудын талаарх мэдээлэл;

(v) Үнэт цаас гаргахтай холбоотой гарсан шийдвэр, тогтоол;

(vi) Үнэт цаасны танилцуулгад тусгах шаардлагатай Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан мэдээлэл;

(vii) Энэхүү гэрээнд зааснаар хязгаарлагдахгүйгээр хууль болон Хороо, Биржийн журамд заасан бусад.

4.2.2. Үнэт цаас гаргагч нь ХБҮЦ гаргах үйл ажиллагаа түүний явцын талаар тухай бүр андеррайтерийг мэдээллээр хангах.

4.2.3. Үнэт цаасыг нийтэд санал болгох үйлчилгээг үзүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг бэлтгэн, төлөвлөгөөний дагуу Андеррайтертай хамтран ажиллана.

4.2.4. Үйлчлүүлэгч нь үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээ, мэдээллийн үнэн зөвийг хариуцах ба уг мэдээллийн үнэн бодит байдалтай нийцээгүйгээс үүдсэн аливаа хохирлыг хариуцна.

4.2.5. Үйлчлүүлэгч нь Андеррайтерийн ажлын хөлсийг Гэрээнд заасан хугацаанд шилжүүлэх үүрэгтэй.

4.2.6. Үйлчлүүлэгч нь Андеррайтертай Үнэт цаасыг олон нийтэд санал болгохоор Маркетинг сурталчилгаанд хамтран ажиллаж, холбогдох зардлыг хариуцна.

4.2.7. Үнэт цаасыг олон нийтэд санал болгохтой холбоотой гуравдагч этгээдэд төлөх аливаа зардал болон үнэт цаасыг анхдагч зах зээлд нийлүүлэх арилжааны төлбөрийг тухай бүр төлөх үүрэгтэй.

5. Андеррайтерийн эрх, үүрэг

5.1. Андеррайтерийн эрх

5.1.1. Андеррайтер нь Гэрээний 3.1-т заасан үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.

5.1.2. Андеррайтер нь Үйлчлүүлэгчийн үүсгэн байгуулсан ТЗК-ийн ХБҮЦ-г нийтэд санал болгон түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах буюу Андеррайтерийн "Best effort" хэлбэрээр ажиллана.

5.1.3. Гэрээт ажлын асуудлаар Үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулсан аудит, үнэлгээний болон бусад хөндлөнгийн байгууллага, хуулийн зөвлөх байгууллагын дүгнэлт, бичиг баримтын бүрдэлд хяналт тавьж, ажлын явцад санал өгч, тэдгээрээс шаардлагатай баримт мэдээллийг шаардах эрхтэй.

5.1.4. Үйлчлүүлэгчээс шаардлагатай мэдээ, мэдээллийг үнэн зөвөөр гаргаж өгөхийг шаардах;

5.1.5. Гэрээнд заасан бусад.

Үйлчлүүлэгч

8

Андеррайтер

5.2. Андеррайтерийн үүрэг

2023

БҮРТГЭВЭР



- 5.2.1. Анхдагч зах зээлийн арилжааны нийлүүлэлтийг гүйцэтгэнэ.
- 5.2.2. Андеррайтер нь бэлтгэсэн контентийг өөрийн холбогдох сувгаар олон нийтэд сурталчлахтай холбоотой зардлыг хариуцна. Энэхүү контент нь хамтарсан маркетингийн төлөвлөгөөнд тусгагдаагүй буюу андеррайтерийн өөрийн бэлтгэсэн контентийг ойлгоно.
- 5.2.3. Гэрээт ажлын асуудлаар Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгч буй аудит, үнэлгээний болон бусад хөндлөнгийн байгууллага, хуулийн зөвлөх байгууллагатай хамтран ажиллаж, шаардлагатай арга хэмжээг шуурхай шийдвэрлэх, зөвлөмж санал өгч ажиллана.
- 5.2.4. Андеррайтер нь гэрээний 3.1-т заасан үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.
- 5.2.5. Энэхүү гэрээнд заасан андеррайтерийн төлбөр, шимтгэлийг шаардах эрхтэй.
- 5.2.6. Гадаад, дотоодын боломжит хөрөнгө оруулагчдыг тодорхойлох, тэдгээрээс хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх, Үнэт цаас гаргагчийг төлөөлөн танилцуулга хийх, санал тавих, уулзалт зохион байгуулах, зуучлах, хөрөнгө оруулагчидтай хэлцэл хийхэд болон гэрээ байгуулахад зуучлах, хамтран ажиллах.
- 5.2.7. Андеррайтер нь гэрээнд заасан үйл ажиллагаатай холбогдуулан Үйлчлүүлэгчид мэргэжлийн зөвлөгөө өгч, Үнэт цаасны танилцуулга бэлтгэх, холбогдох журам, заавар боловсруулах, шийдвэр гаргахад энэхүү гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.
- 5.2.8. Үйлчлүүлэгчийн үүсгэн байгуулах ТЗК-ийн үнэт цаасны данс нээх, ХБҮЦ-г байршуулах ажлыг зохион байгуулах зэргээр брокерийн үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- 5.2.9. Андеррайтер нь Үйлчлүүлэгчийг хөрөнгийн зах зээлтэй холбоотой боломжит бүхий л мэдээллээр хангаж, зөвлөгөө өгч ажиллана.
- 5.2.10. Андеррайтер нь Үйлчлүүлэгчийн үүсгэн байгуулсан ТЗК- д үнэт цаасны данс нээн өгч, олон нийтэд санал болгох ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааны нийлүүлэлтийг гүйцэтгэнэ.
- 5.2.11. Андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд хийгдэж буй бэлтгэл ажил, үнэт цаасны танилцуулга, борлуулалт, татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй холбоотой мэдээлэл, баримт судалгааг тухай бүрд нь гарган өгнө.
- 5.2.12. Андеррайтер нь ХБҮЦ-ыг олон нийтэд сурталчлахтай холбоотой өөрийн бэлтгэсэн контентийн зардлыг хариуцна.
- 5.2.13. Гэрээт ажлын асуудлаар Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгч буй аудит, үнэлгээний болон бусад хөндлөнгийн байгууллага, хуулийн зөвлөх байгууллагатай хамтран ажиллаж, шаардлагатай арга хэмжээг шуурхай шийдвэрлэх үүрэгтэй.
- 5.2.14. Андеррайтерийн томоохон харилцагч, хөрөнгө оруулагч болон стратегийн томоохон хөрөнгө оруулагчдад ХБҮЦ-ны талаар мэдээллийг өгч Үйлчлүүлэгчтэй тохиролцсон нөхцөлөөр тодорхой санал гаргаж, идэвхтэй ажиллана.
- 5.2.15. Гэрээнд заасан бусад.

6. Төлбөр, зардал

- 6.1. Андеррайтерийн үндсэн төлбөр нь 25,000,000 (Хорин таван сая) төгрөг байх бөгөөд төлбөрийг гэрээ байгуулагдсан өдрөөс 3 хоногийн дотор Үнэт цаас гаргагч нь төлнө.
- 6.2. Андеррайтерийн амжилтын төлбөр-ийг татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтын үнийн дүнгээс хувь тооцох бөгөөд татан төвлөрүүлсэн хөрөнгийн 2.5 (хоёр аравны таван) хувь байна. Энэхүү төлбөрийг анхдагч зах зээлийн арилжаа дууссанаар Андеррайтерт төлнө.
- 6.3. Гэрээний 8.1-т заасан төлбөрт Үйлчлүүлэгчийн үүсгэн байгуулсан ТЗК-ийн ХБҮЦ-г танилцуулах /road show/, сурталчлахтай холбогдсон зардал, мэргэжлийн болон холбогдох

Үйлчлүүлэгч

9

Андеррайтер

байгууллагуудын шимтгэл, төрийн байгууллагаас гаргуулан авах лавлагаа тодорхойлолтын төлбөр хамаарахгүй ба тэдгээрийг Үнэт цаас гаргагч бүрэн хариуцна. (СЗХ, МХБ, Арилжааны төлбөр тооцоо ХХК, ҮЦТХТөө ХХК болон бусад).

- 6.4. Андеррайтерийн төлбөрийг "Хаан банк"-нд байрших 5115 085 694 тоот данс руу шилжүүлнэ.
- 6.5. Андеррайтераас үйлчилгээг эхлэн, хүн цаг зарцуулсны дараагаар Үнэт цаас гаргагч үндсэн төлбөр болон амжилтын төлбөрийг төлж байгаа тул төлбөрийг бууруулахгүй, буцаан олгохгүй.
- 6.6. Гэрээний 6.1 болон 6.2-т заасан төлбөрт буюу Андеррайтерийн зохион байгуулсан маркетинг, сурталчилгааны зардал багтсан болно.

7. Гэрээг цуцлах, дуусгавар болох

- 7.1. Талуудын эрх бүхий төлөөлөгч нар Гэрээнд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2. Гэрээний 3.1-т заасан ажиллагааг гүйцэтгэснээр Гэрээ дуусгавар болно.
- 7.3. Гэрээнд заасан ажил дуусгавар болоогүй, Талууд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлаагүй нөхцөлд анх заасан хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 7.4. Гэрээг харилцан тохиролцож, хугацаанаас өмнө дуусгавар болгож болох бөгөөд энэ тохиолдолд үндсэн төлбөрийг буцаан олгохгүй.
- 7.5. Гэрээг дараах тохиолдолд хугацаанаас өмнө цуцална. Үүнд:

7.5.1. Андеррайтер талын санаачилгаар гэрээг цуцлах

- 1) Үйлчлүүлэгч нь шаардлагатай мэдээлэл баримт материалыг гаргаж өгөөгүй, нуун дарагдуулсан, цаг хугацаанаас нь хоцроосон, буруу, дутуу худал мэдээлэл өгсөн, мэдээлэл өгөхөөс татгалзсан бол;
- 2) Үйлчлүүлэгчээс хууль бус болон мэргэжлийн ёс зүйн алдаатай үйлдэл хийхийг шаардсан, тулгасан;
- 3) Андеррайтерийн зүгээс Үйлчлүүлэгчид тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, биелүүлэхээс татгалзсан;
- 4) Гэрээнд заасан үүрэг гүйцэтгэхийг шаардсан боловч шаардлагын дагуу зөрчлөө арилгаагүй;
- 5) Үйлчлүүлэгчийн ХБҮЦ гаргах үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулан ажиллаж буй байгууллагаас гаргасан дүгнэлт нь зохицуулагч байгууллагын шаардлага хангаагүйгээс үнэт цаас гаргах ажиллагаа амжилтгүй болох нөхцөл үүссэн;
- 6) Гэрээний 9.2.3 дахь зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн;
- 7) Үйлчлүүлэгчийг зохицуулах байгууллагаас шаардлага хангаагүй үндэслэлээр үнэт цаасыг бүртгэхээс татгалзсан.

7.5.2. Үйлчлүүлэгчийн санаачилгаар гэрээг цуцлах

- 1) Андеррайтерийн тусгай зөвшөөрлийг зохицуулагч байгууллагаас түдгэлзүүлсэн, цуцалсан, татан буугдсан;
- 2) Гэрээнд заасан үүрэг гүйцэтгэхийг шаардсан боловч шаардлагын дагуу зөрчлөө арилгаагүй.

7.6. Гэрээний үүргээ биелүүлэхтэй холбоотой аливаа мэдэгдэл шаардлагыг Талууд бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд үүрэг гүйцэтгэхтэй холбоотой хугацааг дурдсан байна.

7.7. Талууд гэрээ цуцлах тухай мэдэгдлийг нөгөө талдаа 15 хоногийн өмнө мэдэгдсэн байна.

8. Хариуцлага

8.1 Гэрээг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг буруутай тал буюу Гэрээний үүргээ зөрчсөн тал бүрэн хариуцна.

Үйлчлүүлэгч

10

Андеррайтер

8.2 Үйлчлүүлэгч нь Гэрээг зөрчсөний улмаас Андеррайтерийн санаачилгаар Гэрээг цуцалсан бол Үйлчлүүлэгчээс төлсөн аливаа төлбөрийг буцаан олгохгүй.

БҮРТГЭЭГ-02

9. Нууц хадгалах

9.1. Нууц хадгалах

- 9.1.1. Талууд нь эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд нууц мэдээллийг гэрээний бус зорилгоор шууд болон шууд бус замаар ашиглахгүй, задруулахгүй, эсхүл гуравдагч этгээд болон олон нийтэд мэдээлэхгүй байх үүргийг энэхүү гэрээний явцад, цаашид хүлээнэ.
- 9.1.2. Гэрээгээр хүлээж буй Андеррайтерийн нууц хадгалах үүрэгт дараах нөхцөл байдал хамаарахгүй буюу Андеррайтер хариуцлага хүлээхгүй болно. Үүнд:
- 1) Андеррайтерт мэдээлэл өгөх үед болон дараа нь тухайн мэдээлэл олон нийтэд зарлагдсан,
 - 2) Компанийн бусад эх үүсвэрээр дамжин нууцын бус зэрэглэлтэй материал Андеррайтерт хүрсэн,
 - 3) Гэрээгээр хүлээсэн ямар нэгэн үүргээ зөрчилгүйгээр Андеррайтер нь өөрөө тухайн мэдээллийг олж авсан, эсхүл боловсруулсан,
 - 4) Хуулийн дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр тухайн нууцлалын зэрэглэлийн мэдээлэл олон нийтэд ил болсон,
 - 5) Үнэт цаас гаргагчаас нууц гэсэн тэмдэглэгээг хийгдээгүй ирсэн мэдээлэл.
- 9.1.3. Андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийгдэх нийтэд нээлттэй болох шаардлагатай мэдээллүүдийг нийтэд танилцуулснаар нууц мэдээллийг задруулсан гэж үзэхгүй.
- 9.1.4. Нууцад тооцогдох мэдээллийг эрх бүхий байгууллагаас шаардсан тохиолдолд Гэрээний Талууд нь харилцан бие биедээ мэдэгдэх үүрэг хүлээнэ.
- 9.1.5. Үнэт цаас гаргагчаас Андеррайтерт тусгайлан итгэмжлэн өгсөн, өмнө нь олон нийтэд тараагдаагүй мэдээллийг “Нууц мэдээлэл” гэж тооцох бөгөөд энэ төрлийн мэдээлэл ирүүлэхдээ заавал “нууц” гэсэн тэмдэглэгээтэй ирүүлнэ. “Нууц” тэмдэглэгээтэй ирээгүй мэдээллийг Андеррайтер нууцлах үүрэг хүлээхгүй.

10. Бусад

- 10.1. Энэхүү гэрээг 3 хувь үйлдсэн бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй байна.
- 10.2. Талуудын хооронд гарсан үл ойлголцох байдал, аливаа маргаантай асуудлыг маргаан үүссэнээс хойш ажлын 15 хоногийн дотор харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд ийнхүү зөвшилцөөгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“Омни капитал ББСБ” ХХК

Ч.Эрэлхэг
Гүйцэтгэх захирал

(гарын үсэг, тамга)

“Омни ассет” ХХК

Ч.Даваасүрэн
Гүйцэтгэх захирал

(гарын үсэг, тамга)

“Апекс капитал ҮЦК” ХХК

Б.Лхамдолгор
Гүйцэтгэх захирал

(гарын үсэг, тамга)

Үйлчлүүлэгч

Андеррайтер

БҮРТГЭЛЭЙН ГЭРЧИЛГЭЭ



Хууль зүйн сацлын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000162477

2011.03.02

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011274085

/ Хувийн хэргийн дугаар /

5453283

/ Регистрийн дугаар /

Апекс капитал ҮЦК

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

01

/ дугаар /

2011.02.21

/ он, сар, өдөр /

4610

/ код /

Худалдааны зуучлал

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

6611

Брокер, дилерийн үйл ажиллагаа

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

1,350,000.0

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Цэнтрал тауэр, 9 давхар 903 тоот, Утас1: 99111561, Утас2: . Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Оюуны өмч, улсын бүртгэлийн
ерөнхий газар Хуулийн этгээдийн
бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2018 он 5 сар 18 өдөр



Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Мөнхбаяр овогтой Амар-а Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.04.23	Э.Эрбэнбилэг
2	Дахин гэрчилгээ олгов.	2018.05.18	О.Шижиртуяа
1	Буяндэлгэр овогтой Лхамдолгор -а Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.08.22	Ч.Батдэлгэр
2	6499 Андеррайтерийн үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2018.11.02	Ж.Нямборж
6	66300 Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2019.09.24	С.Мөнхсанчир
7	Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.	2020.04.14	Д.Чулуунтуяа
8	64300 Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2020.04.14	Д.Чулуунтуяа
9	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1700000 мян.төг-р нэмэгдэж нийт 3050000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2020.05.07	О.Өлзийбат
9	Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2020.05.07	О.Өлзийбат
10	Эцсийн өмчлөгч 1 нэмэгдэж 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2020.05.07	О.Өлзийбат
11	66110 Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх үйл ажиллагаа үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2020.05.07	О.Өлзийбат
13	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, ол.мийн, 4 Нийг.Хоризонс оффис, хувьцаа эзэмшигч 6 нэмэгдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 9 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. Улс. хаягийг шинээр бүртгэв.	2022.08.10	Г.Батмөнх
14	Эцсийн өмчлөгч 2 иргэн бүртгэв.	2022.08.10	Г.Батмөнх
15	4610 Худалдааны зуучлал үйл ажиллагааг хассаныг бүртгэв.	2022.08.10	Г.Батмөнх





Энэхүү бүртгэлгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээн зүтгэх Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчин үй.





ТЭГЭЭ-02



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 301/62

2011 оны 03 сарын 28 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 03 сарын 28 өдрийн 75 дугаар тогтоолоор "АПЕКС КАПИТАЛ ҮЦК" ХХК -д ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА
"тамга"



Д.БАЯРСАЙХАН



Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

2023-11-15

2023 оны 05 дугаар
сарын 10-ны өдөр

ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар 23/002

Улаанбаатар хот

Энэхүү Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг:

Нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй, Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, “N тауэр” оффис, 4-р давхар, 402 тоот хаягт орших “Омни Ассет” ХХК (Улсын бүртгэлийн дугаар - 9011851823), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ч.Даваасүрэн (цаашид “Захиалагч” гэх);

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Аюуд Тауэр, 14 давхар, 1404 тоот хаягт орших “ХаанЛекс Партнерс” ХХН (Улсын бүртгэлийн дугаар - 9022001010), түүнийг төлөөлж нөхөрлөлийн Гүйцэтгэх захирал И.Учралбаяр (цаашид “Зөвлөх” гэх) нар Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн энэхүү гэрээг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Гэрээний зорилго нь Захиалагчаас хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх)-ыг нийтэд санал болгон нээлттэй гаргахад Зөвлөхөөс хууль зүйн зөвлөх үйлчилгээ Захиалагчид үзүүлэх, үүнтэй холбоотой талуудын харилцан хүлээх эрх, үүрэг, хариуцлагатай холбогдон гарах аливаа асуудлуудыг зохицуулахад оршино.
- 1.2 Талууд энэхүү Гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биенийхээ эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах бөгөөд гэрээний зорилго, хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна.
- 1.3 Гэрээ, түүний хавсралтад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд Гэрээний хамт хүчин төгөлдөр байна.

ХОЁР. ГЭРЭЭТ АЖИЛ, ТҮҮНИЙ ХУГАЦАА

- 2.1 Зөвлөх нь Захиалагчид дор заасан үйлчилгээ (цаашид “Үйлчилгээ” гэх)-г үзүүлнэ. Үүнд:
 - 2.1.1 ХБҮЦ гаргахтай холбоотой хууль зүйн дүгнэлт боловсруулах.
 - 2.1.2 Зээлийн багцад тавигдах хууль зүйн шаардлагыг Захиалагчтай хамтран тодорхойлох, улмаар Зээлийн багцийн хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, тайлан гаргах.
 - 2.1.3 ХБҮЦ гаргахтай холбоотой байгуулах гэрээ, хэлцэл, шийдвэрийн төсөл хянах.
- 2.2 Зөвлөх нь Үйлчилгээг Захиалагчийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгон нээлттэй гаргах хүртэл хугацаанд ажиллана.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС, ТӨЛБӨР ТООЦОО

- 3.1 Зөвлөхийн Үйлчилгээний хөлс 20,000,000 (хорин сая) төгрөг байна. Энэхүү



2023-11-15

ТАВ. ЗӨВЛӨХИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Зөвлөх нь дараах эрх, үүрэгтэй:

- 5.1.1 Шаардлагатай баримт бичигтэй танилцах;
- 5.1.2 Гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн оновчтой менежментээр гүйцэтгэж, гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт Захиалагчийн зөвлөхийн хувиар ажиллах бөгөөд Захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- 5.1.3 Гэрээгээр хүлээсэн үйлчилгээг заасан хугацаанд бүрэн үзүүлэх;
- 5.1.4 Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд нийцүүлэн хууль зүйн үйлчилгээг үзүүлнэ;
- 5.1.5 Үйлчилгээг үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах;
- 5.1.6 Захиалагчийн нууцыг чандлан хадгалах;
- 5.1.7 Хуулийн дүгнэлтийг агуулгатай холбоотойгоор Захиалагчаас нэмэлт тодруулга хүссэн тохиолдолд тодруулга хийх;
- 5.1.8 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой гаргасан тайлан болон хууль зүйн дүгнэлтийн хариуцлагыг бүрэн хүлээх.

ЗУРГАА. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 6.1 Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Захиалагч өөрийн санаачилгаар гэрээг цуцлах эрхтэй.
 - 6.1.1 Зөвлөх гэрээний үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараах 10 хоногт, эсхүл Захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй;
 - 6.1.2 Зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр энэхүү гэрээг байгуулсан өмгөөллийн нөхөрлөл дампуурсан эсхүл татан буугдсан; эсхүл зөвлөхийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн эсхүл хүчингүй болгосон;
 - 6.1.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 15-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;
 - 6.1.4 Захиалагч өөрийн санаачилгаар дээр зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол.
- 6.2 Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд зөвлөх өөрийн санаачилгаар мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн гэрээг цуцлах эрхтэй.
 - 6.2.1 Гэрээний дагуу төлбөл зохих аливаа төлбөрийг зөвлөхийн бичгээр гаргасан төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр төлөөгүй;
 - 6.2.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 10-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон.
- 6.3 Энэхүү гэрээний 6.1.3, 6.1.4 болон 6.2.1, 6.2.2 -д заасны дагуу гэрээг цуцалсан тохиолдолд гэрээг цуцлах өдрөөс өмнө зохих ёсоор гүйцэтгэсэн бол гэрээний 3 дугаар зүйлд заасны дагуу төлбөл зохих үйлчилгээний хөлсийг Захиалагч нь Зөвлөхөд төлнө.

ДОЛОО. БАТАЛГАА

7.1 Зөвлөх нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хуульчийн



11.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд Зөвлөх нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар Захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Зөвлөх гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.

АРВАН ХОЁР. БУСАД ЗААЛТ

- 12.1 Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон мөрдөнө.
- 12.2 Энэхүү гэрээтэй холбогдон гарах маргаан болон хоёр талын харилцан үл ойлголцох байдлыг талууд харилцан зөвшилцөж ойлголцох, бие биеэ хүндэтгэх замаар шийдэхийг эрмэлзэх ба тохиролцоонд хүрээгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 12.3 Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болох боловч зөвхөн Захиалагчаас зөвшөөрөл өгсөн нөхцөлд зөвлөх үйлчилгээний ажлыг Зөвлөх эхлүүлнэ.
- 12.4 Хэрэв 12.3-т заасанчлан Захиалагчаас зөвлөх үйлчилгээний ажлыг эхлүүлэх зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд энэхүү гэрээний 3.1-т заасан төлбөртэй холбоотой нөхцөл бий болохгүй гэдгийг Зөвлөх хүлээн зөвшөөрсөн болно.
- 12.5 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн нөхцөлд зөвхөн хоёр талын зөвшилцөн тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдэж гарын үсгээр баталгаажуулан гэрээний эх хувьд хавсаргаж болно.
- 12.6 Энэхүү гэрээг хоёр эх хувь үйлдсэн ба хувь тус бүр нь хууль зүйн бүрэн хүчин төгөлдөр баримт болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Ч.ДАВААСҮРЭН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ЗӨВЛӨХИЙГ ТӨЛӨӨЛЖ:


KHAN LEX
PARTNERS
И.УЧРАЛБАЯР
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ







СХХ
0923.11.08 өдөр
БҮРТГЭЭ

Хууль зүйн сайдын 2016 оны
А.204 дүгээр тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000178048

2018.09.21

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9022003026

/ Хувийн хэргийн дугаар /

6351034

/ Регистрийн дугаар /

Өмгөөллийн хаан лекс партнерс ХХН

Нөхөрлөл /ХХН/

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

01

2018.09.18

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

6910

/ код /

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

3

/ гишүүдийн тоо /

200.0

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Баянгол, 6-р хороо, 10-р хороолол, энхтайваны өргөн чөлөө, х103, 1 тост, Утас1: 99001070,
Утас2: 89099106, Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын
бүртгэлийн газар

/ Бүртгэсэн байгууллагын нэр /



8298722
1118262561

Гэрчилгээ дахин олгосон 2019 он 1 сар 23 өдөр

2023-11-15

СЗХ
2023.11.08
оя сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Идэрхангай овогтой Учралбаяр-е Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.09.21	 Д.Гангамөрөн В.Хандсүрэн
2	Дахин гэрчилгээ олгов.	2019.01.23	
3	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимпын, 5 аюуд тавуур, 14 давхар 1404 тоот Утас1: 99001070, Утас2: 89099106, Факс: хаягийг шинээр бүртгэв.	2021.02.10	 Л.Бархасбадь Л.Бархасбадь
4	Эцсийн өмчлөгч 3 ирээн бүртгэв.	2021.02.10	

Handwritten signature

УЛААНБААТАР ХОТ
ОНИН АССЕТ
ХХК
Handwritten signature

Энэхүү гэрчилгээг хуурамчээр үйлдсэн үл гэдэг Монгол Улсын хуулийн тусуу харууллага хүлээн авч
Уг гэрчилгээний гэрчилгээг хуурамч байдлаар үйлдсэн үл гэдэг



2023-11-15
БҮРТГЭВ-02

СЭХ
2023.11.08 өдөр
БҮРТГЭВ
№ 1



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 358

Улаанбаатар хот

Үнэт цаасны зах зээлд оролцогчид
хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн
этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15, 24.3, 63 дугаар зүйлийн 63.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өмгөөллийн хаан лекс партнерс” ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Өмгөөллийн хаан лекс партнерс” ХХН /И.Учралбаяр/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



2023-11-15

2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр

№ 23/001

23/46

Улаанбаатар хот



Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г

Нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Сүхбаатар-13, Метробизнес төв, 6 давхар 603 /Зип код:6920/ хаягт байрлах улсын бүртгэлийн 9018018003, регистрийн 5821975 дугаартай, нягтлан бодох бүртгэлийн итгэмжлэгдсэн байгууллага болох “Шонхор үнэлгээ Аудит” ХХК (цаашид “Гүйцэтгэгч” гэх)-ийг төлөөлж Захирал Д.Шийрэв,

Нөгөө талаас Монгол Улс, Улаанбаатар хот, 210620а, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 7 давхар, 712 тоотод байрлах улсын бүртгэлийн 9011851823, регистрийн 8356327 дугаартай, “Омни ассет” ХХК (цаашид “Үйлчлүүлэгч” гэх)-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ч.Даваасүрэн нар нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам” Холбогдох Үйлчилгээний Олон Улсын Стандарт 4400-ийн хүрээнд Гүйцэтгэгч нь үйлчлүүлэгчийн үнэт цаас гаргахад барьцаалагдах зээлийн багцаас түүвэрлэн шалгаж шалгуур хангаж буй эсэхийг тогтоох, сонгосон аргачлалын дагуу хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү гэрээнд Үйлчлүүлэгчийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажлын хүрээнд барьцаалагдах зээлийн багцаас түүвэрлэн авсан зээлийн гэрээнүүдэд хамаарна.
- 1.3 Гүйцэтгэгч нь Үйлчлүүлэгчээс шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
- 1.4 Гүйцэтгэгч нь гэрээгээр хийж гүйцэтгэх ажлыг мэргэжлийн түвшинд, холбогдох хууль, тогтоомж, стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.
- 1.5 Энэхүү гэрээний хавсралтууд нь гэрээний салшгүй нэг хэсэг болно.

ХОЁР. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Гүйцэтгэгчээс гэрээгээр хийж гүйцэтгэх ажлыг хугацаандаа хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 2.2. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах эрхтэй.
- 2.3. Гүйцэтгэгчийн гэрээгээр хийж гүйцэтгэсэн ажил нь чанарын шаардлага хангаагүй, хууль тогтоомж, журам, стандартад нийцээгүй, ажлын гүйцэтгэлийг хүлээн авах боломжгүй байх тохиолдолд ажлыг дахин гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 2.4. Зээлийн бүхий л мэдээлэл үнэн зөв, бодитой байх хариуцлагыг Үйлчлүүлэгч байгууллагын удирдах ажилтан хүлээнэ.
- 2.5. Гүйцэтгэгчтэй гэрээт ажлын горимуудыг урьдчилан тохиролцож, гэрээт ажлын захидлаар баталгаажуулах,
- 2.6. Сонгосон буюу тохиролцсон горимуудыг гэрээний хавсралт болгон батлах,
- 2.7. Гүйцэтгэгчид гэрээний үүргээ биелүүлэхэд шаардлагатай санхүүгийн болон бусад баримт бичгүүдийн мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн, түргэн шуурхай гаргаж өгөх үүрэгтэй.
- 2.8. Мэдээлэл боловсруулахтай холбоотой математик арга, аргачлал ашиглан гаргах хэсэг дээр холбогдох нарийн мэргэжилтэний дэмжлэг үзүүлнэ.
- 2.9. Үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасны дагуу бүрэн төлж барагдуулах үүрэг хүлээнэ.



ЗУРГАА. НУУЦ ХАДГАЛАХ



6.1. Гүйцэтгэгч, түүний захирал, албан тушаалтан, хариуцсан ажилтан нь энэхүү Гэрээний агуулга болон гэрээг хэрэгжүүлэх явцад мэдсэн, олж авсан Үйлчлүүлэгчийн баримт бичиг, мэдээ, мэдээллийг Үйлчлүүлэгчийн бичгээр өгсөн албан ёсны зөвшөөрөлгүйгээр бусдад задруулж үл болно.

6.2. Гүйцэтгэгч нь Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах үүргээ энэхүү гэрээ дуусгавар болсон эсэхээс үл хамааран хугацаагүйгээр бусдад задруулж үл болно.

6.3. Гэрээний 6.1 дэх хэсэгт заасан баримт бичиг, мэдээ, мэдээллийн нууцыг задруулсан үйлдэл, эс үйлдэлд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.4. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний дагуу хүлээн авсан, мэдсэн нууц баримт бичиг, мэдээ, мэдээллийг хамгаалах, уг мэдээллийг олон нийтэд дэлгэгдэх, алдагдахаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.

ДОЛОО. БУСАД

7.1. Энэхүү гэрээнд Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

7.2. Энэхүү Гэрээгээр зохицуулаагүй бусад асуудлыг Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулах буюу тайлбарлана.

7.3. Гэрээний талаар маргаан гарвал харилцан хүндэтгэх байр сууринаас хандан зөвшилцөж, шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.4. Энэхүү Гэрээнд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг Талууд харилцан тохиролцож, нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7.5. Гэрээг Монгол хэлээр хууль эрх зүйн хувьд адил хүчин төгөлдөр 2 /хоёр/ хувь үйлдсэн бөгөөд Талууд гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үйлчлүүлэгчийг төлөөлж:
“Омни ассет” ХХК-ийн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.ДАВААСҮРЭН

Утас: 7277-8282, 88043130

ЭРСДЭЛИЙН ШИНЖЭЭЧ Б.МӨНХШҮР

Аудиторыг төлөөлж:
“Шонхор үнэлгээ Аудит” ХХК-ийн

ЗАХИРАЛ Д.ШИЙРЭВ

Утас: 7015-0001, 80110088



2023-11-15

БҮРТГЭВ-02



Зээлийн хөрөнгө тус бүрт тавих шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлтийн томъёолол	Баталгаажуулах баримт бичиг
Зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур	
Тасалбар болгох өдрөөр хэвийн ангилагдсан зээл байх	Дансны хуулга, Зээл авах үеийн Монголбанкны ЗМС дээрх мэдээлэл
Хөрөнгийн багцад байгаа зээлийн хүү нь баталгаажсан үнэт цааснаас орж ирэх зээлийн хүүгийн түвшнээс өндөр байх, Энэ нь ТЗК-ийн мөнгөн урсгалын орлого, зарлагатай уялдсан байх,	Зээлийн гэрээ,
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх	Зээлийн гэрээ
Зээлийн багцад байгаа хөрөнгийн үнийн дүнгийн нийлбэр үнэт цаасны төлбөрийн төлөгдөөгүй үнийн дүнгийн нийлбэрийн дүнгээс багагүй байх	Зээлийн гэрээ
Зээлийн стандарт нь анхны үүрэг гүйцэтгэгчийн зээлийн нөхцөлөөс багагүй байх	Зээлийн гэрээ
Зээл төлөгдөхгүй байх эрсдэл даатгагдсан байх	Зээлийн гэрээ, дансны хуулга
Зээл, хүүгийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн санхүүгийн байдлыг харгалзан үзсэн байх.	Зээлийн гэрээ, дансны хуулга
Зээлдэгчийн зээл авахтай холбоотой нөхцлүүдийг хангасан холбогдох шаардлагууд, зээлийн эргэн төлөлтийг хангах шаардлагууд хангагдсан байх	Зээлийн гэрээ, дансны хуулга
Зээлийг Монгол Төгрөгөөр олгож эргүүлэн төлөхөөр байх	Зээлийн гэрээ
Зээлийн хугацаа ХБҮЦ-ийн эргэн төлөгдөх хугацаатай уялдсан байх	Зээлийн гэрээ
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлдэгчид ямар ч төрлийн аливаа төлөх төлбөр, үүрэг хүлээгээгүй байх	Зээлийн гэрээ, дансны хуулга
Хууль зүйн хувьд АҮГ-ийн бүрэн өмчлөлд байх бөгөөд, тухайн зээлийн гэрээгээр бусад этгээдэд давхар үүрэг хүлээгээгүй байх.	Зээлийн гэрээ, дансны хуулга
Төлөлт нь бүрэн хорогдох байдлаар	Тэнцүү төлбөрт
Зээлдэгчид тавигдах шалгуур	
Эрх зүйн бүрэн чадамжтай, 18 нас хүрсэн Монгол улсын иргэн байх	Хүчин төгөлдөр иргэний үнэмлэхний хуулбар, зураг
Зээлийн барьцааны гэрээ, холбогдох бүртгэх байгууллагад бүртгэгдсэн байх	Лавлагаа, бүртгэл хийгдсэн тэмдэглэгээ
Зээл олгох үед харгалзан авч үзсэн өр орлогын харьцааны үзүүлэлт	Зээлийн судалгаа, дүгнэлт





Үйлчлүүлэгч багцад орох бүх зээлийн мэдээллийг нэгтгэж, боловсруулалт хийн баталгаажуулан ирүүднэ.

БҮРТГЭЭ-02

1. Байгууллагад мөрдөгдөх нийтлэг хууль, дүрэм, журмаар тодорхойлогдох үзүүлэлтүүд
 - 1.1 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагууд
 - 1.2 Зээлийн багцад учрах эрсдлүүдийг даатгасан эсэх

2. Зээлийн гэрээгээр тодорхойлогдох зээлийн бүтээгдэхүүний холбогдох үзүүлэлтүүд. Үүнд:
 - 2.1 Хугацаа
 - 2.2 Хүү
 - 2.3 Шимтгэл
 - 2.4 Хэмжээ
 - 2.5 Шалгуур
 - 2.6 Зориулалт
 - 2.7 Хязгаарлалт
 - 2.8 Бусад

3. Хөндлөнгийн мэдээллээр баталгаажих мэдээллүүд. Үүнд:
 - 3.1 Зээлдэгчийн сүүлийн 6 сарын дундаж орлогын мэдээлэл /орлого тасралтгүй байх зээлчдэгчид тавигдах шалгуурыг хангасан байх/
 - 3.2 Зээлдэгч тус бүрийн тооцоолсон өр орлогын харьцааны мэдээлэл
 - 3.3 Зээлийн мэдээллийн сангаас авдаг зээлийн лавлагааны мэдээллүүд
 - 3.4 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас лавлагаа
 - 3.5 Түүвэрт орсон зээлдэгчийн ажлын газар, ажилласан жил, мэргэжил боловсрол, албан тушаал, зээлийн хүү, хугацаа гэх мэт зээлдэгчийг төлөөлөх бусад мэдээллүүд
 - 3.6 Бүртгэх байгууллагын лавлагаа
 - 3.7 Зээлийн хувийн хэрэг, зээлийн хорооны шийдвэр



Хууль зүйн сангийн 2016 оны
Х.28 дугаар тушаалаар батлав



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000128499

2014.03.27

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9018018003

/ Хувийн хэргийн дугаар /

5821975

/ Регистрийн дугаар /

Шонхор үнэлгээ аудит

ХХК

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

01

2014.03.24

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

6920

/ код /

Аудитын үйл ажиллагаа /2016.01.07-2019.01.07/

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

6621

Хөрөнгийн үнэлгээ хийх /хугацаа 2014.12.17-2017.12.17/

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

2

1 000,00

/ хугацаа /

/ гишүүдийн тоо /

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Чингэлтэй, 2-р хороо, 27, 3 тоот, Утас1: 99018172, Утас2: 99098173, Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяа /



Оюуны өмч, улсын бүртгэлийн
ерөнхий газрын Хуулийн
этгээдийн бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2016 он 10 сар 28 өдөр

[Handwritten signature]

2023-11-15

СЭХ
2023 11 08
БҮРТГЭВ
N 1

БҮХТӨВ 02 Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэл	
		Огноо	Угсаа
1	Балданям овогтой Эрдэнэочир-а гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2016.09.26	Угсаа
2	Далин гэрчилгээ олгов.	2018.10.28	Ажлаагч гэмдэг Шийдвэрлүүлэгч С.Мөнхсанчир
1	Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасвагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2017.01.31	С.Мөнхсанчир
2	5879 Санхүү, нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээ болон сурвалт эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2017.01.31	УЛСЫН С.Мөнхсанчир 322
3	Улаанбаатар, Сүхбаатар, 6-р хороо, Сүхбаатар, 13, 302 өрөөлөө 503 тоот, Утас1 95185515, Утас2 99098173, Факс 70150001 хаягийг шинээр бүртгэв.	2017.01.31	С.Мөнхсанчир
4	Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасвагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2018.03.21	Б.Гэрэлзүл
5	Даважаяа овогтой Шибрэ-а гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.03.21	Б.Гэрэлзүл
6	Хувь нийлүүлэгчээс 0 нэмэгдэж, 1 хасвагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2018.06.06	О.Шийрэгтүүл
7	6920 Аудитын үйл ажиллагаа /2019.01.23-2022.01.23/ эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. 6621 Харвандын үнэлгээ хийх /хувиараа 2018.03.01-2021.03.01/ эрхлэх үйл ажиллагааг шинээр бүртгэв.	2019.06.17	Э.Эрдэнэбилэ



САНГИЙН ЯАМ

Сэнгийн сайдын 2010 оны 19 дүгээр
тушаалын 4 дүгээр хавсралт

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2-2016

Дугаар

“Шонхор үнэлгээ Аудит” ХХК

Аж ахуйн нэгжийн нэр:

Улсын бүртгэлийн дугаар: 5821975

Аж ахуйн нэгжийн хаяг: УБ хот, ЧД, 2-р хороо, 27-р байр, 3 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2016 оны 01 сарын 07-ны өдөр, тушаал № 2

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД

Б.БОЛОР


УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2023-11-08 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2023-11-15

БҮРТГЭВ-02



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа
сунгах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.5, 15 дугаар зүйлийн 15.4.2, Аудитын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аудитын үйл ажиллагаа эрхлэх дараах хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар тус тус сунгасугай.

д/д	Хуулийн этгээдийн нэр	Сунгах хугацаа
1	"Энур Аудит" ХХК	2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс
2	"Авера-Аудит" ХХК	2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс
3	"Алаг уул финанс Аудит" ХХК	2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс
4	"Гэрэлт Хөхийн Тэнцвэрт Аудит" ХХК	2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс
5	"Мэжик Консалтинг Аудит" ХХК	2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс
6	"Номгон Аудит" ХХК	2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс
7	"Пантер Мидланд Аудит" ХХК	2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс
8	"ПрайсуотерХаусКулерс Аудит" ХХК	2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс
9	"Уваа-уул аудит" ХХК	2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс
10	"Шонхор Үнэлгээ Аудит" ХХК	2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс

2. Тусгай зөвшөөрлийн хугацаа нь сунгагдсан хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/-т үүрэг болгосугай.


Б.ЖАВХЛАН

9763000099





2023-11-15

БҮРТГЭВ-02



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2022.04.22

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл

Регистрийн дугаар : 5821975

Нэр : ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ

Зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл

Авсан огноо : 2022-01-23

Дуусах огноо : 2025-01-23

Хүчинтэй эсэх : Хүчинтэй

Тусгай зөвшөөрлийн нэр : АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ



Цахим систем нь бусад төрийн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг татан авч байнын шалгуур болгон ашиглаж байгаа бөгөөд QR кодыг уншуулах үед тухайн шалгууруудыг хангасан эсэхээс хамааран гэрчилгээний төлөв өөрчлөгдөх буюу тухайн үеийн байдлаар харагдахыг анхаарна уу



2023-11-15

БҮРГЭВ-02



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2017 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

“Шонхор үнэлгээ аудит” ХХК-ийг үнэт цаасны
зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх
хуулийн этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.17, 24.3, Хорооны 2013 оны 452 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шонхор үнэлгээ аудит” ХХК-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Шонхор үнэлгээ аудит” ХХК /Б.Эрдэнэ-Очир/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.



С.ДАВААСҮРЭН



“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК (“КОМПАНИ”) - ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох,
түүнтэй байгуулах зөвшөөрөл олгох тухай

2023 оны 07 сарын 25-ны өдөр

№ ТУЗ- 23/009

Улаанбаатар хот

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11.4 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын 3.4.5 дахь хэсэг болон Компанийн дүрмийн 6.4.4.3 дахь хэсэгт тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Компанийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаатай холбоотойгоор “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК-ийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан хөрөнгө итгэмжлэн удирдагч этгээдээр томилсугай.
2. Энэхүү тогтоолын дагуу “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК-тай Компанийг төлөөлөн Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулахыг ТУЗ-ийн дарга /А.Батболд/-д зөвшөөрсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА



А.БАТБОЛД



“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 07 сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Хурлын ирц:

ТУЗ-ийн гишүүн С.Нина

ТУЗ-ийн гишүүн Х.Хэрлэн

ТУЗ-ийн гишүүн А.Батболд нарын 100%-ийн ирцтэйгээр хуралдав.

Хурал болсон газар: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сэнтрал тауэр оффис, 712 тоот хурлын өрөө

Хурал эхэлсэн, дууссан: 2023.07.25, Мягмар гариг, 10:00 цагт эхэлж, 11:40 цагт дуусав.

Хурлаар хэлэлцсэн асуудал: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, түүнтэй байгуулах зөвшөөрөл олгох тухай тухай

Хэлэлцсэн нь:

ТУЗ-ийн гишүүд нь:

- “Омни ассет ТЗК” ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаатай холбоотойгоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан хөрөнгө итгэмжлэн удирдагч этгээдээр “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК-ийг томилох эсэхийг хэлэлцэв.

Шийдвэрлэсэн нь:

Хэлэлцсэн асуудлын хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөл дараах шийдвэрийг санал нэгтгэйгээр гаргав.

- Хэлэлцсэн асуудлын хүрээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаатай холбоотойгоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан хөрөнгө итгэмжлэн удирдагч этгээдээр “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК-ийг томилохоор шийдвэрлэв.
- “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК-тай Компанийг төлөөлөн Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулахыг ТУЗ-ийн дарга /А.Батболд/-д зөвшөөрөв.

Хурлын тэмдэглэлийг баталгаажуулсан:

ТУЗ-ийн дарга А.Батболд:

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ТУЗ-н гишүүн С.Нина:

ТУЗ-н гишүүн Х.Хэрлэн:



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-11-15

БАТЛАВ:

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА

А.БАТБОЛД



БАТЛАВ:

“ЮУ ЭЙ ЭФ АССЕТ
МЕНЕЖМЕНТ” ХХК

ГҮЙЦӨТГЭХ ЗАХИРАЛ

Х.МАРИАМОРДОНО



ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭ

2023 оны 07-р сарын 25-ны өдөр

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК

болон

“ЮУ ЭЙ ЭФ АССЕТ МЕНЕЖМЕНТ” ХХК

Гэрээний дугаар:23/006

УЛААНБААТАР



Энэхүү ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭ (цаашид “Гэрээ” гэх)-г Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Монгол Улсын Иргэний хуулийн 359-368 дугаар зүйлүүдийг тус тус удиртгал болгон сайн дурын үндсэн дээр дор дурдсан талууд

Нэг талаас: Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 11-р хороо, Н тауэр, 402 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн 8356327 дугаартай Санхүүгийн Зохицуулах Хорооны 2023 оны 6 сарын 30-ны өдрийн №256 дугаар тогтоолын дагуу олгогдсон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Омни Ассет ТЗК” ХХК (цаашид “Үнэт цаас гаргагч” эсхүл “ТЗК” гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга А.Батболд

Нөгөө талаас: Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын төв өргөө 10 давхар, 1005 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн 2870657 дугаартай Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 10 сарын 28-ны өдөр № 473 дугаар тогтоолын дагуу олгогдсон Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК (цаашид “Хөрөнгө итгэмжлэн удирдагч” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Х.Маргад-Эрдэнэ

дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

1. Энэхүү Гэрээний зорилго нь ТЗК зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх) гаргах үйл ажиллагаатай холбоотой Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс төлөх болон Гэрээний дагуу хамтран ажиллах зарчим, талуудын эрх үүргийг тодорхойлоход оршино.
2. Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ үнэнч шударгаар биелүүлж, үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, харилцан бие биенийн ашиг сонирхлыг хүндэтгэх, Гэрээгээр тохиролцсон анхны тохиролцоог тууштай хадгалах, шуурхай, бүтээлчээр хамтран ажиллана.
3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийг хууль болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар захиран зарцуулах, ашиглахгүй бөгөөд гагцхүү гэрээгээр тодорхойлсон эрх хэмжээний хүрээнд ажиллах зарчмыг баримтална.
4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн үйл ажиллагаанд энэхүү Гэрээ болон ТЗК-ийн батлан мөрдөж буй дараах журмуудын холбогдох зохицуулалтыг энэхүү гэрээнд нийцүүлэн даган мөрдөнө. Үүнд:
 - 4.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Үйлчилгээ үзүүлэгч, Хөндлөнгийн аудиторыг сонгох солих журам;
 - 4.2. Хөрөнгө итгэмжлэн удирдах журам;
 - 4.3. Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам;
 - 4.4. Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам;
 - 4.5. Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын журам;
 - 4.6. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам.
5. Энэхүү Гэрээний үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд Талууд өөрөөс шалтгаалах бүхий л хүчин чармайлтыг гаргаж ажиллана.
6. Хэрэв Гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дараах дарааллын дагуу, ач

холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль;
- 6.2. Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам;
- 6.3. Монголын Хөрөнгийн биржийн журам;
- 6.4. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ;
- 6.5. ТЗК-аас баталсан бүх дүрэм, журмууд.

7. Гэрээтэй холбоотой асуудлаар талууд албан бичгээр болон шуудан, и-мэйл, утсаар харилцана.

Үнэт цаас гаргагчийг төлөөлж:

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг
төлөөлж:

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН

“ЮУ ЭЙ ЭФ АССЕТ МЕНЕЖМЕНТ”
ХХК-ИЙН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
А.БАТБОЛД

ГҮЙЦӨТГӨХ ЗАХИРАЛ
Х.МАРГАЛ-ЭРДЭНЭ



1. Нэр томьёо

1.1. Энэхүү Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёо нь доорх утгыг илэрхийлнэ. Үүнд:

- 1.1.1. “Анхны үүрэг гүйцэтгүүлэгч” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт тодорхойлсон этгээд байх ба “Омни Ассет ТЗК” ХХК-ийн хувьд “Омни Капитал ББСБ” ХХК байна.
- 1.1.2. “Үйлчилгээ үзүүлэгч” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт тодорхойлсон этгээд байх ба “Омни Ассет ТЗК” ХХК-ийн хувьд “Омни Капитал ББСБ” ХХК байна.
- 1.1.3. “Зээлдэгч” гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй зээлийн гэрээ байгуулж, зээлийн хүү болон үндсэн төлбөрийг зээлийн гэрээний дагуу буцаан төлөх үүргийг хүлээсэн иргэн, хуулийн этгээдийг;
- 1.1.4. “Зээл” гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид зээлийн гэрээний дагуу олгох мөнгөн хөрөнгийг;
- 1.1.5. “Зээлийн данс бүртгэл” гэж Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацаатай нь бүртгэсэн мэдээллийг;
- 1.1.6. “Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах” Багцын хөрөнгийг солих, нэмэгдүүлэх, буцаан худалдахыг;
- 1.1.7. “Зээлийн эргэн төлөлт” гэж Зээлдэгчийн зээлийн гэрээнд заасан хуваарьт үндсэн болон хүүгийн төлбөрийг;
- 1.1.8. “Төлбөр цуглуулах данс” гэж ТЗК-ийн “Үнэт цаасны төлбөр цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх журам”-ын 2.2.1-д заасан данс болох бөгөөд Цугларсан төлбөрийг хүлээн авах Капитрон банканд нээсэн 3000124051 тоот дансыг;
- 1.1.9. “Тасалбар болох огноо” гэж “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам” 4.4.1 дэх хэсэгт заасан ХБҮЦ-ны төлбөр хүлээн авах эзэмшигчдийн жагсаалтыг авсан өдрийг;
- 1.1.10. “Багцын эргэн төлөлт” гэж Үйлчилгээ үзүүлэгчээс Үнэт цаас гаргагч руу шилжүүлж буй зээлийн эргэн төлөлтийг;
- 1.1.11. “Цугларсан төлбөр” гэж Төлбөр цуглуулах дансанд цугларсан мөнгөн хөрөнгийн дүнг;
- 1.1.12. “ҮЦТХТ” гэж Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийг.

2. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ

- 2.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үйлчилгээг үзүүлнэ.
- 2.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү Гэрээний 2.1-д заасан үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан байх бөгөөд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хариуцах мэргэжилтнийг томилно.

3. Хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг эзэмших, удирдах

3.1. Хөрөнгийн багцыг удирдах, хяналт тавих:


3.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д Хөрөнгө худалдах, худалдан авах



2023

гэрээний дагуу шилжүүлсэн хөрөнгийг жагсаалтын дагуу ТЗК-ийн нэрийн өмнөөс өөрийн программ хангамжаар хүлээн авч, багцын бүртгэлийг баталгаажуулах;


- 3.1.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн хөрөнгийн багцтай холбоотой санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл, зээлийн данс бүртгэлийг өөрийн данс бүртгэл, санхүүгийн тайлан тооцоо, хөрөнгийн бүртгэлээс тусад нь бүртгэх, хөтлөх;
- 3.1.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлэн авах хөрөнгө нь ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавьж ажиллана;
- 3.1.4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зээлийн данс бүртгэлийг хянаж, алдаа, зөрчил илэрсэн бол түүнийг залруулах арга хэмжээг тухай бүр авах, Үйлчилгээ үзүүлэгчид шаардлага хүргүүлэх;
- 3.1.5. Зээлийн багцтай холбоотой бичиг баримт, мэдээллийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үйлчилгээ үзүүлэгч нараас шаардан авах эрхтэй;
- 3.1.6. ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөр ХБҮЦ-ны төлбөр болон ТЗК-ийн бусад төлбөрийн үүргүүдийг гүйцэтгэх боломжгүй болсон эсхүл, Хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гарвал энэ тухай нэн даруй ТЗК-д буюу ТЗК-ийн ТУЗ-д мэдэгдэх.
- 3.2. Багцын хөрөнгөд дараах байдлаар өөрчлөлт оруулна.
 - 3.2.1. Багцын хөрөнгийг солих;
 - 3.2.2. Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;
 - 3.2.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах.
- 3.3. Багц дахь хөрөнгөд дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож хөрөнгийг солино. Үүнд:
 - 3.3.1. Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхүйц байна гэж ТЗК үзсэн;
 - 3.3.2. Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн “Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ”-нд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн;
 - 3.3.3. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй 90-ээс дээш хоног хэтэрсэн;
 - 3.3.4. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болох нь тогтоогдсон бол;
- 3.4. Багц дахь хөрөнгөд дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч багцын хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:
 - 3.4.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангахгүй буюу ХБҮЦ-ны хөрөнгийн багцаас орох орлого нь ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
 - 3.4.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу ТЗК нь нээлтэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт ХБҮЦ гаргахаар болсон;
 - 3.4.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн



2023-11-11

тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолд нийцүүлэн үнэт цаас эзэмшигчдэд төлөх төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон.

- 3.5. Багц дахь хөрөнгөд дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана. Үүнд:
- 3.5.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээнд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
- 3.5.2. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувьд зээлийн эргэн төлөлтийн хугацаа 90-ээс дээш хоног хэтэрсэн, эсхүл 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд;
- 3.5.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд.
- 3.6. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зүгээс багц дахь зээлийн эргэн төлөлт болон Үйлчилгээ үзүүлэгчийн сарын тайланд үндэслэн хянан баталгаажуулалт хийж энэхүү Гэрээний 3.3 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн тохиолдолд хөрөнгийг солихтой холбоотойгоор дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:
- 3.6.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд заасан шалгуур хангасан “орлуулах хөрөнгийн жагсаалт”-аар солино.
- 3.6.2. Анхны үүрэг гүйцэтгэгчээс харилцан тохиролцсон орлуулах хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн программд оруулж холбогдох актыг үйлдсэнээр хөрөнгийг сольж бүртгэсэнд тооцно.
- 3.6.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д шилжүүлсэн орлуулах хөрөнгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр хэмжээ нь шаардлага хангахгүй хөрөнгийн үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүгийн дүнгийн нийлбэр дүнгээс зөрүүтэй байх тохиолдолд авлага, өглөгийг тооцоо нийлсэн актад тусгаж, барагдуулна.
- 3.7. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зүгээс хянан баталгаажуулалт хийсний үндсэн дээр энэхүү Гэрээний 3.4 дэх хэсэгт заасан нөхцөл үүссэн талаар мэдээллийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдээлж, дараах байдлаар хөрөнгийг нэмэгдүүлэх ажиллагааг гүйцэтгэнэ.
- 3.7.1. Багц дахь Зээлийн эргэн төлөлтийн мэдээлэлд үндэслэн багцын хөрөнгийг нэмэгдүүлэх дүнг гаргаж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний тусгай нөхцөлийн 4 дүгээр зүйлд заасан шалгуур хангасан “нэмэгдүүлэх хөрөнгийн жагсаалт”-ыг авч харилцан тохиролцож нэмэгдүүлнэ.
- 3.7.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон нэмэгдүүлэх хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн программд оруулж холбогдох актыг үйлдэж, тооцоог хийснээр хөрөнгийн багцыг нэмэгдүүлж бүртгэгдсэнд тооцно.
- 3.8. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зүгээс хянан баталгаажуулалт хийсний үндсэн дээр энэхүү Гэрээний 3.5 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн талаар мэдээллийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид дараах байдлаар мэдээлж, багцыг буцаан худалдах ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:
- 3.8.1. Гэрээний 3.5.1-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй зээлийн хөрөнгийг буцаан



2023.8.2

БҮРТГЭВ



худалдах актыг үйлдэж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь буцаан худалдсан зээлийн холбогдох төлбөрийг ТЗК-д шилжүүлнэ.

- 3.8.2. Гэрээний 3.5.2, 3.5.3-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэгчийн тайланд үндэслэн багцын хөрөнгийн үлдэгдлийг гаргаж ТЗК-ийн ТУЗ-д танилцуулж буцаан худалдах эсэхийг шийдвэрлүүлнэ.
- 3.8.3. Гэрээний 3.8.2-д заасны дагуу багцыг буцаан худалдахаар шийдвэрлэсэн тохиолдолд ТЗК нь буцаан худалдах мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлнэ.
- 3.8.4. Гэрээний 3.8.3-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ТЗК-тай Хөрөнгийн багцыг буцаан худалдах гэрээг байгуулж, холбогдох төлбөрийг төлнө.
- 3.9. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ гэрээний 3.2-д заасан нөхцөлийг хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулан ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргийг гүйцэтгүүлэх бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой Үйлчилгээ үзүүлэгчид шүүхэд нэхэмжлэл гаргахыг мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавина.
- 3.10. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү Гэрээнд заасан багцад өөрчлөлт оруулахтай холбоотой баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллана.
- 3.11. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 11.3, 11.4-д заасан мэдээлэл, тайланг тус журамд заасан хугацаанд хүргүүлнэ.
- 4. Үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх**
- 4.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү Гэрээнд заасны дагуу төлбөр цуглуулах дансны хуулга авах, үлдэгдэл шалгах эрхтэй бөгөөд Үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр цуглуулах дансанд шилжүүлсэн Хөрөнгийн багцын эргэн төлөлтийн дүнг Зээлийн данс бүртгэлтэй тулган бүртгэж, баталгаажуулна.
- 4.2. ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөс зарлага гаргахтай холбоотой эрхийг ТЗК-ийн ТУЗ-өөс өгсөн зөвшөөрлийн хүрээнд Хөрөнгө итгэмжлэн удирдагч хэрэгжүүлнэ.
- 4.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам”-д заасны дагуу Үнэт цаас гаргагчийг төлөөлөн ХБҮЦ-ны төлбөр хүлээн авах бөгөөд Үнэт цаас эзэмшигчдийн жагсаалтыг ҮЦТХТ-өөс авч, ХБҮЦ-ны төлбөрийн тооцооллыг хийж ҮЦТХТ-д хүргүүлнэ.
- 4.4. ТЗК нь ҮЦТХТ-тэй ХБҮЦ хадгалуулах, ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэх зорилгоор гэрээ байгуулах бөгөөд “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам”-д заасны дагуу тухай бүр холбогдох төлбөрийг ҮЦТХТ-ийн дансанд байршуулна.
- 4.5. ТЗК нь ҮЦТХТ-өөс Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дансанд ХБҮЦ борлуулсны орлого орж ирсэн өдрөөс эхлэн Хүүгийн төлбөрийг улирал тутамд, үндсэн төлбөрийг хугацааны эцэст төлнө.
- 4.6. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөрийн тооцоог гаргахдаа татварын өмнөх болон дараах байдлаар гаргах бөгөөд ТЗК нь татварыг хассан дүнгээр ҮЦТХТ-д шилжүүлж, ТЗК нь үнэт цаас эзэмшигчийн нэрээр холбогдох татварыг суутган тайлагнана.



4.7. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдөх хуваарь, үнийн дүнгийн тооцооллыг алдсан, үнэт цаас эзэмшигчийн мэдээллийг буруу бичсэн зэрэг төлбөр тооцоотой холбоотой алдаа гарсан бол нэн даруй алдааг засах арга хэмжээ авна. Хэрэв хөрөнгө итгэмжлэн удирдагчийн гаргасан алдааны улмаас үнэт цаас эзэмшигч, ТЗК болон бусад этгээдэд хохирол учирсан бол хохирлыг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.

4.8. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдсөн өдрөөс хойш 3 хоногийн дотор “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-д заасны дагуу ХБҮЦ-ны төлбөр төлсөн тухай мэдээллийг хүргэнэ.

4.9. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдсөн өдрөөс хойш 3 хоногийн дотор ХБҮЦ эзэмшигчдийн жагсаалт, эзэмшигч буй нэгж ХБҮЦ-ны тоо, ХБҮЦ эзэмшигчид төлөгдсөн төлбөр, татварт төлсөн дүн зэрэг мэдээллийг ТЗК-ийн ТУЗ-д танилцуулна.

5. Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт

5.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Төлбөр цуглуулах дансан дахь ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөрөөс илүү гарсан хэсэг буюу түүнд хамаарахгүй мөнгөн хөрөнгөөр дараах зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтыг төгрөгөөр хийж болно. Үүнд:

5.1.1. Арилжааны банкны хадгаламжид байршуулах;

5.1.2. Монгол Улсын Засгийн газар, Монголбанкаас гаргасан үнэт цаасыг худалдан авах;

5.1.3. Зохицуулагч байгууллагаас зөвшөөрсөн аливаа хэлбэрээр хөрөнгө оруулах.

5.2. Гэрээний 5.1-т заасан хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэлийг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.

5.3. Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт хийх үед эрсдэл үүсэхээр бол зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт хийхийг хориглоно.

5.4. ХБҮЦ-ны төлбөрийг хугацаандаа төлөх боломжийг хангах зорилгоор зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын дуусах хугацааг ХБҮЦ-ны төлбөр төлөх хугацаатай уялдуулж тохируулсан байна.

6. Баталгаа

6.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээний хугацаанд дараах баталгааг ТЗК болон ХБҮЦ эзэмшигч нарт гаргаж байна. Үүнд:

6.1.1. ХБҮЦ эзэмшигчийн эрх ашгийг тэргүүн ээлжид хамгаалж ажиллах;

6.1.2. Хөрөнгийн багцыг зохистой удирдах болон энэхүү гэрээнд заасан үйлчилгээ үзүүлэхээс өөрөөр итгэмжилсэн хөрөнгийг ашиглахгүй, мэдээллийг тухай бүр үнэн зөвөөр ХБҮЦ эзэмшигчид, эрх бүхий байгууллага болон ТЗК-ийн ТУЗ-д тайлагнаж ажиллах;

6.1.3. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах, түүнийг хэрэгжүүлэх холбогдох зөвшөөрлийг авсан болно;

6.1.4. ТЗК-ийн хөрөнгийг өөрийн компанийн хөрөнгөөс тусад нь бүртгэх;

6.1.5. ТЗК-д энэхүү гэрээнд заасан үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бүрдүүлсэн бөгөөд харилцан ажиллах мэргэжлийн, ёс зүйтэй мэргэжилтнийг томилон ажиллуулах;

6.1.6. ТЗК болон ХБҮЦ эзэмшигчийн эрх ашигт харш, тэдгээрийг хохироосон аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх;



2023 -11-

Хөрөнгө итгэмжлэн удирдагч эсхүл түүнээс томилсон ажилтны буруутай үйлдлийн улмаас ТЗК, ХБҮЦ эзэмшигч нарт шууд болон шууд бус хохирол учруулсан бол хохирлыг өөрийн хөрөнгөөр барагдуулна.



7. Үйлчилгээний хөлс

- 7.1. ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас ирүүлсэн нэхэмжлэхэд үндэслэн энэхүү гэрээний хавсралт №1-д заасан хуваарийн дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн Худалдаа хөгжлийн банкны 499358818 тоот дансанд төлнө. Төлбөр төлөх өдөр нь ажлын бус өдөр таарсан тохиолдолд дараагийн ажлын өдөрт багтаан шилжүүлнэ.
- 7.2. Үйлчилгээний хөлсөнд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар багтсан бөгөөд хуульд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч тайлагнана.
- 7.3. ТЗК нь Гэрээний 7.1-т заасан хугацаанд үйлчилгээний хөлсийг төлөөгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн дүнгээс хоногийн 0.1 хувийн алданги тооцно.
- 7.4. ТЗК нь үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагчдад үнэт цаасны хугацаанаас өмнө урьдчилан төлж дуусгасан эсхүл Гэрээний тусгай нөхцөлийн 2.1-т заасан нөхцөл үүсээгүй байхад Үнэт цаас гаргагчийн саналаар гэрээг үндэслэлгүйгээр цуцалсан тохиолдолд үлдэх хугацаанд хамаарах гэрээний Хавсралт №1-т тусгасан үйлчилгээний хөлсийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид 1 (нэг) удаа бөөн дүнгээр төлнө.

8. Гэрээ хүчин төгөлдөр болох

- 8.1. Энэхүү гэрээ нь Санхүүгийн зохицуулах хорооноос ХБҮЦ-ыг олон нийтэд санал болгон арилжаалах зөвшөөрөл олгосноор талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 8.2. Гэрээг 5 хувь үйлдэх бөгөөд эдгээр нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна. Үнэт цаас гаргагч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Андеррайтерт хадгалуулна.

9. Гэрээний хугацаа

- 9.1. Энэхүү Гэрээ нь байгуулагдсан үеэс эхлэн талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дуусгавар болох хүртэл буюу ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дуусган Үнэт цаас гаргагч татан буугдах өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.
- 9.2. ХБҮЦ-ны хугацаа дуусахаас өмнө Анхны үүрэг гүйцэтгүүлэгч ХБҮЦ-ыг буцаан худалдан авсан тохиолдолд хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно.

10. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал

- 10.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас тухайлбал (дайн, гал түймэр, үер, газар хөдлөлт, ажил хаялт, гоц халдварт өвчин, хөл хорио гэх мэт) зэрэг нөхцөл байдал нь гэрээний үүргийн биелэлтэд шууд нөлөөлсөн нотлогдсон бол талууд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөгдөнө. Энэ үед гэрээний үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 10.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсон ба үүний улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тухайгаа нотлох үүрэг хүлээнэ.
- 10.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн талаар тухайн цаг үед нь нөгөө талдаа мэдэгдээгүй бол ирээдүйд уг нөхцөл байдлыг үндэслэл болгох эрхгүй.





11. Гэрээнд ашигжих хэл БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE

11.1. Энэхүү гэрээнд Монгол хэлийг ашиглана. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах баримт бичиг нь энэ хэл дээр байна.

12. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

- 12.1. Талуудын аль нэг нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдэж, харилцан зөвшилцөнө.
- 12.2. Талууд харилцан зөвшилцсөн гэрээний нэмэлт өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн холбогдох зөвшөөрлийн үндсэн дээр нэмэлт өөрчлөлтийг зөвхөн бичгээр байгуулж, талууд гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 12.3. Гэрээний нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд Гэрээний нэгэн адил үйлчилнэ.

13. Эрх залгамжлах болон гэрээний үүргийг шилжүүлэх

- 13.1. Энэхүү Гэрээ нь Талуудын холбогдох эрх залгамжлагчид мөн адил үйлчилнэ.
- 13.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан “эрх хүлээн авагч” нь хөрөнгө болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад шаардлагатай бүх арга хэмжээ авч, ТЗК-ийн нийт хөрөнгө, санхүүгийн тайлан, тэнцэл, баримт бичиг, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг зэргийг хүлээн авч Үнэт цаас гаргагчийн эрх залгамжлагчаар тооцогдоно.
- 13.3. Хууль ёсны эрх залгамжлагчдаас бусад этгээдэд үүргийг шилжүүлэхийг хориглоно.
- 13.4. Дээрх тохиолдолд энэхүү гэрээг хэрэгжүүлэхээр байгуулсан бусад гэрээнүүд хүчин төгөлдөр байна.

14. Гэрээний нууцлал

- 14.1. Нийгэд ил болгосон, эсхүл ХБҮЦ гаргах ажиллагааны хүрээнд Үнэт цаасны танилцуулгад тусгаж олон нийгэд танилцуулагдах болон холбогдох хууль журмын дагуу тодорхой этгээдүүдэд танилцуулах мэдээллээс бусад мэдээллийг нууц мэдээлэл гэнэ.
- 14.2. Талууд хууль тогтоомж төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад нууц мэдээллийг бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр аливаа этгээдэд задруулах, хэрэглэх эсвэл өөр бусад зорилгоор ашиглахыг хориглоно.
- 14.3. Нууц мэдээллийг талууд гэрээ цуцлагдсан эсхүл дуусгавар болсон өдрөөс хойш 10 жилийн хугацаанд хадгална.
- 14.4. Дээрх тохиолдолд нууц мэдээллийг задруулсан тал нөгөө талдаа яаралтай мэдэгдэх үүрэг хүлээнэ.

15. Хүчингүй заалтууд

- 15.1. Холбогдох хуулийн дагуу энэхүү Гэрээний аливаа заалт хууль бус, хүчингүй, хэрэгжүүлэх боломжгүйд тооцогдвол:
 - 15.1.1. Тус заалт нь бүрэн салгах боломжтой;
 - 15.1.2. Тус хууль бус, хүчингүй болон хэрэгжих боломжгүй заалт нь өмнө энэхүү гэрээний заалт байгаагүйд тооцогдох бол;
 - 15.1.3. Гэрээний бусад заалтууд хүчинтэй хэвээр байх бөгөөд тус хүчингүй, хууль бус болон хэрэгжих боломжгүй заалт нь ямар нэг байдлаар гэрээний бусад заалтад нөлөөлөхгүй.





16.1. Талуудын хооронд энэхүү Гэрээний зүйлтэй холбоотой асуудлаар өмнө нь хэлэлцэгдэж байсан хэлцэл, харилцан ойлголцлын санамж бичиг, урьдчилсан нөхцөлүүд, Гэрээ болон бусад хэлэлцээр (Бичгээр болон амаар хийгдсэнээс үл хамааран бүх харилцаа холбоог үүнд хамааруулна) байгаа бол тэдгээрийг энэхүү Гэрээ бусад хэлэлцээрийн баримт бичгийн хамт орлох бөгөөд энэхүү Гэрээ нь (аливаа нэмэлт өөрчлөлт болон бусад Хэлэлцээрийн баримт бичгийн хамт) үүний дагуу зохицуулагдаж буй асуудлын хувьд талуудын хооронд хийгдсэн цорын ганц нэгдмэл гэрээнд тооцогдоно.



1. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих

- 1.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээнд заасан зөрчил гаргасан эсхүл гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, үүргээ биелүүлэх шаардлага хүргүүлсэн боловч гаргасан зөрчлөө арилгаагүй, үүргээ гүйцэтгэхгүй болох нь тогтоогдсон эсхүл үүргээ биелүүлэх чадваргүй болсон, дампуурах нөхцөл байдал бий болсон, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих шаардлага үүссэн зэрэг тохиолдолд Гэрээг ТЗК-ийн ТУЗ-ийн шийдвэрээр цуцална.
- 1.2. Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг энэхүү Гэрээ болон холбогдох хууль, журамд заасан үндэслэлээр солих тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагчид ажлын 30 өдрийн өмнө мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 30 өдөрт багтаан Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хадгалагдаж байсан ХБҮЦ-ны болон Хөрөнгийн багцтай холбоотой баримт бичгийг Үнэт цаас гаргагчийн шинээр томилогдсон этгээдэд хүлээлгэн өгөх эрхтэй.
- 1.3. Үнэт цаас гаргагч нь шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгон, томилж амжаагүй тохиолдолд буюу шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчтай гэрээ байгуулах хүртэл ТЗК-ийн ТУЗ өөрөөр шийдвэрлээгүй бол тийнхүү шинээр томилогдох хүртэл хугацаанд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хууль тогтоомж болон энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ хэвийн, урьдын адил гүйцэтгэх үүрэгтэй.
- 1.4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шинээр томилогдсон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид ажил хүлээлцэх актын дагуу ТЗК-тай холбоотой эзэмшиж байсан бүхий л мэдээлэл, баримт бичиг, данс тооцоо, бэлэн мөнгө, тайланг баримтаар болон цахимаар ямар нэгэн шимтгэлгүйгээр хүлээлгэн өгснөөр гэрээ цуцлагдсанд тооцно.

2. Гэрээний үүрэг зөрчсөнд тооцох

- 2.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг дараах тохиолдолд зөрчил гаргасанд тооцож, гэрээг цуцлах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
 - 2.1.1. Энэхүү Гэрээнд заасан Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээг гэрээнд зааснаар гүйцэтгээгүй, гүйцэтгэхийг шаардсан хэдий ч зөрчлөө заасан хугацаанд арилгаагүй;
 - 2.1.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэт, зохих ёсны дагуу гүйцэтгээгүйн улмаас ХБҮЦ эзэмшигчид болон ТЗК-д шууд болон шууд бус хохирол учирсан;
 - 2.1.3. Хөрөнгийн багцыг буруу удирдсан буюу хөрөнгийн багцад зохих өөрчлөлт оруулаагүйгээс ХБҮЦ-ны төлбөр хүрэлцэхгүй болсон, ХБҮЦ эзэмшигчид хугацаандаа төлбөр хүлээн авах боломжгүй нөхцөлийг бий болгосон;
 - 2.1.4. ХБҮЦ эзэмшигчид, эрх бүхий этгээдэд хүргэх мэдээллийг “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-д заасан хугацаанд удаа дараа мэдээлээгүй.
- 2.2. ТЗК-ийг дараах тохиолдолд зөрчил гаргасан тооцож, гэрээг цуцлах арга хэмжээг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хэрэгжүүлнэ.
 - 2.2.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний хөлсийг төлбөр төлөх өдрөөс 10 ба түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн.



2.3. Гэрээний үүрэг зөрчсөний хариуцлага.

2.3.1. Зөрчил гаргасан тал нь уг зөрчилтэй холбоотой нөгөө талд учирсан хохирлыг шууд болон шууд бус хохирлыг төлөх үүргийг хүлээнэ.

2.3.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн буруутай үйл ажиллагаанаас хамааран ХБҮЦ-ны төлбөрийг хоцроосон бол хоцроосон өдрөөр тооцон ХБҮЦ эзэмшигчид холбогдох хүүг нэмж төлөх үүргийг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.

3. Эрх шилжүүлэх

3.1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхдээ шаардлагатай туслалцаа авах зорилгоор туслах этгээдийг томилон ажиллуулах боломжтой. Энэ тохиолдолд туслах этгээдийн мэдээлэл, гүйцэтгүүлэх ажлыг урьдчилан ТЗК-д мэдэгдсэн байна.

3.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн үзүүлэх үйлчилгээтэй холбоотой туслах этгээд ажиллуулахтай холбоотой зардлыг дангаараа хариуцна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

“ЮУ ЭЙ ЭФ АССЕТ МЕНЕЖМЕНТ”
ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Нэр: А.Батболд

Нэр: Х.Маргад-Эрдэнэ

Албан тушаал: ТУЗ-ийн дарга

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

Гарын үсэг:



2023-11-05 Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний хөлс
БҮРГЭВ-02

№	Төлбөр төлөх огноо	Төлөх төлбөрийн дүн (төгрөг)
1	2023/09/05	5,000,000.00
2	2023/10/05	5,000,000.00
3	2023/11/06	5,000,000.00
4	2023/12/05	5,000,000.00
5	2024/01/05	5,000,000.00
6	2024/02/05	5,000,000.00
7	2024/03/05	5,000,000.00
8	2024/04/05	5,000,000.00
9	2024/05/06	5,000,000.00
10	2024/06/05	5,000,000.00
11	2024/07/05	5,000,000.00
12	2024/08/05	5,000,000.00
13	2024/09/05	5,000,000.00
14	2024/10/07	5,000,000.00
15	2024/11/05	5,000,000.00
16	2024/12/05	5,000,000.00
17	2025/01/06	5,000,000.00
18	2025/02/05	5,000,000.00
19	2025/03/05	5,000,000.00
20	2025/04/07	5,000,000.00
21	2025/05/05	5,000,000.00
22	2025/06/05	5,000,000.00
23	2025/07/07	5,000,000.00
24	2025/08/05	5,000,000.00
Нийт		120,000,000.00



СЭХ
2023.09.16 өдөр

2023.09.16
УТТГ-3-32



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000236781



2021.09.16 / Бүртгэсэн он, сар, өдөр /
9011831586 / Хувийн хэргийн дугаар /
2870657 / Регистрийн дугаар /

Юнайтед айр файнэнс Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, харилцлагын хэлбэр /

Дүрэм / Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр 01 2005.01.27
/ шийдвэрийн нэр / / дугаар / / он, сар, өдөр /

46100 Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа
- Код / Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй 1 50,000.00
/ хугацаа / / гишүүдийн тоо / / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, СТӨ-ний 10 давхарт 1005 тоот, Утас1: 80808888, Утас2: ,
Факс
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Э. БАТОЧИР
Гарын үсэг



2023-11-15

он 2023 сар 11 Өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Хүрэл овогтой Маргадэрдэнэ-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(төмилсөн)-ыг бүртгэв	2021.09.16	Э.Балынцур
2	46100 Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа үйл ажиллагааг хассаныг бүртгэв. 68200 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа /2021.10.28-/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2021.11.09	Т.Зулзаяа
3	68200 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа үйл ажиллагааг хассаныг бүртгэв. 66110 Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2022.04.19	Т.Зулзаяа
4	Юнайтед айр файнэнс оноосон нэр Юу Эй Эф ассет менежмент болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2023.07.26	Ш.Шижиртуяа



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



000236781



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 316/18

2021 оны 10 сарын 28 өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 28 өдрийн 473 дугаар тогтоолоор "ЮУ ЭЙ ЭФ АССЕТ МЕНЕЖМЕНТ" ХХК -д Хөрөнгө итгэмжлэн удирдах

_____ үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов

ДАРГА
Тамга



Д БАЯРСАЙХАН



СЗХ
 о-2023-01. 06 дөр
 4. АНД ТӨВ ГЭВ
 № 1

"Олон улс Аирлайнс" ХХК-ийн өнөөсөн ирэн 10 үйлдвэр Ассет Менежмент" ХХК-ийн өнөөсөн ирэн

2023-11-15

ДОРОВ Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн гэмдэгт

БҮРТГЭЭ-02

Дэд	Хаяг	Утас	Гэмдэгт хийсэн огноо, ГЭМДЭГ
1	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, СТО-нийн 10 давхар, 1005 тоот.	70122346	2

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн гэмдэгт

Дэд	Хувь нийлүүлсэн хөрөнгийн нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ
1.		2021.10.28	№473	50.000.000



2023-11-13

ҮРТГЭВ-02

“ОМНИ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 07 сарын 20 -ны өдөр

Улаанбаатар хот

Хурлын ирц: ТУЗ-н гишүүн С.Нина
ТУЗ-н гишүүн Х.Хэрлэн
ТУЗ-н гишүүн А.Батболд 100%-ийн ирцтэйгээр хуралдав.

Хурал болсон газар: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр оффис, 712 тоот хурлын өрөө

Хурал эхэлсэн, дууссан: 2023 оны 07 сарын 20-ны өдрийн, 11:00 цагт эхэлж 12:00 цагт дуусав.

Хурлаар хэлэлцсэн асуудал: Санхүүгийн тайлан дээр аудит хийлгэх аудитын газар сонгох

Хэлэлцсэн нь:

“Омни ассет ТЗК” ХХК-ийн санхүүгийн дөрвөн тайлан дээр үнэлгээ хийх аудитын байгууллага сонгох талаар хэлэлцэв.

Шийдвэрлэсэн нь:

Хэлэлцсэн асуудлын хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөл дараах шийдвэрийг санал нэгтгэйгээр гаргав.

- “Аудитын үйлчилгээ үзүүлэгчээр 100 хувийн саналтайгаар нягтлан бодох бүртгэлийн итгэмжлэгдсэн байгууллага болох “Шонхор үнэлгээ Аудит” ХХК сонгов.
- Аудитын үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулах эрхийг ТУЗ-ийн дарга А.Батболд-д олгов.

Хурлын тэмдэглэлийг баталгаажуулсан:

ТУЗ-ийн дарга А.Батболд: _____

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ТУЗ-н гишүүн С.Нина: _____

ТУЗ-н гишүүн Х.Хэрлэн: _____





2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөр

№23/52

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Сүхбаатар-13, Метробизнес төв, 6 давхар 603 /Зип код:6920/ хаягт байрлах Улсын бүртгэлийн 9018018003, регистрийн 5821975 дугаартай, нягтлан бодох бүртгэлийн итгэмжлэгдсэн байгууллага болох “Шонхор үнэлгээ Аудит” ХХК (цаашид “Аудитор” гэх)-ийг төлөөлж Захирал Д.Шийрэв, нөгөө талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 11-р хороолол, N тауэр оффис, 403 тоот хаягт байрлах регистрийн 8356327 дугаартай, “Омни ассет” ХХК-ийг төлөөлж (цаашид “Үйлчлүүлэгч” гэх)-ийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга А.Батболд нар харилцан тохиролцож, дараах нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр гэрээ байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Гэрээний зорилго нь Үйлчлүүлэгчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болох санхүүгийн тайлангийн Аудитын ажилд нэмэлт тодруулга хийх зохицуулахад оршино.
- 1.2 Гэрээ нь Үйлчлүүлэгч ХБҮЦ гаргасан өдрөөс эхлэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааны санхүүгийн үйл ажиллагаанд хамаарах бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын ажлыг гүйцэтгэж, зохих дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлснээр дуусгавар болно.

ХОЁР. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Байгууллагын аж ахуй санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд холбогдох стандартын дагуу үнэн зөв тусган, мөн эдгээртэй холбогдох баримт, материал, тайлбарыг бүрэн танилцуулах бөгөөд энэ талаар үүсэх хариуцлагыг хүлээх тухайгаа нотолсон тодорхойлолтыг Аудиторт гаргаж өгнө.
- 2.2. Санхүүгийн тайлангаа баглагдсан маягт, зааврын дагуу үнэн зөв гаргаж, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-д заасан хугацаанд Аудиторт ирүүлнэ. Тайлант үед хамаарагдах ажил гүйлгээний бүх баримт, мэдээг бүртгэл тайландаа бүрэн тусгаж, тайланг бэлтгэхдээ Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын дагуу нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим бодлогыг мөрдлөгө болгоно.
- 2.3. Тайлангаа Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн талаар гаргасан хуульчилсан акт, дүрэм, журам, стандарт, аргачлалын дагуу үнэн зөв гаргасан байна. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулалтын баримт бичиг /гэрээ, дүрэм/-т өөрөөр заасан бол түүний заалтын дагуу тайлан гаргасан байж болно.
- 2.4. Санхүүгийн тайланг шалгаж баталгаажуулах явцад нэмэлт мэдээ, баримт тодотгол шаардагдах бол түүнийг тухай бүрд Аудиторт гаргаж өгнө. Мөн нэмэлт бичилт, залруулга, өөрчлөлтийг Аудиторын шаардсан хугацаанд хийх үүрэг хүлээнэ.
- 2.5. Үйлчлүүлэгч нь Аудитороос тайлангийн талаар гаргасан дүгнэлтэй санал зөрсөн тохиолдолд аудитын дүгнэлтийн талаар тайлбар өгөхийг шаардах эрхтэй.
- 2.6. Аудиторт гаргаж танилцуулсан санхүүгийн баримтын үнэн зөв, бодитой байх хариуцлагыг Үйлчлүүлэгч байгууллагын удирдах ажилтан хүлээнэ.
- 2.7. Үйлчлүүлэгч Аудиторын үйлчилгээний төлбөрийг бүхэлд нь төлж барагдуулах үүрэг хүлээнэ.



ГУРАВ. АУДИТОРЫН ЭРХ, ҮҮРЭГ



- 3.1. Үйлчлүүлэгчийн ирүүлсэн тайланг Аудиторроор шалгуулна. Аудитор шаардлагатай гэж үзвэл гэрээт болон туслах аудитор авч ажиллуулж болно.
- 3.2. Үйлчлүүлэгчийн тайланг шалгаж баталгаажуулахдаа нягтлан бодох бүртгэл, санхүүгийн талаарх хуульчилсан акт, дүрэм, журам, заавар, стандарт, аргачлалыг удирдлага болгон ажиллана.
- 3.3. Үйлчлүүлэгчийн тайланг баталгаажуулахдаа:
 - 3.3.1. Тайлан иж бүрдэл болсон эсэх;
 - 3.3.2. Нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтөлсөн эсэх;
 - 3.3.3. Тайланг зохих аргачлалын дагуу гаргасан эсэх;
 - 3.3.4. Хөрөнгийн болон авлага, өглөгийн дансны үлдэгдлийн баталгаа буй эсэх;
 - 3.3.5. Үйл ажиллагааныхаа орлого, зарлага, үр дүнг бүртгэл, тайландаа үнэн зөв бөгөөд бүрэн гүйцэт тусгасан эсэх;
 - 3.3.6. Үйлчлүүлэгчийн хөрөнгө санхүүгийн нөөцийн байршил ба ашиглалтын байдал зэргийг онцлон анхаарна.
- 3.4. Үйл ажиллагааны баримтжуулалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалтын талаар мэргэжлийн зөвлөгөө өгч тусална.
- 3.5. Үйлчлүүлэгчээс гаргаж ирүүлсэн тайланг үндэслэн баримт, холбогдох мэдээ, мэдээлэлд тулгуурлан шалгаж баталгаажуулах ба шаардлагатай гэж үзсэн нэмэлт баримт материалыг шаардаж авах, биечлэн үзэх, тайлбар нотолгоог хүмүүсээс бичгээр гаргуулан авах эрхтэй.
- 3.6. Санхүүгийн тайланг баталгаажуулахтай холбогдсон хариуцлагыг аудитын байгууллага хүлээнэ.

ДӨРӨВ. АЖЛЫН ХУГАЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

- 4.1. Аудитор нь Үйлчлүүлэгчийн тайлан, холбогдох баримт материалыг бүрэн хүлээн авсан өдрөөс эхлэн аудитын ажлыг гүйцэтгэх бөгөөд материалыг бүрэн хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор аудитыг хийж гүйцэтгэн, дүгнэлтийг Үйлчлүүлэгчид хүлээлгэн өгнө.
- 4.2. Энэхүү санхүүгийн тайлангийн аудитын ажлын хөлс нь 6,000,000 (зургаан сая) төгрөг байна. Энэхүү дунд бүх төрлийн татвар, зардлууд багтсан болно.
- 4.3. Ажлын хөлсний 50 хувийг аудитын ажлыг эхлэхэд, үлдэгдэл 50 хувийг Аудитор аудитын ажлыг гүйцэтгэн, дүгнэлтийг Үйлчлүүлэгч хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Гэрээнд заасан дансанд шилжүүлнэ.
- 4.4. Аудитор төлөх үйлчилгээний төлбөрийг доор дурьдсан дансанд шилжүүлнэ.

Харилцагчийн нэр: Шонхор үнэлгээ Аудит ХХК
Банк: Голомт банк 1165114887 /төгрөгийн/
ХХБанк 411018425 /төгрөгийн/

ТАВ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ГЭРЭЭГ ЦУЦЛАХ БОЛОН ДУУСГАВАР БОЛГОХ ҮНДЭСЛЭЛ

- 5.1. Энэхүү гэрээнд гагцхүү талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр хийсэн гэрээний хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд эх хувьд баллаж засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг хүчингүйд тооцно.
- 5.2. Аль нэг нь энэхүү гэрээнд заасны дагуу гэрээг хугацаанаас өмнө цуцлах эсвэл гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хүсвэл энэ тухайгаа нэг сараас доошгүй хугацааны өмнө нөгөө талд албан бичгээр мэдэгдэнэ.



- 5.3. Энэхүү гэрээг аль нэг талын санаачилгаар үндэслэлгүйгээр цуцлахыг хориглох бөгөөд дараах тохиолдолд гэрээг цуцалж болно.
- 5.3.1. Талууд харилцан тохиролцсоны дагуу гэрээг цуцлах
- 5.3.2. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар шаардлага хүргүүлэх бөгөөд шаардлагад дурьдсан хугацаанд үүргээ биелүүлээгүй бол
- 5.4. Энэхүү гэрээний хугацаа дууссан, эсхүл аль нэг тал нь эрх зүйн чадамжгүй болсон, энэхүү гэрээнд заасны дагуу гэрээ цуцлагдсан тохиолдолд гэрээ дуусгавар болно.



ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

- 6.1. Аудитор нь Үйлчлүүлэгчийн үйл ажиллагааны технологийн болон бизнесийн нууцыг бусдад задруулахгүй байх үүрэг хүлээнэ.
- 6.2. Үйл ажиллагааны орлого, зарлага, санхүүгийн үр дүнг тайландаа буруу, эсхүл дутуу тусгаснаас үүсэх материаллаг хохирлыг Үйлчлүүлэгч бүрэн хариуцна. Аудитор нь энэ талаар Үйлчлүүлэгчийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.
- 6.3. Аудитор нь Үйлчлүүлэгч болон холбогдох этгээдээс ямар нэгэн хэлбэрээр хараат бусаар бие дааж үйл ажиллагаа явуулна.
- 6.4. Гэрээнд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудлыг аль нэг тал санал болгоогүй нөхцөлд уг гэрээг хүчинтэйд тооцно.
- 6.5. Аудитор нь Үйлчлүүлэгчийнхээ тайланг баталгаажуулах хугацааг гэрээнд зааснаас хэтрүүлсэн нь Үйлчлүүлэгчээс хамаараагүй бол хугацаа хэтрүүлсэн ажлын хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.
- 6.6. Аудитор нь Бүх нийтийн байдлын зэрэгт шилжсэн, хөл хориотой холбоотой гэрээнд заасан хугацааг хэтрүүлсэн тохиолдолд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлд хамаарахгүй буюу энэхүү гэрээний 6.5-д заасны дагуу алданги тооцно.
- 6.7. Гэрээний талаар маргаан гарвал харилцан хүндэтгэх байр сууринаас хандан зөвшилцөж, шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.8. Гэрээг Монгол хэлээр хууль эрх зүйн хувьд адил хүчин төгөлдөр 2 /хоёр/ хувь үйлдэж Үйлчлүүлэгч 1 хувь, Аудитор 1 хувь хадгалах бөгөөд Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

5821975

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үйлчлүүлэгчийг төлөөлж:
“Омни ассет ТЗК” ХХК -ийн

ТУЗ-ИЙН ДАРГА А.БАТБОЛД

Утас: 99795115



Аудиторыг төлөөлж:
“Шонхор үнэлгээ Аудит” ХХК-ийн

ЗАХИРАЛ ДЭШИЙРЭВ

Утас: 7015-0001, 80110088





Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 8-р хороо
Соёлын төв өргөө 10 давхар 1005 тоот
Утас/факс: 976-70122346, Утас: 976-70142346
Шуудангийн хаяг: Улаанбаатар хот 15160, Ш/Х 186

2023/08/03 № 23/38
танай _____ -ны № _____ -т

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг
сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай,

"Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК (РД: 2870657) ("Компани") нь "Омни Ассет ТЗК" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг биржийн зах зээлд олон нийтэд танилцуулах, санал болгох төсөлд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Компани нь уг үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч дор дурдсан хуулийн этгээдүүдтэй холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран оролцож буйгаас өөрөөр аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохыг үүгээр баталгаажуулж байна. Үүнд:

- i. Үнэт цаас гаргагч "Омни Ассет ТЗК" ХХК;
- ii. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч бөгөөд үйлчилгээ үзүүлэгч "Омни Капитал ББСБ" ХХК;
- iii. Зээлийн шинжилгээ гаргагч "Шонхор Үнэлгээ Аудит" ХХК;
- iv. Хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч Өмгөөллийн "ХаанЛекс Партнерс" ХХН;
- v. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Апекс Капитал ҮЦК" ХХК.

Компани нь дээр заасан хуулийн этгээдүүдтэй үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг тухай бүр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу авч хэрэгжүүлэхээ үүгээр мэдэгдэж байна.

Түүнчлэн, Компани, түүний эрх бүхий албан тушаалтнууд нь Санхүүгийн зохицуулах хорооны банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам батлах тухай 179 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа болно.

Хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.МАРГАД-ЭРДЭНЭ





Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН
Монгол Улс, Улаанбаатар 14240
Сүхбаатар дүүрэг, Олимпын гудамж 5,
Аюуд Тауэр, 14-р давхар, 1404 тоот
Утас/Факс +976-7747-1122
Имэйл: info@khanlex.mn
Вэб: www.khanlex.mn

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНД

2023.07.26 № 1/03/239

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай

“ХаанЛекс Партнерс” ХХН [РД:6351034] (“Хуулийн фирм”) нь “Омни ассет ТЗК” ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг биржийн зах зээлд олон нийтэд танилцуулах, санал болгох төсөлд хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчээр ажиллаж байна. Хуулийн фирм нь уг үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч дор дурдсан хуулийн этгээдүүдтэй холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран оролцож буйгаас өөрөөр аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохыг үүгээр баталгаажуулж байна. Үүнд:

- i. Үнэт цаас гаргагч “Омни ассет ТЗК” ХХК;
- ii. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч бөгөөд үйлчилгээ үзүүлэгч “Омни капитал ББСБ” ХХК;
- iii. Хөрөнгө итгэмжлэн удирдагч “Юнайтед Айр Файнэнс” ХХК
- iv. Зээлийн шинжилгээ гаргагч “Шонхор үнэлгээ аудит” ХХК

Хуулийн фирм нь дээр заасан хуулийн этгээдүүдтэй үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг тухай бүр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу авч хэрэгжүүлэхээ үүгээр мэдэгдэж байна.

Түүнчлэн, Хуулийн фирм, түүний эрх бүхий албан тушаалтнууд нь Санхүүгийн зохицуулах хорооны банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам батлах тухай 179 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа болно.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ЦАХГАЛБАЯР





САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНД

“АПЕКС КАПИТАЛ ҮЦК” ХХК

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпын гудамж 4, Нью горизонт, 901 тоот
Утас: 7510-7500, И-мэйл: investment@apex.mn,
Вэб: www.apex.mn

2023 / 1 / 07 / 28 # 178
танай _____ # _____ Т

**Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг
сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай**

“Апекс капитал ҮЦК” ХХК /РД: 5453283/ нь “Омни ассет ТЗК” ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг биржийн зах зээлд олон нийтэд танилцуулах, санал болгох төсөлд Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Компани нь уг үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч дор дурдсан хуулийн этгээдүүдтэй холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран оролцож буйгаас өөрөөр аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохыг үүгээр баталгаажуулж байна. Үүнд:

1. Үнэт цаас гаргагч “Омни ассет ТЗК” ХХК;
2. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч бөгөөд үйлчилгээ үзүүлэгч “Омни капитал ББСБ” ХХК;
3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч “Юнайтед Айр Файнэнс” ХХК
4. Зээлийн шинжилгээ гаргагч “Шонхор үнэлгээ аудит” ХХК
5. Хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН

Компани нь дээр заасан хуулийн этгээдүүдтэй үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг тухай бүр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу авч хэрэгжүүлэхээ үүгээр мэдэгдэж байна.

Түүнчлэн, Компани, түүний эрх бүхий албан тушаалтнууд нь Санхүүгийн зохицуулах хорооны банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам батлах тухай 179 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа болно.



Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ЛХАМДОЛГОР



2023-11-15



Omni Капитал

Бэлтгэсэн Санхүүгийн Балуулагч


Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар Дүүрэг 8-р хороо,
Сүхбаатарын талбай-2, Сэнтрал тауэр оффис, 712, 713 тоот
Утас: 7010-5657, 9979-5115

Цахим шуудан: info@omnicapital.mn

2023.06.20 № 1/2103

танай _____ -ны № _____ -т

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНД



Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын
талаар мэдэгдэл гаргах тухай

Омни капитал ББСБ ХХК РД:6075657 (“Компани”) нь “Омни ассет ТЗК” ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг биржийн зах зээлд олон нийтэд танилцуулах, санал болгох төсөлд анхны үүрэг гүйцэтгэгчийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Компани нь уг үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч дор дурдсан хуулийн этгээдүүдтэй холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран оролцож буйгаас өөрөөр аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохыг үүгээр баталгаажуулж байна. Үүнд:

- i. Хөрөнгө итгэмжлэн удирдагч “Юнайтед Айр Файнэнс” ХХК
- ii. Зээлийн шинжилгээ гаргагч “Шонхор үнэлгээ аудит” ХХК
- iii. Хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН
- iv. Андеррайтер “Алекс капитал ҮЦК”


Компани нь дээр заасан хуулийн этгээдүүдтэй үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг тухай бүр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу авч хэрэгжүүлэхээ үүгээр мэдэгдэж байна.

Түүнчлэн, Компани, түүний эрх бүхий албан тушаалтнууд нь Санхүүгийн зохицуулах хорооны банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам батлах тухай 179 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа болно.

Хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРЭЛХЭГ





“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6 дугаар хороо, Метро бизнес оффис,
6 дугаар давхар 603 тоот

Утас: 70150001, 80110088
Цахим хаяг: www.shonkhor.mn
И-мэйл: shonkhor.mn@gmail.com

2023 07.31 № 23/52

танай _____ -ны № _____ -т

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг
сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай

Шонхор үнэлгээ Аудит ХХК, РД:5821975 (“Компани”) нь “Омни ассет ТЗК” ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг биржийн зах зээлд олон нийтэд танилцуулах, санал болгох төсөлд Зээлийн шинжилгээ хийх үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Компани нь уг үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч дор дурдсан хуулийн этгээдүүдтэй холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран оролцож буйгаас өөрөөр аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохыг үүгээр баталгаажуулж байна. Үүнд:

- i. Үнэт цаас гаргагч “Омни ассет ТЗК” ХХК;
- ii. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч бөгөөд үйлчилгээ үзүүлэгч “Омни капитал ББСБ” ХХК;
- iii. Хөрөнгө итгэмжлэн удирдагч “Юнайтед Айр Файнэнс” ХХК
- iv. Хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН
- v. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч “Алекс капитал ҮЦК” ХХК

Компани нь дээр заасан хуулийн этгээдүүдтэй үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг тухай бүр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу авч хэрэгжүүлэхээ үүгээр мэдэгдэж байна.

Түүнчлэн, Компани, түүний эрх бүхий албан тушаалтнууд нь Санхүүгийн зохицуулах хорооны банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам батлах тухай 179 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа болно.



Хүндэтгэсэн,

Захирал



Д.Шийрэв



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

ГОЛОМТ БАНК
Сийн сайлыг салгуулна

2023-11-15

БҮРТГЭЭГЭЭ

СЭХ
0233
БҮРТГЭЭ
Цахим гүйлгээний баримт

Хүснэгтийн үндсэн дүнгээр 200986870

Татсан огноо: 2023-08-07 10:43

Шилдүүтгэчийн дан нийтлэлээр

2035101262
MN190015002035101262

Хүтээн авагчийн дан

100900025002

Гүйлгээний дүн

100,000.00 MNT

Гүйлгээний төлөв

Амжилттай

Шилдүүтгэчийн нэр
ОМНИ КАПИТАЛ ББСБ

Хүтээн авагчийн нэр
СЭХ.ТЭМДЭГТ ХУРААМЖ
ОРЛОГО

Гүйлгээний өгөг
Омни Ассет ХБҮЦ гаргахад улсын тэмдэгтийн
хураамж-Омни Капитал ББСБ

Хүтээн авагчийн банк
Төрийн сан

Гүйлгээний өдөр
2023-08-07

Гүйлгээний шилжүүлэгчтэйг

Ч. ДАВААСҮРЭН

Гүйлгээний шилжүүлэгчтэйг

Гүйлгээний баталсан хэргийг

01 ГОЛОМТ БАНК
ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хууль зэмсэгтэйгээр Г. Голomt Банк ХХК



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

ГОЛОМТ БАНК
Сайн сайлалт санхүүжилт

2023-11-15

БҮРТГЭЭ-02



Цахим гүйлгээний баримт

Хүтээгчийн хэргийн дугаар: 200986416

Татсан өгнөө: 2023-08-07 10:13

Шилдүүтгэчийн дангийн дугаар

Хүтээгч ачаагчийн дан

Гүйлгээний түл

Гүйлгээний төлөв

2035101262

1105021404

2,000,000.00 MNT

Амжилттай

MN190015002035101262

MN090015001105021404

Шилдүүтгэчийн нэр

Хүтээгч ачаагчийн нэр

Гүйлгээний үзэг

ОМНИ КАПИТАЛ ББСБ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХК

Омни Ассет ХБУЦ-ийн МХБ-д өргөдөл хүлээн
авч хянах хөлс-Омни Капитал ББСБ

Хүтээгч ачаагчийн банк

Гүйлгээний өгнөө

Голомт Банк

2023-08-07

Гүйлгээний шилжүүлэг

Гүйлгээний захирагчийн нэр

Гүйлгээний захирагчийн нэр

Ч. ДАВААСҮРЭН



Бүх зүйлс хуульчилж хангагдсан. © Голомт Банк ХХК

